



# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРОО

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНКНААС САНХҮҮЖҮҮЛСЭН  
ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ЗЭЭЛ ОЛГОЛТ,  
ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН ЯВЦАД ХИЙСЭН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН

## ТАЙЛАН

Улаанбаатар  
2023 он

## АГУУЛГА

ҮЙЛ ЯВДЛЫН ХУРААНГУЙ.....	4
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ .....	5
Хянан шалгах ажлын зорилт:.....	5
Хянан шалгах ажлын арга зүй .....	6
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ЗАРЧИМ .....	7
ХЯНАН ШАЛГАХ АЖЛЫН ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ.....	8
Монгол Улсын Засгийн газрын тус банктай холбоотой шийдвэрүүд: .....	9
УИХ, Монголбанк, Үндэсний аудитын газар, Засгийн газрын Монгол Улсын Хөгжлийн Банкны үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалт: .....	9
Авлигатай тэмцэх газрын банкны зээлийн үйл ажиллагаанд хийж буй хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах үйл ажиллагаа: .....	10
Улсын Ерөнхий прокурорын газрын банкны зээлийн үйл ажиллагаатай холбоотой хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах үйл ажиллагаанд тавьж буй хяналт:.....	10
Аудитын хуулийн этгээдийн гаргасан дүгнэлт зөвлөмж: .....	10
ХЯНАН ШАЛГАЛТЫН АЖЛЫН ЦАР ХҮРЭЭ .....	13
НЭГ. НОТЛОХ БАРИМТ ИРҮҮЛЭХ ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТ .....	15
Улсын ерөнхий прокурорын газрын мэдээлэл.....	17
Авлигатай тэмцэх газрын мэдээлэл .....	18
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын мэдээлэл .....	20
Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээлэл.....	21
Ашигт малтмал, газрын тосны газрын мэдээлэл .....	21
ХОЁР. НОТЛОХ БАРИМТЫН ИЖ БҮРДЭЛД ХЯНАЛТ ХИЙХ ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	22
ГУРАВ. ХЯНАН ШАЛГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	26
ДӨРӨВ. ОЛОН УЛСЫН АУДИТЫН КОМПАНИУДЫН ДҮГНЭЛТ ЗӨВЛӨМЖ, ӨМНӨХ ЖИЛҮҮДЭД ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ .....	50
ТАВ. УИХ, МОНГОЛБАНК, ЗАСГИЙН ГАЗАР, ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР БОЛОН БУСАД АУДИТЫН ХУУЛИЙН ЭТГЭЭДЭЭС ХИЙСЭН ХЯНАЛТ, ҮР ДҮН .....	53
ЗУРГАА. ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ СОНСГОЛ, МЭДЭЭЛЛИЙН ХУРААНГУЙ ...	77
УИХ-ын Хянан шалгах түр хорооны СОНСГОЛ-I .....	80
УИХ-ын Хянан шалгах түр хорооны СОНСГОЛ-II .....	83
УИХ-ын Хянан шалгах түр хорооны СОНСГОЛ-III .....	97
ДОЛОО. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ДҮГНЭЛТ .....	113
НАЙМ. ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ, ЗӨВЛӨМЖ .....	113
ХАВСРАЛТУУД .....	117

**ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР**

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
АТГ	Авлигатай тэмцэх газар
АХЭ	Аудитын хуулийн этгээд
АМГТГ	Ашигт малтмал, газрын тосны газар
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ЗГҮЦ	Засгийн газрын үнэт цаас
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗТХЯ	Зам, тээвэр хөгжлийн яам
ЗУХ	Зээлийн удирдлагын хороо (Хөгжлийн банк)
ЖДҮХС	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан
МГТБҮ	Монголын газрын тос боловсруулах үйлдвэр
МУХБ	Монгол Улсын Хөгжлийн банк
НББ	Нягтлан бодох бүртгэл
НЗДТГ	Нийслэлийн засаг даргын Тамгын газар
НХОГ	Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар
ӨБҮХ	Өмчлөх бусад үндсэн хөрөнгө
TAX	Төсөл, арга хэмжээ
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ТБОНӨХБАУХАТХ	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕГ	Татварын Ерөнхий газар
ТЕЗ	Төсвийн Ерөнхийлөн захирагч
ТЗТБ	Төрийн захирагааны төв байгууллага
ТОСК	Төрийн орон сууцны корпораци
УБЕГ	Улсын Бүртгэлийн Ерөнхий газар
ҮЕПГ	Улсын Ерөнхий Прокурорын газар
ҮИХ	Улсын Их Хурал
ҮУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
ҮАБЗ	Үндэсний Аюулгүй Байдлын зөвлөл
ҮАГ	Үндэсний Аудитын газар
ҮХОБ	Үндэсний Хөрөнгө Оруулалтын банк
ХХБ	Худалдаа Хөгжлийн банк
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам
ХШТХ	Хянан шалгах түр хороо
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ЭХЯ	Эрчим хүчний яам

## ҮЙЛ ЯВДЛЫН ХУРААНГУЙ

2022.04.15	Монгол Улсын Их Хурлын 14 дүгээр тогтоолоор Улсын Их Хурлын Хянан шалгах Түр хороог байгуулав.
2022.05.31	Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах Түр хорооны “Нотлох баримт гаргуулах тухай” 02 дугаар тогтоол батлагдав.
2022.06.07	Улсын Их Хурлын Хянан шалгах Түр хорооны 03 дугаар тогтоолоор хянан шалгагч нарыг томилж, “Ажлын даалгавар”-ыг батлав.
2022.10.12	Улсын Их Хурлын Хянан шалгах Түр хорооны 04 дүгээр тогтоолоор шинжээч нарыг томилов.
2022.10.14	Монгол Улсын Их Хурлын 61 дүгээр тогтоолоор “Хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай” шийдвэр гаргав.
2022.11.14	Улсын Их Хурлын Хянан шалгах Түр хорооны 07 дугаар тогтоолоор Хянан шалгах хорооны хянан шалгагч, шинжээчдийн арилжааны банкуудад хийх газар дээрх шалгалтын удирдамж, бүрэлдэхүүнийг батлав.
2022.11.14	Улсын Их Хурлын Хянан шалгах Түр хорооны хуралдаанаар “Хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлэх тухай” 08 дугаар тогтоол гаргаж, Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооноос Төрийн байгууллагад ажиллах удирдамж батлав.
2022.12.12	Улсын Их Хурлын Хянан шалгах Түр хорооноос “Түр хорооны сонсгол товлон зарлах тухай” 9 дүгээр тогтоолыг батлав.
2022.12.12	Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах Түр хорооны хуралдаанаар “Түр хорооны сонсголд гэрчээр дуудах тухай” 10 дугаар тогтоолыг батлав.
2023.01.16-20	МУХБ-наас шууд санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрийн зарцуулалттай холбоотой нээлттэй сонсгол I зохион байгуулсан.
2023.02.06-08	Засгийн газарт шилжүүлсэн 355 төсөл хөтөлбөр, МУХБ-ны охин компаниар дамжуулан олгосон санхүүгийн болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны зарцуулалттай холбоотой нээлттэй сонсгол II зохион байгуулсан.
2023.03.13-17	МУХБ-ны эх үүсвэрийг арилжааны 10 банкаар дамжуулан олгосон 2542 дэд зээлдэгчийн санхүүжилт, мөнгөн хөрөнгийн удирдлагатай холбоотой нээлттэй сонсгол III зохион байгуулсан.
2023.04.17	Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах Түр хорооны ээлжит хуралдаан болов.

## НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.2, 34.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор Хянан шалгах Түр хороог байгуулж, хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хяналт шалгалтын ажлыг гүйцэтгэлээ.

Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах Түр хороо нь “Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явц, байдал”-ыг шалгах чиг үүрэгтэй болно.

Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах Түр хорооны 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 03 дугаар тогтоолоор хянан шалгагч нарыг томилж, хянан шалгагчийн “Ажлын даалгавар”-ыг хавсралтаар, 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 08 дугаар тогтоолоор шинжээч нарыг томилж “Шалгалтын удирдамж”-ийг баталсан.

### Хянан шалгах ажлын зорилт

Монгол Улсын Хөгжлийн Банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явцад хяналт шалгалт хийж, дүнг Улсын Их Хурлаас байгуулсан Хянан шалгах түр хороо, бусад эрх бүхий байгууллага, албан тушаалтанд танилцуулахад ажлын зорилт чиглэгдсэн. Үүнд:

- УИХ-ын ХШТХ-ны хянан шалгагчдаас Хөгжлийн банкнаас олгосон зээлээс чанаргүй ангилалд бүртгэгдсэн зээлийн эргэн төлөлтийн явцад гарч байгаа ахиц дэвшлийг үнэлж дүгнэх, нотлох зүйлд тулгуурлан хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэвэл зохих асуудлыг тодорхойлох;
- МУХБ-ны эх үүсвэрээр санхүүжүүлсэн хөгжлийн гэх тодотголтой олгосон бүхий л хэвшлийн зээлдэгчийн зээлийн эргэн төлүүлэх үйл явцад дэмжлэг үзүүлэх, эрчимжүүлэх, удаашралтай байгаагийн шалтгаан, үр дагаврыг тооцож, үр нөлөөг үнэлэх;
- Ажлын зорилтыг хураангуйлснаар гол асуудал нь цаг үе, олон нийтийн шаардлагаар банкны үйл ажиллагаанд оршиж байсан болон өнөөгийн нөхцөл байдалд хүргэсэн бодит шалтгаан нөхцөлийг найдвартай эх сурвалжид түшиглэн дүгнэх.

УИХ-ын ХШТХ-ны 2022 оны 08, 09 дүгээр тогтоолын хүрээнд батлагдсан ажлын удирдамжид тодорхойлсноор зарим төрийн захиргааны төв байгууллагууд болон арилжааны банкууд хамрагдсан.

Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны тогтоолоор баталсан хянан шалгагч нарын Ажлын даалгаварт дараах үндсэн ажилбаруудыг тусгасан<sup>1</sup>. Үүнд:

Д.д	Үндсэн ажлын нэр
1	Шаардлагатай нотлох баримт бүрдүүлэх (Сангийн яам, Монголбанк, Хөгжлийн банк, Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Үндэсний аудитын газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар)
2	Дээрх нотлох баримтыг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд шаардаж гаргуулах
3	Нотлох баримт цуглуулах явцад болон Түр хорооны үйл ажиллагаатай холбоотой асуудлаар холбогдох этгээдээс тайлбар авах
4	Нөхцөл байдалтай газар дээр нь танилцах, газар дээр нь очиж танилцаж тэмдэглэл үйлдэх
5	Цуглуулсан нотлох баримт болон холбогдох бусад бичиг баримтад дүн шинжилгээ хийх
6	Олон улсын аудитын компаниудын дүгнэлт зөвлөмж, өмнөх жилүүдэд өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг системчлэн дүгнэлт гаргах

<sup>1</sup> Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 03 дугаар тогтоолын хавсралт

7	Зориулалтын бусаар зээлээ ашигласан байж “болзошгүй” зээлдэгч нарын бусад банканд хийсэн гүйлгээний жагсаалт гаргах
8	Улсын бүртгэлийн ерөнхий газраас чанаргүй зээлийн ангилалд орсон зээлдэгчид болон хамаарал бүхий этгээдүүдийн эд хөрөнгө, үл хөдлөх хөрөнгийн жагсаалт гаргуулах
9	Ашигт малтмал, газрын тосны газраас чанаргүй зээлийн ангилалд орсон зээлдэгчид болон хамаарал бүхий этгээдүүдийн нэр дээр бүртгэлтэй тусгай зөвшөөрлийн мэдээллийг гаргуулах
10	Ажлыг тайлгаха үе шат

### Хянан шалгах ажлын арга зүй

Хянан шалгах ажлыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Их хурлын Хяналт шалгалтын тухай хуулиар тодорхойлсон Хянан шалгагчийн ажлын даалгаварт тусгасан нотлох баримт бүрдүүлэх, хянан шалгах дэд асуудлын дагуу нэмэлт нотлох баримт цуглуулж дүн шинжилгээ хийх, холбоотой талууд, албан тушаалтантай ярилцлага хийх, тайлбар тодруулга авах, нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж, түүвэр шалгала явуулах, мэдээлэл тайлбар авч ажлын баримт материал үйлдэх, шаардлагатай тохиолдолд Түр хорооны бүрэн эрхийн дагуу тулган баталгаажуулалт хийх бусад нэмэлт горим, сорилыг хэрэгжүүлсэн<sup>2</sup>.

Хянан шалгах ажлын явц, нөхцөл байдлаас шалтгаалан Түр хорооны бүрэн эрхийн хүрээнд холбогдох шийдвэрийг гаргах, шинжээч томилох, төрийн байгууллага, албан тушаалтан, Хөгжлийн банкны зээлдэгч, бусад харилцагч этгээдээс нэмэлт тодруулга авч нотлох баримт гаргуулахад хүчин чармайлт гарган ажиллалаа.

Хяналт шалгалтын явцад хуулийн этгээдээс бүрдүүлсэн ажлын баримт материал нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасан нотлох баримтын шаардлагыг хангасан байх хуулийн зохицуулалтын дагуу баримтын иж бүрэн байдал, хуулийн хүчин төгөлдөр байдлыг хангуулахад анхаарсан.

Хяналт шалгалтын үйл ажиллагаа нь ажлын даалгаварт тусгагдсан асуудлаар гүйцэтгэх горим, ажилбаруудыг гүйцэтгэхдээ Хөгжлийн банкны хуулиар тодорхойлсон үйл ажиллагааны зарчим чиг үүргийн хэрэгжилтийн хүрээнд зээлийн орчинтой холбогдох хууль тогтоомжид заасан зарчим, асуудлын хүрээнд гол чиглэлүүдээ тодорхойлж, нөхцөл байдалд суурилсан дүн шинжилгээг хийж, дүгнэлт, цаашид өнөөгийн хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх санал боловсруулахад анхаарсан.

Хөгжлийн банкны татан төвлөрүүлсэн хөрөнгийн болон зээлийн зохистой удирдлагын үр дүн нь үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтээр хэрхэн хангагдаж ирсэн, түүнчлэн банкны үйл ажиллагаатай холбоотой хөндлөнгийн болон УИХ, Монголбанк, Төрийн аудитын байгууллага, Засгийн газар, Сангийн яам, бусад нэгжээс гүйцэтгэсэн аудит, хяналт шалгалтын дүн үнэн зөв байдлыг илэрхийлж байсан эсэх, дүгнэлт зөвлөмж, түүний мөрөөр төлөвлөсөн хариу арга хэмжээний гүйцэтгэл, хэрэгжилтийн үр дүн ямар түвшинд хүрснийг цуглуулсан хяналт шалгалтын баримт материалд тулгуурлан үнэлсэн.

УИХ-ын ХШТХ-ны тогтоолд заасан нотлох баримт, түүнийг хариуцан ажиллаж буй банк болон төрийн байгууллагуудыг хамруулан мэдээлэл хүлээн авч, түүнд түшиглэн судалгаа, нотлох баримтыг үнэлэх ажлыг гүйцэтгэсэн болно.

Хөгжлийн банкны асуудлаар хяналт шалгалтын ажлын даалгаврын дагуу цуглуулсан нотлох баримтад үндэслэн хямралд түлхсэн нөхцөл байдлын шалтгаан, түүнээс авах сургамж, бодит байдалд суурилсан санал дүгнэлт гаргахыг зорьж, асуудал дахин давтагдахаас урьдчилан сэргийлж ёс зүй, хариуцлагын асуудлыг хөндөхөд ч давхар анхаарсан болно.

Хянан шалгах ажлын явцад өнөөгийн нөхцөл байдалд хүргэсэн шалтгаан нөхцөл, хариуцлагын асуудлаар нотлох зүйлсэд тулгуурлан байр сууриа илэрхийлэх, зээлийн эргэн төлөлтийн хариуцлагатай ил тод байдлыг хангуулах, олон нийтэд үнэн зөв, бодит нөхцөл байдлыг мэдээлэхэд түлхэц өгөхөд чиглүүлсэн.

<sup>2</sup> Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 44 дүгээр зүйл.

Хянан шалгагч, шинжээчийн дүгнэлтийн цар хүрээний хувьд зээл олголтын үндэслэл, гүйлгээ бүрд харгалзах гэрээ, зээлдэгч болон гүйцэтгэгч иргэн, ААН, байгууллагын санхүүгийн анхан шатны баримт материалтай нэг бүрчлэн танилцах боломжгүй, цаг хугацаа хязгаарлагдмал, зөвхөн харилцах дансны хуулгыг үндэслэн зээлийн зарцуулалтыг нягталсан тул худалдан авч буй бараа, ажил, үйлчилгээ нь зориуулалтын дагуу байсан эсэхийг эцэслэн тогтоох боломжгүй байсан.

## ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ЗАРЧИМ

Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хороо байгуулах тухай 2022 оны 14 дүгээр тогтоол, ХШТХ-ноос баталсан шийдвэрийн дагуу МУХБ-наас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явц, байдлыг шалгах хязгаарын хүрээнд гүйцэтгэсэн болно<sup>3</sup>.

Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуульд заасан ажлын даалгаврын хүрээнд хянан шалгах ажлыг гүйцэтгэхдээ хуульд заасан хязгаарлалтын хэм хэмжээг баримтлан цуглуулсан болон дүн шинжилгээний нотлох зүйлсэд тулгуурлан дүгнэлт гаргаж, энэхүү тайланг бэлтгэсэн<sup>4</sup>.

Хянан шалгах ажлын явцад МУХБ-нд хохирол учруулсан байж болзошгүй асуудлаар хууль хяналтын байгууллага (ҮЕПГ, АТГ)-д шалгагдаж байгаа болон хяналт тавин ажиллаж байгаа хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд нөлөөлөхгүйгээр мэдээлэл солилцо замаар Хөгжлийн банкны чанаргүй зээлийн эргэн төлөлтийн цаашдын үйл ажиллагаанд түлхэц өгөх, нотлох баримтад тулгуурлан цаг хожих, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгыг агуулж байсан.

### Хянан шалгах ажлыг гүйцэтгэхдээ анхаарсан асуудал,

- ⇒ Хангалттай бөгөөд зохицой нотлох зүйлс олж авах;
- ⇒ Баримтжуулалтад анхаарах, нэмэлт материал бүрдүүлэх.

### Хянан шалгах ажлын талбар,

- ⇒ Хөгжлийн банкны зээл олголт, төлүүлэлтийн байдалд дүгнэлт гаргах;
- ⇒ Зээл төлүүлэлт, үлдэгдлийн мэдээлэл авч дүгнэлт гаргах;
- ⇒ Чанаргүй зээл үүсэх шалтгаан нөхцөлийг судалж дүгнэлт гаргах;
- ⇒ Хууль хяналтын байгууллагаас ирүүлсэн мэдээллийг шинжлэх;
- ⇒ Чанаргүй зээлийн ангилалд бүртгэлтэй зээлийн материалтай танилцах;
- ⇒ Чанаргүй зээлийн ангилалд бүртгэлтэй зээлдэгчийн УБЕГ, АМГТГ-т бүртгэгдсэн мэдээллийг авч, дүгнэлт гаргах ажилбаруудыг гүйцэтгэх.

Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах Түр хорооны 2022 оны 04, 08 дугаар тогтоолын дагуу томилогдсон түр хорооны шинжээчид нь ХШТХ-ны тогтоолоор баталсан удирдамжийн хүрээнд арилжааны банкууд болон зарим төрийн байгууллагуудад ажилласан.

ХШТХ-ны хянан шалгагч, шинжээчийн баг удирдамжийн дагуу Засгийн газраас тус банканд чиглэл болгосон болон МУХБ-ны эх үүсвэрээс шууд олгосон, арилжааны банкаар дамжуулан олгосон санхүүжилтийг холбоотой дансдын гүйлгээг хөөн шалгах аргаар, төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг гүйцэтгэлийн баримтад суурилан нягтлан дүгнэсэн.

Мөн зарим төрийн захиргааны байгууллагууд (ЗТХЯ, ГЕГ, ЭХЯ, БХБЯ, УУХҮЯ, ХХААХҮЯ, БСШУСЯ, Сангийн яам, НЗДТГ)-ын хариуцсан салбарт хэрэгжсэн төсвийн шинж

<sup>3</sup> Монгол Улсын Их Хурлын 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн "Хянан шалгах түр хороо байгуулах тухай" 14 дүгээр тогтооолын 2 дахь хэсэг

<sup>4</sup> 44.6.Хянан шалгагч нь тусгай шалгалтын дунд үндэслэн тайланг бичгээр гаргаж, сонсголд амаар танилцуулах бөгөөд уг тайлантай танилцах боломжийг түр хорооны гишүүн бурд олгоно. Түр хорооноос авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх зөвлөмжийг тайланд тусгаж болно.

чанартай хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэл үр дүнгийн баримт материалыг хянан үзсэн.

ЗГХЭГ-аас ирүүлсэн Бондын зөвлөлийн хуралдааны 2 удаагийн тэмдэглэлийг ирүүлээгүй тул тодруулах ажлыг гүйцэтгэсний дээр ҮАБЗ-ийн 2 удаагийн зөвлөмж гаргах хуралдааны тэмдэглэлтэй хуульд заасан үндэслэлийн хүрээнд нууцын журмаар танилцсан болно.

УИХ-ын ХШТХ-ны 2022 оны 08 дугаар тогтоол нь “Хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлэх тухай” байсан бөгөөд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталж, “Шалгалтын удирдамж”-ыг баталж, түүний дагуу МУХБ-наас санхүүжилт авсан төрийн байгууллага болон арилжааны банкуудад чиглэл өгч ажилласан.

Хянан шалгагч, шинжээч нарт Түр хорооны хуралдаанаар дарга, гишүүдээс чиглэл болгосон асуудал болон ХШТХ-ны даргын баталсан “Ажлын даалгавар”, арилжааны банк, төрийн зарим байгууллагад хийх “Газар дээрх шалгалтын удирдамж”-д туссан ажилбаруудыг гүйцэтгэхдээ ашиг сонирхлын зөрчилгүй ажиллахыг эрхэмлэн хууль дээдлэх, олон нийтийн эрх ашгийг хүндэтгэн ажилласан болно.

УИХ-ын ХШТХ-ны 2022 оны 09 дүгээр тогтоолоор Түр хорооны сонсголыг явуулах үе шат, хугацаа, нотлох баримтыг шинжлэн судлах сонсголын сэдэв агуулгыг батлан зохион байгуулахаар товлосны дагуу хэрэгжүүлсэн.

### **Хянан шалгагч, шинжээчийн бүрэлдэхүүн**

Хяналт шалгалтын ажлын хэсгийн бүрэлдэхүүний хувьд 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрөөс 2023 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийг хүртэл хянан шалгагчаар Л.Эрдэнэчулуун (ҮАГ-ын менежер), И.Уянга (МБ-ны улсын байцаагч), 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдрөөс 2023 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийг хүртэл шинжээчээр О.Оргилмаа (МБ-ны улсын байцаагч), О.Лхагвадорж (МБ-ны улсын байцаагч), Б.Эрдэнэбат (ҮАГ-ын ахлах аудитор), Б.Хишигтогтох (ҮАГ-ын ахлах аудитор), Ч.Амарбаясгалан (ХЗДХЯ-ын ахлах мэргэжилтэн), О.Мөнхбат (дата аналист), Г.Лхагвадорж (МБ-ны эдийн засагч) нарын 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилогдож ажилласан.

### **ХЯНАН ШАЛГАХ АЖЛЫН ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ**

Монгол Улсын Их Хурлаас Хөгжлийн банкны тухай хуулийг 2011 оны 02 дугаар сарын 10-ны өдөр баталж байсан бол Засгийн газрын 2011 оны 151 тогтоолоор МУХБ-ны дүрэм, бүтэц, зохион байгуулалтыг баталж, Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн дагуу албан ёсоор 2011 оны 3 дугаар сарын 25-ны өдөр тус банк үүсгэн байгуулагдаж, үйл ажиллагаа нь эхэлснээс хойш 6 жилийн дараа буюу 2017 оны 02 дугаар сарын 10-ны өдөр хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан байна.

МУХБ-ны тухай хуулийн /2011 он/ 18.1.9-д “Хөгжлийн банкны зохистой засаглалын бодлого, журмыг тогтоож, хэрэгжилтэд хяналт тавих” гэж заасан ч МУХБ-ны ТҮЗ-өөс 2016 оныг хүртэлх хугацаанд энэ талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байв.

УИХ-ын 2014 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан “Эдийн засгийн идэвхжилийг нэмэгдүүлэх арга хэмжээний чиглэл”-ийн 3.37 -д “…Хөгжлийн банкны тухай хууль болон холбогдох бусад хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг боловсруулж, өргөн мэдүүлэх”-ийг Засгийн газарт үүрэг болгосон ч тодорхой үр дүн гараагүй байна.

МУХБ-ны тухай хуулийн /2017 он/ шинэчилсэн найруулга нь банкнаас зээл олгох, төсөл санхүүжүүлэх зарчмыг шинэчлэн, үйл ажиллагааны хүрээ өргөжих боломж нэмэгдэж, Монголбанк, Засгийн газрын зүгээс тавих хяналтын тогтолцоог шинэчилжээ.

Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын зөвлөл (цаашид “ҮАБЗ” гэх) 2012 оны 12 дугаар сарын 03-ны өдөр 28/20 дугаар зөвлөмжийг гаргаснаар түүнийг үндэслэн “Бодлогын зөвлөл” байгуулж, ҮАБЗ-ийн “зөвлөмжийг үндэслэн” уг зөвлөлөөс Засгийн газрын үнэт цаасыг арилжаалж бүрдүүлсэн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх “Бодлогын зөвлөлийн зөвлөмж”-ийг гаргаж, тэрхүү зөвлөмжөөр төсөл, хөтөлбөрүүдийг

боловсруулж Засгийн газарт оруулж шийдвэрлүүлэх чиглэл өгч эхэлснээс хойш тус банкны зээл олгох үйл ажиллагаа эрчимжик эхэлсэн байна.

ҮАБЗ-ийн 2012 оны “Засгийн газрын үнэт цаасны талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газарт чиглэл болгосон 6 заалт бүхий 28/20 дугаар зөвлөмж гарснаас хойш ҮАБЗ-ийн 2014 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн “Засгийн газрын үнэт цаас арилжаалж бүрдүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тухай” Засгийн газарт чиглэл болгосон 8 заалт бүхий 19/10 тоот зөвлөмж гарч байжээ.

МУХБ-наас зээлийн үйл ажиллагааг эхлүүлснээс хойших хугацаанд нийт 7.5 их наяд төгрөгийн зээлийг 3000 гаруй төсөл, арга хэмжээнд олгосноос хянан шалгах үйл ажиллагааг эхлүүлэх үед буюу 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар 59 зээлдэгчийн 3.1 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байв.

МУХБ бусдаас татан төвлөрүүлэх эх үүсвэрийн хэмжээг дунд болон урт хугацааны стратеги төлөвлөгөөнд тусган төлөвлөж байсан хэдий ч санхүүжүүлэх төслүүдийн эдийн засгийн үр ашгийн тооцоо, ТЭЗҮ, зураг төсөл зэрэг төлөвлөлт, судалгааны бэлтгэл ажил бүрэн хангагдаагүй байхад хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлж байжээ.

Өнгөрсөн хугацаанд МУХБ-ны мөнгөн хөрөнгийн удирдлага үр нөлөөтэй хэрэгжээгүйгээс алдагдсан боломжийн зардлыг үүсгэж ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлж байсны зэрэгцээ дотоод хяналтын тогтолцоог 2017 оноос зохих ёсоор бүрдүүлсэн ч үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулалтын “үр нөлөө” хангалтгүй түвшинд явж ирсэн байна.

#### **Монгол Улсын Засгийн газрын тус банктай холбоотой шийдвэрүүд:**

- Засгийн газраас Монгол Улсын Хөгжлийн банкны эрх зүйн орчинтой холбоотойгоор 2010 оноос эхлэн 2017 оны 02 дугаар сарын 10-ныг хүртэл хугацаанд банканд үүрэг болгосон, банкны үйл ажиллагаанд хамаарах нийт 196 тогтоол, тэмдэглэл гарсан. Үүнд:
  - Банкны бүтэц, зохион байгуулалттай холбоотой – 13
  - Банкны эх үүсвэр, үнэт цаас гаргахтай холбоотой - 19
  - Банкнаас санхүүжүүлэх төсөл, хөтөлбөртэй холбоотой – 162
  - Банкны үйл ажиллагаатай холбоотой Монгол Улсын Ерөнхий сайдын захирамж, сайдын тушаал – 32
- Засгийн газраас Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн дагуу 2017 оны 02 дугаар сарын 10-наас хойш 2021 оныг дуустал хугацаанд банкны үйл ажиллагаатай холбоотой нийт 34 тогтоол, тэмдэглэл гарсан. Үүнд:
  - Банкны бүтэц, зохион байгуулалттай холбоотой - 16
  - Банкнаас санхүүжүүлэх төсөл, хөтөлбөртэй холбоотой – 17
  - Банкны үйл ажиллагаатай холбоотой Ерөнхий сайдын захирамж, тушаал – 3
- Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагаатай холбоотой тогтоол, захирамж, тушаал /УИХ, Засгийн газраас бусад/
  - Өнгөрсөн хугацаанд холбогдох эрх бүхий байгууллагаас тус банкны үйл ажиллагаатай холбоотой 35 шийдвэр гарсан байна.

#### **УИХ, Монголбанк, Үндэсний аудитын газар, Засгийн газрын Монгол Улсын Хөгжлийн Банкны үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалт:**

Сүүлийн жилүүдэд Хөгжлийн банкны үйл ажиллагаанд УИХ /2022/, Засгийн газар /2019/, Монголбанк /2018, 2021/, Монголбанк, Сангийн яамны хамтарсан /2020/, ҮАГ /2021/, PWC /2018/ зэрэг эрх бүхий байгууллагаудаас хийгдсэн томоохон хяналт шалгалтаар нийт 170 зөрчилтэй асуудал тэмдэглэгдэж, үр дүнд үндэслэсэн нийт 192 дүгнэлт, зөрчил болон эрсдэлийг бууруулах нийт 232 зөвлөмж өгч байв.

- Эдгээр алдаа зөрчил, дүгнэлт, зөвлөмжийг ангилбал /594/;
- Зээлийн үйл ажиллагаа ба түүний орчин /112/
  - Банкны Засаглал, удирдлага болон дотоод хяналт, төлөвлөлтийн үйл ажиллагаа /135/
  - Дотоод үйл ажиллагаа /86/
  - Эрсдэл /135/
  - Хөрөнгийн удирдлага /107/
  - Санхүүгийн тайлagnal ба нягтлан бодох бүртгэлтэй холбоотой /19/ алдаа, зөрчлийг хөндлөнгийн болон эрх бүхий байгууллагын аудит, хяналт шалгалтын тайланд тэмдэглэсэн байна.

**Авлигатай тэмцэх газрын банкны зээлийн үйл ажиллагаанд хийж буй хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах үйл ажиллагаа:**

- Мөрдөн шалгах ажиллагаа,
  - ⇒ АТГ-т нийт 39 хэрэг бүртгэлтийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас 15 хэргийг эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татаж, 2 хэргийг нэгтгэж мөрдөн байцаалтын 15 хэргээс 11 хэргийг холбогдох хуулийн үндэслэлээр нэгтгэж, мөрдөн байцаалтын 4, хэрэг бүртгэлтийн 22 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

**Улсын Ерөнхий прокурорын газрын банкны зээлийн үйл ажиллагаатай холбоотой хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах үйл ажиллагаанд тавьж буй хяналт:**

- ⇒ Хөгжлийн банкны зээл олгох үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомжийг зөрчиж зээл олгосноор давуу байдал бий болгож улмаар тус банканд хохирол учруулсан байж болзошгүй гэсэн үндэслэлээр хэрэг бүртгэлтийн 22 хэргийг хянах байна.
- ⇒ Тус Мөрдөн байцаалт явуулж буй 4 хэрэгт улс төрд нөлөө бүхий этгээд 5, Хөгжлийн банкны болон төрийн бусад байгууллагын эрх бүхий албан тушаалтан 48, ААН-ийн албан тушаалтан 24, нийт 77 хүнд холбогдуулан эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татан мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулж байна.

#### **Аудитын хуулийн этгээдийн гаргасан дүгнэлт зөвлөмж:**

Аудитын хуулийн этгээдийн гүйцэтгэсэн хөндлөнгийн аудитын дүгнэлт, удирдлагын захидалд дурдсан аудитын ажлын дүнд ажигласан зүйлсэд тулгуурлан гаргасан санал, зөвлөмжүүдийн буюу тус банкны засаглах үйл ажиллагааны эрсдэл болон “Зээлийн орчин”-той холбоотой талбаруудад хэрэгжсэн горим, нөхцөл байдал, үйл ажиллагааг авч үзсэн.

Хөгжлийн банк үүсгэн байгуулагдсанаас хойших жил бүрийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн байдлын тайлagnalд УБ аудит ХХК /1/, DELOITTE /3/, PWC /3/, KPMG /4/ тус тус аудитыг гэрээний үндсэн дээр гүйцэтгэсэн байна.

Аудитын хуулийн этгээдээс гүйцэтгэсэн аудитын дүн, удирдлагад хүргүүлэх захидалд зээлийн багцын хурдацтай ёсөлттэй уялдсан үүсэж болзошгүй эрсдэл бий болохыг, үнэ цэний бууралт, чанаргүйдлээс урьдчилан сэргийлэх талаар холбогдох горим тогтолцоог нэвтрүүлэх асуудлаар (2013 оноос эхлэлтэй) зохих зөвлөмж өгч ирснийг тэмдэглэж байна.

МУХБ-ны 2011-2021 оны санхүүгийн жилийн дуусгавар болгосон санхүүгийн байдалд аудит хийлгэсэн байдлаас үзэхэд АХЭ-ээс 119 асуудлаар нийт 266 зөвлөмжийг удирдлагын захидаар хүргүүлж байсан ба зөвлөмжийн агуулга давхцаж байгааг онцолж байна.

Түүнчлэн Хөгжлийн банкны зээлжих зэрэглэлийн үнэлгээг Монгол Улсын Засгийн газрын үнэлгээтэй адил түвшинд үнэлж ирсэн байна.

## Монгол Улсын Хөгжлийн банкны өрөнхий мэдээлэл

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 195 дугаар тогтоолоор Монгол Улсын эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах тэргүүлэх салбаруудад хэрэгжих төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх, импортыг орлох, экспортын орлогыг нэмэгдүүлэх үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор Монгол Улсын Хөгжлийн банк (цаашид “МУХБ” гэх) байгуулахаар шийдвэрлэж байсан.

МУХБ-ны тухай хуулийг 2017 онд шинэчлэн баталж, банкны эрх зүйн байдлыг “Хөгжлийн банк нь үндэсний эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах тэргүүлэх салбаруудад хэрэгжих төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх, импортыг орлох, экспортын орлогыг нэмэгдүүлэх үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилготой, энэ хуулийн 8.1-д заасан үйл ажиллагааг эрхлэх чиг үүрэг бүхий ашигийн төлөө хуулийн этгээд байна” гэж тодорхойлсон.

“Монгол Улсын Хөгжлийн банк” ХХК-ийн төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг ЗГХЭГ 2016 оноос эхлэн хэрэгжүүлж байсныг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн 122 дугаар тогтоолоор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлж эхэлсэн байна.

МУХБ үүсгэн байгуулагдсанаас хойш /2011 он/ Засгийн газраас банктай холбоотой гаргасан 165 тогтоол, тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгавраас бүрэн хэрэгжсэн 123, хэрэгжих шатанд байгаа 14, хэрэгжих боломжгүй 28 арга хэмжээ байна гэж ХШТХ-нд мэдээлсэн<sup>5</sup>.

МУХБ үүсгэн байгуулагдсанаас хойш ТҮЗ-ийн даргаар нийт 9 хүн ажилласнаас 1 хүн 2022 оны 03 дугаар сарын 24-нөөс одоог хүртэл ажиллаж байгаа бөгөөд ажилласан хугацааны хувьд хамгийн бага нь 51, их нь 1404 өдөр буюу ажилласан ба 8 хүн дунджаар уг албан тушаалд 617 хоног ажилласан байна. Ажиллаж байсан 8 хүний 25 хувь нь 3 ба түүнээс бага сар ажилласан бол 75 хувь буюу дийлэнх нь 6 сараас дээш буюу 3.8 жил хугацаагаар ажилласан байна.

ТҮЗ-ийн гишүүнээр нийт 25 хүн ажиллаж байснаас ажилласан хугацааны хувьд хамгийн бага нь 110, их нь 1404 өдөр ажилласан ба дунджаар 673 хоног ажилласан байна. Нийт 25 гишүүний 24 хувь нь 1 жил хүртэл хугацаанд ажилласан бол үлдсэн 76 хувь нь 1-3.8 жил хүртэл хугацаагаар тус тус ажиллажээ.

ТҮЗ-ийн хараат бус гишүүдээр нийт 23 хүн ажилласнаас 7 хүн 2022 оны 03 дугаар сарын 24-нөөс одоог хүртэл ажиллаж байгаа бөгөөд ажилласан хугацааны хувьд хамгийн бага нь 73, их нь 2069 өдөр ажилласан ба 16 хүн дунджаар 791 хоног ажилласан байна. Ажиллаж байсан 16 хүний 12.5 хувь нь 1 жил хүртэл хугацаанд ажилласан бол үлдсэн 87,5 хувь нь 1-ээс 5.6 жил хүртэл ажилласан байна.

МУХБ-ны Гүйцэтгэх захирлаар нийт 6 хүн ажилласнаас 1 хүн 2021 оны 08 дугаар сарын 03-наас одоог хүртэл ажиллаж байгаа бөгөөд ажилласан хугацааны хувьд хамгийн бага нь 217, их нь 1106 өдөр ажилласан ба 5 хүн дунджаар тус албан тушаалд 696 хоног ажилласан байна. Ажиллаж байсан 5 хүний 20 хувь нь 1 жил хүртэл хугацаанд ажилласан бол үлдсэн 80 хувь нь 1-3 жил хүртэл ажилласан байна.

Тэргүүн дэд болон дэд /орлогч/ захирал, газрын захирлаар нийт 35 хүн ажилласнаас 7 хүн томилогдсон өдрөөс хойш ажиллаж байна. Тодруулбал, 2013 оноос хойш ажиллаж байгаа 2 хүн байгаа ба хамгийн богино хугацаанд ажилласан хүн 1 жил ба түүнээс урт хугацаанд ажиллаж байна. Нийт 35 хүнээс ажилласан хугацааны хувьд хамгийн бага нь 23, их нь 3948 өдөр ажилласан ба 28 хүн дунджаар тус албан тушаалд 837 хоног ажилласан байна. Ажиллаж байсан 28 хүний 14 хувь нь 1 жил ба түүнээс бага хугацаанд ажилласан бол 86 хувь нь 1.2 жилээс 10.8 жил хүртэл хугацаагаар ажилласан байна.

Судалгааны дүнгээр банкны үйл ажиллагааны үр дүнг голчлон хариуцах удирдлага болон удирдлагын багийн гишүүн нэг бүрийн ажилласан хугацаа тогтвортой бус, банкны үндсэн бүтээгдэхүүн болох томоохон төслийн хэрэгжилтийн үр дүнтэй холбон авч үзвэл ажиллах хугацааны гэрээний хэрэгжилт, ажлын үр дүнг тооцох тогтолцоо хангалтгүй

<sup>5</sup> Эх сурвалж: Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн ХЭГ/2399 дугаар албан бичиг

үйлчилж ирсэн, нөгөө талаас хараат бус байдалд нөлөөлөхүйц байсан. /Хүний нөөцийн судалгааг хавсралт 1-т үзүүлэв/

Хөгжлийн банкны зохион байгуулалтын бүтэц, хүний нөөцийн хөдлөл өөрчлөлт өнгөрсөн хугацаанд дараах байдалтай байсан. Үүнд:

*Хүснэгт 1. МУХБ-ны бүтцийн өөрчлөлт хүний нөөцийн хөдөлгөөн*

Д.д	Өөрчлөлт оруулсан тухай тогтоол, шийдвэр	Бүтэц (газар, нэгж, алба)	Батлагдсан орон тоо	Ажиллаж буй орон тоо	Чөлөөлөгдсөн ажилтан	Шинээр ажилд орсон ажилтан
1	ТУЗ-ийн 2012 оны 10 дугаар тогтоол	Газар – 4 Хэлтэс – 11	47	78	8	35
2	ТУЗ-ийн 2012 оны 54 дугаар тогтоол	Газар – 4 Хэлтэс – 12 Нэгж – 3	87	79	13	14
3	ТУЗ-ийн 2014 оны 11, 12 дугаар тогтоол	Газар – 5 Хэлтэс – 19 Алба – 1	168	131	20	45
4	ТУЗ-ийн 2016 оны 69 дугаар тогтоол	Газар – 4 Хэлтэс – 13 Алба – 1	149	134	33	109
5	ТУЗ-ийн 2017 оны 91 дүгээр тогтоол	Газар – 4 Хэлтэс – 13 Алба – 3	149	146	39	59
6	ТУЗ-ийн 2019 оны 35 дугаар тогтоол	Газар – 4 Хэлтэс – 13	149	138	66	77
7	ТУЗ-ийн 2020 оны 16 дугаар тогтоол	Газар – 6 Хэлтэс – 11	110	106	27	19
8	ТУЗ-ийн 2021 оны 21 дүгээр тогтоол	Газар – 5 Хэлтэс – 15 Алба – 2	131	100	41	4

Банкны бүтцийн нэгжүүдэд ажиллаж ирсэн болон чөлөөлөгдсөн, шинээр ажилд орсон ажилнуудын тоо нийт батлагдсан орон тооны хэмжээнд харьцуулснаар өндөр хувьтай, тогтвортой бус байдалтай, энэ нь тухайн хугацаанд томилогдсон удирдлагын шийдвэртэй холбоотой, нөгөө талаас томилгоо дагасан хүний нөөцийн өөрчлөлт банкны үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулаагүй, засаглалын алдаанд хүргэсэн байна.

МУХБ-ны ТУЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 67 дугаар тогтоолоор 2023 оны бизнес төлөвлөгөөг баталсан ч цаашид нөхцөл байдалтай уялдуулан алсын харааг тодорхойлох, урт болон дунд хугацаанд баримтлах стратеги, түүнийг хэрэгжүүлэх арга замыг боловсруулах шаардлагатай байсан.

Банкны үйл ажиллагаанаас зээл олголт, эргэн төлөлт, түүний орчинтой холбоотой үйл ажиллагаа залилангийн эрсдэлд өртөмтгий байдаг ч залилангийн эрсдэлийг тодорхойлж үнэлэх зохистой горим нэвтрүүлж, уг эрсдэлийг их гэж үнэлсэн тохиолдолд урьдчилан сэргийлэх, илрүүлэх тогтолцоо /горим журам/ үйлчлээгүй байсан.

Дээр дурдсан стратеги, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд залилантай тэмцэх стратегийг боловсруулж, залилангаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, удирдах арга хэмжээг үйл ажиллагааныхаа төлөвлөгөөнд тусгаж өгөх хэрэгтэй байсан.

МУХБ нь 2022 оны эхнээс чанаргүй зээлийг төлүүлэх талаар хэрэгжүүлсэн арга хэмжээ, УИХ-аас байгуулсан ажлын хэсгийн тайланг сонсгосон нээлттэй хэлэлцүүлэг болон хууль хяналтын байгууллагын хэрэг бүртгэлтийн болон мөрдөн шалгах ажиллагаа, шүүхийн

шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үр дүн, УИХ-ын Хянан шалгах Түр хороог байгуулсан нь чанаргүй зээлийн эргэн төлөлтөд ахиц гаргасан<sup>6</sup>.

МУХБ нь зээлийн багцын чанарын мэдээллээ олон нийтэд 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр зарласан байдаг<sup>7</sup>. Түүнээс хойш буюу 2022.01.20-2022.12.31-ний өдрийн хооронд нэг их наяд 80 тэрбум төгрөг эргэн төлөгдсөн ба зээлийн эргэн төлөлтийг бэлэн мөнгөөр, үнэт цаасаар, өмчлөх бусад үндсэн хөрөнгө авах зэргээр төлүүлжээ.

## ХЯНАН ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХҮРЭЭ

Хянан шалгалтын ажил нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын хууль тогтоомжийн хүрээнд хяналт шалгалтын ажлын зорилгыг хэрэгжүүлэхэд шаардлагатай МУХБ байгуулагдсанаас хойших хугацааны зээл олголт, эргэн төлөлттэй холбоотой баримт материалууд болон зээлдэгч аж ахуйн нэгж, байгууллага, арилжааны банкуудаар дамжуулан санхүүжилт олгосон зээлийн олголт, ашиглалт зарцуулалттай холбоотой материал, дансны гүйлгээ, төсөл, хөтөлбөрийн үр өгөөж, Хөгжлийн банкны үйл ажиллагааны үр ашигт байдал, түүнд тавигдах дотоод болон хөндлөнгийн хяналтын тогтолцооны үйлчлэлтэй холбоотой баримт материалыг хамруулсан.

ХШТХ-ны хяналт шалгалтын ажлын хэсэг нь МУХБ-наас шууд санхүүжүүлсэн 77 зээлдэгчийн 3.2 их наяд төгрөг, арилжааны банкаар дамжуулан олгосон 2542 зээлдэгчийн 1.6 их наяд төгрөг, Засгийн газарт шилжүүлсэн 355 зээлдэгчийн 2.5 их наяд төгрөг, тус банкны охин компаниудаас санхүүжүүлсэн 35 зээлдэгчийн 161.6 тэрбум төгрөгийн багцын хамаарал болон зарцуулалтыг данс хөөх зарчмаар шалгаж, төсөл хөтөлбөрийн олголт, хэрэгжилттэй холбоотой мэдээллийг Хөгжлийн банкнаас ирүүлсэн баримт материалыг үндэслэн гурван удаагийн нээлттэй сонсголоор танилцуулсан болно.

Хяналт шалгалтын ажлын хэсэг нь дээрх хугацаанд нийт 1.04 сая гаруй хуудас баримт материалын хүрээнд хяналт шалгалах хийж, холбогдох асуудлыг нэгтгэн дүгнэсэн.

- Хянан шалгах түр хороонд МУХБ, Монголбанк, Сангийн яам, ТЕГ, ЯАГ, АТГ, УЕПГ, ШШГЕГ, УБЕГ, АМГТГ-аас нийт 25 мянга гаруй хуудас материал, share folder үүсгэн 4700 орчим файл, CD хэлбэрээр 1 ш баримт материал, “hard drive” хэлбэрээр 1ш баримт материал хүлээн авсан.
- Нийт УБЕГ-аас 54 мянга гаруй хуудас материал:
  - Монгол Улсын Хөгжлийн банк үйл ажиллагаа явуулж эхэлсэн 2012 оноос хойш улс тэрийн өндөр албан тушаал, ТЕГ, ЦЕГ, АТГ, УЕПГ-ын удирдлага, МУХБ-ны ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлагын багт тус бүр ажиллаж байсан болон ажиллаж байгаа 306 иргэн, тэдгээрийн гэр бүл, албан тушаалын хамаарал бүхий 1627 иргэн дээр бүртгэлтэй 4568 хуулийн этгээдийн ойролцоогоор 20 мянган хуудас хуулийн этгээдийн улсын бүртгэлийн лавлагaa;
  - МУХБ-ны нийт 3500 гаруй зээлдэгчийн идэвхтэй, идэвхгүй хувьцаа эзэмшигч, өмнөх ба одоогийн гүйцэтгэх удирдлага, эцсийн өмчлөгч нар дээр бүртгэлтэй хуулийн этгээдүүдийн ойролцоогоор 34 мянган хуудас Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн лавлагaa;
- МУХБ-ны архивын баримтаас нийт 480 гаруй зээлдэгчийн зээлийн хувийн хэрэгт хавсаргасан 129 мянга гаруй хуудас материал;
- Арилжааны 14 банкны (Хaan, ХХБ, УБХБ, Голомт, Төрийн, Хас, Капитрон, Капитал, Кредит, Богд, Тээвэр хөгжлийн, УХОБ, Ариг, Чингисхаан) нийт 820 мянга гаруй хуудас 4479 зээлийн хувийн хэргийн материал болон дансны хуулга; /Дэлгэрэнгүйг Хавсралт 2-т үзүүлэв/
- Сангийн яам, ЗТХЯ, ЭХЯ, БХБЯ, УУХҮЯ, ХХДАХҮЯ, БШУЯ, ГЕГ, НЗДТГ-аас нийт 20 мянга гаруй хуудас зээлийн хувийн хэрэг, зарцуулалттай холбоотой

<sup>6</sup> Тус банкны нийт зээл, хүүгийн үлдэгдлийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар авч үзвэл хэвийн 695.8 тэрбум, анхаарал хандуулах ангилалд 584.9 тэрбум, чанаргүй ангилалд 1511.0 тэрбум, бүгд 2,791.7 тэрбум төгрөг байсан.

<sup>7</sup> Хөгжлийн банк 67 зээлдэгчийн 3.2 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээний зээлийн багцын үлдэгдэлтэй байснаас 55.3 хувь нь чанаргүй ангилалд багтсаныг 2022 оны 01 сарын 20-ны өдөр олон нийтэд зарлаж байсан.

гэрээ, хэлцэл, албан бичиг, хяналт шалгалтын тайлан болон холбогдох бусад судалгаа.

#### **Тодорхойлсон эрсдэл бүхий асуудал:**

- МУХБ-ны хуулиар тодорхойлсон өөрийн эрх ашигийг илэрхийлэх гүйцэтгэх удирдлагын хараат бус, бие даасан үр нөлөөтэй үйл ажиллагаа болон банкны хувьцаа эзэмшигч /Засгийн газар/ хооронд тодорхой хил хязгаар бүхий харгалзах зохицуулалт үйлчлээгүй.
- МУХБ үүсгэн байгуулагдсанаас хойш татан төвлөрүүлсэн хөрөнгийн хурдацтай өсөлт нь тодорхой хугацааны дараа эргэн төлөлтийн буюу ирээдүйд төлбөрийн чадварын хүндэрэл үүсгэж болохыг ажиллаж ирсэн тухайн цаг үеийн банкны удирдлагуудаас мэдэрсэн байх мэргэжлийн “ур чадвар” тогтоогдоогүй.
- МУХБ-ны үйл ажиллагаанд хяналт тавих дотоод нөөц, туршлага ур чадвар байгаагүйгээс хэтийн сөрөг үр дагавраас зайлсхийж чадаагүй, эцсийн шатанд дотоод хяналт нь зээлдэгчийн найдвартгүй байдлыг нөхөхүүц байж чадаагүй.
- Зээл олгох үйл ажиллагаанд Засгийн газрын болон гүйцэтгэх удирдлагын оролцоо, улс төрд нөлөө бүхий этгээдийн ашиг сонирхол идэвхтэй нөлөөлсөн байж болзошгүй.
- Банкны зээлийн үйл ажиллагаа, хөрвөх болон төлбөрийн чадварын аюулгүй байдлын үзүүлэлт олон нийтийн эрх ашигийг хөндөж байсан, банкны үйл ажиллагаанд тавигдах хөндлөнгийн болон иргэд, олон нийтийн хяналт зээл олголтын хурдыг гүйцээгүй, ил тод бус байсан.
- Хөгжлийг дэмжсэн бэлэн төсөл байгаагүйн зэрэгцээ өндөр эрсдэлтэй зээл олголт нь банкны өөрийн хөгжлийн урт хугацааны эрх ашигт нийцээгүй, Төлөөлөн удирдах зөвлөлийн болон гүйцэтгэх удирдлагын зээл олгох шийдвэр банкны хөгжлийн ямар өгөгдөл, мэдээлэлд үндэслэн гарч байсан тухай хангалттай иж бүрэн нотлох зүйлс хангалтгүй.
- МУХБ-ны шууд зээлийн нийт үлдэгдэл 2,601.3 тэрбум төгрөг, үүнээс 51.3 хувь буюу хэвийн ангилалд 1,334.3 тэрбум төгрөг, 22.5 хувь буюу анхаарал хандуулах ангилалд 584.8 тэрбум төгрөг, 26.2 хувь буюу чанаргүй ангилалд 682.2 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байсан.

#### **Шинээр илэрсэн нөхцөл байдлын тухай**

ХШТХ-ны 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн ээлжит хурлаар хянан шалгах ажилтай холбоотой дараах шинээр илэрсэн нөхцөл байдалд дүгнэлт гаргаж, танилцуулахыг хянан шалгагч, шинжээч наарт үүрэг болгосон. Үүнд:

- Нэг этгээд, түүний холбогдох этгээдийн активыг багцалж тооцох;
- Мөнгөн хөрөнгийн удирдлагыг зохистой удирдсан эсэх;
- Нийт зээлдэгчийн хамаарал бүхий этгээдийг илрүүлэх, тэдгээрийн зээлийн зарцуулалтыг шалгах, зориулалт бусаар ашиглаад хэвийн төлөлттэй байсан эсэхэд дүгнэлт өгөх;
- Хөгжлийн банкны санхүүгийн байдалд дүгнэлт гаргасан аудитын хуулийн этгээдийн гэрээгээр хүлээсэн үүрэг хариуцлага хангалтгүй, бусад эрх бүхий байгууллагын хянан шалгах ажлын зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байгаа тул нарийвчлан шалгах;
- МУХБ-нд баримт материал нь байхгүй дараах зээлийн багцын зарцуулалтад дүгнэлт өгөх;
  - Арилжааны банкаар дамжуулан олгосон 1.6 их наяд төгрөгийн 2542 дэд зээлдэгчийн зээлийн зарцуулалтад дүгнэлт хийх;
  - Засгийн газарт шилжсэн 2.5 их наяд төгрөгийн 355 төслийн зарцуулалт хэрэгжилтэд дүгнэлт хийх.

## НЭГ. НОТЛОХ БАРИМТ ИРҮҮЛЭХ ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТ

1.1 ХШТХ-ны 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн “Нотлох баримт ирүүлэх” тухай 02 дугаар тогтоолын дагуу холбогдох байгууллагуудын ирүүлсэн нотлох баримтын иж бүрдэл дараах байдалтай байна. Үүнд:

*Хүснэгт 2. Нотлох баримтын бүрдүүлээр*

Д.д	Нотлох баримт ирүүлэх байгууллага	ХШТХ-ны тогтоолын дагуу (агуулга)	Ирүүлсэн огноо (хуудас)	Тайлбар
1	Сангийн яам	<ul style="list-style-type: none"> <li>▪ Хөгжлийн банканд хийсэн хяналт шалгалтуудын талаарх мэдээлэл</li> <li>▪ Хөгжлийн банкнаас зээл авсан төрийн өмчийн оролцоотой зээлдэгчдийн мэдээлэл, зээлийн эргэн төлөх боломжтой эсэх талаарх судалгаа, тайлбар</li> <li>▪ Хөгжлийн банканд өгсөн чиглэл, удирдамж</li> </ul>	2022.06.22 01/4404 372 хуудас материал	Нэмэлт материал гаргуулсан
2	Монголбанк	<ul style="list-style-type: none"> <li>▪ Хөгжлийн банканд хийсэн хяналт шалгалтуудын тайлан</li> <li>▪ Хөгжлийн банканд өгч байсан чиглэл, удирдамжууд болон биелэлтүүдийн мэдээлэл</li> </ul>	2022.06.22 A-1/698 200 хуудас материал	Нэмэлт материал гаргуулсан
3	Хөгжлийн банк	<ul style="list-style-type: none"> <li>▪ Зээлийн багцын мэдээлэл (зээлдэгч ААН, түүний хараат болон охин компани, зээл олгох шийдвэр гаргасан албан тушаалтуудын шийдвэр (он, дарааллаар), авсан зээлийн хэмжээ, зээлийг зориулалт бусаар зарцуулсан эсэх, зээл олгосон валют, зээлийн хүү, эргэн төлөлтийн байдал, чанарын ангилал гэх мэт)</li> <li>▪ Зээлийн үлдэгдэл болон хүүгийн өр, төлбөрөө хэрхэн барагдуулах талаар зээлдэгчээс гаргасан тайлбар, зээл тус бүрд Хөгжлийн банкнаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тайлан</li> <li>▪ Шүүх, цагдаа, авлигатай тэмцэх байгууллагад шалгагдаж байгаа зээлдэгчийн жагсаалт, явц, үр дүнгийн талаарх мэдээлэл</li> <li>▪ Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн нэрс, зээлийн хэмжээ, хүү, хугацаа, зээлийн эргэн төлөлтийн талаарх мэдээлэл</li> <li>▪ Төслийн орлогоос эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр ААН-үүдэд олгосон зээлийн багцын мэдээлэл (шууд болон арилжааны банкуудаар дамжуулан олгогдсон, хараат болон охин компаниар дамжуулан олгосон)</li> <li>▪ Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй, төсөвт шилжүүлсэн зээлийн багцын талаарх мэдээлэл</li> <li>▪ ТУЗ болон гүйцэтгэх захирлын баталсан зээлийн үйл ажиллагаатай холбоотой бодлого, журам, зааврууд (нэмэлт өөрчлөлтийн хамт)</li> <li>▪ ТУЗ болон ЗҮХ-ны бүрэлдэхүүний талаарх мэдээлэл (2012-2022)</li> <li>▪ Эргэн төлөгдсөн болон бусад хэлбэрээр хаагдсан зээлийн жагсаалт</li> <li>▪ Үлдэгдэлтэй зээл тус бүрийн мэдээлэл</li> <li>▪ Бүтцийн өөрчлөлт хийсэн буюу зээлийн гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулсан зээлдэгчийн жагсаалт</li> <li>▪ Зээл олгох үеийн зээлдэгчийн эрсдэлийн судалгаа (бусад банк, санхүүгийн байгууллагад зээлтэй байсан эсэх, байсан бол зээлүүдийн чанарын үзүүлэлт)</li> <li>▪ Зээл баталсан зээлийн хорооны болон ТҮЗ-ийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэл</li> <li>▪ Хөгжлийн банкны байр худалдан авсан болон “Блуумберг” телевизтэй байгуулсан гэрээний талаарх мэдээлэл</li> <li>▪ Хөгжлийн банк, түүний охин компаниудын хоорондох санхүүжилт болон охин компаниудын олгосон санхүүжилтийн талаарх мэдээлэл</li> </ul>	2022.06.20 2/931 Нийт 4833 хуудас материал	Нэмэлт материал гаргуулсан
4	ҮЕПГ (шаардлагатай бол нууцын	<ul style="list-style-type: none"> <li>▪ Хөгжлийн банкны зээлтэй холбоотой хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд шалгагдаж байгаа хэргийн явц, тухайн хэргийн талаарх мэдээлэл</li> </ul>	2022.06.22 1/4072 13 хуудас	Ирүүлсэн нотлох баримтад түшиглэн уулзарт хийсэн.

	шаардлага хангуулах)	<ul style="list-style-type: none"> <li>▪ Мөрдөн байцаах ажиллагааны үе шатанд барагдуулсан зээлийн эргэн төлөлтийн талаарх мэдээлэл</li> <li>▪ Битүүмжилсэн эд хөрөнгийн жагсаалт</li> <li>▪ Шүүхэд шилжүүлсэн хэргийн мэдээлэл</li> <li>▪ Өмнө болон одоо улс төрд нөлөө бүхий этгээдтэй холбоотой Хөгжлийн банкны зээлдэгчийн мэдээлэл, улс төрчдийн талаарх мэдээлэл</li> <li>▪ Чанаргүй зээлийн ангилалд орсон зээлдэгч нарын нуун дарагдуулсан, бусдад шилжүүлсэн, хувьцаа худалдан авсан байж болзошгүй, шалгагдаж буй эд хөрөнгийн талаарх мэдээлэл, гадаад дотоод хадгаламжууд</li> </ul>		
5	АТГ (шаардлагатай бол нууцын шаардлага хангуулах)	<ul style="list-style-type: none"> <li>▪ МБА хийгдэж байгаа хэргийн талаарх мэдээлэл</li> <li>▪ Шүүхэд шилжүүлсэн болон шүүхээр хянан шийдвэрлэгдсэн хэргүүдийн талаарх мэдээлэл</li> <li>▪ Хөгжлийн банкнаас авсан зээлийн хөрөнгийн зарцуулалтын талаарх дансны хуулга санхүүгийн тайлан, цуглуулсан баримтууд</li> <li>▪ Зээлийн төлбөр огт хийгдээгүй болон 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс хойш зээлээ төлөөгүй ААН-үүдийн зээл авахаас өмнөх хугацааны дансны үлдэгдэл, зээлийн зарцуулалтын талаарх дансны хуулга, санхүүгийн тайлан, зарцуулалттай холбоотой цуглуулсан баримт, холбогдох гэрээнүүд</li> <li>▪ Зээлийн төлбөр огт хийгдээгүй болон 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс хойш зээлээ төлөөгүй ААН-үүд зээлийн хөрөнгийг бусдад шилжүүлсэн уг гүйлгээг хүлээн авсан компанийн болон хувь хүний дансны тухайн гүйлгээг хүлээн авахаас өмнөх үлдэгдэл, тухайн хөрөнгийн зарцуулалтын талаарх дансны хуулга, санхүүгийн тайлан, зарцуулалттай холбоотой цуглуулсан нотлох баримт, гэрээнүүд</li> <li>▪ Зээлийн хөрөнгийн зарцуулалтын ул мөрийг мөшгөн тогтооход илрүүлсэн дээрх мэдээлэлд багтаагүй шаардлагатай бусад мэдээлэл</li> </ul>	2022.06.27 01/8837 14 хуудас	Ирүүлсэн нотлох баримтад түшиглэн хийх уулзалт зохион байгуулгадаагүй.
6	ШШГЕГ	<ul style="list-style-type: none"> <li>▪ Хөгжлийн банктай холбоотой шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шилжсэн хэргийн талаарх мэдээлэл</li> <li>▪ Хөгжлийн банктай холбоотой шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үр дүн, өр барагдуулалтын талаар хийсэн ажлын мэдээлэл</li> </ul>	2022.06.21 01/1440 18 хуудас	Ирүүлсэн нотлох баримтад түшиглэн уулзалт хийсэн. Ирүүлсэн мэдээллийг шинэчилсэн
7	ҮАГ	<ul style="list-style-type: none"> <li>▪ Хөгжлийн банканд хийсэн хяналт шалгалтуудын талаарх тайлан, мэдээлэл</li> <li>▪ Хяналт шалгалтын хүрээнд өгсөн зөвлөмж, дүгнэлт</li> </ul>	2022.06.13 1230 7 ширхэг 282x	Нэмэлт тайлбар авсан.
8	УБЕГ	<ul style="list-style-type: none"> <li>▪ Хөгжлийн банкны бүх зээлдэгч, ААН-үүдийн хувьцаа эзэмшигчид болон хамаарал бүхий этгээдүүдийн талаарх 2010-2022 оны буртгэлийн мэдээллүүд /66 хуулийн этгээдтэй холбогдох/</li> </ul>	2022.06.20 10/5402 658хуудас /CD/	Баримтад түшиглэн газар дээр нь тулгалт хийж ажилласан.
9	ТЕГ	<ul style="list-style-type: none"> <li>▪ Хөгжлийн банкны зээлдэгчийн татвар төлөлтийн байдал, санхүүгийн тайлан мэдээлэл</li> </ul>	2022.06.20 01/1463 376kВ Цахим файл	Баримтад түшиглэн тулган баталгаажуулалт хийв
<b>Нийт</b>		<b>Есөн байгууллага</b>	-	-

1.2 ХШТХ-ны нотлох баримт ирүүлэх тухай 2022 оны 03 дугаар тогтоопын дагуу зарим төрийн байгууллага буюу АТГ, ҮЕПГ мэдээллээ бүрэн ирүүлээгүй, хамтран ажиллах албан бичиг хүргүүлсний дараа хуулийн “хязгаарлалттай” гэсэн тайлбар, мэдээллийг өгсөн.

1.3 Цаашид үүсэж болзошгүй нөхцөл байдал, хууль тогтоомжийн нийцэлтэй уялдуулан УИХ-ын Түр хорооны хянан шалгах асуудалтай уялдуулан мэдээлэл авах ажлын зохион байгуулалт, мэдээлэл түгээлт, солилцооны хамтын ажиллагааг хангаж ажиллах нь зохимжтой байна.

## Улсын ерөнхий прокурорын газрын мэдээлэл

1.4 УИХ-ын ХШТХ-ны тогтоолын биелэлттэй холбоотой мэдээллийг УЕПГ-аас дараах бүлгээр бэлтгэн дэлгэрэнгүй тайлбарын хамт ирүүлсэн. УЕПГ-аас ХШТХ-ны даргын нэр дээр ирүүлсэн мэдээллийн агуулга дараах байдалтай байна<sup>8</sup>.

- “Хөгжлийн банкны зээлтэй холбоотой хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд шалгагдаж байгаа хэргийн” (1),
  - ⇒ Хөгжлийн банкны зээл олгох үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомжийг зөрчиж зээл олгосноор давуу байдал бий болгож улмаар тус банканд хохирол учруулсан байж болзошгүй гэсэн үндэслэлээр хэрэг бүртгэлтийн 22 хэрэг,
  - ⇒ Тус Мөрдөн байцаалт явуулж буй 4 хэрэгт улс төрд нөлөө бүхий этгээд 5, Хөгжлийн банкны болон төрийн бусад байгууллагын эрх бүхий албан тушаалтан 48, ААН-ийн албан тушаалтан 24, нийт 77 хүнд холбогдуулан эрүүгийн хэрэг үүссэн яллагдагчаар татан мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулж байна.
    - Тус банканд ажиллаж байсан эрх бүхий албан тушаалтнууд албан тушаалтын байдлаа урвуулан ашиглаж, нэр бүхий 17 ААН-д зээл олгосон байж болзошгүй,
- Мөрдөн шалгах ажиллагааны явцад барагдуулсан зээлийн эргэн төлөлтийн талаарх мэдээлэл (2),
  - ⇒ Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд шалгагдаж байгаа хэргүүдэд гэмт хэргийн улмаас улсад нийт 2.4 их наяд төгрөгийн хохирол учирсан бөгөөд 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар мөрдөн шалгах ажиллагааны явцад 250.3 тэрбум төгрөгийн хохирлыг төлүүлжээ.
- Битүүмжилсэн эд хөрөнгийн жагсаалт (3),
  - ⇒ Хуульд заасан үндэслэлээр 47 ААН, тэдгээрийн хувьцаа эзэмшигчид болон банкны албан тушаалтан нийт 61 иргэний 664 ширхэг үл хөдлөх хөрөнгө, 763 ширхэг тээврийн хэрэгсэл, арилжааны банкууд дахь 104 харилцах болон хадгалаамжийн данс, 25 аж ахуйн нэгжийн хувьцааны шилжилт хөдөлгөөнийг хязгаарласан байна.
  - ⇒ Мөн яллагдагч нарын өмчлөлийн 40 үл хөдлөх эд хөрөнгө, 18 тээврийн хэрэгсэл, машин механизмыг битүүмжилжээ.
- Шүүхэд шилжүүлсэн хэргийн мэдээлэл (4),
  - ⇒ Үүнээс шилжүүлсэн 2 зээлтэй холбоотой хэрэг эцэслэн шийдвэрлэгдээгүй байна.
- Өмнө болон одоо улс төрд нөлөө бүхий этгээдтэй холбоотой Хөгжлийн банкны зээлдэгч улс төрчдийн талаар (5),
  - ⇒ Хөгжлийн банкны зээлтэй холбоотой өмнө болон одоо улс төрд нөлөө бүхий этгээдтэй хамааралтай байж болзошгүй эрх бүхий этгээдийн 13 зээлийн материалыг хянаж байна.

УИХ-ын ХШТХ-ны 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 03 дугаар тогтоолын хавсралтаар баталсан хянан шалгагчийн “Ажлын даалгавар”-ын 1 дэх хэсгийн шаардлагатай нотлох баримт бүрдүүлэх ажилбарын тусгагдсан буюу УЕПГ-аас гаргуулахаар тодорхойлсон 4 дэх заалтын “е” хэсэгт бичигдсэн “Чанаргүй зээлийн ангилалд орсон зээлдэгч нарын нуун дарагдуулсан, бусдад шилжүүлсэн, хувьцаа худалдан

<sup>8</sup> ХШТХ-нэд УЕПГ-ын 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 1/4072 албан бичгээр ирүүлсэн мэдээлэл

ҮЕПГ-аас  
иরүүлсэн  
баримтын  
бүрдэл:

авсан байж болзошгүй, шалгагдаж буй эд хөрөнгийн талаарх мэдээлэл, гадаад дотоод хадгаламжууд” гэсэн иж бүрдэл баримтын талаар УИХ-ын ХШТХ-ны 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн “Номлох баримт гаргуулах тухай” 02 дугаар тогтоолын холбогдох хэсэгт батламжлаагүй” байсны дээр уг баримт материал ирээгүй болно.

1.5 ХШТХ-нд ирүүлсэн мэдээлэл болон Хөгжлийн банкны чанаргүй ангилалд бүртгэгдсэн зээлээс ҮЕПГ-т хянагдаж буй бүртгэгдсэн зээлдэгчтэй холбоотой хэрэг бүртгэлт, арга хэлбэр, хянан шийдвэрлэлтийн үр дүн болон төр, нийтийн ашиг сонирхлыг хэрхэн төлөөлж ажиллаж байгаатай танилцаж, хяналт тавих үйл ажиллагааны үр нөлөөг үнэлэх, дээр дурдсан иж бүрдэл баримт материалын талаар мэдээлэл авах зорилго, цаашид ХШТХ-той хэрхэн үйл ажиллагаагаа уялдуулаар ХШТХ-ны хянан шалгагч настай хамтран ажиллах хүсэлт уламжилсан болно.

1.6 Энэхүү дурдсан мэдээлэл болон ҮЕПГ-ын холбогдох албан тушаалтантай хийсэн уулзалтаар хэрэг бүртгэлт болон мөрдөн шалгах ажиллагааны талаар нээлттэй мэдээллийг өгөх боломжгүйгээ илэрхийлсэн бөгөөд хянан шалгагчийн зүгээс хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэсэн арга хэмжээний үр дүнд үндэслэн цаашид дараах дүгнэлтэд хүрч, түүний дагуу зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй гэсэн доорх саналыг хянан шалгагч нарын зүгээс дэвшигүүлсэн байна. Үүнд:

Гол асуудал	Санал
<ul style="list-style-type: none"><li>▪ Мэдээллийн нууцлалттай байдал нь хяналт шалгалтын үйл ажиллагааг хязгаарлах, хамтран ажиллах боломж хаагдмал:</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>▪ Цаашид эрх бүхий байгууллага /Түр хороо/-ыг мэдээллээр хангах тусгайлсан зохицуулалттай болох:</li></ul>

### Авлигатай тэмцэх газрын мэдээлэл

1.7 УИХ-ын ХШТХ-ны тогтоолын дагуу АТГ-ын Мөрдөн шалгах хэлтсээс мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа Хөгжлийн банкны эрх бүхий албан тушаалтнуудтай холбоотой хэргийн талаарх 14 хуудас товч мэдээллийг ирүүлсэн<sup>9</sup>.

АТГ-аас  
ириүүлсэн  
баримтын  
бүрдэл:

Ирүүлсэн мэдээллээс үзэхэд ... УИХ-ын ХШТХ-ны 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 03 дугаар тогтоолын хавсралтаар баталсан хянан шалгагчийн “Ажлын даалгавар”-ын 1 дэх хэсгийн шаардлагатай номлох баримт бүрдүүлэх ажилбарт тусгагдсан буюу АТГ-аас гаргуулахаар тодорхойлсон 5 дахь заалтад тусгагдсан “б”, “в”, “г”, “д”, “е” хэсэгт бичигдсэн доорх мэдээлэл”-ийг ХШТХ-нд ирүүлээгүй. Тухайлбал:

- **“б” хэсэг буюу** “Шүүхэд шилжүүлсэн болон шүүхээр хянан шийдвэрлэгдсэн хэргүүдийн талаарх мэдээлэл”,
- **“в” хэсэг буюу** “Хөгжлийн банкнаас авсан зээлийн хөрөнгийн зарцуулалтын талаарх дансны хуулга санхүүгийн тайлан, цуглуулсан баримтууд”
- **“г” хэсэг буюу,** “Зээлийн төлбөр огт хийгдээгүй болон 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс хойш зээлээ төлөөгүй ААН-үүдийн зээл авахаас өмнөх хугацааны дансны үлдээгдэл, зээлийн зарцуулалтын талаарх дансны хуулга, санхүүгийн тайлан, зарцуулалттай холбоотой цуглуулсан баримт, холбогдох гэрээнүүд”
- **“д” хэсэг буюу** “Зээлийн төлбөр огт хийгдээгүй болон 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс хойш зээлээ төлөөгүй ААН-үүд зээлийн хөрөнгийг бусдад шилжүүлсэн

<sup>9</sup> ХШТХ-нд АТГ-ын 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 01/8837 дугаар албан бичгээр ирүүлсэн мэдээлэл

уг гүйлгээг хүлээн авсан компанийн болон хувь хүний дансны тухайн гүйлгээг хүлээн авахаас өмнөх үлдэгдэл, тухайн хөрөнгийн зарцуулалтын талаарх дансны хуулга, санхүүгийн тайлан, зарцуулалттай холбоотой цуглуулсан нотлох баримт, гэрээнүүд”

- “**“е” хэсэг буюу “Зээлийн хөрөнгийн зарцуулалтын ул мөрийг мөшгөн тогтооход илрүүлсэн дээрх мэдээлэлд багтаагүй шаардлагатай бусад мэдээлэл”** зэрэг болно.

1.8 АТГ-аас ХШТХ-ны даргын нэр дээр ирүүлсэн мэдээллийн агуулга дараах байдалтай байна.

- **Мөрдөн шалгах ажиллагаа,**

- АТГ-т нийт 39 хэрэг бүртгэлтийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас 15 хэргийг эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татаж, 2 хэргийг нэгтгэж мөрдөн байцаалтын 15 хэргээс 11 хэргийг холбогдох хуулийн үндэслэлээр нэгтгэж, мөрдөн байцаалтын 4, хэрэг бүртгэлтийн 22 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

- **Нөхөн төлүүлсэн хохирол,**

- Хууль бус зээл олгосон үйлдлийн улмаас 2.4 их наяд төгрөгийн хохирол учирснаас 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар 269.5 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжээ.

- **Хязгаарласан хөрөнгө,**

- Холбогдох хуулийн үндэслэл, прокурорын зөвшөөрлийн дагуу Хөгжлийн банкнаас зээл авсан ААН-үүд болон тэдний хамаарал бүхий этгээдүүдийн 687 ширхэг хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлан мөрдөн шалгах ажиллагаа явуулсан бол, мэдээлэл ирүүлсэн үеийн байдлаар 821 ширхэг хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлан мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

- **Яллагдагчийн талаарх мэдээлэл,**

- Хөгжлийн банкны зээлтэй холбоотойгоор 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар 79 хүн, 6 хуулийн этгээдийг яллагдагчаар татсан байна.
- Яллагдагчаар татагдсан этгээдүүд дотор өмнө болон одоо улс төрд нөлөө бүхий 12, хуулийн этгээд 6 ААН байна.

1.9 АТГ-аас ХШТХ-ны даргын нэр дээр ирүүлсэн мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа болон яллагдагчийн талаар хавсралтаар (цаасаар) ирүүлсэн мэдээлэл нь 79 хүртэл дугаартай боловч 16, 17, 37, 38, 39 дэх дугаар нөхөгдөөгүй, мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй хэргийн судалгааны хүснэгтэн мэдээллийг дугаарлаагүй, 2 зээлдэгчийн мэдээлэл давхардсан байсан болно.

1.10 Ирүүлсэн мэдээлэл болон чанаргүй зээлийн эргэн төлөлттэй холбоотой АТГ-ын хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах үйл ажиллагааны явцад Хөгжлийн банкны зээлдэгчтэй холбоотой зээлийн эргэн төлөлт болон хохирол нөхөн барагдуулалтын асуудлаар ХШТХ-ны хянан шалгагч нартай хамтран ажиллах хүсэлтийг уламжилсан болно.

1.11 Энэхүү тайландаа дурдсан мэдээлэл болон АТГ-ын “Мэдээлэл хүргүүлэх тухай” албан бичгээр хэрэг бүртгэлт болон мөрдөн шалгах ажиллагааны талаар нээлттэй мэдээллийг өгөх боломжгүйгээ илэрхийлсэн<sup>10</sup>.

1.12 Хянан шалгагчдын зүгээс хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэсэн арга хэмжээний үр дүнд үндэслэн цаашид дараах дүгнэлтэд хүрч, түүний дагуу зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэвшиүүлсэн байна.

<sup>10</sup> АТГ-ын Мөрдөн шалгах хэлтсийн 2011 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 06/14730 дугаар албан бичиг

Гол асуудал	Санал
<ul style="list-style-type: none"> <li>▪ Мэдээллийн нууцлалттай байдал хяналт шалгалтын үйл ажиллагааг хязгаарлах, хамтран ажиллах боломжгүй:</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>▪ Цаашид эрх бүхий байгууллага /түр хороо-/ ыг мэдээллээр хангах тусгайлсан зохицуулалттай болох:</li> </ul>

### Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын мэдээлэл

1.13 ШШГЕГ нь нотлох баримт ирүүлэх тухай ХШТХ-ны тогтоолын биелэлттэй холбоотой нийт 18 хуудас материал ирүүлсэн<sup>11</sup>.

1.14 Түүний дотор хуулийн хүчин төгөлдөр шийдвэр, гүйцэтгэх хуудсыг үндэслэн Монгол Улсын Хөгжлийн банкны нэхэмжлэлтэй 12 гүйцэтгэх баримт бичгийг хүлээн авснаас албадлагын арга хэмжээний дүнд 4 гүйцэтгэх баримт бичгийн 5.9 тэрбум төгрөгийн төлбөрийг эцэслэн шийдвэрлэж дуусгавар болгосон тухай дурдсан ч мөн 17.2 тэрбум төгрөгийн 4 гүйцэтгэх ажиллагаа шүүгчийн захирамжаар түдгэлзсэн байдалтай байгааг мэдээлсэн.

1.15 Тус газарт 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар нийт 207.8 тэрбум төгрөгийн 4 гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаа бол дуусгавар болгосон баримт бичигт ахлах шийдвэр гүйцэтгэгчийн тогтоол, түдгэлзсэн баримт бичигт шүүгчийн захирамжийн хуулбарыг ирүүлсэн байна.

1.16 Ирүүлсэн мэдээлэл болон чанаргүй зээлийн эргэн төлөлттэй холбоотой ШШГЕГ-аас хэрэгжүүлж буй шийдвэр гүйцэтгэлийн үйл ажиллагааны үр дүн болон тулгамдсан байж болзошгүй асуудлаар мэдээлэл солилцох, ХШТХ-той хэрхэн үйл ажиллагаагаа уялдуулах талаар хүсэлт уламжлан уулзалт хийсэн.

1.17 Уулзалтын дүнд нотлох баримтын шугамаар ирүүлсэн мэдээллийг шинэчлэн 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар хүлээн авсан болно.

1.18 Шинэчилсэн мэдээллээс үзэхэд 164.8 тэрбум төгрөгийн төлбөрийн үлдэгдэлтэй 7 төлбөр төлөгч, гүйцэтгэх баримт бичгийг түдгэлзсэн 15.8 тэрбум төгрөгийн төлбөрийн үлдэгдэлтэй 3 төлбөр төлөгч байсан бол дууссан гүйцэтгэх баримт бичгийн хувьд 6 төлбөр төлөгчийн 199.6 тэрбум төгрөгийн төлбөрийг барагдуулсан байна.

1.19 Түдгэлзүүлсэн гүйцэтгэх баримт бичиг бүхий 3 төлбөр төлөгчийн мэдээлэл дараах байдалтай байгаа бөгөөд гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлсэн шалтгааныг нарийвчлан хянах шаардлагатай, гүйцэтгэлийн ажиллагаа үндсэндээ төлбөр төлөгчийн гомдолд үндэслэн шүүгчийн шийдвэрээр хойшлогдсон байна<sup>12</sup>. Үүнд:

Хүснэгт 3. Түдгэлзүүлсэн гүйцэтгэх баримт бичиг

Д.д	Төлбөр төлөгч	Шүүхийн шийдвэрийн		Гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлсэн	
		/огноо, дугаар/	ГА үүсгэсэн огноо	/огноо, дугаар/	Үндэслэл
1	“Монлаа” ХХК, “Их-Үсгэл” ХХК, Х.Энхсайхан	2019.05.29 СБД-1274	2019.09.18	2022.03.16	Хөрөнгийн үнэлгээг дахин хийлгэх төлбөр төлөгчийн гомдлын дагуу шүүгчийн захирамж
2	“Дэд бүтэц инженеринг” ХХК	2021.06.21 СБД-1241	2021.11.23	2022.05.25	Үргийн гүйцэтгэлд барьцаалсан хөрөнгөд дахин үнэлгээ хийлгэх гомдлоор шүүгчийн захирамж
3	“Ганхүдэг-Орд” ХХК, “Барилтрейд” ХХК, Т.Туул	2020.01.21 ДУА-122	2021.03.31	2022.02.08	Хөрөнгийн үнэлгээг хүчингүйд тооцуулах төлбөр төлөгчийн гомдлоор шүүгчийн захирамж гарсан

1.20 Хөгжлийн банкны зээлдэгчдийн асуудлаар эрх бүхий байгууллагын хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын болон шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явагдаж байгаа хэргийн эцэслэн шийдвэрлэлтийн явц, үр дүнгийн байдлаас шалтгаалан “Онцгой горим” хэрэгжих асуудлыг цаашид ч хянан үзэж хэрэгжүүлэх шаардлагатай.

<sup>11</sup> ХШТХ-нд ШШГЕГ-ын 2022 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 01/1440 дугаар албан бичгээр ирүүлсэн мэдээлэл

<sup>12</sup> ШШГЕГ-аас шинэчлэн ирүүлсэн мэдээлэл 2022 оны 09 дүгээр сарын 30-ны байдлаар

1.21 Түүнчлэн, төрийн өмчийн нэгжид олгосон зээлийн зарцуулалтыг хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, гаргасан үр дүнтэй нь холбон хянан үзэх шаардлага үүссэн бөгөөд Түр хороонд ирүүлсэн нотлох баримт, өнөөгийн нөхцөл байдал, олж авсан мэдээлэлтэй уялдуулан дүгнэлт хийж дараах арга хэмжээг санал болгож байна. Үүнд.

Гол асуудал	Санал
<ul style="list-style-type: none"> <li>Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд төлбөр хариуцагчаас шалтгаалан саатал гарч байна.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн үйл ажиллагаанд эрх бүхий байгууллага болон төлбөр авагч талуудын оролцоог нэмэгдүүлэх:</li> </ul>

### Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээлэл

1.22 УБЕГ-аас Хөгжлийн банкны санхүүжилттэй гэх 66 хуулийн этгээдийн болон хамаарал бүхий этгээдүүдийн улсын бүртгэлийн дэлгэрэнгүй лавлагааг ирүүлсэн байна. Лавлагаанд зээлдэгч этгээдийн “ундсэн”, “хаягийн”, “хувьцаа эзэмшигч, гишүүдийн”, “гүйцэтгэх удирдлагын”, “үүсгэн байгуулагчийн”, “эцсийн өмчлөгчийн”, “эрхлэн үйл ажиллагааны”, “хөрөнгийн”, “хуулийн этгээдийн нэрийн”, “тамга, тэмдгийн хяналтын дугаар олгосон”, “гэрчилгээний” гэсэн бүрдүүлбэрээр мэдээллийг ирүүлжээ<sup>13</sup>.

1.23 УБЕГ-аас<sup>14</sup> Хөгжлийн банкнаас санхүүжилттэй гэх нийт 66 хуулийн этгээдийн болон хамаарал бүхий хуулийн этгээдүүдийн улсын бүртгэлийн дэлгэрэнгүй лавлагаа (хавсралт 658 хуудастай)-г ХШТХ-нд ирүүлсэн бол ажлын даалгаварт батлагдсаны дагуу чанаргүй зээлийн ангилалд бүртгэгдсэн зээлдэгчтэй холбоотой хувьцаа эзэмшигчид, хамаарал бүхий этгээдийн судалгааг дахин гаргуулж, өгөгдлийг хэрхэн тоолох, хэрхэн боловсруулалт, анализ хийж үр дүнг илэрхийлдэг асуудлаар газар дээр нь ажиллаж, зарим мэдээллийг хамтран боловсруулсан болно.

1.24 Энэхүү судалгааны зорилго нь иж бүрэн байдлыг хангуулах, цаашилбал холбогдох этгээдийн “зээл авснаас хойш” хувьцаа эзэмшигчийн “төлөв”-ийн болон бүртгэлтэй хөрөнгийн “хөдлөл өөрчлөлт” хийгдсэн эсэхийг хянахад шаардлагатай байсан.

1.25 Нөгөө талаас хууль тогтоомжийн дагуу улсын бүртгэлд эцсийн өмчлөгчийг бүртгүүлэх шийдвэрийн хэрэгжилт ямар байгааг хянан үзэж, холбогдох тайлбарыг УБЕГ-ын холбогдох албан тушаалтнаас гаргуулж албан ёсны мэдээллийг нэмэлт байдлаар авсан болно.

1.26 Ажлын даалгаварт батлагдсан Хөгжлийн банкны чанаргүй зээлийн ангилалд орсон зээлдэгчид болон хамаарал бүхий этгээдүүдийн эд хөрөнгө, үл хөдлөх хөрөнгийн жагсаалтыг авч шинжээчийн дүгнэлт гаргах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор албан ёсоор хандаж нэмэлт мэдээлэл гаргуулах ажилтныг томилуулан хамтран ажилласан.

Гол асуудал	Санал
<ul style="list-style-type: none"> <li>УБЕГ-т бүртгэлтэй мэдээлэл байнгын өөрчлөлт хийгддэг тул өмнөх үеийн нөхцөл байдлаас өөрчлөгдсөн байж болзошгүй.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Аливаа зээлтэй холбоотой гэрээ хэлцлийн талуудын хулээх хариуцлагатай холбоотойгоор албан ёсны лавлагааг хавсаргаж, эд хөрөнгийн болоод үүрэг гүйцэтгэлийн баталгаанд дэмжлэг болгох:</li> </ul>

### Ашигт малтмал, газрын тосны газрын мэдээлэл

1.27 УИХ-аас байгуулагдсан ажлын хэсэгт АМГТГ-ын 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 1/911 дугаар бүхий албан бичгээр<sup>15</sup> ирүүлсэн мэдээллээс үзэхэд Геологи, уул уурхайн кадастрын хэлтсийн бүртгэлд Монгол Улсын Хөгжлийн банкны барьцаанд бүртгэлтэй байгаа 15 тусгай зөвшөөрөл байна гэжээ.

<sup>13</sup> УБЕГ-ын 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 10/5402 дугар албан бичгээр ирүүлсэн мэдээлэл

<sup>14</sup> Эх сурвалж: УБЕГ-ын 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 10/5402 дугаар албан бичиг

<sup>15</sup> Эх сурвалж: “УИХ-ын даргын 2022 оны 20 дугаар захирамжаар байгуулагдсан Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, шалгалт хийсэн талаарх Монгол Улсын Засгийн газар, Монголбанк болон аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжтэй танилцаж, дунг УИХ-д танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийн баримт бичиг” Боть-02

1.28 “Зууны мэдээ” сонини 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн дугаарт нийтлэгдсэн (АТГ-ын албан ёсны цахим хуудас: [www.iaac.mn](http://www.iaac.mn)) 15 ААН-ийн нэрээр тус хэлтэст 56 ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүртгэлтэй байна гэж мэдээлэгдсэн.

1.29 Хянан шалгагч нарын зүгээс Хөгжлийн банкны чанаргүй зээлдэгч, тэдгээрийн хамаарал бүхий этгээдийн нэр дээр бүртгэлтэй 25 ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн жагсаалтыг нэмж авсан.

Гол асуудал	Санал
<ul style="list-style-type: none"><li>Барьцаанд бүртгэлтэй тусгай зөвшөөрлийн хөдлөлд өөрчлөлт орж болзошгүй.</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>Тусгай зөвшөөрлийн хөдлөл өөрчлөлтийг чанаргүй зээлийн эргэн төлөлт хангагдах хүртэлх хугацаанд банкны санаачилгад суурilan өөрчлөлт оруулах асуудлыг шийдвэрлэж байх:</li></ul>

## ХОЁР. НОТЛОХ БАРИМТЫН ИЖ БҮРДЭЛД ХЯНАЛТ ХИЙХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.2 УИХ-ын ХШТХ-нд ирүүлсэн нотлох баримтын бүрдүүлбэрт хяналт хийж дараах байгууллагуудаас нэмэлт баримт материал гаргуулан авч ажилласан<sup>16</sup>. Үүнд:

- Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт,**
  - Хөгжлийн банкийг байгуулснаас хойших зохион байгуулалт, үйл ажиллагаа болон зээл олголттой холбоотой гаргаж, хэрэгжүүлсэн тогтоол, шийдвэр, түүний биелэлтийн мэдээллийг,
- Сангийн яаманд хандаж,**
  - Сангийн яамнаас 2020 онд гүйцэтгэсэн хяналт шалгалтын ажлын тайлан, гаргасан шийдвэр, өгсөн чиглэл болон өмнөх бүх хяналт шалгалтуудаар өгсөн зөвлөмж, үүрэг даалгаврын биелэлт, хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээллийг,
- Монголбанканд хандаж,**
  - Монголбанкнаас 2017 онд гүйцэтгэсэн хяналт шалгалтын ажлын тайлан, гаргасан шийдвэр болон өмнөх бүх хяналт шалгалтаар өгсөн зөвлөмж, үүрэг даалгаврын биелэлт, хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээллийг,
- Хөгжлийн банкны санхүүжилтээр төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон зээлийн асуудлаар салбар хариуцсан төрийн захиргааны төв болон хамаарал бүхий бусад байгууллагуудад хандаж,**
  - Монгол Улсын Шадар сайд,
  - Барилга, хот байгуулалтын яам,
  - Боловсрол, шинжлэх ухааны яам,
  - Зам, тээврийн хөгжлийн яам,
  - Сангийн яам
  - Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам,
  - Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам,
  - Эрчим хүчний яам,
  - Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч,
  - Гаалийн ерөнхий газар.
- Хамтран ажиллах, мэдээллийн чанар, нотлох баримтын хуулийн хүчин төгөлдөр чадамжийг сайжруулах, ажлын эрчмийг алдагдуулахгүй, мэдээлэл авах асуудлаар дараах байгууллагад хандаж,**
  - Авлигатай тэмцэх газар,
  - Улсын ерөнхий прокурорын газар,
  - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар,
  - Улсын бүртгэлийн ерөнхий газар,
  - Ашигт малтмал, газрын тосны газар,

<sup>16</sup> УИХ-ын ХШТХ-ны 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн УИХ-16/8038, УИХ-16/8039, УИХ-16/8040

- *Татварын өрөнхий газар.*

2.3 Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явц, байдлыг дамжуулан санхүүжүүлсэн нийт эх үүсвэртэй нь уялдуулан дэд зээлдэгч бүрээр зээлийн зарцуулалтын мэдээллийн анхдагч эх үүсвэрт тулгуурлан хянан үзэх зорилгоор арилжааны банкуудад тус тус нотлох баримтын шаардлагыг ханган ирүүлэх албан бичгийг илгээж, мэдээллийг гаргуулж ажилласан байна<sup>17</sup>.

2.4 ХШТХ-ноос хянан шалгач нарыг ажиллах боломжоор хангах, хамтран ажиллах тухай албан бичгийг АМГТГ, УЕПГ, УБЕГ, ШШГЕГ, АТГ-т хандан хүргүүлж Хөгжлийн банкны зээлдэгчидтэй холбоотой нэмэлт мэдээлэл авах, зээл эргэн төлүүлэх ажлын эрчмийг алдагдуулахгүй байх зорилгоор цаашид хууль тогтоомжийн дагуу хэрхэн хамтран ажиллах, нийтийн эрх ашгийн үүднээс нэгдмэл ашиг сонирхлын дор зохистой шийдэл гаргах боломж, тухайн асуудлаар санал бодлоо солилцож ажиллах шийдвэрийг гарган уулзалт зохион байгуулсан<sup>18</sup>.

2.5 Хөгжлийн банкны эх үүсвэрээр санхүүжүүлж улсын төсөвт шилжүүлсэн зээлийн асуудлаар Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээр нийт санхүүжилт олгосон төсөл, арга хэмжээнээс өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалт, төсөвт өртөг, хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэсэн ажлын чанар, хэрэгжилт болон хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлсэн эсэх байдалд нарийвчилсан шалгалт хийхийг холбогдох сайд нар болон Нийслэлийн Засаг даргад даалгасан байна.

2.6 Хөгжлийн банкны эх үүсвэрээр Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжих чиглэлээр олгох зээлийн асуудлаар ҮАБЗ-өөс гаргасан анхны зөвлөмж болон дараагийн үе шатанд зөвлөмж болгосон бусад шийдвэрийн дагуу хэрэгжсэн болон үл хэрэгжсэн асуудал, “Бондын зөвлөл”-ийн үйл ажиллагааг эхэлснээс татан буулгах хүртэлх шийдвэрийн хэрэгжилт, мөн бусад үйл ажиллагааны хүрээнд холбоотой талуудад үүрэг болгосон асуудлын биелэлт, үр дүнгийн талаарх мэдээллийг хуульд заасан нотлох баримтын шаардлагыг хангаж иж бүрнээр ирүүлэхийг ҮАБЗ-ийн Нарийн бичгийн дарга, ЗГХЭГ-ын дарга нарт хүргүүлсэн.

2.7 Асуудал дэвшүүлснээр ҮАБЗ-ийн Нарийн бичгийн даргаас зөвлөлийн шийдвэр гаргалтын асуудлаар хууль тогтоомжид тусгагдсаны дагуу хаалттай хэлбэрээр уулзалт зохион байгуулах саналыг ирүүлсэн бол танилцах боломжоор хангагдахын тулд Түр хорооны даргаас дахин асуудал тавьж, ҮАБЗ-ийн гаргасан шийдвэртэй холбогдуулан хийсэн хурлын тэмдэглэлтэй хаалттай хэлбэрээр танилцсан болно.

2.8 ЗГХЭГ-аас ирүүлсэн материалд “Бондын зөвлөл”-ийн нийт 10 хуралдааны цахим тэмдэглэлийг ирүүлж, 2 хуралдааны тэмдэглэл ирээгүй бөгөөд хуралдааны тэмдэглэлийг сонссоноор хэлэлцэж шийдвэрлэсэн асуудалтай танилцсан.

2.9 УИХ-аас байгуулсан ХШТХ-ны 02 дугаар тогтоолын дагуу холбогдох байгууллагууд (Сангийн яам, Монголбанк, Хөгжлийн банк, Улсын Ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Үндэсний аудитын газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар)-ын нотлох баримтын гүйцэтгэл 60 хувьтай байсан тул нэмэлт арга хэмжээг хэрэгжүүлсэн<sup>19</sup>.

*Хүснэгт 4. Хэрэгжүүлсэн горим, арга хэмжээ*

Байгууллагын нэр	Албан бичиг	Цахим шуудан	Уулзалт	Нэмж ирүүлсэн материал
УБЕГ	2022.08.30-ны өдрийн УИХ-16/8042 2022.09.27-ны өдрийн УИХ-16/8826	4	Хянан шалгач нар УБЕГ-т 2022.09.09-16-ны өдрүүдэд ажилласан.	Чанаргүй зээлдэгч нарын хамаарал бүхий этгээдийн нэмэлт мэдээллүүд

<sup>17</sup> УИХ-ын ХШТХ-ны 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн УИХ-16/8043, УИХ-16/8044, УИХ-16/8045, УИХ-16/8046, УИХ-16/8047, УИХ-16/8048, УИХ-16/8049, УИХ-16/8050, УИХ-16/8051, УИХ-16/8052

<sup>18</sup> УИХ-ын ХШТХ-ны 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн УИХ-16/8041, УИХ-16/8042, УИХ-ын ХШТХ-ны 2022 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн УИХ-16/8284, УИХ-16/8285, УИХ-ын ХШТХ-ны 2022 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн УИХ-16/8434

<sup>19</sup> Эх сурвалж: Хянан шалгах Түр хорооны хянан шалгалтын ажлын явцын тайлан, 2022 оны 10 дугаар сарын 12

МУХБ	-	12	Хянан шалгагч нар МУХБ-нд газар дээр нь ажилласан.	Шаардлагатай мэдээлэл
АМГТГ	2022.08.30-ны өдрийн УИХ-16/8041	1	Хянан шалгагч нар 2022.09.28-ны өдөр ажилласан.	Тусгай зөвшөөрлийн нэмэлт мэдээлэл
УБЕГ	2022.09.07-ны өдрийн УИХ-16/8285	1	Хянан шалгагч нар 2022.10.06-ны өдөр ажилласан.	-
АТГ	2022.09.13-ны өдрийн УИХ-16/8434	1	-	-
Монголбанк	2022.08.30-ны өдрийн УИХ-16/8040	-	-	2017 оны шалгалтын материал
Сангийн яам	2022.08.30-ны өдрийн УИХ-16/8039	-	Хянан шалгагч 2022.10.04-ний өдөр ажилласан.	-
ШШГЕГ	2022.09.07-ны өдрийн УИХ-16/8284	1	Хянан шалгагч нар 2022.09.28-ны өдөр ажилласан.	Хэрэг бүртгэлийн тоон мэдээллийг шинэчилж авсан.
ЗГХЭГ	2022.08.30-ны өдрийн УИХ-16/8038	-	-	-

2.10 Хянан шалгах ажлын хүрээнд нэмж гаргуулсан нотлох баримт материал дараах байдалтай байна. Үүнд:

*Хүснэгт 5. Нэмэлтээр гаргуулсан баримт бичиг*

Банкны нэр	Албан бичиг	Нэмж ирүүлсэн материал	Яам, агентлагийн нэр	Албан бичиг	Нэмж ирүүлсэн материал
Хаан	2022.08.30-ны УИХ-16/8049	1111 зээлдэгчийн материал	ЭХЯ	2022.09.20-ны УИХ-16/8650	50 төслийн материал
Голомт	2022.08.30-ны УИХ-16/8051	396 зээлдэгчийн материал	ГЕГ	2022.09.20-ны УИХ-16/8657	2 төслийн материал
ХХБ	2022.08.30-ны УИХ-16/8047 2022.08.30-ны УИХ-16/8050	135 зээлдэгчийн материал	ЗТХЯ	2022.09.20-ны УИХ-16/8649	86 төслийн материал
Төр	2022.08.30-ны УИХ-16/8053	173 зээлдэгчийн материал	БХБЯ	2022.09.20-ны УИХ-16/8651	37 төслийн материал
Хас	2022.08.30-ны УИХ-16/8048	472 зээлдэгчийн материал	УУХҮЯ	2022.09.20-ны УИХ-16/8652	3 төслийн материал
Капитрон	2022.08.30-ны УИХ-16/8045	71 зээлдэгчийн материал	ХХААХҮЯ	2022.09.20-ны УИХ-16/8653	1 төслийн материал
Чингис хаан	2022.08.30-ны УИХ-16/8043	39 зээлдэгчийн материал	БШУЯ	2022.09.20-ны УИХ-16/8654	1 төслийн материал
ҮХОБ	2022.08.30-ны УИХ-16/8044	48 зээлдэгчийн материал	Сангийн яам	2022.09.20-ны УИХ-16/8655	3 төслийн материал
Ариг	2022.08.30-ны УИХ-16/8052	5 зээлдэгчийн материал	Шадар сайд	2022.09.20-ны УИХ-16/8656	1 төслийн материал
Капитал	2022.08.30-ны УИХ-16/8046	92 зээлдэгчийн материал	НЗДТГ	2022.09.20-ны УИХ-16/8658	171 төслийн материал

2.11 Монгол Улсын Их Хурлын даргын 20 дугаар захирамжаар “Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, шалгалах хийсэн талаарх Монгол Улсын Засгийн газар, Монголбанк болон аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжтэй танилцаж, дүнг Улсын Их Хуралд танилцуулах” үүрэг бүхий ажлын хэсгийн дүгнэлтээр нийт 34 зээлдэгчийн 37 төслийн санхүүжилт зориулалт бусаар зарцуулагдсан байж болзошгүй гэж дүгнэсэн.

2.12 Хяналт шалгалах ажлыг эхлүүлэх болон үүссэн нөхцөл байдалтай холбоотойгоор чанааргүй зээлдэгч, тэдгээрийн хамаарал бүхий этгээдийн хөрөнгийн жагсаалтын мэдээллийг хянан үзэхэд суурь мэдээлэл дараах байдалтай байсан. Үүнд:

- УБЕГ-аас 66 зээлдэгчийн хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагагаа эхний албан бичгээр ирсэн ч тулган баталгаажуулалт хийж, бүртгэл, тайллагналын цахим горимтой танилцах зорилгоор 2022 оны 09 дүгээр сарын 09-16-ны өдрүүдэд УБЕГ-т ажиллаж, дараах мэдээллийг цуглувансан.

- Чанаргүй зээлдэгчийн идэвхтэй болон идэвхгүй хуулийн этгээдийн мэдээлэл,
  - Чанаргүй зээлдэгчийн хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын мэдээлэл
  - Чанаргүй зээлдэгчийн эцсийн өмчлөгчийн мэдээлэл,
  - Чанаргүй зээлдэгчийн дээрх этгээдүүдийн гэр бүлийн гишүүдийн мэдээлэл,
  - Чанаргүй зээлдэгчийн компанийн нэр дээрх хөрөнгийн мэдээлэл,
  - Идэвхтэй хуулийн этгээдийн хөрөнгийн мэдээлэл,
  - Идэвхгүй хуулийн этгээдийн хөрөнгийн мэдээлэл,
- **Баталгаажуулалтын хувьд хэрэгжүүлсэн нэмэлт ажилбар:**
    - Хянан шалгагч нар цуглуулсан мэдээллийг үндэслэн нийт 34 зээлдэгчийн хамаарал бүхий этгээдийг илрүүлэх 4 шугамын аргаар шалгалтыг хийсэн болно. Энэ нь идэвхтэй идэвхгүй ХЭ-ийг хуулийн этгээд бол иргэн хүртэл задлах, иргэн бол тухайн иргэний нэр дээрх хуулийн этгээдүүдийг тодорхойлсон.
    - УБЕГ-аас өмнөх ажлын хэсэгт зээлдэгч нарын мэдээллийг иргэн хүртэл задалж, гэр бүлийн гишүүдийн мэдээллийн хамт хүргүүлсэн тухай мэдэгдсэн.
    - Дээрх жагсаалтыг харгалзан чанаргүй зээлдэгч нарын хөрөнгийн жагсаалтыг гаргасан.

## ГУРАВ. ХЯНАН ШАЛГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1 УИХ-ын ХШТХ-ны 2022 оны “Нотлох баримт ирүүлэх тухай” 03 дугаар тогтоолын дагуу ажлын даалгаварт дурдсан байгууллагаас Хөгжлийн банкны зээлийн үйл ажиллагаатай хамаарал бүхий баримт мэдээллийг хүлээн авах, шаардлагатай нэмэлт материалыг гаргуулж хуульд заасны дагуу хянан шалгах ажлыг гүйцэтгэсэн.

**Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль батлагдсантай зэрэгцэн Монгол Улсын Их Хурлын 2011 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 15 дугаар тогтоол нь зээл олгох үйл ажиллагааны эхлэл болсон**

3.2 Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтыг үндэслэн УИХ-аас баталсан “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2011 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 15 дугаар тогтоолоор дараах төсөл, хөтөлбөрүүдийг МУХБ-ны санхүүжилтээр 2011 оноос хэрэгжүүлж эхлэхийг Засгийн газарт даалгаснаар томоохон гэх төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх эхлэл тавигдсан. Үүнд:

- УИХ-ын 2010 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 36 дугаар тогтоолоор баталсан “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтом хөтөлбөр,
- УИХ-ын 2010 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 32 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлого”,
- Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2011 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай УИХ-ын 2010 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн 45 дугаар тогтоолд заасан “Сайншанд” аж үйлдвэрийн цогцолбор,
- УИХ-ын 2008 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 47 дугаар тогтоолоор баталсан “Төрийн хөрөнгөөр гүйцэтгэн дараа төлөгдөх нөхцөлтэйгөөр барих аято зам, эрчим хүчиний барилга, байгууламжийн жагсаалт”

3.3 Харин УИХ-аас дээр дурдсанаас өөрөөр Хөгжлийн банкны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан шаардлагын дагуу тус банкаас санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг батлаагүй байна.

**Монгол Улсын Их Хурлын 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 52 дугаар тогтоолоор Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрч, уг хөрөнгөөр хэрэгжүүлэх салбар чиглэлийг тодорхойлсон байна**

3.4 Монгол Улсын Их Хурлын 2012 оны 52 дугаар тогтоолоор эдийн засгийн өсөлтийг хангах, урт хугацааны хөгжлийн хөрөнгө оруулалт хийх, экспортыг дэмжих бодлогыг санхүүжүүлэх зорилгоор дунд, урт хугацааны 5 тэрбум хүртэлх ам.долларын Засгийн газрын үнэт цаасыг 2012-2014 онуудад үе шаттайгаар олон улсын зах зээлд арилжаалахыг Монгол Улсын Засгийн газарт зөвшөөрчээ<sup>20</sup>.

3.5 Уг тогтоолын 2 дахь заалтад тухайн хөрөнгийг нийгмийн халамжийн аливаа үйлчилгээ болон улсын төсвийн орлогын дутагдлыг нөхөхөөс бусад “эрдэс баялаг, зам, тээвэр, эрчим хүч, харилцаа холбоо, барилга, банк санхүү, аж үйлдвэрийн салбар”-т хэрэгжүүлэх эдийн засгийн үр ашиг бүхий томоохон төслүүдэд зарцуулахыг чиглэл болгосон байна.

3.6 Гэвч тогтоолын дээрх заалт нь хэт ерөнхийлсөн, нөгөө талаас энэ салбарын хамрах хүрээний хувьд өргөн, олон салбарыг хамарсан, уг салбарын нэрээр л бол ямар ч төсөл, хөтөлбөр, төсвийн шинж чанартай арга хэмжээг санхүүжүүлэх бололцоог олгосон байна.

**ҮАБЗ-ийн зөвлөмжид эдийн засгийн аюулгүй байдлыг бэхжүүлэх, үр ашиг, эргэн төлөгдөх баталгаа бүхий дэд бүтэц, үйлдвэрлэлийн төсөл, хөтөлбөрүүдийг тэргүүн ээлжид санхүүжүүлэхийг зөвлөсөн**

3.7 ҮАБЗ-ийн 2012 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн “Засгийн газрын үнэт цаасны талаар авах зарим арга хэмжээний тухай” 28/20 дугаар зөвлөмжид үнэт цаастай холбогдуулан УИХ, Засгийн газраас хэрэгжүүлэх ажлын ерөнхий чиглэлүүд тусгагдсан байна.

<sup>20</sup> Монгол Улсын Их Хурлын 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 52 дугаар тогтоол

3.8 ҮАБЗ-ийн “Засгийн газрын үнэт цаасны талаар авах зарим арга хэмжээний тухай” зөвлөмжид УИХ, Засгийн газар, зөвлөлийн Нарийн бичгийн даргад өгсөн зөвлөмжийн гол агуулга нь дараах байдалтай байсан<sup>21</sup>. Үүнд:

- **Монгол Улсын Их Хуралд (2 заалт бүхий):**
  - ⇒ Бүрдүүлсэн хөрөнгийн зарцуулалт, эргэн төлөлт, тавих хяналтад шаардагдах нэмэлт эрх зүйн орчныг УИХ-ын намрын чуулганд багтаан бүрдүүлэх.
  - ⇒ Засгийн газрын үнэт цаасны зарцуулалт, төслийн сонголт, хэрэгжүүлэлтэд тавих хяналтыг УИХ-ын Эдийн засгийн байнгын хороонд, үнэт цаасны үйлчилгээ, хүүгийн болон үндсэн төлбөрийг барагдуулах, түүнийг төсвийн эх үүсвэртэй уялдуулахад тавих хяналтыг УИХ-ын Төсвийн байнгын хороонд тус тус хариуцуулах;
- **Монгол Улсын Засгийн газарт (6-н заалт бүхий):**
  - ⇒ Сонгосон төсөл, хөтөлбөрт олгох санхүүжилтийн асуудлыг Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлэж, УИХ-ын даргад танилцуулах;
  - ⇒ Эдийн засгийн бие даасан, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн үр ашиг, эргэн төлөгдөх баталгаа бүхий дэд бүтэц, үйлдвэрлэлийн нэг төсөл хөтөлбөрт олгох санхүүжилтийн нийт хэмжээний 1/3-ээс хэтрэхгүй байх;
  - ⇒ Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх зорилгоор мэргэжлийн болон салбар хариуцсан байгууллагын төлөөлөл, бие даасан шинжээчдийг оролцуулсан “Бодлогын зөвлөл байгуулах”, төсөл, хөтөлбөрийн сонголтын ил тод байдлыг хангах, иргэний хяналтын дор хэрэгжүүлэх, Засгийн газрын бодлогын залгамж чанарыг хадгалах;
- **Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Нарийн бичгийн даргад (2 заалт бүхий):**
  - ⇒ Хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, Зөвлөлийг мэдээллээр хангах, хөрөнгийн эх үүсвэрийн зарцуулалт, ашиглалтад хууль хяналтын байгууллагын ажлын уялдааг хангаж ажиллах (АТГ, ТЕГ болон бусад) зэрэг үндсэн асуудлаар зөвлөмж гаргаж байжээ.

3.9 Зээлийн гол шаардлага нь “Эдийн засгийн бие даасан, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн, үр ашиг, эргэн төлөгдөх баталгаа бүхий дэд бүтэц, үйлдвэрлэлийн төсөл, хөтөлбөрүүдийг тэргүүн ээлжид санхүүжүүлэхэд оршиж байсан.

3.10 Түүнчлэн тогтоолын Засгийн газарт зөвлөмж болгосон хэсэгт үнэт цаасыг арилжаалах замаар бүрдүүлсэн хөрөнгийн эх үүсвэрээс төсөл, хөтөлбөр сонгон санхүүжүүлэх асуудлыг тухай бүр Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлэж, УИХ-ын даргад бичгээр танилцуулж байх гэсэн байна.

#### **Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 179 дүгээр тогтоолоор “Бодлогын зөвлөл” байгуулагдсан**

3.11 ХШТХ-ноос Бодлогын зөвлөлийн асуудлаар ЗГХЭГ-т хандсаны дагуу 2022 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн “Баримт, мэдээлэл хүргүүлэх тухай” ХЭГ/2686 дугаар албан бичгээр мэдээлэл ирүүлсэн (CD 1 ширхэг, баримт 466 хуудас)<sup>22</sup>.

3.12 Засгийн газрын үнэт цаас борлуулж, босгосон хөрөнгөөр хийх “бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөрийг сонгох шалгуур үзүүлэлтийг тогтоох, үүсэж болох эрсдэлийг тооцох, эрсдэлийн удирдлагаар хангах” үүрэг бүхий Бодлогын зөвлөл дараах бүрэлдэхүүнтэй ажилласан байна. Үүнд:

- **Дарга,** - Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг  
**Орлогч дарга,** - Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр

<sup>21</sup> Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2012 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 28/20 дугаар зөвлөмж

<sup>22</sup> ХШТХ-ны даргын 2022 оны УИХ-16/10387 дугаар албан бичиг

- Гишүүд,**
- Сангийн сайд Ч.Улаан
  - Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга Ч.Сайханбилэг
  - Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулга
  - Уул, уурхайн сайд Д.Ганхуяг
  - Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайхан
  - Эрчим хүчний сайд М.Сономпил
  - Зам, тээврийн сайд А.Гансүх
  - УИХ-ын Эдийн засгийн Байнгын хорооны дарга  
Б.Гарамгайбаатар (зөвшилцсөнөөр)
  - УИХ-ын Төсвийн Байнгын хорооны дарга  
Ц.Даваасүрэн (зөвшилцсөнөөр)
  - Монголбанкны Ерөнхийлөгч Н.Золжаргал  
(зөвшилцсөнөөр)
  - Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан  
(зөвшилцсөнөөр)
  - Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга  
П.Цагаан (зөвшилцсөнөөр)
  - Улсын Их Хурлын даргын ахлах зөвлөх Д.Одхүү
  - Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын  
захирагч Э.Бат-Үүл
- Нарийн бичгийн  
дарга**
- Эдийн засгийн хөгжлийн яамны ТНБД-ын үүргийг түр  
орлон гүйцэтгэгч Б.Шинэбаатар нар ажилласан.

3.13 ҮАБЗ-ийн зөвлөмж, Засгийн газрын шийдвэрээр байгуулагдсан Бодлогын зөвлөлийн бүрэлдэхүүнд бие даасан шинжээч ажиллуулах, төсөл, хөтөлбөрийн сонголт ил тод, хариуцлагатай, цаг хугацаандаа хэрэгжиж байх зарчмыг иргэний хяналт дор хэрэгжүүлэх зөвлөмж хэрэгжээгүй байна.

3.14 Ирүүлсэн мэдээлэлд Засгийн газрын Бодлогын зөвлөл байгуулах тухай шийдвэр, тус зөвлөлийн 2013-2014 онд гаргасан I, II, III, IV, V зөвлөмж, хуралдааны I, II, IV, V, VI, VII, VIII, IX, X, XII дугаар хуралдааны (III болон XI дүгээр хуралдааны тэмдэглэл ирээгүй) аудио тэмдэглэл байсан болно<sup>23</sup>.

3.15 Ажиглалтад суурилан нэмэлт тайлбар авах чиглэлээр ЗГХЭГ-т дахин хандаж тодруулга авсан бөгөөд тодруулгын явцад нийт 11 удаа хуралдсан талаарх мэдээллийг бид авсан.

3.16 Бодлогын зөвлөлийг байгуулсан тухай шийдвэрт эрсдэлийг тооцох, шинжээчдийн багийг ажиллуулах, шалгуур үзүүлэлттэй байх, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, санхүүжилтийн хуваарьт хяналт тавих заалтууд туссан боловч хэрэгжээгүй байна.

3.17 Бодлогын зөвлөл нь дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тогтоолд батлагдаж байсан ч бидний олсноор бодлогын зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой үр дүнг үнэлэх хангалттай баримт материал хангалтгүй байсан.

- Зөвлөлийн ажиллах журам, үйл ажиллагааны төлөвлөгөөтэй байх, үүсэж болох эрсдэлийг урьдчилан тооцож, үнэлгээ гаргах бүхий дэд ажлын хэсэг, дотоод, гадаадын шинжээчдийн багийг байгуулж ажиллуулах, төсөл, хөтөлбөр бүрд шалгуур үзүүлэлтийн дагуу эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлийн удирдлагаар хангах, байнгын төлөвлөгөөтэйгөөр хяналт тавих, хөтөлбөрийн хэрэгжилт, санхүүжилтийн хуваарьт хяналт тавьж ажиллах үүргийг хүлээж байсан боловч хуралдааны тэмдэглэлээс үзвэл хэрэгжсэн гэж үзэх үндэслэл алга байна.**

3.18 ХШТХ-нд ирүүлсэн Бодлогын зөвлөлийн хуралдааны 10 удаагийн цахим тэмдэглэлээс үзэхэд салбар хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын сайд нараас санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг ерөнхийлсөн танилцуулгыг хийж, зөвлөлийн зөвлөмж гарган Засгийн газарт хүргүүлж байжээ.

<sup>23</sup> 3 болон 11 дүгээр хуралдааны бичлэг болон 1-12 дугаар хуралдааны тэмдэглэлийг цаасан сууриар албан ёсоор баталгаажуулсан баримтгүй гэж мэдээлэл ирүүлсэн

3.19 Бодлогын зөвлөлийн хуралдааны цахим тэмдэглэлийг сонссоноор зохион байгуулалт, дэгийн асуудал хангартгүй, хуралдаанаар хэлэлцүүлсэн асуудлын мэдээллийг сонсох хэлбэртэйгээс үр ашигт байдал, хэтийн үр өгөөжийн тооцоолол бүхий асуудал үндсэндээ хөндөгдөөгүй ерөнхийлсөн байдлаар хуралдаан зохион байгуулагджээ.

3.20 Бодлогын зөвлөлийн хуралдааны шийдвэрлэх хэсэгт дэмжсэн салбар болоод тухайллан зарим аж ахуйн нэгжийн төсөлд санхүүжилт олгохыг дэмжсэн шийдвэрийг гаргаж ирсэн. Тухайлбал,

- “Гудамж төсөл”, Хурдны зам, Тавантолгойн нүүрсний орд газарт цахилгаан станц барих, Шинэ төмөр зам барих томоохон төсөл болон ААН-ийн хувиар “Эрэл” ХХК-ийн БҮК-1 төсөл, “МИАТ” ТӨХХК-ийн Голомт банк хооронд байгуулсан агаарын хөлгийн худалдан авах зээлийн төлбөр, ТОСК, төмөрлөгийн үйлдвэрлэлийг дэмжиж “Мон-Лаа” ХХК, “Бэрэн групп” ХХК, цементийн үйлдвэрлэлийг дэмжихэд “Монголын алт” ХХК, “Монполимет” ХХК-д, эрүүл мэндийн чиглэлээр “Энхийн шүүдээр ХХК-ийн төслийг санхүүжүүлэх зөвлөмж гарсан.

3.21 Бодлогын зөвлөлийн зөвлөмжийн тогтоох хэсэг буюу зөвлөмж болгох хэсэг нь УАБЗ-ийн 28/20 дугаар зөвлөмжийг үндэслэн гэж бичигдсэн бөгөөд зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудалд үндэслэсэн тухай дурдсан зүйлгүй байна.

3.22 Харин зөвлөлөөс гаргасан зөвлөмжийн “шийдвэрлэх хэсэг” нь төсөл, хөтөлбөрүүдийг зохих журмын дагуу боловсруулан Засгийн газарт оруулахыг зөвлөлийн орлогч дарга буюу хариуцсан (ЭЗХЯ) сайдад даалгасан хэлбэртэй байжээ.

3.23 Бодлогын зөвлөлийн хуралдаанаас зөвлөмж гарган шаардлагатай гэж үзсэн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхийг даалгахдаа зохих журмын дагуу төслийн баримт бичгийг боловсруулан Засгийн газарт оруулж хэлэлцүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг холбогдох сайд нарт үүрэг болгож байсан байна.

3.24 Бодлогын зөвлөлийн дэмжлэгтэй болон Засгийн газрын шийдвэрийг үндэслэн олгосон зээлийн хувьд Хөгжлийн банк ямар нэг эрсдэл хүлээгээгүй учраас хүлээх хариуцлага сул, хуульд заасан зээлийн шалгуур үзүүлэлтэд тавих хяналт хангартгүй байсан.

3.25 МУХБ-наас авсан зээл олголт, төлүүлэлтийн нэгтгэсэн мэдээллээс үзэхэд Бодлогын зөвлөлийн зөвлөмжид нэр дурдаж Засгийн газрын шийдвэрээр дараах зээлдэгчдэд зээл олгосон. Үүнд:

**A. Үлдэгдэлтэй “ШУУД” зээлийн багцын хувьд:**

- “Зөвлөмж I”-ийн хүрээнд ЭХЯ-наас захиалж, хариуцсан “Тавантолгойн нүүрсний орд газрыг түшиглэн 450 МВт хучин чадалтай цахилгаан станц барих төсөл”
- “Зөвлөмж III”-ийн хүрээнд УУЯ, БХБЯ-наас захиалж, хариуцсан ТОСК БҮ-1, ТОСК БҮ-2, Бэрэн групп ХХК, Эрэл ХХК, Мон Лаа ХХК
- “Зөвлөмж V”-ын хүрээнд УУЯ, ЭЗХЯ-наас захиалж, хариуцсан “Мак цемент” ХХК, “Монполимет” ХХК-д тус тус олгосон.

**B. Хаагдсан “ШУУД” зээлийн багцын хувьд:**

- “Зөвлөмж III”-ын хүрээнд ТОСК ТӨҮГ-ын хэрэгжүүлсэн Увс, Архангай, Сэлэнгэ, Дархан-Уул аймагт хэрэгжсэн 1000 айл орон сууцны хөтөлбөр

**B. Арилжааны банкуудаар “ДАМЖУУЛАН” хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн зээлийн хувьд:**

- “Зөвлөмж II”-ын хүрээнд УХААЯ-наас захиалж, хариуцсан ХАА, хөнгөн үйлдвэрийн ноос, ноолуур, сүү, хүлэмж болон оёдлын салбарын төслийг Голомт банкаар дамжуулан олгосон.
- “Зөвлөмж V”-ын хүрээнд УХААЯ-наас захиалж, хариуцсан “Экспортыг дэмжих, импортыг орлох 2 тэрбум төгрөгөөс дээш өртөг бүхий үйлдвэрлэлийн 888 төсөл”-ийг Голомт, Капитал, Капитрон, Төрийн, УБХБ, УХОБ, Хаан, Хас, ХХБ-аар тус тус дамжуулан олгосон.

- “Зөвлөмж V”-ын хүрээнд Голомт банкаар дамжуулан “Энхиийн шүүдэр” ХХК-ийн “Дуслын шингэний үйлдвэрийн төсөл”
- “Зөвлөмж V”-ын хүрээнд УХААЯ-наас захиалж, хариуцсан “Экспортыг дэмжих, импортыг орлох 2 тэрбум төгрөгөөс доош өртөг бүхий үйлдвэрлэлийн 888 төсөл”-ийг ЖДҮХС-арилжааны банкууд болох Голомт, Капитал, Капитрон, Төрийн, УБХБ, УХОБ, Хаан, Хас, ХХБ, Чингис хаан банкаар тус тус дамжуулан зээл олгосон.

**Г. Банкны эх үүсвэрээр “ТӨСВӨӨС ЭРГЭН ТӨЛӨГДӨХ” нөхцөлтэйгөөр 2012-2017 онуудад хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний /Засгийн газарт шилжүүлсэн/ хувьд:**

- “Зөвлөмж I”-ийн хүрээнд ЗТХЯ-наас захиалан хэрэгжүүлсэн “Шинэ төмөр зам төсөл, ЭЗХЯ, НЗДТГ-НХОГ-аас захиалж хамтран хэрэгжүүлсэн Нийслэл хот, хот орчмын гудамж, замын шинэчлэлийн төслүүдэд тус тус дамжуулан олгосон.
- “Зөвлөмж II”-ийн хүрээнд зээл ЗТХЯ, ЭХЯ, БХБЯ-наас захиалж, хариуцсан зарим аймгийн төв, улсын чанартай орон нутаг дахь авто зам, нийслэлийн бус, хот орчмын орон сууцны хорооллын дэд бүтэц, цахилгаан дамжуулах шугам сүлжээ барьж байгуулах төсөл.

3.26 Бодлогын зөвлөлийн зөвлөмжид үндэслэж Засгийн газраас санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагыг Засгийн газрын тогтоолд шууд заасантай холбогдон Хөгжлийн банкны үйл ажиллагааг хууль, журмын дагуу явуулахад зарим хүндрэл гарч, зээлийн үндсэн зарчим болох зээлийн судалгаа хийж эрсдэл, үр ашгийг тодорхойлох, хөгжлийг дэмжих үр ашигтай, эрсдэлгүй, эргэн төлөгдөх баталгаа бүхий төсөл, хөтөлбөрийг болон хэрэгжүүлэгчийг сонгон санхүүжүүлэх үр нөлөөтэй хөрөнгө оруулалтын тогтолцоо тухайн үед үйлчилж чадаагүй.

3.27 ТБОНӨХБАУХАТ хуулийн 3 дугаар зүйлийн 3.6-д "Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагаатай холбогдсон бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулахгүй" гэж заасныг үндэслэн гаргасан Засгийн газрын тогтоолд нэр заасан компаниудтай МУХБ шууд гэрээ байгуулж байжээ.

3.28 ҮАБЗ-ийн 2014 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 19/10 дугаар зөвлөмж нь өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн хангалтгүй байдлыг хэлэлцэж, Засгийн газрын Бодлогын зөвлөлийг буулгах нь зүйтэй гэж үзсэн.

3.29 ҮАБЗ-ийн Ажлын албанаас хийсэн шалгалтаар өмнөх зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, тухайлбал гол асуудлаар буюу өмнөх зөвлөмжийн 1.1-ийн үнэт цаасны зарцуулалт, эргэн төлөлт, тавих хяналтад шаардагдах нэмэлт эрх зүйн орчныг бүрдүүлэх гэсэн УИХ-д даалгасан заалт хэрэгжээгүй байна.

3.30 Түүнчлэн 2.2-ын эдийн засгийн бие даасан, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн үр ашиг, эргэн төлөгдөх баталгаа бүхий төсөл, хөтөлбөрт бус хөрөнгийн нийт 50.0 хувийг ойрын хугацаанд эргэн төлөгдөх баталгаагүй төслүүдэд зарцуулсан, 2.4-ийн Засгийн газрын эрсдэлийг багасгах, хөрөнгө оруулалтын орчныг дэмжих үүднээс нэг төсөл, хөтөлбөрт хийх санхүүжилт нь тухайн төслийн нийт санхүүжилтийн 1/3-ээс хэтрэхгүй байх гэсэн заалтыг баримтлаагүй байсан тухай зөвлөлийн хуралдааны тэмдэглэлд үлджээ.

3.31 ҮАБЗ-ийн Ажлын албанаас хуралдаанд танилцуулсан дүн, хэлэлцсэн асуудал, оруулсан зөвлөмжийн төслийг хэлэлцэн шийдвэрлэсэн Зөвлөлийн зөвлөмжийн 2.7 дахь хэсэгт Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2012 оны 28/20 дугаар зөвлөмжийн 2.4-ийн заалтыг биелүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцох тухай, 2.8 дахь хэсэгт Хөгжлийн банкны үнэт цаас гаргах, арилжих, зарцуулах, зээл олгох үйл ажиллагаанд хяналт тавьж, уг банкнаас гаргасан үнэт цаасны арилжаа, зарцуулалт, эргэн төлөлт, эх үүсвэрийн талаар Улсын Их Хурал болон ҮАБЗ-д тухай бүрд танилцуулж байх тухай зааж өгсөн байна.

**ҮАБЗ-ийн 2014 оны 19/10 дугаар зөвлөмжийн 2 дахь хэсгийн 4-т Бодлогын зөвлөлийг татан буулгах тухай заасан ч зөвлөмж гаргасан байна**

3.32 ҮАБЗ-ийн 19/10 дугаар зөвлөмж нь 2014 оны 05 дугаар сарын 06-ны өдөр гарч, Монгол Улсын Засгийн газарт Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2012 оны 28/20 дугаар зөвлөмжийн 2.5-д заасан Бодлогын зөвлөлийг татан буулгах тухай байсан ч ҮАБЗ гарснаас хойш 14 хоногийн дараа буюу Засгийн газраас байгуулсан Бодлогын зөвлөлийн 5 дахь удаагийн зөвлөмж нь 2014 оны 05 дугаар сарын 20-ны өдөр гарсан байна.

3.33 Бодлогын зөвлөлийн дээрх зөвлөмжөөр нийт 4 аж ахуйн нэгжийн төсөл, экспортыг дэмжих, импортыг орлох үйлдвэрлэлийн 579 төсөл, арга хэмжээг дэмжихээр шийдвэрлэсэн байна.

3.34 ҮАБЗ-ийн зөвлөлийн Засгийн газрын үнэт цаасны талаар авах зарим арга хэмжээний тухай, үнэт цаас арилжаалж бүрдүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тухай өмнөх болон дараагийн зөвлөмжийн талаар ил тод, нээлттэй мэдээлэл алга байна.


3.35 Засгийн газрын тогтоолуудад төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх болон хэрэгжүүлэх байгууллага, олгох мөнгөн дүн, хугацааг шууд заасан, түүнчлэн эрсдэл, үр ашгийг нарийвчлан судалж тодорхойлоогүй төсөл, арга хэмжээ их хэмжээгээр баталж байжээ.

**Монгол Улсын Хөгжлийн банкны хуулийн шинэчлэлийн зорилтод нийцсэн төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх төрийн шийдвэр амжилттай хэрэгжээгүй**

3.36 Монгол Улсын Хөгжлийн банкны тухай анхны хууль (2011 он) батлагдсанаас хойш 2017 оны 2 дугаар сард хуулийн шинэчилсэн найруулга батлагдсан ч түүнээс хойш хуулийн хэрэгжилтэй холбогдуулан үр дагаврын үнэлгээ, төлөв байдлын судалгаа албан ёсоор хийгдээгүй байна.

3.37 Хуулийн шинэчилсэн найруулга нь тус банкны эрх зүйн байдлыг илүү тодотгож өгсөн ч өмнөх хуулийн гол заалт болох хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрүүдийн жагсаалтыг Улсын Их Хурлын хаврын чуулганаар батлуулж байх заалтыг хасаж, харин УИХ болон Засгийн газар төсөл, хөтөлбөрийг тусгайлан батлахгүй байхаар хуульчилжээ.

3.38 Хөгжлийн банкны эрхлэх үйл ажиллагааны хүрээг өргөжүүлж шинэчлэхдээ төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэхэд Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогод нийцсэн байх, банк өөрийн санхүүжилт олгох шийдвэрийг бие даан гаргах зохицуулалт тусгасны дээр банкны хяналтын тогтолцоо, үйл ажиллагааны хязгаарлалтыг шинэчлэн тогтоож өгсөн байна.



- ⇒ Зээл олгох шийдвэрийг ... холбогдох дүгнэлтэд үндэслэн Зээлийн хороо гаргана.
  - ⇒ /Хуулийн 8.2 дах заалт/
  - ⇒ Энэ хуулийн 8.1-д заасан төсөл, хөтөлбөрт Засгийн газраас баталгаа гаргасан тохиолдолд Хөгжлийн банк нь уг төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх болно. Засгийн газрын баталгаа нь зөвхөн уг төсөл, хөтөлбөр дотор Засгийн газрын эзэмших, өмчлөх хувиар хязгаарлагдсан, баталгааг даатгагдсан төсөл, хөтөлбөрийн зээлд гаргана.
  - ⇒ /Хуулийн 9.1 дэх заалт/
  - ⇒ Банкны татан төвлөрүүлсэн, Засгийн газрын баталгаа гаргаснаас бусад хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг Төлөөлөн удирдах зөвлөл батална.
  - ⇒ /Хуулийн 9.3 дах заалт/
- ⇒ хөтөлбөрийг тусгайлан батлахгүй.
  - ⇒ /Хуулийн 23.2 дах заалт/ ... Хөгжлийн банкны санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр дамжуулан Засгийн газарт хүргэх.
  - ⇒ /Хуулийн 24.1.3 дах заалт/
  - ⇒ Энэ хуулийн 25.3-т заасан хяналт, шалгалт хийх журмыг Засгийн газар батална.
  - ⇒ /Хуулийн 25.4 дэх заалт/ Хөгжлийн банк хянан шалгачтай байх бөгөөд хянан шалгач нь энэ хууль болон гэрээний дагуу тус банкны эх үүсвэрийг ашиглаж байгаа төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, шалгалт хийнэ. /Хуулийн 27.1 дэх заалт/

**Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль (2017.02.10)-ийн эн тэргүүнд хянан үзэх шаардлагатай зохицуулалтууд:**

- ⇒ **23 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх** 23.1.2 дахь заалт “Хөгжлийн банкны санхүүгийн тайлангийн талаарх аудитын дүгнэлтийг баталж, түүний үйл ажиллагаанд хийсэн дүгнэлтийн хамт Монгол Улсын Их хуралд хүргүүлэх”
- ⇒ **25 дугаар зүйл. Хөгжлийн банканд тавих хяналт** 25.1.Хөгжлийн банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам, активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулах, зарцуулах журмыг санхүү төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг харгалzan Монголбанк батална.
- ⇒ **28 дугаар зүйл. Хөгжлийн банкны үйл ажиллагаанд тавих хязгаарлалт** 28.1.1.зээл, баталгаа, зээлтэй адилтгах актив хөрөнгийн нийт дүн нь өөрийн хөрөнгийг 30 дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй бөгөөд түүний хэмжээг Монголбанк тогтооно. 28.1.2.Монголбанк нь том зээлдэгчийг тодорхойлох, түүнд олгох зээлийн дээд хэмжээ болон нийт хэмжээг тогтоох, тайлагнах журмыг батална. Нэг зээлдэгч болон түүнд холбогдох этгээдэд олгох зээлийн нийт хэмжээ нь Хөгжлийн банкны өөрийн хөрөнгийг 8 дахин нэмэгдүүлсэн хэмжээнээс хэтрэхгүй байна.

#### **Тус банкны хуулийн анхны болон шинэчилсэн найруулга, банкны өөрийн зээлийн бодлого санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрт тавигдах шаардлагатай нийцээгүй**

3.39 Банкны өмнөх болон шинэчилсэн найруулга, банканд мөрдөж ирсэн зээлийн бодлогыг тодорхойлж байгаа тэргүүлэх чиглэл, зарчим, үндсэн нөхцөлүүд ихэнх зээлдэгч нар дээр алдагдсан байна.

3.40 Тус банкны ТУЗ-ийн тогтоо ор зээлийн бодлогыг удаа дараа баталсан боловч олгосон зээлийн зориулалт, өнөөгийн нөхцөл байдал болон зээлийн чанаргүйдэл, тухайлсан төсөл, хөтөлбөрийн агуулгыг хуулийн нийцэлтэй холбон авч үзвэл хангагдаагүй, санхүүжүүлсэн төслүүдийн үр өгөөжийн талаарх судалгаа, мэдээлэл хангалтгүй байна.

#### **Хүснэгт 6. МУХБ-ны зээлийн бодлогын өөрчлөлт**

Бодлого	МУХБ-ны ТУЗ-ийн тогтоол /2011.08.25/	МУХБ-ны ТУЗ-ийн тогтоол /2017.04.20-27/	МУХБ-ны ТУЗ-ийн тогтоол /2019.06.24-28/
Тэргүүлэх чиглэл	<ul style="list-style-type: none"> <li>- Эрчим хүчний үйлдвэрлэл, дамжуулах шугам</li> <li>- Боловсруулах үйлдвэрлэл (Байгаль орчинд ээлтэй дэвшилтэй техник, технологи нэвтрүүлэх үйлдвэрлэл, түүхий эд, ашигт малтмалын хагас, бүтэн боловсруулалт)</li> <li>- Дэд бүтэц</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Уул уурхай</li> <li>- Хөдөө аж ахуй</li> <li>- Эрчим хүч</li> <li>- Дэд бүтэц</li> <li>- Барилга/Дахин төлөвлөлт</li> <li>- Эрүүл мэнд</li> <li>- Мэдээллийн технологи</li> <li>- Инновац, боловсрол</li> </ul>	---

<b>Зарчим</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Зээлийн үйл ажиллагаанд хараат бус, ил тод, хариуцлагатай, тогтвортой, үр ашигтай байх зарчмуудыг баримтална.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Улсын төсвөөс болон хувийн хэвшлээс бие даан санхүүжүүлэхэд хүндрэлтэй, эдийн засгийн үр ашигтай төслийг санхүүжүүлнэ.</li> <li>- Банкны 2 жилийн хугацаанд санхүүжүүлэх зээл, баталгаа, батлан даалтын нийт дүнгийн 60-аас доошгүй хувийт экспорт дэмжсэн хөтөлбөрт зарцуулна.</li> <li>- Санхүүжилт, баталгаа, батлан даалт дотоодын зах зээлийн нөхцөлөөс хөнгөлөлттэй байна.</li> <li>- Тогтвортой санхүүжилт</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Улсын төсвөөс болон хувийн хэвшлээс бие даан санхүүжүүлэхэд хүндрэлтэй, эдийн засгийн үр ашигтай төслийг санхүүжүүлнэ.</li> <li>- Экспорт дэмжихээс бусад төрлийн зээлийн нийт зээлд эзлэх зохистой хэмжээг гүйцэтгэх удирдлага тогтоож, ТҮЗ-аар батлуулна.</li> <li>- Зээлийн нөхцөл нь дотоодын зах зээлийн нөхцөлөөс хөнгөлөлттэй байна.</li> <li>- Тогтвортой санхүүжилт</li> <li>- Экспортолдог болон экспортлох боломжкоо хангасан зээлийн хүсэлтийг эхэлж судална.</li> <li>- Төсөл бүрэн хэрэгжиж дууссан төслийг дахин санхүүжүүлэхгүй.</li> <li>- Бусад банк санхүүгийн байгууллагад 90-ээс дээш хоногийн зөрчилтэй, эсхүл 2 болон түүнээс дээш бүтцийн өөрчлөлтөд орсон зээлийг дахин санхүүжүүлэхгүй.</li> </ul>
<b>Зээлийн төрөл</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Төслийн санхүүжилтийн зээл</li> <li>- Байгууллагын санхүүжилтийн зээл</li> <li>- Гадаад худалдааны санхүүжилтийн зээл</li> <li>- Баталгаа, батлан даалт</li> <li>- Тусгай нөхцөлтэй төслийн зээл</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Төслийн санхүүжилтийн зээл</li> <li>- Байгууллагын санхүүжилтийн зээл</li> <li>- Гадаад худалдааны санхүүжилтийн зээл</li> <li>- Баталгаа, батлан даалт</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Төслийн санхүүжилтийн зээл</li> <li>- Байгууллагын санхүүжилтийн зээл</li> <li>- Экспорт, импортын зээл</li> <li>- Баталгаа, батлан даалт</li> <li>- Дамжуулан зээл</li> </ul>
<b>Үндсэн нөхцөл, шаардлага</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Хүүг зээлийн хороо тогтооно.</li> <li>- Дунд 5-10 жил, урт (10-15), тусгай нөхцөлтэй зээл болон гадаад худалдааны зээл (1-5 жил) байна.</li> <li>- Зээлийн хорооны зээл батлах эрхийг ТҮЗ хагас жилд 1 удаа батална</li> <li>- Зээлийн хороо нь богино болон дунд хугацааны 5 тэрбум хүртэлх төгрөгийн зээлийг үйл бие даан шийдвэрлэж болно.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Банк нь хүү, шимтгэлийг тогтоох аргачлалтай байх ба аргачлалыг гүйцэтгэх удирдлагаас баталсан журмаар зохицуулна.</li> <li>- Санхүүжилт хүсэгч нь бусад банк, санхүүгийн байгууллагад чанаргүй зээлийн үлдэгдэлгүй байх</li> <li>- Зээлийг үндэсний болон гадаад валютаар олгож болох бөгөөд төслийн борлуулалтын орлоготой уялдуулан харилцан тохиролцож болно.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- 20 тэрбум дээш эсхүл түүнтэй тэнцэх гадаад валютын дүнгээс дээш хэмжээтэй зээлийн хүсэлтийг хүлээн авч шийднэ /дамжуулан зээл хамаарахгүй/.</li> <li>- Зээлийг үндэсний болон гадаад валютаар олгож болох бөгөөд төслийн борлуулалтын орлоготой уялдуулан харилцан тохиролцож болно.</li> <li>- Зээлийн дээд хэмжээ төслийн өртийн 85 хувиас хэтрэхгүй байна.</li> </ul>

3.41 Зээлийн бодлого, зарчмыг шинэчлэн тодорхойлж 2019 оны А-177 дугаар тушаалаар шинэчлэн баталсан журмын хүрээнд зээл олгох хүртэл үйл явцын үе шатны ажлуудыг гүйцэтгэхэд хангалттай хугацааг мөрдөж байсан боловч үр нөлөө хангалтгүй байжээ.

3.42 Тухайлбал, харилцагчийн зээлийн хүсэлт гаргасан хугацаанаас хойш тодорхой ажилбаруудын дараа харилцагчийн материал бүрдүүлэх, судалгаа шинжилгээ хийхэд 90 орчим хоног байгаа бол зээл эцэслэн шийдвэрлэгдэх хүртэл нийт хугацаа дунджаар 4.4 сар байна.

3.43 Зээлийн урьдчилсан судалгаа хангалтгүй хийгдэж, журмаар зохицуулагдсан үе шатны ажилбарууд хангалттай, үр нөлөөтэй байж чадаагүй, нөгөө талаас нэмэлт өөрчлөлт оруулсан болон шинэчилсэн журам мэдэгдэхүйц чанарын ялгаа алга байна.

3.44 Зээл олгох үйл ажиллагаа, зээлийн орчинтой холбоотой залилангийн эрсдэлд өртөмтгийн байдлаас зайлсхийх, урьдчилан сэргийлэх, илрүүлэх зохистой горим журам байгаагүй, үүнийг гол баримт бичгүүдэд тодорхойлсон зүйлгүй явж ирсэн.

## Хяналт шалгалтыг эхлүүлэх үед банкны “тухайн үеийн байдлаар” ирүүлсэн төслийн санхүүжилтийн болон зээлийн чанарын үзүүлэлт сүл байсан

3.45 Хөгжлийн банкны зээлийн үлдэгдлийн мэдээллийг 2022 оны 06 дугаар сарын 15-ны байдлаар тасалбар болгон үлдэгдэлтэй зээлдэгчийн болон тэдгээрийн зээлийн дэлгэрэнгүй шинэчилсэн мэдээллийг хүлээн авч хянан шалгах ажлын суурь үзүүлэлт болгон ашигласан.

3.46 Хяналт шалгалтын ажлын явцад Хөгжлийн банкны мэдээлэлд үндэслэн шууд зээлийн үлдэгдлийн төлөв болон чанарын ангилал, үндсэн валют, зээл олгох үеийн шийдвэрлэлтийн түвшин, зээлийн зориулалт түүний хэрэгжилт, төслийн хэрэгжилтийн байдлыг судалж үзсэн.

3.47 Хяналт шалгалтыг эхлүүлэх үеийн байдлаар авсан мэдээллээс МУХБ-ны шууд олгосон зээлийн шийдвэрлэлтийн түвшин буюу эцэслэсэн шийдвэрлэсэн байдал дараах байдалтай байсан<sup>24</sup>. /Дэлгэрэнгүйг Хавсралт 3-т үзүүлэв/

Хүснэгт 7. МУХБ-ны зээл олголтыг эцэслэн шийдвэрлэсэн байдал, зээлийн нийт үлдэгдэл, (тоо, тбм.төг)

Д.д	Зээл олгох шийдвэрийн хэлбэр	Зээлийн тоо	Үүнээс				
			Олгосон зээл (тухайн өдрийн ханшаар)	Зээлийн төлбөрийн үлдэгдэл			
			Үндсэн зээл	Xүү	Торгууль	Нийт	
1	ТҮЗ-ийн тогтоол	44	2,482.3	2,450.5	483.1	21.0	2,954.6
2	ТҮЗ-ийн тэмдэглэл	5	96.9	97.6	29.2	0.9	127.7
3	Гүйцэтгэх захирал	18	71.1	53.2	10.5	0.8	64.5
	Дүн	67	2,650.2	2,601.3	522.8	22.7	3,146.8

- Хөгжлийн банкны зээл олгох шийдвэрийг гурван түвшинд эцэслэн гаргаж ирснээс нийт үлдэгдэлтэй байгаа зээлдэгчийн 44 буюу 65.7 хувийг төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор, 5 буюу 7.5 хувийг төлөөлөн удирдах зөвлөлийн тэмдэглэлээр, 18 буюу 26.8 хувийг гүйцэтгэх захирлын тушаалаар тус тус шийдвэрлэсэн байна.
- Тухайн үеийн байдлаар банкны тайлан тэнцилийн анхаарал хандуулах болон чанаргүй ангилалд бүртгэлтэй нийт 33 зээлийн 29-ийг ТҮЗ-ийн тогтоолоор, 4-ийг ТҮЗ-ийн тэмдэглэлээр, 10 зээлийг гүйцэтгэх захирлын тушаалаар тус тус олгож байсан.

3.48 Түүнчлэн банкнаас олгосон шууд зээл нь үндэсний мөнгөн тэмдэгтийг оролцуулаад гадаад валютаар татсан эх үүсвэрээр олгосон ба нийт зээлийн үлдэгдэл нь тухайн үеийн ханшаар 2.6 их наяд төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэлтэй байсан. Үүнд:

Хүснэгт 8. МУХБ-наас олгосон зээлийн үндсэн валют, зээлийн үлдэгдлийн нэгтгэсэн дүн

Д.д	Валют	Олгосон зээлийн мэдээлэл		Зээлийн төлбөрийн үлдэгдэл (тбм.төг)			
		Сая валют	Олгох үеийн ханш (тбм.төг)	Үндсэн зээл	Xүү	Торгууль	Нийт
1	MNT	963,716.9	963.72	822.9	148.3	3.1	974.3
2	USD	626.8	1,195.96	1,288.2	359.3	19.4	1,666.9
3	EUR	120.3	353.28	344.8	2.7	0.05	347.5
4	JPY	5,745.9	126.74	112.9	12.3	0.3	125.5
5	CNY	70.2	31.69	32.5	0.28	-	32.8
Төгрөгт хөрвүүлсэн ханшаар		2,671.39	2,601.3	522.9	22.8	3,146.8	

- Татан төвлөрүүлсэн хөрөнгөд суурилсан гадаад валютын санхүүжилт нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн /мэдээлэл авах үеийн ханшаар төгрөгт хөврүүлснээр/ 60.0 гаруй хувийг зээлж байгаа нь ханшийн өндөр эрсдэлийг дагуулж байна.
- Нөгөө талаас энэ нь гадаад валютаар татсан эх үүсвэрт суурилсан зээлийн эргэн төлөлт саарсан тохиолдолд ханшийн эрсдэл хэвээр хадгалагдах буюу улам идэвхжих улмаар даамжрах хандлагатай.

<sup>24</sup> Хяналт шалгалтын ажил эхлэх үед МУХБ-ны 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөр ирүүлсэн мэдээлэл

## Санхүүжүүлсэн төслийн хэрэгжилт, зээлийн ашиглалт, зарцуулалт тавих дотоод хяналтын үр нөлөө сул байсан

3.49 МУХБ-ны гүйцэтгэх удирдлагаас тус банкны эх үүсвэрээс санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтыг хуульд заасан үндэслэлээр зорилго, хамрах хүрээг тогтоосон удирдамжийг батлан үе шаттайгаар хэрэгжүүлж, гүйцэтгэсний дараа ажлын хэсэг баталгаажуулж, шалгалтын мөрөөр авах арга хэмжээг тушаалаар албажуулж, үр дүнг дотоод нэгжүүд хариуцан ажиллаж ирсэн<sup>25</sup>.

3.50 Гэвч банкны зээлийн дотоод хяналт шалгалтаар<sup>26</sup> зарим зээлдэгчийн үйл ажиллагаанд зөрчилтэй байдал үүссэн, гэрээний үүргийн хэрэгжилт хангалтгүй байсан нь нотлогдож байсан ч хяналт шалгалтын ажлын үр нөлөө хангалтгүй байсан байна.

### Хяналт шалгалтын ажлын гол зорилго!

- “... банкны эх үүсвэрээр санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих ажлын хүрээнд тус банкнаас төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэхэд олгосон зээлийн зарцуулалтыг шалгаж төсөл, хөтөлбөрийн нийгэм, эдийн засгийн үр ашгийн бодит байдал, санхүүгийн нөхцөл байдлыг судалж, зээлийн зарцуулалт, эргэн төлөлт, гэрээний хэрэгжилтийг дүгнэн, зориулалт бусаар ашигласан, үр ашиггүй зарцуулсан зээлийн эх үүсвэрийг буцаан, үр ашигтай эргүүлэн хуваарилах ажлыг зохион байгуулах”-д оршиж байсан.

### Хяналт шалгалтын гол үр дүн юу байв?

- Зээлийн дотоод хяналт шалгалтыг үе шаттайгаар тодорхой удирдамжийн дор гүйцэтгэж, түүнийхээ үр дүнг тайлагнаж байсан байна.
- Гэвч зээлийн дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлснээр зориулалт бусаар ашигласан байж болохуйц болон төслийн үр дүн хангалтгүй, зөрчилтэй зээлийн дүнг тодорхойлон зээлдэгчийн үйл ажиллагаанд үнэлгээ дүгнэлт өгч, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлон шийдвэр гаргасан ч хэрэгжилт хангалтгүй байсан.

3.51 Энэ нь МУХБ-ны ТҮЗ-ийн дэргэдэх болон гүйцэтгэх удирдлага, зохион байгуулалт дахь хяналт шалгалтын чиг үүрэг бүхий нэгжийн чиг үүргийн хэрэгжилт, бүхэлдээ дотоод хяналтын тогтолцоо сул байсантай холбоотой байна.

3.52 Хяналт шалгалтыг эхлүүлэх үед Хөгжлийн банкнаас олгосон зээлээс өнөөгийн байдлаар хэвийн гэсэн ангилалд бүртгэлтэй нийт 26 зээлдэгчийн үндсэн зээл, хүү, тorgуулийн 1,479.6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна гэж мэдээлсэн бөгөөд эдгээр зээлдэгчийн гэрээ, төлбөрийн хуваарьт ямар нэг өөрчлөлт хийгдээгүй байсан.

3.53 Хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй арга хэмжээний хүрээнд чанаргүй зээлийн эргэн төлөлтийг хариуцан тус банкны Экспорт, импорт, худалдааны санхүүжилтийн газар (ЭИХСГ), Төслийн санхүүжилтийн газар (ТСГ), Эрсдэлийн удирдлагын газар (ЭУГ) зээлийн төлөв байдалд хяналт тавин ажиллаж байна.

**Хүснэгт 9. Чанаргүй зээлийн хяналтыг хэрэгжүүлж буй зохион байгуулалтын нэгж**

Экспорт, импорт, худалдааны санхүүжилтийн газар		Төслийн санхүүжилтийн газар		Эрсдэлийн удирдлагын газар	
Зээлдэгчийн нэр	Төлбөрийн үлдэгдэл (тбм.төг)	Зээлдэгчийн нэр	Төлбөрийн үлдэгдэл (тбм.төг)	Зээлдэгчийн нэр	Төлбөрийн үлдэгдэл (тбм.төг)
Говь ХК 1	42.9	Вестерн холд ХХК	86.3	Энсада истерн ХХК	31.9
Говь ХК	33.7	Мак цемент ХХК	133.6	Моннис майнинг ХХК	128.5
Дархан минж ХХК	1.1	Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ	15.3	<b>Түгээмэл түмэн хишиг ХХК</b>	24.8
Дорнын цас ХХК	2.2	ДЦС-4 ТӨХК	245.8	<b>Ачлал трейд ХХК</b>	59.6
Изинис-Эйр вейз ХХК	29.8	Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК	214.9	<b>Империал гоулд майнинг ХХК</b>	15.7
МИАТ ТӨХК	15.1	<b>Эрдэнэс Монгол ХХК</b>	156.5	<b>Монпеллетс ХХК</b>	2.4

<sup>25</sup> Үндэслэл: Банкны тухай хууль болон Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль, зээлдэгчтэй байгуулсан “Зээлийн гэрээ”-ний эрх үүрэг ба хариуцлагатай холбоотой заалтууд

<sup>26</sup> Эх сурвалж: МУХБ-ны Гүйцэтгэх удирдлагын баталсан удирдамжийн дагуу гүйцэтгэсэн ажлын тайлангууд

Вертекс майнинг партнер ХХК	12.3	Дорнод бүсийн ЭХС ТӨХК	32.8	Цэцэнс майнинг ХХК	55.6
Эйч энд Эйч земикон ХХК	1.6	Эгийн гол УЦС ТӨХХК	48.9		
Модун ХХК	4.9	Эрчим хүчний яам	51.3		

Тайлбар: Шар өнгөөр тэмдэглэсэн нь ангилал зөрүүтэй буюу Монголбанкны шалгалтаар ангилал бууруулсан.

3.54 Гэвч хэвийн ангилалд бүртгэлтэй гэх зарим зээлийн чанарын ангилал зөрүүтэй буюу Монголбанкны хяналт шалгалтаар ангиллыг бууруулан үнэлсэн (Модун ХХК, Эрдэнэс Монгол ХХК, Эгийн гол УЦС ТӨХХК, Эрчим хүчний яам, Түгээмэл түмэн хишиг ХХК, Ачлал трейд ХХК, Империал гоулд майнинг ХХК, Монпеллетс ХХК) бөгөөд нөхцөл байдлын судалгаанаас үзэхэд тухайн зээлүүдэд анхаарал хандуулж төслийн явц, эдийн засгийн үр ашгийг хянан үзэх, мөнгөн урсгалын төсөөллийг гаргах, барьцаа хөрөнгийн үнэлгээ, одоогийн нөхцөлийг давтан судалж, эргэн төлүүлэх ажиллагааг нээлттэй болгох шаардлагатай байсан.


Гол асуудал	Санал
<ul style="list-style-type: none"> <li>Монгол Улсын хөгжлийн банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгын 27 дугаар зүйл нь “Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналт” гэснээс өөрөөр хүчин чадлын хувьд өмнөх хуулийн<sup>27</sup> (хүчингүй болсон) заалттай харьцуулахад ялгагдах зүйлгүй, чадамжийг нэмэгдүүлж чадаагүй байна.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулиар тус банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, зээлийн эргэн төлөлтөд тавих хяналтыг сайжруулахад хуулийн уг заалтыг дахин хянан үзэх шаардлагатай байсан.</li> </ul>
<ul style="list-style-type: none"> <li>Хөгжлийн банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгад ил тод байдлын тухайд зүйлчлэхдээ зөвхөн банкны баримтлах зарчим, банкны жилийн эцсийн аудит хийсэн санхүүгийн тайланг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх асуудлыг хөндсөн болохоос зээл олголтын үйл явц, зээлээр санхүүжсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн ил тод байдлыг хангах талаар зохицуулалтгүй байна.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Нэгэнт тусгайлсан хууль батлан мөрдөж байгаа учраас Хөгжлийн банкны эх үүсвэрээр санхүүжүүлсэн хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явцыг хүлээгдэж буй үр дүн, үр өгөөж нь тод харагдахуйц ил тод байдлыг нэхсэн хуулийн тогтоомжийн нэмэлт өөрчлөлт оруулахыг санал болгож байна. Энэ нь хөгжлийн төслүүдийг зарлах, санхүүжүүлэх зээл олголтын болон таагүй үр дагаварт хургэхээс урьдчилан сэргийлэх үйл явцтай ч хамааралтай.</li> </ul>
<ul style="list-style-type: none"> <li>Засгийн газрын 2022 оны 220 дугаар тогтоолоор Төрийн өмчтэй болон төрийн өмчийн оролцоотой зарим хуулийн этгээдийн тус банкнаас авсан зээлийн өр төлбөрийг барагдуулах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын холбогдох гишүүн, хуулийн этгээдийн удирдлагад даалгасан.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 220 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх ч гэсэн тухай зээлийн ашиглалт, зарцуулалтад тусгайлсан шалгалтыг нэн яаралтай гүйцэтгэх нь зүйтэй байсан.</li> </ul>

<sup>27</sup> Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль, 2011 оны 2 дугаар сарын 10-ны өдөр Улсын Их Хурал, Монгол Улс

## Банкны үйл ажиллагааны эрсдэлд суурилсан урт болон дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх шаардлагатай байсан

3.55 Хөгжлийн банкны нийт пассив 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 3.4 их наяд төгрөгтэй тэнцэж байгаа бөгөөд үүнээс 2,732.8 тэрбум төгрөг нь өрийн бичиг, 582.4 тэрбум төгрөг нь бусдаас авсан зээл байна.

Дурслэл 1. Хөгжлийн банкны пассивын бүтэц, 2011-2022 он (тблм.төг)



Эх сурвалж: Монгол Улсын Хөгжлийн банкнаас авсан үзүүлэлтэд суурилав.

3.56 Хөгжлийн банкны хөрөнгийн татан төвлөрүүлэлт 2015 оныг хүртэл эрчимтэй өсөлтийг хадгалж байсан бөгөөд мөн үед активын бүтэц дэх зээл ба урьдчилгаа өндөр өсөлттэй буюу хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гол эх үүсвэр нь болж байсан байна.


3.57 Активын бүтцэд анхаарч зээл олгох үйл ажиллагааны сөрөг үр дагавраас зайлсхийж чадах эцсийн шатны хамгаалалт бүхий итгэл үнэмшил бүхий стратеги, бодлогын хянамгай байдлын талаар хангалттай баримт материал алга байсан.

3.58 2015 он хүртэл татан төвлөрүүлсэн хөрөнгийн хурдацтай өсөлт нь тодорхой хугацааны дараа эргэн төлөлтийн буюу ирээдүйд төлбөрийн чадварын хүндрэл үүсгэж болохыг тухайн үеийн банкны удирдлагуудаас мэдэrsэн байх мэргэжлийн ур чадварыг шаардаж байсан.

3.59 Энэ нь хөгжлийн банкны өөрийн эрх ашгийг илэрхийлэх гүйцэтгэх удирдлага болон банкны эздийн /Засгийн газар/ хооронд тодорхой хил хязгаар бүхий харгалзах зохицуулалт үйлчлээгүй байсантай холбоотой юм.

3.60 Хөгжлийн банкны нийт актив 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 4.2 их наяд төгрөгтэй тэнцэж байна. Үүнээс 62 хувь буюу нийт зээлийн үлдэгдэл 2.6 их наяд төгрөг байгаа бөгөөд тус үзүүлэлт 2012-2021 оны хооронд дунджаар 71 хувьтай тэнцүү байсан байна.

Дурслэл 2. Хөгжлийн банкны активын бүтэц, 2011-2022 он (тблм.төг)



Эх сурвалж: Монгол Улсын Хөгжлийн банкнаас авсан үзүүлэлтэд суурилав.

3.61 Өнгөрсөн хугацаанд зээл олголтын үлдэгдлээс харахад 2015 оны эцсийн байдлаар 4,986.6 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байсан нь түүхэн хугацаанд хамгийн өндөр үзүүлэлттэй байжээ. Дурдсанчлан 2015 оноос хойш активын бүтэц дэх зээлийн багцын чанарт мэдэгдэхүйц өөрчлөлт ажиглагдах бөгөөд энэ үеэс эхлэн чанаргүйдлийн шинж тэмдэг ажиглагдаж эхэлснийг анзаарах ёстой байсан.

3.62 Хэдийгээр өнгөрсөн жилд шууд зээлийг төлүүлэх үйл ажиллагааг ахисан түвшинд гаргаж байгаа ч 2022 оны эцэст чанаргүй зээлийн хэмжээ өсөж, зээлийн багцын чанар муудсан, татан төвлөрүүлсэн хөрөнгийн 2023 оны эргэн төлөлтийн хуваарьт эрсдэл учрахаар байна.

3.63 МУХБ-ны чанаргүй зээлийн харьцаа 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 53.7%-тай тэнцэж байгаа бөгөөд 882.6 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулаад байна.

3.64 Чанаргүй зээлийн харьцаа нь 2021 оноос огцом нэмэгдсэн бөгөөд 2013-2020 оны хооронд дунджаар 11.9%-тай тэнцэж байсантай харьцуулахад сүүлийн жилүүдэд зээлийн бодлого алдагдсан гэж үзэж болно.


Дүрслэл 3. Чанаргүй зээлийн харьцаа болон зээлийн эрсдэлийн сангийн хэмжээ, 2011-2022 он (тбм.төг)



Эх сурвалж: Монгол Улсын Хөгжлийн банкнаас авсан үзүүлэлттэд суурилав.

3.65 Хөгжлийн банк 2023 онд нийт 3,620.1 тэрбум төгрөгтэй тэнцэх татан төвлөрүүлсэн хөрөнгийн төлбөр төлөх хуваарьтай байгаа бөгөөд үүнд зээлийн эргэн төлөлтийн байдал, валютын ханшийн өөрчлөлт сөрөг нөлөө үзүүлэхээр байна.

Дүрслэл 4. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн эргэн төлөлтийн хуваарь (2023 он, 2024-2031 он, тбм.төг)



Эх сурвалж: Монгол Улсын Хөгжлийн банкнаас авсан үзүүлэлттэд суурилав.

3.66 Монгол Улсын Хөгжлийн банкнаас авсан үзүүлэлттэд суурилан Монголбанкнаас /2022.12.31-ний өдрийн/ зарласан албан ханшийг ашиглан валютын зээлийн эргэн

төлөлтийг хөрвүүлснээр тус онд үндсэн валютаар 539.5 сая ам.доллар, 30 тэрбум иен, 143.6 сая евро, 443.7 тэрбум төгрөг, 6.4 сая юанийн зээл буюу бондын төлбөрийг тухайн валютаар төлөхөөр байна.


3.67 Харин 2024-2031 оны хооронд нийт 366.4 төгрөгтэй тэнцэх евро, төгрөг, юанийн эх үүсвэрийг төлөх хуваарьтай байна.

#### **Монгол Улсын Хөгжлийн банк мөнгөн хөрөнгийн удирдлагыг зохистой хэрэгжүүлээгүй**

3.68 МУХБ 2011 оноос үйл ажиллагааг эхлүүлснээс хойших хугацаанд нийт 7.4 их наяд төгрөгтэй тэнцэх эх үүсвэрийг олон улсын зах зээлд бонд арилжаалах, банк санхүүгийн байгууллагаас зээл авах, Засгийн газрын санхүүжилт авах зэргээр татан төвлөрүүлсэн байна.

3.69 Олон улсын болон дотоодын зах зээлд нийт 6 удаагийн бонд гаргасан бөгөөд хугацааны хувьд болон активын бүтэцтэй харьцуулахад 2013-2015 онд нийт олгосон зээлийн 50-60 хувийг эзэлж байна.

Дурслэл 5. Хөгжлийн банкны бонд, нийт актив, хадгаламжийн харьцуулалт (үндсэн валют)



Эх сурвалж: Монгол Улсын Хөгжлийн банкнаас авсан үзүүлэлтэд суурилав.

3.70 МУХБ-ны 2011-2023 оны хооронд нийт гадаад валютаар татан төвлөрүүлсэн хөрөнгийн хувьд жигнэсэн дундаж хүүгийн хэмжээ нь жигнэсэн дундаж бодит өртгөөс 0.6-2.9 нэгжээр нэмэгдсэн, нийт эх үүсвэрийн жигнэсэн дундаж хугацаа 4.8 жил байна.

Хүснэгт 10. Хөгжлийн банкны татан төвлөрүүлсэн хөрөнгийн бодит зардлын үзүүлэлт

Валют	ЖДХҮҮ	ЖД бодит өртөг	Татан төвлөрүүлсэн дүн /сая валют/	ЖДХугацаа /жил/
MNT	5.34%	5.34%	2,453,664.5	3.88
USD	6.04%	6.64%	2,082.3	4.63
EUR	3.86%	4.35%	139.6	3.97
JPY	1.52%	4.40%	30,000.00	10.00
CNY	5.10%	6.10%	420.0	9.51
Нийт /сая төгрөг/			7,398,851.0	4.80

3.71 МУХБ-наас 2012-2023 оны хооронд санхүүжүүлсэн нийт төсөл хөтөлбөрийн жигнэсэн дундаж хүүгийн түвшин тухайн валютаарх эх үүсвэрийн бодит өртгөөс 1.5-5.8 нэгж байгаа, банкны нийт актив, пассивын дундаж хугацааны зөрүү нь нийт активын дундаж хугацааны 30 хувиас хэтэрсэн байгаа нь төлбөрийн эрсдэл үүссэн байгааг харуулж байна.

**Хүснэгт 11. Хөгжлийн банкны хаагдсан болон үлдээгдэлтэй шууд зээлийн багц (ундсэн валют, хугацаа)**

Валют	ЖДХүү	Олгосон дүн /тэрбум төгрөг/	Олгосон дүн /сая валют/	ЖДХугацаа /жил/
MNT	11.13%	1,137.05	1,137,045.9	6.93
USD	8.41%	1,611.2	897.1	7.30
EUR	5.37%	357.9	121.8	8.09
JPY	6.88%	149.4	7,211.5	6.36
CNY	7.63%	37.5	81.5	10.01
Нийт /тэрбум төгрөг/			3,303.0	7.27

**Мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн зохицуулалт**

3.72 Банкнаас 2015 он хүртэл мөнгөн хадгаламжийн үйл ажиллагааны журмыг батлуулаагүй байсан бөгөөд хадгаламжийн үйл ажиллагааг тодорхой, оновчтой болгох зорилгоор Гүйцэтгэх захирлын 2015 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А-16 дугаар тушаалын хавсралтаар “МУХБ-наас арилжааны банкуудад хадгаламж байршуулах, татан төвлөрүүлэх журам”-ыг батлан мөрдөж ажилласан.

3.73 Энэхүү батлагдсан журмаар хадгаламж байршуулах, буцаан татах шийдвэр гаргах, эрхийн хязгаарлалтуудыг тогтоох, эх үүсвэрийн чөлөөт мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг ямар шалгуураар арилжааны банкуудад байршуулах, банк хоорондын захаас богино хугацаат эх үүсвэр татан төвлөрүүлэх үйл ажиллагааг зохицуулж ирсэн.

3.74 Түүнчлэн журмаар арилжааны банкны санхүүгийн байдалд эрсдэлийн үнэлгээ хийх, хэдий хэмжээний мөнгөн хадгаламж байршуулах, хэмжээ тогтоох аргачлалыг баталж, үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж байсан байна.

3.75 Дээрх журам нь 2017 оны 5 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан бөгөөд Гүйцэтгэх захирлын тухайн өдрийн А-69/1 дугаар тушаалаар “Хөгжлийн банкнаас дотоодын арилжааны банкуудад байршуулах мөнгөн хадгаламжийн дээд хэмжээ буюу хязгаарлалтыг тухайн банкны нийт активын 10 хувьтай тэнцүү байхаар” тогтоосон ба гүйцэтгэх захирлын 2015 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А-16 дугаар тушаалын хавсралтаар баталсан “МУХБ-наас арилжааны банкуудад хадгаламж байршуулах, татан төвлөрүүлэх журам”-ыг хүчингүй болгосон байдаг.

3.76 Мөн гүйцэтгэх захирлын 2017 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн А-269 дугаар тушаалаар “Мөнгөн хадгаламж байршуулах үйл ажиллагааны журам”-ыг шинээр баталсан бөгөөд өмнөх журамтай харьцуулбал мөнгөн хадгаламж буцаан татахад байршуулсан мөнгөн хадгаламжийн гэрээний хугацаа дуусах хугацаанаас өмнө бүтэн болон хэсэгчилсэн дүнгээр мөнгөн хадгаламжийн хүүгийн хамтаар эргэн төлүүлэх гэж тусгасан.

3.77 Түүнчлэн мөнгөн хадгаламж байршуулахад “банкнаас хадгалагчид байршуулсан мөнгөн хадгаламжийн хэмжээ нь хадгаламжийн тайлант хугацааны нийт активын 12%-иас хэтрэхгүй байх” зэрэг тодорхой заалтуудыг тусгасан байна.

3.78 Одоогийн мөрдөж буй “Мөнгөн хадгаламж байршуулах үйл ажиллагааны журам” нь гүйцэтгэх захирлын 2019 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн А-179 дугаар тушаалаар батлагдсан бөгөөд журмын хавсралтаар “Байршуулах хадгаламж болон харилцахын хязгаарлалтын хэмжээг тогтоох аргачлал”-ыг баталсан байна.

**Арилжааны банкуудад байршуулсан мөнгөн хадгаламж:**

3.79 МУХБ-ны удирдлага мөнгөн хөрөнгийн удирдлагыг зохистой хэрэгжүүлээгүй нь Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуульд /2011 он, 2017 он/ заасан ашигтай ажиллах заалтыг хангаж ажиллаагүй, орлого олох боломжийг алдахад хүргэсэн байна.

3.80 ЗГҮЦ-ны өгөөж 2014 оны 10 дугаар сард 15.538-16.15 хувь байхад Улаанбаатар хотын банк, Худалдаа хөгжлийн банкны эзэмшиж байсан 11.0-11.5 хувийн хүүтэй нийт 55.0 тэрбум төгрөгийн ЗГҮЦ-ыг худалдан авснаас 1.7 тэрбум төгрөгийн орлого олох боломж байсан.


3.81 2012-2022 оны хугацаанд арилжааны банкуудад зарим төгрөгийн хадгаламжийг Монголбанкны бодлогын хүүгийн түвшнээс 0.05-5.25 пунктээр бага хүүтэйгээр байршуулснаас нийт 35.3 тэрбум төгрөг, валютын хадгаламжийг эх үүсвэрийн хүүгийн

түвшнээс 0.25-3.75 пунктээр бага хүйтэй байршуулснаас нийт 21.6 тэрбум төгрөгийн орлого олох боломжийг тус тус алдсан гэсэн тооцоолол гарч байна.

- Тухайлбал, Худалдаа хөгжлийн банкнаас 7.5 хувийн хүйтэй, 232 хоногийн хугацаатайгаар татсан 78.5 сая ам.долларыг Голомт банканд 3 хувийн хүйтэй, 31 хоногийн хугацаатайгаар;
- Монголбанкны бодлогын хүү 12 хувь байхад Улаанбаатар хотын банканд 117.7 тэрбум төгрөгийг 10.5 хувийн хүйтэй, 178 хоногийн хугацаатайгаар;
- Монголбанкны бодлогын хүү 10.5 хувь байхад Худалдаа хөгжлийн банканд 179.4 тэрбум төгрөгийг 9.3 хувийн хүйтэй, 94 хоногийн хугацаатайгаар тус тус байршуулсан байна.

3.82 МУХБ-наас арилжааны 14 банканд байршуулсан мөнгөн хадгаламжийн үйл ажиллагааны хувьд 3642 ширхэг мөнгөн хадгаламжийн гэрээ байгуулсан бөгөөд 2012-2022 оны хугацаанд арилжааны банкуудад зарим төгрөгийн хадгаламжийг Монголбанкны бодлогын хүүгийн түвшнээс 0.05-5.25 пунктээр бага хүйтэйгээр байршуулснаас нийт 35.3 тэрбум төгрөг, валютын хадгаламжийг эх үүсвэрийн хүүгийн түвшнээс 0.25-3.75 пунктээр бага хүйтэй байршуулснаас ойролцоогоор 21.6 тэрбум төгрөгийн орлого олох боломжийг тус тус алдсан байна.

#### Дурслэл 6. Байршуулсан мөнгөн хадгаламжийн үүссэн алдагдсан боломжийн зардал



3.83 Төв банкны богино хугацаат үнэт цаасыг банкууд 7 хоног бүр өөрийн хүссэн хэмжээгээр худалдаж авах боломжтойгоос гадна уг үнэт цаасны хүү нь бодлогын хүү болдог бөгөөд ТБҮЦ нь 100% баталгаатай эргэн төлөгддөг, хөрвөх чадвар хамгийн өндөртэй үнэт цаас байдаг тул санхүүгийн шинжилгээнд зах зээлийн жишиг хүү болгон ашигладаг.

3.84 Банкуудын үйл ажиллагаанаас илүүдсэн эсвэл дутагдсан эх үүсвэрийг банкууд хоорондоо байршуулж ажилладаг бөгөөд уг байршуулж буй эх үүсвэрийн жигнэсэн дундаж хүйтэй МУХБ-ны байршуулж буй хадгаламжийн хүүг харьцуулах боломжтой юм.

3.85 Гэвч МУХБ нь арилжааны банкны үйл ажиллагаанаас ялгаатай, байршуулж буй хадгаламжийн хэмжээ өндөр зэргээс шалтгаалан бодлогын хүйтэй хадгаламжийн хүүг жиших байдлаар тооцоолох нь зүйтэй гэж үзсэн.

3.86 МУХБ нь 2011 оноос 2022 оныг хүртэл холбогдох журмын хүрээнд жилд дунджаар 388.8 тэрбум наяд төгрөг, 167.8 сая ам.доллар, 31.3 сая евро болон 6.9 тэрбум иенийн нийт 3642 ширхэг мөнгөн хадгаламжийг Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлдэг дотоодын 14 арилжааны банкуудад байршуулсан ажилласан байна.

3.87 Банкнаас байршуулсан мөнгөн хадгаламжийн өрөнхий мэдээллийг валют тус бүрээр нь нэгтгэн үзэхэд дараах байдалтай байна.

**Хүснэгт 12. Хөгжлийн банкнаас байршуулсан мөнгөн хадгаламж (ундсэн валютаар)**

Валют	Төгрөг	Ам.доллар	Евро	Иен
Байгуулсан нийт хадгаламжийн гэрээний тоо	2815	486	120	221
Нийт хэмжээ	₮ 388.87 тэрбум	\$ 167.84 сая	€ 31.27 сая	¥ 6.93 тэрбум
ЖДХүү	11.29%	5.63%	7.38%	4.11%
ЖДХугацаа	39 хоног	47 хоног	26 хоног	133 хоног

**Хүснэгт 12.1. Хөгжлийн банкнаас арилжааны банкуудад байршуулсан төгрөгийн хадгаламж**

№	Банк	Хадгаламжийн тоо	Байршуулсан нийт хэмжээ /тэрбум ₮/*	ЖДХүү	ЖДХугацаа
1	ХХБ	434	91.33	11.38%	34
2	УБХБ	342	70.91	13.23%	31
3	Хаан Банк	246	71.39	11.40%	47
4	Богд Банк	9	3.39	11.75%	137
5	ТХБ	108	7.00	11.14%	28
6	Капитрон Банк	123	6.81	13.50%	31
7	Чингис Хаан Банк	438	18.07	12.00%	26
8	Хас Банк	119	37.58	10.93%	59
9	Голомт Банк	202	27.47	11.05%	31
10	Кредит Банк	1	0.00	11.00%	2
11	Капитал Банк	108	5.32	12.56%	26
12	Хадгаламж Банк	21	2.48	10.23%	45
13	ҮХОБанк	180	3.91	13.73%	23
14	Төрийн Банк	484	43.20	12.72%	26
<b>Нийт</b>		<b>2815</b>	<b>388.87 тэрбум ₮</b>	<b>11.29%</b>	<b>39 хоног</b>

\*Тайлбар: 2011-2022 оны хугацаанд Хөгжлийн банкнаас нэг жилд дунджаар байршуулсан төгрөгийн мөнгөн хадгаламжийн дүн

**Хүснэгт 12.2. Хөгжлийн банкнаас арилжааны банкуудад байршуулсан ам.долларын хадгаламж**

№	Банк	Хадгаламжийн тоо	Байршуулсан нийт хэмжээ /сая ам.доллар/*	ЖДХүү	ЖДХугацаа
1	Худалдаа Хөгжлийн Банк	28	15.38	6.12%	55
2	Улаанбаатар Хотын Банк	42	11.46	6.32%	76
3	Хаан Банк	66	21.27	6.02%	103
4	Богд Банк	9	0.80	6.60%	44
5	Капитрон Банк	46	71.85	5.89%	29
6	Чингис Хаан Банк	25	0.53	7.14%	34
7	Хас Банк	46	14.47	6.13%	75
8	Голомт Банк	49	23.44	5.20%	91
9	Капитал Банк	46	1.90	7.47%	26
10	Хадгаламж Банк	10	0.85	4.71%	36
11	ҮХОБанк	42	0.85	5.96%	37
12	Төрийн Банк	77	5.03	6.40%	27
<b>Нийт</b>		<b>486</b>	<b>167.84 сая ам.доллар</b>	<b>5.63%</b>	<b>47 хоног</b>

\*Тайлбар: 2011-2022 оны хугацаанд Хөгжлийн банкнаас нэг жилд дунджаар байршуулсан ам.долларын мөнгөн хадгаламжийн дүн

**Хүснэгт 12.3. Хөгжлийн банкнаас арилжааны банкуудад байршуулсан өврөгийн хадгаламж**

№	Банк	Хадгаламжийн тоо	Байршуулсан нийт хэмжээ /сая өврөг/*	ЖДХүү	ЖДХугацаа
1	Худалдаа Хөгжлийн Банк	1	0.05	3.75%	28
2	Улаанбаатар Хотын Банк	14	28.23	7.02%	76
3	Хаан Банк	5	0.28	3.60%	41
4	Чингис Хаан Банк	4	0.04	5.71%	30
5	Хас Банк	1	0.00	5.50%	1
6	Голомт Банк	24	1.22	6.54%	72
7	Капитал Банк	42	0.88	8.48%	53
8	ҮХОБанк	27	0.40	7.29%	45
9	Төрийн Банк	2	0.17	7.13%	51
<b>Нийт</b>		<b>120</b>	<b>31.27 сая өврөг</b>	<b>7.38%</b>	<b>26 хоног</b>

\*Тайлбар: 2011-2022 оны хугацаанд Хөгжлийн банкнаас нэг жилд дунджаар байршуулсан өврөгийн мөнгөн хадгаламжийн дүн

**Хүснэгт 12.4. Хөгжлийн банкнаас арилжааны банкуудад байршуулсан иенний хадгаламж**

№	Банк	Хадгаламжийн тоо	Байршуулсан нийт хэмжээ /сая иен/*	ЖДХҮУ	ЖДХугацаа
1	Худалдаа Хөгжлийн Банк	33	2,663.28	4.78%	162
2	Улаанбаатар Хотын Банк	18	1,559.60	5.68%	155
3	Хаан Банк	30	629.37	1.89%	106
4	Тээвэр Хөгжлийн Банк	2	142.38	5.15%	274
5	Капитрон Банк	7	44.47	3.93%	53
6	Чингис Хаан Банк	21	13.38	2.52%	12
7	Хас Банк	30	370.04	3.27%	78
8	Голомт Банк	33	1,252.11	3.62%	109
9	Капитал Банк	25	221.35	5.60%	57
10	ҮХОБанк	22	30.40	5.00%	48
<b>Нийт</b>		<b>221</b>	<b>6,926.38 сая иен</b>	<b>4.11%</b>	<b>133 хоног</b>

\*Тайлбар: 2011-2022 оны хугацаанд Хөгжлийн банкнаас нэг жилд дунджаар байршуулсан иенийн мөнгөн хадгаламжийн дүн

**Гэрээний хугацаанаас өмнө буцаан дуудсан мөнгөн хадгаламж**

3.88 Арилжааны банкуудад мөнгөн хадгаламж байршуулах харилцаа 2015 оны 2 дугаар сарыг хүртэл нарийвчилсан зохицуулалтгүйгээс зарим мөнгөн хадгаламжийн гэрээнд хадгаламжийг бутнээр болон хэсэгчлэн буцаан татах үед тооцох хүүг үндсэн хүүгээс бага байхаар тусгаж байжээ.

3.89 МУХБ арилжааны банкуудад байршуулсан мөнгөн хадгаламжийг үндэслэлгүйгээр хугацаанаас нь өмнө буцаан татсан, мөнгөн хадгаламжийг буцаан татах үеийн хүүгийн зөрүүг хамгийн бага түвшинд байлгах бодлого баримтлаагүй зэргээс нийт 4.2 тэрбум төгрөг, 713 мянган ам.долларын хүүгийн орлого олох боломжийг алдсан гэсэн тооцоолол гарч байна.

3.90 Тухайлбал, 2013, 2014 онд нийт 121.7 тэрбум төгрөгийн 26 мөнгөн хадгаламж, 10.0 тэрбум иений 2 мөнгөн хадгаламжийг хугацаанаас нь өмнө буцаан татсанаас шалтгаалж 1.9 тэрбум төгрөг, 168.0 сая иений хүүгийн орлого олох боломжийг тус тус алдсан бөгөөд хадгаламж буцаан татсан тухайн өдрүүдэд МУХБ-наас бусад арилжааны банкуудад нийт 584.2 тэрбум төгрөг, 9.9 тэрбум иений мөнгөн хадгаламж байршуулж байсан нь буцаан татах хэрэгцээ шаардлага байгаагүй харуулж байна.

3.91 Хөгжлийн банк 2011 оноос 2020 он хүртэлх хугацаанд арилжааны банкуудад байршуулсан мөнгөн хөрөнгийг хугацаанаас нь өмнө татах тохиолдол их байсан бөгөөд иений мөнгөн хадгаламжийн хувьд нийт дүнгийн 68.0 хувийг гэрээнд заасан хугацаанаас өмнө буцаан дуудсан бөгөөд мөнгөн хадгаламжийн гэрээний дагуу олох байсан хүүгийн орлогын 70.5 хувийг олсон байна.

3.92 Мөнгөн хадгаламжийн гэрээний дагуу олох байсан хүүгийн орлогын хэмжээ хугацаанаас нь өмнө буцаан дуудсанаар олсон хүүгийн орлогын хэмжээнээс төгрөгийн хадгаламжийн хувьд 14.79 тэрбум төгрөг, ам.долларын хадгаламжийн хувьд 3.17 сая ам.доллар, европийн хадгаламжийн хувьд 13.5 мянган евро байгаа бол иений хадгаламжийн хувьд 1.2 тэрбум иенээр бага байна.

**Хүснэгт 13. Хөгжлийн банкны мөнгөн хадгаламжийн гэрээний дагуу олох байсан хүүгийн орлого болон банкны олсон хүүгийн орлогын зөрүү**

Валют	Төгрөг	Ам.доллар	Евро	Иен
Байгуулсан нийт хадгаламжийн гэрээний тоо	280	79	11	48
Нийт хэмжээ	₮ 2.16 их наяд	\$ 500.36	€ 16.0 сая	¥ 60.87 тэрбум
Буцаан дуудаагүй тохиолдолд тооцох ЖДХҮУ	11.81%	5.27%	7.25%	4.81%
Буцаан дуудсан тохиолдолд тооцох ЖДХҮУ	10.69%	4.74%	7.04%	4.18%
Буцаан дуудаагүй тохиолдолд олох байсан хүүгийн орлого /гэрээний дагуу/	41.88 тэрбум ₮	6.82 сая \$	537.10 мянган €	1.70 тэрбум ¥
Буцаан дуудсанаас шалтгаалан олсон хүүгийн орлого	26.91 тэрбум ₮	3.65 сая \$	401.83 мянган €	0.5 тэрбум ¥
Зөрүү	-14.97 тэрбум ₮	-3.17 сая \$	-13.5 мянган €	-1.20 тэрбум ¥

3.93 Түүнчлэн 2011 оноос 2016 оныг дуустал Хөгжлийн банк нь арилжааны банкуудтай мөнгөн хадгаламж байршуулахдаа гэрээний хугацаанаас өмнө буцаан дуудсан тохиолдолд хадгаламжид тооцох хүү нь анх гэрээнд тусгасан хүүгийн түвшингээс буурах нөхцөлтэй гэрээг байгуулж иржээ.

3.94 Дээрх нөхцөл хэрэгжиж байх хугацаанд банк нь төгрөгийн 61 хадгаламж, ам.долларын 15 хадгаламж, еврогийн 1 хадгаламж, иений 12 хадгаламж буюу нийт 89 хадгаламжийг хугацаанаас өмнө буцаан дуудаж гэрээний нөхцөлөөс бага хүүгийн орлого олсон байдаг. Байршуулсан хугацаагаар гэрээнд дурдсан үндсэн хүүгээр олох байсан хүүгийн орлого болон банкны олсон хүүгийн орлогын зөрүүг тусгав.

*Хүснэгт 14. Гэрээний нөхцөлөөр олох байсан хүүгийн орлого болон банкны олсон хүүгийн орлогын зөрүү*

Валют	Төгрөг	Ам.доллар	Евро	Иен
Байгуулсан нийт хадгаламжийн гэрээний тоо	61	15	1	12
Нийт хэмжээ	₮ 1.11 их наяд	\$ 218.3	€ 2.5 сая	¥ 39.9 тэрбум
Буцаан дуудаагүй тохиолдолд тооцох ЖДХүү	10.60%	5.01%	6.45%	4.74%
Буцаан дуудсан тохиолдолд тооцох ЖДХүү	8.48%	3.78%	5.2%	3.78%
Буцаан дуудаагүй тохиолдолд олох байсан хүүгийн орлого /байршуулсан хугацаагаар/	20.4 тэрбум ₮	1.84 сая \$	50 мянган €	349.87 сая ¥
Буцаан дуудсанаас шалтгаалан олсон хүүгийн орлого	16.1 тэрбум ₮	1.44 сая \$	40 мянган €	279.3 сая ¥
<b>Зөрүү</b>	<b>-4.2 тэрбум ₮</b>	<b>-399.0 мянган \$</b>	<b>-10 мянган €</b>	<b>-70.59 сая ¥</b>

#### **Гэрээний хугацаанд төлөгдөөгүй мөнгөн хадгаламж**

3.95 Хөгжлийн банк нь 2011 оноос хойш 2022 оныг хүртэл мөнгөн хадгаламж байршуулах үйл ажиллагааг авч хэрэгжүүлэхэд гэрээний дагуу хугацаандаа төлөгдөөгүй 2 мөнгөн хадгаламж, хугацаанаас өмнө буцаан дуудах мэдэгдэл өгөхөд дуудсан огноогоор төлөгдөөгүй алданги үүссэн 9 мөнгөн хадгаламжийн тохиолдол үүссэн байна.

3.96 МУХБ-ны Хөрөнгө удирдлагын хорооны 2019 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 19/01/29 дүгээр дүгнэлтийг үндэслэн Чингис хаан банканд 10.0 тэрбум болон 15.0 тэрбум төгрөгийн нийт 25.0 тэрбум төгрөгийн 2 ширхэг мөнгөн хадгаламжуудыг байршуулж, тухайн хадгаламжуудын хугацаа 2020 оны 3 дугаар сарын 20-ны өдөр дууссан боловч одоог болтол буцаан татаж чадаагүй байна.

*Хүснэгт 15. Хөгжлийн банкны буцаан төвлөрүүлж чадаагүй хадгаламжийн улдээгдэл /тбм. төг/*

Утга	Хадгаламж 1	Хадгаламж 2
Үндсэн дүн	15.0	10.0
Хүүгийн дүн	0.4	0.25
Хугацаандаа төлөөгүйд тооцсон алданги	7.7	5.1
Дүн	<b>23.1</b>	<b>15.4</b>
<b>Нийт</b>		<b>38.5</b>

3.97 Хөгжлийн банкны хувьцаа эзэмшигчээс 2020 оны 05 дугаар сард арилжааны банкуудад байршуулсан мөнгөн хадгаламжийн төвлөрлийг бууруулах, буцаан татан төвлөрүүлэх талаарх чиглэл өгсний дагуу Худалдаа хөгжлийн банк, Улаанбаатар хотын банк, Капитрон банк, Тээвэр Хөгжлийн банкуудад байршуулсан хадгаламжийг хугацаанаас өмнө буцаан дуудах мэдэгдэл өгч ажилласан.

Хүснэгт 16. Хөгжлийн банкны буцаан дуудсан хадгаламжийн мэдээлэл

Банк	Валют	Дүн тэрбум нэгж	Хүү	Эхлэх	Дуусах	Буцаан дуудсан огноо	Төлсэн огноо	Алданги төлсэн эсэх
УБХБ	Төгрөг	15	12.5%	2020/02/19	2020/05/19	2020/05/18	2020/05/18	Үгүй
Капитрон	Төгрөг	5	13.2%	2020/02/20	2020/05/25	2020/05/18	2020/05/25	Тийм
ТХБ	Төгрөг	30	12.5%	2019/12/16	2020/06/15	2020/05/18	2020/06/30	Шүүхийн шатанд
ХХБ	Төгрөг	25	12.5%	2019/12/30	2020/06/18	2020/05/18	2020/06/18	Үгүй
ХХБ	Төгрөг	25	12.5%	2019/12/30	2020/06/25	2020/05/18	2020/06/25	Үгүй
ХХБ	Төгрөг	20	12.5%	2019/12/31	2020/07/01	2020/05/18	2020/07/01	Үгүй
ХХБ	Төгрөг	30	12.5%	2020/02/14	2020/08/12	2020/05/18	2020/08/12	Үгүй
УБХБ	Иен	1	4.0%	2020/03/03	2020/08/10	2020/06/02	2020/07/10	Үгүй
ТХБ	Иен	0.85	4.5%	2020/02/10	2020/08/10	2020/06/02	2020/08/10	Шүүхэд
Нийт	Төгрөг	150.0	12.52%	-	-	2020/05/18	-	-
	Иен	1.85	4.23%			2020/06/02		

Арилжааны банкуудаас татан төвлөрүүлсэн мөнгөн хадгаламж

3.98 МУХБ нь 2012-1015 онд төлбөрийн чадварын үзүүлэлт хангалттай байх үед арилжааны банкуудаас мөнгөн хадгаламж татах нийт 18.9 тэрбум төгрөгийн хүүгийн зардал үүсгэсэн байна.

Дүрслэл 7. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа үзүүлэлт



Дүрслэл 8. Банкны тогтвортой санхүүжилтийн харьцаа



3.99 Татан төвлөрүүлсэн мөнгөн хадгаламжийн хувьд 2011-2022 оны хугацаанд нийт 16 гаднын болон дотоодын банк, санхүүгийн байгууллагуудаас жилд дунджаар 923.9 сая төгрөг, 150.8 сая ам.доллар болон 9.4 сая европийн нийт 582 ширхэг мөнгөн хадгаламжийн гэрээг байгуулан ажилласан байна.

Хүснэгт 17. Хөгжлийн банкны татан төвлөрүүлсэн мөнгөн хадгаламжийн ерөнхий мэдээлэл /үндсэн валют/

Валют	Төгрөг	Ам.доллар	Евро
Байгуулсан нийт хадгаламжийн гэрээний тоо	65	402	115
Нийт хэмжээ	₮ 923.98 сая	\$ 150.81 сая	€ 9.4 сая
ЖДХҮҮ	10.36%	6.13%	3.78%
ЖДХугацаа	4 хоног	129 хоног	70 хоног

3.100 Банк болон валют тус бүрээр дэлгэрүүлэн авч үзвэл дараах байдалтай байгаа болно.

Хүснэгт 17.1. Хөгжлийн банкны татан төвлөрүүлсэн төгрөгийн хадгаламж, арилжааны банкуудаар

№	Банк	Хадгаламжийн тоо	Байршуулсан нийт хэмжээ /сая ₮/*	ЖДХҮҮ	ЖДХугацаа
1	Худалдаа Хөгжлийн Банк	7	262.72	10%	3
2	Улаанбаатар Хотын Банк	5	92.23	11%	4
3	Хаан Банк	11	24.66	11%	1
4	Хас Банк	15	124.94	11%	2
5	Голомт Банк	13	299.21	9%	5
6	Төрийн Банк	14	120.23	12%	9
<b>Нийт</b>		<b>65</b>	<b>923.98</b>		

\*Тайлбар: 2011-2022 оны хугацаанд Хөгжлийн банкнаас нэг жилд дунджаар татан төвлөрүүлсэн төгрөгийн мөнгөн хадгаламжийн дүн

## Хүснэгт 17.2. Хөгжлийн банкны татан төвлөрүүлсэн ам.долларын хадгаламж, арилжааны банкуудаар

№	Банк	Хадгаламжийн тоо	Байршуулсан нийт хэмжээ /сая ам.доллар/*	ЖДХҮҮ	ЖДХугацаа
1	Худалдаа Хөгжлийн Банк	14	50.78	6%	325
2	Улаанбаатар Хотын Банк	16	4.68	6%	82
3	Хaan Банк	101	37.45	6%	102
4	Богд Банк	13	1.20	7%	77
5	Капитрон Банк	60	2.20	6%	30
6	Чингис Хaan Банк	2	0.00	2%	1
7	Хас Банк	52	22.51	6%	91
8	Голомт Банк	33	10.24	5%	86
9	Үндэсний Хөрөнгө Оруулалтын Банк	12	0.46	5%	50
10	Төрийн Банк	72	10.32	6%	59
11	Eugene Investment & Securities Co.Ltd	5	2.62	6%	183
12	International Bank Economic Co-Operation	6	1.17	4%	166
13	Daishin Securities Co., Ltd	3	1.80	8%	181
14	Mirae Asset Daewoo Co., Ltd	7	4.27	7%	182
15	Shinhan Investment Corp	2	0.57	9%	183
16	Sk Securities Co., Ltd	4	0.55	8%	183
<b>Нийт</b>		<b>402</b>	<b>150.81</b>		

\*Тайлбар: 2011-2022 оны хугацаанд Хөгжлийн банкнаас нэг жилд дунджаар татан төвлөрүүлсэн ам.долларын мөнгөн хадгаламжийн дүн

## Хүснэгт 17.3. Хөгжлийн банкны татан төвлөрүүлсэн өврөгийн хадгаламж, арилжааны банкуудаар

№	Банк	Хадгаламжийн тоо	Байршуулсан нийт хэмжээ /сая евро/*	ЖДХҮҮ	ЖДХугацаа
1	ХХБ	5	0.27	6%	29
2	УБХБ	15	0.58	5%	19
3	Хaan Банк	1	0.00	6%	1
4	Богд Банк	6	0.05	5%	7
5	Капитрон Банк	1	0.01	5%	30
6	Чингис Хaan Банк	1	0.17	6%	87
7	Хас Банк	86	8.34	4%	129
<b>Нийт</b>		<b>115</b>	<b>9.42</b>		

\*Тайлбар: 2011-2022 оны хугацаанд Хөгжлийн банкнаас нэг жилд дунджаар татан төвлөрүүлсэн өврөгийн мөнгөн хадгаламжийн дүн

3.101 МУХБ мөнгөн хөрөнгийн удирдлагыг зохистой хэрэгжүүлээгүйгээс өнгөрсөн хугацаанд банкны хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээний түвшинд урт хугацааны төлбөрийн чадварын үзүүлэлтийг актив, пассивын хугацааны зөрүүний шинжилгээтэй уялдуулж ажиллаагүй байна.

- **Нийт актив, пассивын жигнэсэн дундаж хугацаа сөрөг 2.5 жил байгаа нь мөнгөн урсгалын зөрүү дунджаар сөрөг болж, төлбөрийн чадварын хүндрэлд орох эрсдэлийг бий болгосон байна.**
- **Актив, пассивын нийт жигнэсэн дундаж хүүний зөрүү валютын хувьд 1.02-2.48 нэгжийн зөрүүтэй байгаа, эргээд хугацааны хувьд сөрөг байгаа нь ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн байна.**

3.102 МУХБ-наас арилжааны банканд байршуулсан мөнгөн хадгаламжийн үйл ажиллагааны хувьд,

- **МУХБ-наас арилжааны 14 банканд байршуулсан мөнгөн хадгаламжийн үйл ажиллагааны хувьд 3642 ширхэг мөнгөн хадгаламжийн гэрээ байгуулсан бөгөөд 2012-2022 оны хугацаанд арилжааны банкуудад зарим төгрөгийн хадгаламжийг Монгол банкны бодлогын хүүгийн түвшнээс 0.05-5.25 пунктээр бага хүүтэйгээр байршуулснаас ойролцоогоор 35.3 тэрбум төгрөг, валютын хадгаламжийг эх үүсвэрийн хүүгийн түвшнээс 0.25-3.75 пунктээр бага хүүтэй байршуулснаас ойролцоогоор 21.6 тэрбум төгрөгийн орлого олох боломж алдсан.**

- МУХБ болон түүний охин компаниудаас Чингис хаан банканд байршуулсан ойролцоогоор 39.9 тэрбум төгрөгийн мөнгөн хадгаламжууд хугацаандаа төлөгдөөгүй, шүүхэд хандсан байна.

3.103 Арилжааны банкуудаас татсан мөнгөн хадгаламжийн үйл ажиллагааны хувьд,

- Татан төвлөрүүлсэн мөнгөн хадгаламжийн хувьд 2011-2022 оны хугацаанд нийт 16 гаднын болон дотоодын банк, санхүүгийн байгууллагуудаас жилд дунджаар 923.9 сая төгрөг, 150.8 сая ам.доллар болон 9.4 сая еврогийн нийт 582 ширхэг мөнгөн хадгаламжийн гэрээг байгуулан ажилласан байх бөгөөд МУХБ нь 2012-1015 онуудад төлбөрийн чадварын үзүүлэлт хангалттай байх үед арилжааны банкуудаас мөнгөн хадгаламж татаж нийт 18.9 тэрбум төгрөгийн хүүгийн зардал үүсгэсэн.

3.104 Гэрээний хугацаанаас өмнө буцаан дуудсан мөнгөн хадгаламжийн хувьд,

- МУХБ арилжааны банкуудад байршуулсан мөнгөн хадгаламжийг үндэслэлгүйгээр хугацаанаас нь өмнө буцаан татсан, мөнгөн хадгаламжийг буцаан татах үеийн хүүгийн зөрүүг хамгийн бага түвшинд байлгах бодлого баримтлаагүй зэрэгээс нийт 4.2 тэрбум төгрөг, 713.0 сая төгрөг хүүгийн орлого олох боломжийг алдсан.

3.105 Мөнгөн хадгаламжийн гэрээний алданги тооцохгүй, бүртгэлээс хассан залруулгын гүйлгээний хувьд,

- МУХБ нь 2020 онд арилжааны 4 банкны мөнгөн хадгаламжийг хугацаанаас өмнө буцаан дуудсан бөгөөд тус шийдвэртэй холбоотойгоор нийт 4.6 тэрбум төгрөгийн алдангийн орлогыг тооцохгүй, бүртгэлээс хассан нь ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн байна.

### **Монгол Улсын Хөгжлийн банкны зээлжих зэрэглэлийг Засгийн газрын үнэлгээтэй адил түвшинд тогтоож ирснийг онцлох нь зүйтэй**

3.106 Хөгжлийн банкны ТҮЗ-ийн шийдвэрээр 2014 оноос эхлэн олон улсын зэрэглэл тогтоогч агентлагуудад хандан банкны зээлжих зэрэглэлийн үнэлгээг<sup>28</sup> тогтоолгож эхэлсэн ба өнгөрсөн жилүүдэд Монгол Улсын болон Засгийн газрын зээлжих зэрэглэлийг тогтоож байсантай адил түвшинд тогтоож ирсэн байна.

3.107 Хөгжлийн банкны 2022 оны зээлжих зэрэглэлийг Мүүдийс (2022.09.30), Стандарт энд Пүүрс (2022.09.28), Фитч (2022.08.03) агентлагууд тус тус үнэлж, үүссэн чанаргүй активыг шийдвэрлэх арга хэмжээ үр дүнтэй байгааг онцлон зээлжих зэрэглэлийн үнэлгээг “Монгол Улсын Засгийн газрын үнэлгээ”-тэй адил түвшинд үнэлсэн байна.

3.108 Монгол Улсын Хөгжлийн банкны зээлжих зэрэглэлийг тогтоож, үнэлгээ өгсөн байна. Үүнд:

- Стандарт энд Пүүрс агентлаг, анхны бие даасан зээлжих зэрэглэлийг 2015 онд “B+” /сөрөг/ буюу Монгол Улсын Засгийн газартай ижил түвшинд тогтоосон. (Хөгжлийн банк нь Засгийн газраас дэмжлэг авах бүрэн боломжтой чухал үүрэг бүхий цорын ганц 100 хувь төрийн өмчтэй бодлогын банк болохын хувьд болон Монгол Улсын Засгийн газар Хөгжлийн банкаар дамжуулан дэд бүтцийн томоохон төслийдээ хэрэгжүүлнэ гэдэгт итгэж байгаа бөгөөд Хөгжлийн банкны оролцоог аль нэг арилжааны банк орлох боломжгүй тул ийнхүү үнэлсэн)
  - ⇒ Хөгжлийн банкны зээлжих зэрэглэлийг 2016 онд Монгол Улсын зээлжих зэрэглэлийг төсвийн гүйцэтгэл болон эдийн засгийн өсөлтийн хэтийн төлөөвөөс шалтгаалан “B-”/тогтвортой/ болгон бууруулсан.
  - ⇒ Монгол Улсын Засгийн газрын төсвийн гүйцэтгэл сайжирч, төсвийн зарцуулалтын хатуу хяналт болон эдийн засаг өсөлт мэдэгдэхүйц хурдассан учир зээлжих зэрэглэлийг буцаан “B” /тогтвортой/ болгон өсгөсөнтэй зэрэгцэн Хөгжлийн банкны зээлжих зэрэглэлийг 2018 онд мөн адил түвшинд ахиулсан.
  - ⇒ Хөгжлийн банкны 2022 оны 3 дугаар улиралд зээлжих зэрэглэлийн үнэлгээг хийж 2022 оны 9 сарын 28-ны өдөр B3 /тогтвортой/ хэвээр үлдээж буй

<sup>28</sup> “Улсын зээлжих зэрэглэл” гэдэг нь гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдаас аливаа улс, санхүүгийн байгууллагад олгосон зээлийн хүүгийн болон үндсэн төлбөрийг эргэн төлөх чадвар, зээлдэгчийн ерөнхий эрсдэлийг илтгэх үзүүлэлт.

тухай мэдээлсэн. Тус агентлаг Хөгжлийн банкийг 100 хувь төрийн өмчтэй Монгол Улсын цорын ганц хөгжлийн болон экспорт-импортын банкны чухал үүргийг хэрэгжүүлэгч бодлогын банк хэмээн ийнхүү үнэлсэн.

- ⇒ Хөгжлийн банк нь өөрийн зээлжих зэрэглэлийн үнэлгээг 2018 оноос хойш Засгийн газрын зэрэглэлийн түвшинд буюу В3 /тогтвортой/ түвшинд хадгалсан.

- **Мүүдийс агентлаг**, 2015 оны 10 дугаар сарын 27-ны өдөр зээлжих зэрэглэлийн үнэлгээг Монгол Улсын зэрэглэлтэй адил түвшинд буюу “B2” /сөрөг/ гэж үнэлсэн. (Хөгжлийн банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээ нь дотоодын арилжааны банкуудаас илт сайн байсан 2012-2014 онд банкны зээлийн үзүүлэлт нь даруй 288% -р өссөн хэдий ч биет хөрөнгийн үзүүлэлт нь 2014 оны эцэст 10.95% байгаа нь сайн үзүүлэлт бөгөөд 100 хувь төрийн өмчтэй бодлогын банк учир ийнхүү үнэлсэн)

- ⇒ Засгийн газрын зэрэглэлийг бууруулсантай адил Хөгжлийн банкны зэрэглэл мөн адил түвшинд буюу “Caa1”/тогтвортой/ болон буурсан.
- ⇒ ОУВС-ийн өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд холбогдох арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн зэрэгээс шалтгаалан 2018 онд улсын зэрэглэлийг В3 болгон ахиулсантай зэрэгцүүлэн Хөгжлийн банкны зэрэглэлийг мөн өсгөсөн.
- ⇒ Хөгжлийн банк нь ээлжит жилийн зээлжих зэрэглэлээ 2022 оны 3 дугаар улиралд үнэлгээлсэн бөгөөд Засгийн газрын зэрэглэлийн адил түвшинд буюу Монгол Улсын Засгийн газрыг шаардлагатай үед Хөгжлийн банканд санхүүгийн болон бусад дэмжлэгийг үзүүлэх эрх зүйн зохицуулалттайг харгалзан үзэж үнэлгээг тогтоосон.

- **Фитч агентлаг**, Монгол Улсын зэрэглэлтэй ижил түвшинд буюу “B” /тогтвортой/ гэж үнэлсэн бөгөөд зэрэглэлд өөрчлөлт оруулаагүй байна.

- ⇒ Хөгжлийн банкийг 2022-2023 онуудад активын чанарын асуудлаа шийдвэрлэхэд гол анхаарлаа хандуулж байгааг болон Засгийн газрын дэмжлэгийг шаардлагатай тохиолдолд авах бүрэн боломжтойг онцлон тэмдэглэж В /тогтвортой/ хэвээр үлдээсэн байна.

3.109 Стандарт энд Пүүрс, Мүүдийс болон Фитч агентлагын тогтоосон Хөгжлийн банкны зээлжих зэрэглэлийг үнэлгээг гаргахад голлон авч үзэж, нөлөөлсөн хүчин зүйлс нь зэрэг тохиолдолд төсвийн гүйцэтгэл болон эдийн засгийн өсөлтийн хэтийн төлвөөс шалтгаалсан Засгийн газрын зэрэглэлээр хязгаарлагддаг ба ялгаатай буюу өндөр тогтох боломжгүй, Хөгжлийн банкны оролцоог аль нэг арилжааны банк орлох боломжгүй экспорт-импортын банкны чухал үүргийг хэрэгжүүлэгч бодлогын банк гэж үзсэн.

3.110 Тухайн явцад өөрийн хөрөнгийн хүрэлцээ дотоодын арилжааны банкуудаас сайн байсан, Засгийн газраас өрийн удирдлагыг амжилттай хэрэгжүүлж, төсвийн алдагдлыг бууруулсан мөн ОУВС-ийн өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд холбогдох арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн зэрэг шалтгаан нөлөөлжээ.

3.111 Харин “Мүүдийс” агентлаг нь 2017-2018 онуудад Засгийн газрын шууд болон шууд бус өрөө эргэн төлөх чадварын тодорхойгүй байдал болон урт хугацаанд үргэлжилсэн төсвийн алдагдал болон өсөлтийн сүл төлөв нь Засгийн газрын өрийг өндөр түвшинд хүргэсэн тул Монгол Улсын зээлжих зэрэглэлийг “Caa1” /тогтвортой/ түвшинд буулгасан. Засгийн газрын зэрэглэлийг бууруулснаар Хөгжлийн банкны зэрэглэл мөн адил түвшинд буюу “Caa1” /тогтвортой/ болон буурч байсан.

3.112 “Мүүдийс” агентлагтай тус банкны жилийн үнэлгээ хийлгэх уулзалтыг хийж, банкны активын чанар, санхүүгийн нөхцөл байдлын талаар мэдээлэл, тодруулга өгснөөр тус банкны үнэлгээг хэвээр үлдээсэн байна.

3.113 Түүнчлэн “Фитч” агентлаг нь Хөгжлийн банкийг 2022-2023 онуудад активын чанарын асуудлаа шийдвэрлэхэд гол анхаарлаа хандуулан ажиллаж байгаа бөгөөд улсын хөгжлийн бодлогын томоохон төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх чухал үүрэг гүйцэтгэдэг цорын

ганц бодлогын банкны хувьд Засгийн газрын дэмжлэгийг шаардлагатай тохиолдолд авах бүрэн боломжтойг онцлон тэмдэглэж мөн В /тогтвортой/ гэж хэвээр үлдээсэн.

3.114 Мүүдийс зээлжих зэрэглэл тогтоогч агентлагтай МУХБ-ны үнэлгээний уулзалтыг хийж, МУХБ-ны активын чанар, санхүүгийн нөхцөл байдал болон Монгол Улсын банк санхүүгийн салбарын тухай асуултуудад хариулж, тодруулга өгснөөр “Мүүдийс” агентлаг МУХБ-ны үнэлгээг хэвээр үлдээжээ.

3.115 Тус банкны зээлжих зэрэглэл Засгийн газартай адил түвшинд тогтоогдож байсныг харгалзах ёстой бөгөөд өрийн удирдлагын буюу актив, пассивын удирдлагыг сайжруулах, эргэн төлөлтийн хуваарьт эрсдэл учрах, хүндрэлтэй байдалд хүргэж болзошгүй байгаа тул чанаргүй зээлийн эргэн төлөлтийг эрчимжүүлэх шаардлагатай байна.

## ДӨРӨВ. ОЛОН УЛСЫН АУДИТЫН КОМПАНИУДЫН ДҮГНЭЛТ ЗӨВЛӨМЖ, ӨМНӨХ ЖИЛҮҮДЭД ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ

4.1 МУХБ үүсгэн байгуулагдсанаас хойш жил бүрийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн байдлын тайлагнаанд Улаанбаатар аудит ХХК /1/, DELOITTE /3/, PWC /3/, KPMG /4/ тус тус аудитыг гэрээний үндсэн дээр гүйцэтгэсэн байна.

4.2 МУХБ-ны санхүүгийн үйл ажиллагаанд хараат бус хөндлөнгийн аудитын этгээдээс гүйцэтгэсэн аудитын дүн, удирдлагад хүргүүлэх захидалд зээлийн багцын хурдацтай өсөлттэй уялдсан үүсэж болзошгүй эрсдэл бий болохыг, үнэ цэнийн бууралт, чанаргүйдлээс урьдчилан сэргийлсэн горим тогтолцоог нэвтрүүлэх тухай (2013 оноос эхлэлтэй) зохих зөвлөмж өгч байсныг тэмдэглэж байна.

4.3 Тус банкны 2011-2021 оны санхүүгийн жилийн дуусгавар болгосон санхүүгийн байдалд аудит хийлгэсэн байдлаас үзэхэд дээрх АХЭ-ээс 119 асуудлаар нийт 266 зөвлөмжийг удирдлагын захидааар хүргүүлсэн байна.

4.4 АХЭ-ийн гүйцэтгэсэн хөндлөнгийн аудитын дүгнэлт, удирдлагын захидалд дурдсан аудитын ажлын дүн, ажиглалтад тулгуурлан гаргасан санал, зөвлөмжөөс тус банкны засаглах үйл ажиллагааны эрсдэл болон зээлийн орчинтой холбоотой талбараадад хэрэгжсэн горим, үйл ажиллагаа, нөхцөл байдлыг авч үзсэн.

4.5 Банкны санхүүгийн тайланд Улаанбаатар аудит ХХК нэг удаа, DELOITTE, PWC, KPMG зэрэг аудитын хуулийн этгээд тус бүр 3-4 удаа давтамжтай аудитыг гүйцэтгэсэн бөгөөд онилсон бүлэг асуудлын хураангуй, мөн түүний нөлөөллийг тооцсоноор дараах чиглэлд эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, хариу арга хэмжээний төлөвлөгөөтэй байж үр нөлөөг сайжруулах шаардлагатай нь ажиглагдсан болно.

Талбар	Болзошгүй үр дагаврын эсрэг эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх шаардлагатай
Зээлийн эргэн төлөгдөх магадлал болон ирээдүйн мөнгөн урсгалын шинжилгээ	Зээлийн болзошгүй эрсдэлийн сангийн хэмжээг тохиромжгүй хэмжээгээр тогтоох, санг хянах боломжгүй болох;
Тухайлсан зээлийн төсөөллийн эргэн шалгалаат	Эргэн шалгалтын горимыг дэмжих баримтжуулалт дутагдалтай байдал нь үнэ цэнийн бууралт юунаас үүссэн эсэхийг хянах, буцаан шалгах үр дүнд хүндэрэл учруулж болзошгүй болох;
Зээлийн шалгуур үзүүлэлтийн харьцааны тооцоолол	Тооцооллын буруу үйлдэл нь гэрээний зөрчлийг давхар үүсгэх, банкны нэр хүнд сурхах;
Барьцаа хөрөнгийн хөндлөнгийн үнэлгээ	Хараат, туршилагагүй үнэлгээ нь үнэлгээ тохиромжгүй байдлаар үнэлэгдэх, улмаар эрсдэлийн сан буруу тооцох, удирдлагын шийдвэр буруу гарах;
Арилжааны банкуудын барьцаа	Барьцаа хөрөнгийн шаардлага хангаагүйгээс материаллаг хэмжээний алдагдалд хүргэж болзошгүй;
Үнэ цэнийн бууралтын нөөцийн бүлгийн үнэлгээний тооцоолол	Эрсдэлийн санг илүү, эсхүл дутуу байгуулах эрсдэл үүсгэх, Үнэлгээний тооцоолол эсхүл тооцоолох арга зүй зөрүүтэй, тооцооллыг хийхдээ 1.5 хувиар тооцоолдог нь Монголбанкны журам, заавар болон түүхэн мэдээлэл, бусад үнэлгээтэй нийцэхгүй;
Зээлдэгчдийн аудитлагдсан санхүүгийн тайлан	Зээлдэгчийн талаар буруу шийдвэр гаргах эрсдэл үүсэх, Зээлдэгчийн СТОУС-ын дагуу аудитлагдаагүй тайлан авч байгаа нь санхүүгийн үзүүлэлт ил тод бус, хангалттай мэдээллийг агуулдаггүй;
Санхүүжүүлсэн төслүүдийг хянах хараат бус хянан шалгагч	Хуулийн нийцэл буюу МУХБ-ны хуулиар тодорхойлогдсон зорилго, зорилтод нийцсэн төслийн санхүүжилтийн үр ашиг хангагдахгүйд хүрэх;
Зээлийн ирээдүйн мөнгөн урсгалын төсөөлөл	Зээлийн мөнгөн урсгалын төсөөлөл, ялгаатай хувилбаруудын нөлөөллийн шинжилгээг дэмжих мэдээлэл дутмагаас эрсдэлийн сан байгуулах, хянахад хүндэрлэлтэй байх.

4.6 Үйл ажиллагааны дотоод орчин, сайн засаглалаас гадна зээл, зээлийн орчинтой холбоотой гол асуудлын хувьд эрсдэлийг тогтмол “Дунд”-аас “Өндөр” гэсэн түвшинд үнэлгэдэж байсан.

4.7 Ихэнх тохиолдолд удирдлагын захидааар хүргэгдсэн зөвлөмжид “Өмнөх жилийн аудит”-ын хүрээний “зээлийн орчин”-той ажиглалт, түүнд суурилсан “зөвлөмж” давтагдсан нь зөвлөмжийн дагуу авсан гэх хариу арга хэмжээний үр дүн төдийлөн гаралагүй хэвээр хадгалагдсан, уламжлалт эрсдэл бодитойгоор оршиж ирсэн байна.

4.8 Хөгжлийн банкны 2011-2021 он хүртэл жил бүрийн санхүүгийн тайлагнаанд аудит хийж, өгсөн зөвлөмжид өмнөх жилийн аудитын хүрээнд ижил төсөөтэй агуулга бүхий, горим, арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг удирдлагын захидлаар хүргүүлж байсныг харж болно.

4.9 Аудитын хуулийн этгээдийн өгсөн гол асуудлаарх зөвлөмж өмнөх жилийн аудитын хүрээнд ижил төстэй агуулгаар бичигдэж байсан нь тухайн үеийн банкны удирдлагаас хэрэгжүүлсэн хариу арга хэмжээний гүйцэтгэл хангалтгүй байсныг гэрчилнэ.

4.10 Аудитын хуулийн этгээдийн гүйцэтгэсэн хараат бус аудиторын тайлан, тухайн үед удирдлагын захидлаар хүргүүлж байсан зөвлөмжийн агуулга хэрэгжилтийг дараах байдлаар үнэлж байна. Үүнд:

#### Гол асуудал нь:

- Аудитын хуулийн этгээдээс хийсэн аудитын дунд өгсөн удирдлагын захидалд дурдсан асуудлууд нь банкны үйл ажиллагааг хэвийн үр ашигтай горимоор явуулж, үйл ажиллагааны хувьд томоохон сайжралыг олж авахуйц давуу талыг олгож байсан.
- Аудитын хуулийн этгээдээс Хөгжлийн банканд хүргүүлсэн жил бүрийн аудитын удирдлагын захидалд үүсэж болзошгүй нөхцөл байдлаас сэргийлсэн горим, тогтолцоог бий болгох хангалттай хэмжээний зөвлөмжийг давтан аудитаар өгч байсан.
- Давтан буюу дахин гүйцэтгэсэн аудитаар өмнөх зөвлөмжийн агуулга давтагдаж байсан нь удирдлагын захидлаар хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилт, банкны удирдлагаас өгсөн хариу/биелэлт хангалтгүй, хүсэл сонирхол бага байсныг гэрчилнэ.
- Аудитын хуулийн этгээдийн санхүүгийн тайланг баталгаажуулахдаа үнэ цэнийн бууралт үүссэн, хугацаа хэтэрсэн зээлийн болзошгүй эрсдэлийн сангийн тооцоолол, эргэн төлөгдөх магадлал, активын ангилаал зэрэгтэй холбоотой санхүүгийн тайланд материаллаг нөлөө бүхий эрсдэлийг тогтоож, нэг ижил асуудлыг 3-4 жил хөндөн тавьж байсан.
- Гэвч бүхэлдээ асуудлыг үүссэн шалтгааныг арилгах оновчтой зөвлөмж санал болгоогүй, өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийг давтан хянаж, хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг хангалтгүй хэрэгжүүлсэн. Нөгөө талаас банкны ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын зүгээс зөвлөмжийг хэрэгжүүлэх идэвх санаачилга гаргаагүй алдаа зөрчил жил бүр давтан гарсан.
- Санхүүгийн тайлангийн аудитыг АОУС-аар гүйцэтгэж, төрийн өмчийн эзэмшилтэй учраас ТАБ-ын мөрдөж буй АДБОУС болон үндэсний стандартыг мөрдөхөд анхаарал хандуулах нь зохицтой байгаа бөгөөд түүнийг баримтлахгүйгээр хөндлөнгийн АХЭ-ийн гүйцэтгэх аудит нь хамрах хүрээ, зорилго зорилт, түүний үр нөлөө явцуу хүрээнд зохион байгуулагдах эрсдэлтэй байна<sup>29</sup>.

#### Шийдвэрлэгдээгүй гол асуудал нь:

- Удирдлагын захидлаар хүргүүлсэн зөвлөмжийн дэлгэрэнгүйд үндэслэн банкны удирдлагаас өгсөн хариу/биелэлтэд анхаарч ажиллах ёстой байсан боловч хэрэгжилт хангалтгүй байсан.

4.11 Түүнчлэн дараах асуудлыг МУХБ-ны тухай хууль болон дотоод үйл ажиллагааны зохицуулалтын хүрээнд анхаарч шийдвэрлэвэл зохистой байна. Үүнд:

- “**Аудитаар хэрэгжүүлэх арга хэмжээ**” буюу “**Менежментийн захидлаар санал, зөвлөмж хүргүүлсэн ч биелүүлэх эсэх нь ТУЗ болон банкны гүйцэтгэх удирдлагын идэвх санаачилгаас хамаарах”**

<sup>29</sup> АДБОУС 1250-д “Төрийн бодлого, хууль тогтоомж, дүрэм журам, Засгийн газрын тогтоол, хууль тогтоох байгууллагын шийдвэрээр улсын секторын байгууллагын аудитад бүрэн эрх, нэмэлтт үүрэг хүлээлгэдээ. Үүнд төсвийн болон хариуцлагын тухай хууль тогтоомжийг зөрчсөн үйлдлийг төрийн аудитор илрүүлсэнтэй холбоотой аудитын болон тайллагнах үүрэг орж болно... Иймд төрийн аудитор үүнийг байнга санаж зөрчил илэрсэн үед анхаарвал зохино”

⇒ Шалгагдагч этгээд төрийн эзэмшилийн хэлбэртэй тул хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар албан шаардлага өгдөг. Хэрэв шалгагдагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтоох, мөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тохиолдолд албан шаардлага хүргүүлэх, албан шаардлагыг хэрэгжүүлээгүй тохиолдолд хариуцлага тооцуулах зэрэээр шат дараалсан арга хэмжээг хэрэгжүүлэх ёстойг алжын даалгаварт тусгадаггүй байна.

- “Мэдээллийн хязгаарлалт” буюу “Менежментийн захидалтыг зөвхөн тухайн байгууллагад зориулж бэлтгэдэг бөгөөд аудитын хуулийн этгээдийн урьдчилан бичгээр авсан зөвшөөрөлгүйгээр хуулбарлах буюу гуравдагч этгээдэд ил болгох, эсхүл бүхлээр нь болон хэсэгчлэн ишлэх, дурдахыг хориглодог”

⇒ Төрийн аудитын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2-д “Төрийн аудитын байгууллага төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээлэл агуулснаас бусад аудитын тайланг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан журмын дагуу улирал бүр гаргаж, өөрийн цахим хуудсаар олон нийтэд мэдээлнэ” гэж заасан байдгийг харгалзан нотлох ажлын хүрээнд ТАБ ээлжит хяналт шалгалтыг гүйцэтгэж байх нь зохимжтой байна.

4.12 АХЭ-ээс хүргүүлсэн удирдлагын захидалд дурдсан зөвлөмжийн хэрэгжилт дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 18. Зөвлөмжийн хэрэгжилт

Он	Онилсон асуудал ба чиглэлийн тоо	Хэрэгжсэн	Хэрэгжиж буй	Хэрэгжээгүй
2011	3	3	-	-
2012	16	15	1	-
2013	5	3	2	-
2014	7	4	3	-
2015	10	6	4	-
2016	17	16	1	-
2017	27	16	10	1
2018	11	5	6	-
2019	10	5	4	1
2020	15	8	5	2
2021	17	7	10	-

4.13 АХЭ санхүүгийн тайланг баталгаажуулахдаа үнэ цэнийн бууралт үүссэн, хугацаа хэтэрсэн зээлийн болзошгүй эрсдэлийн сангийн тооцоолол, эргэн төлөгдөх магадлал, активын ангилал зэрэгтэй холбоотой санхүүгийн тайланд материаллаг нөлөө бүхий эрсдэлийг тогтоож, нэг ижил асуудлыг 3-4 жил хөндөж байсан. Гэвч асуудлыг үүсгэсэн шалтгааныг нь арилгах оновчтой зөвлөмж санал болгоогүй. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийг давтан хянаж, хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг хангалтгүй хэрэгжүүлсэн. Нөгөө талаас банкны ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын зүгээс зөвлөмжийг хэрэгжүүлэх идэвх санаачилга гаргаагүй алдаа зөрчил жил бүр давтан гарсан.

4.14 Санхүүгийн тайлангийн аудитыг АОУС-аар гүйцэтгэж, төрийн өмчийн хэлбэрийн хувьд ТАБ-ын мөрдөж буй АДБОУС болон үндэсний стандартыг мөрдөхөд анхаарал хандуулах, түүнийг баримтлахгүйгээр хөндлөнгийн АХЭ-ийн гүйцэтгэх аудит нь хамрах хүрээ, зорилго зорилт, үр нөлөө явцуу хүрээнд зохион байгуулагдах эрсдэлтэй.

4.15 Өмнөх жилийн аудитын хүрээний зээлийн орчинтой холбогдсон ажиглалт, түүнд суурилсан зөвлөмж давтагдсан нь зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн гэх хариу арга

хэмжээний үр дүн төдийлөн гараагүй хэвээр хадгалагдсан, уламжлалт эрсдэл бодитойгоор оршиж ирсэн, өмнөх зөвлөмжийн агуулга давтагдаж байгаа нь удирдлагын захидаар хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байгааг гэрчилж байна.

4.16 Зарим жилүүдэд баталгаажуулах аудитын дүнд суурилан өгсөн зөвлөмжид банкны гүйцэтгэх удирдлагаас өгсөн хариу нь зөвлөмжийг хүлээн авахаар гарч байсан ч дараагийн тайлант жилийн баталгаажуулах аудитаар өгсөн зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлсэн талаар удирдлагын захидалд дурдаагүй байна.

#### **ТАВ. УИХ, МОНГОЛБАНК, ЗАСГИЙН ГАЗАР, ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР БОЛОН БУСАД АУДИТЫН ХУУЛИЙН ЭТГЭЭДЭЭС ХИЙСЭН ХЯНАЛТ, ҮР ДҮН**

5.1 Монгол Улсын Хөгжлийн банк үүсгэн байгуулагдсанаас хойших хугацаанд болон УИХ-ын ажлын хэсэг, Хянан шалгах түр хороо байгуулагдах хүртэл тус банкны үйл ажиллагаанд олон удаагийн шалгалт хийгджээ. /Дэлгэрэнгүйг Хавсралт 4-т үзүүлэв/

5.2 Өнгөрсөн хугацаанд МУХБ-ны үйл ажиллагаанд УИХ /2022/, Засгийн газар /2016, 2019/, Монголбанк /2018, 2021/, ЯАГ /2021/, Монголбанк, Сангийн яамны хамтарсан /2020/, PWC /2018/ зэрэг эрх бүхий байгууллагаудаас хийгдсэн голлох хяналт шалгалтаар нийт 170 гаруй зөрчилтэй асуудал тэмдэглэгдэж, хяналт шалгалтын дүнд үндэслэсэн нийт 192 дүгнэлт бичиж, зөрчил болон эрсдэлийг арилгах нийт 237 зөвлөмж өгсөн байна.

#### **Олон удаагийн давтамжтай болон эрх бүхий байгууллагаудын давхардсан хяналт шалгалтын үйл ажиллагааны үр нөлөөт байдал хангалтгүй байсан**

5.3 Эрх бүхий байгууллагаудын хяналт шалгалтын тайланда албан ёсоор бичигдсэн зөвлөмжөөс гадна уг тайланда дурдсан алдаа дутагдлыг зөвлөмжөөр хүлээн зөвшөөрч засан сайжруулах чиглэлээр тоон агуулгад шилжүүлэн авч үзвэл нийт 450 гаруй болсон.

5.4 МУХБ-ны өнөөгийн удирдлагын 2022 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн А-63 дугаар тушаалаар төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх ажлын хэсэг байгуулж, удирдамжийг батлан, шалгалтын хамрах хүрээнд 2018-2022 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд эрх бүхий байгууллагаас хийгдсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг бүрэн арилгасан эсэх болон шалгалтын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хянан үзэх зорилготой ажилласан байна.

*Хүснэгт 19. Хамрагдсан шалгалтууд*

Д.д	Шалгалт хийсэн эрх бүхий байгууллага	Он	Хяналт шалгалтаас өгсөн зөвлөмж, дүгнэлтийг баталгаажуулсан баримт бичиг	Баримт бичгийн огноо, дугаар
1	PWC аудит	2018	Дэлгэрэнгүй шинжилгээний тайлан	2018.04.12
2	Монголбанк		Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаал №А-290	2018.11.27 №А-290
3	Үндэсний аудитын газар	2019	МУ-ын Ерөнхий аудиторын тушаал	2019.05.03 №А/41
4	Засгийн газар	2019	МУ-ын Засгийн газар албан тоот	2019.05.03 №ХЭГ/Н-30
5	Үндэсний аудитын газар	2021	МУ-ын Ерөнхий аудиторын тушаал	2022.03.15 №07/631
6	Монголбанк	2020	Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаал	2021.12.13 №А-336
7	Улсын Их Хурал	2022	УИХ-ын даргын захирамж	2022.01.31 20 тоот

5.5 МУХБ-ны үйл ажиллагаанд эрх бүхий байгууллагаас гүйцэтгэсэн хяналт шалгалт болон аудитын хуулийн этгээдийн санхүүгийн тайланг баталгаажуулах аудитын үр нөлөө сул байсан.

5.6 МУХБ-ны үйл ажиллагаанд эрх бүхий байгууллага, хөндлөнгийн аудитын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилт дараах байдалтай байна. Үүнд:

**Бүрэн хэрэгжсэн 101 буюу 26.2 хувь, үүнээс:**

- ✓ Дотоод үйл ажиллагаатай холбоотой 23,
- ✓ Засаглах тогтолцооны ажил, үйлчилгээтэй холбоотой 15,
- ✓ Зээлийн орчин, тухайлсан зээлтэй холбоотой 17,
- ✓ Мөнгөн хөрөнгө, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн удирдлагатай холбоотой 28,
- ✓ Эрсдэлийн удирдлагатай холбоотой 16,
- ✓ Санхүүгийн тайлагнал, НББ-тэй холбоотой 2.

**Хэрэгжилт хангалтгүй 86 буюу 22.3 хувь, үүнээс:**

- ✓ Дотоод үйл ажиллагаатай холбоотой 9,
- ✓ Засаглах тогтолцооны ажил, үйлчилгээтэй холбоотой 10,
- ✓ Зээлийн орчин, тухайлсан зээлтэй холбоотой 30,
- ✓ Мөнгөн хөрөнгө, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн удирдлагатай холбоотой 6,
- ✓ Эрсдэлийн удирдлагатай холбоотой 25,
- ✓ Санхүүгийн тайлагнал, НББ-тэй холбоотой 6.

**Хэрэгжээгүй 36 буюу 9.3 хувь, үүнээс:**

- ✓ Засаглах тогтолцооны ажил, үйлчилгээтэй холбоотой 14,
- ✓ Зээлийн орчин, тухайлсан зээлтэй холбоотой 4,
- ✓ Мөнгөн хөрөнгө, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн удирдлагатай холбоотой 3,
- ✓ Эрсдэлийн удирдлагатай холбоотой 15,

**Хэрэгжих шатанд буюу үргэлжилж буй 162 буюу 42.1 хувь үүнээс:**

- ✓ Дотоод үйл ажиллагаатай холбоотой 15,
- ✓ Засаглах тогтолцооны ажил, үйлчилгээтэй холбоотой 17,
- ✓ Зээлийн орчин, тухайлсан зээлтэй холбоотой 44,
- ✓ Мөнгөн хөрөнгө, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн удирдлагатай холбоотой 16,
- ✓ Эрсдэлийн удирдлагатай холбоотой 59,
- ✓ Санхүүгийн тайлагнал, НББ-тэй холбоотой 11.

Эрх бүхий байгууллагын тухайлсан шалгалт, аудитын хуулийн этгээдийн баталгаажуулах аудитын “үр нөлөө” нь дараагийн шатандaa “АХИЦ ДЭВШИЛ”-ээр үнэлэгдэж байх ёстой.

Гэвч үр нөлөө хангалттай түвшинд байж чадаагүй, нөгөө талаас дурдсан байгууллагуудын тусгайлсан, нарийчилсан, өргөтгөсөн, хэсэгчилсэн зэрэг шалгалтуудын мөрөөр, мөн давтан хийсэн болон эзлжит хяналт шалгалтын үеэр өмнөх шалгалтын илрүүлэлт, алдаа зөрчлийг хэрхэн арилгасан талаар үндсэндээ хянаж байгаагүй, энэ талаар учир холбогдолтой, бодит нөхцөл байдлыг илтгэх хангалттай “НОТЛОХ ЗҮЙЛ” олдоогүй болно.

Эцэст нь МУХБ-ны хууль тогтоомжид заасан үйл ажиллагаанд тавих төрийн хяналтын чиг үүрэг хангалтгүй хэрэгжиж ирсэн гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Эрх бүхий байгууллагаас гүйцэтгэсэн хяналт шалгалтын мөрөөр арга хэмжээг эртэчлэн аваагүйгээс өнөөгийн нөхцөл байдалд хургэсэн байна.

5.7 Тухайлбал, эрх бүхий байгууллагын гүйцэтгэлийн хяналт шалгалт, хөндлөнгийн хуулийн этгээдийн баталгаажуулах аудитын мөрөөр давтан хийх үе шатны ажлын гүйцэтгэл, түүнд суурилсан ахиц дэвшилийг үнэлэх, нөлөөллийг тооцох ажил хангалтгүй байсан.

5.8 МУХБ-ны дотоод хяналтын тогтолцооны хүрээнд Монгол Улсын хууль тогтоомж, санхүүгийн удирдлагын үр ашиг, үр нөлөөтэй байдал, хэмнэлтийн горим зөрчсөн тохиолдол гарч байсан ч тухай бүр нь таслан зогсоон шийдвэртэй арга хэмжээг авч чадаагүй.

5.9 Энэ байдал нь дотоод хяналтын тогтолцооны үйлчлэл сул, эрх бүхий байгууллага хяналт шалгалтынхаа мөрөөр илэрсэн зөрчил, алдаа дутагдлыг таслан зогсоох, засан залруулж, шийдвэрлэх үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн.

5.10 МУХБ-ны зээлийн үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагаанд эрх бүхий байгууллагаас үе шаттай хяналт, шалгалт хийж, илэрсэн алдаа зөрчлийг арилгах талаар санал, зөвлөмж өгч, хуулийн байгууллагуудаар хянуулах тодорхой саналыг өгч ирсэн ч илэрсэн асуудлаар тухай бүр нь МУХБ нь эдгээр алдаа, зөрчлийг арилгуулахаар хууль хяналтын байгууллагад албан ёсоор хандаж, шийдвэрлүүлэх асуудлыг орхигдуулсан.

## **Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 36 дугаар тогтоолоор байгуулсан ажлын хэсгийн шалгалт**

5.11 Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 36 дугаар тогтоолоор байгуулсан ажлын хэсгийн шалгалтаар Монгол Улсын Хөгжлийн банкны татан төвлөрүүлсэн эх үүсвэр, төслийн сонгон шалгаруулалт, төслийн санхүүжилтийн зарцуулалт болон хэрэгжилтэд хяналт шалгалт хийх, цаашид учирч болзошгүй эрсдэлд үнэлэлт, дүгнэлт өгөхөд оршиж байсан.

5.12 Ажлын хэсэг дараах асуудлыг хөндсөн байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газарт 8;
- Хууль, эрх зүйн хүрээний нийцэл, тэдгээрийн хүрээнд шийдвэрлэвэл зохих асуудлаар 8;
- Монгол Улсын Хөгжлийн банканд тусгайлан 24;
  - МУХБ-ны Актив, пассивын удирдлагын хороонд 11;
  - Зээлийн хороонд 2;
  - Эрсдэлийн удирдлагын хороонд 10;
  - Эдгээрийн хороодын хамаарал бүхий асуудлыг нэгтгэн б чиглэлээр холбогдох хууль тогтоомжийн нийцлийг хангаж ажиллах;
- Шалгалтын дунд үндэслэн хуулийн хяналтын байгууллагад чиглэл болгон татан төвлөрүүлсэн хөрөнгийн ашиглалт, үнэт цаас гаргалт, тухайлсан зээл, санхүү хөрөнгийн захиран зарцуулалт, дотоод үйл ажиллагаатай холбоотой 21 асуудлаар нийт 703.6 тэрбум төгрөг болон 315.2 сая ам.долларын үнийн дун бүхий ажил, үйлчилгээг хянуулж шийдвэрлүүлэх асуудлыг гаргаж ирсэн байна.

5.13 Шалгалтын дунг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, үр дунг олон нийтэд мэдээлж ажиллан, банкны тухайн үеийн удирдлагууд болон төрийн холбогдох байгууллагуудад үүрэг өгч байсан ч уг тайлан нууцын зэрэглэлд шилжсэнээр ач холбогдлыг бууруулсан бол 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн “Төрийн нууцад хамаарах мэдээллийг ил болгох тухай” 114 дүгээр тогтоолын үйлчлэлээр ил болсон.

5.14 Энэхүү шалгалт нь МУХБ-нд хийсэн өргөн хүрээний анхны томоохон шалгалт байсан гагцхүү тухай үед нууцалснаар /5 жил илүү хугацаанд/ хяналт шалгалтын үр дунд МУХБ-ны үйл ажиллагаа хэвийн явагдах анхны шаардлага хангагдах байсан.

5.15 Уг шалгалтын мөрөөр Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны 49 дүгээр тэмдэглэлээр улсын төсвөөс эргэн төлөгдхөн нөхцөлтэйгөөр Хөгжлийн банкнаас олгосон зээл болох 3.0 их наяд төгрөгийн дун бүхий 371 төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг хянах чиглэл өгөгдөж, МУХБ-ны ТҮЗ-ийн 2016 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 69 дүгээр тогтоолоор шалгалттай холбоотой арга хэмжээг анх удаагаа авч хэрэгжүүлж эхэлсэн байна.

## **Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 219 дүгээр тогтоолын дагуу төсөл, арга хэмжээг төсөвт шилжүүлсэнтэй холбогдуулан авсан арга хэмжээ**

5.16 Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 52 дугаар тэмдэглэлээр МУХБ-ны эх үүсвэрээр санхүүжүүлж, Засгийн газрын 2016 оны 219 дүгээр тогтоолоор Засгийн газарт шилжүүлсэн нийт 3.1 их наяд төгрөгийн үнийн дун бүхий 348 төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хянах үүрэг өгсөн ч төсвийн ерөнхийлөн захирагчдын Нарийвчилсан хяналт шалгалтын материалыаас үзэхэд “үр нөлөөт” байдал хангалттай түвшинд хүргэж тайлагнаагүй, төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон зээлийн хөрөнгийн зарцуулалт, түүний үр ашиг, үр өгөөж, үр дүнгийн талаас асуудлыг хөндөөгүй байсан.

5.17 Хууль тогтоомжийн зөрчилтэй асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн тухай, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тодорхой дүгнэлт гараагүй байна.

5.18 Засгийн газрын 2019 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдааны 19 дүгээр тэмдэглэлээр Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагаанд хийсэн ээлжит шалгалтын

дүнгийн талаар Засгийн газрын гишүүдэд танилцуулж, шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар шийдвэрийн төсөл боловсруулан, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх, газар дээрх шалгалтын тайлангаар цаашид авах арга хэмжээний санал /37/-ыг тодорхойлж, хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтуудад даалгасан.

▪ **Монгол Улсын Засгийн газраас байгуулсан ажлын хэсэг**

- МУХБ-ны тухай хуулийн зарим заалтууд зөрчигдсөнийг тогтоосон тул Зөрчлийн тухай хуульд заасны дагуу хэрэг нээх нөхцөл бүрдсэн гэдгийг тэмдэглэсэн;

▪ **Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал:**

- МУХБ-ны зээлийн орчин, зээлдэгчийн зээлийн ашиглалт, санхүү, аж ахуй, дотоод үйл ажиллагаа, мөнгөн хөрөнгийн удирдлага, эх үүсвэрийн ашиглалт, үнэт цаас гаргалт, ТҮЗ-ийн зохион байгуулалт, мэдээ тайлан гаргалт, тайлagnalын ил тод байдал зэргээр нийт 62 асуудлыг хөндсөн;

▪ **Хөгжлийн банкнаас олгосон зээлд илэрсэн зөрчил:**

- Нийт 8 зээлдэгчид олгосон зээлийн шийдвэрлэлт, ашиглалт, зарцуулалт, эргэн төлөлт, барьцаа хөрөнгийн асуудлыг тусгайлан авч үзэж зөрчилтэй асуудлыг тайланд дэлгэрэнгүй байдлаар тусгасан;

▪ **Цаашид авах арга хэмжээний санал:**

- Газар дээрх шалгалтын мөрөөр нийт 37 асуудлаар хэрэгжүүлэх арга хэмжээний санал гаргаж Засгийн газрын 2019 оны 169 дүгээр тогтоол гарчээ.

**Засгийн газрын шууд хамаарал бүхий төслүүдийн хэрэгжилт, үр дүнг тооцох ажил хангалтгүй байсан**

5.19 Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 52 дугаар тэмдэглэл /Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр Хөгжлийн банкнаас 2012-2016 онд санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээ/-ээр өгсөн үүргийн хэрэгжилт хангалтгүй, үр нөлөөтэй байж чадаагүй байна.

5.20 Монгол Улсын Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүргийн дагуу зээлд хамрагдсан буюу хариуцсан ТЕЗ-дын салбарт хэрэгжсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд нарийвчилсан шалгалт хийсэн гэх ирүүлсэн танилцуулга, баримт материалд үндэслэн үр нөлөөт байдлыг хянан үзсэн.

5.21 Хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүргийн дагуу ТАХ-ний хэрэгжилтэд хяналт хийж бичсэн танилцуулгыг ЗГХЭГ-т тухай бүр хүргүүлж байсан ч хяналт шалгалтын материалын агуулгаас үзэхэд үр нөлөөт байдал хангалттай түвшинд хүрсэн эсэхийг тайлагнаагүй, төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон зээлийн хөрөнгийн зарцуулалт, түүний үр ашиг, үр өгөөж, зориулалт, үр дүнгийн байдал талаас дорвitoй асуудал хөндөөгүй, илрүүлсэн буюу хууль тогтоомжийн зөрчилтэй асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн тухай, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тодорхой дүгнэлт санал аль ч тайландаа бичигдээгүй байжээ.

5.22 “Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор” /Цагдаагийн байгууллага хянаж байсан гэх боловч тодорхойгүй шалтгаанаар буцаагдсан/, “Нүүрснээс синтетик байгалийн хий үйлдвэрлэх” төслийн нэгжүүд татан буугдсан бол төслийн үр дүнг үнэлж цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ тодорхойгүй, зээлийн зарцуулалтыг нэг бүрчлэн хянаж шалгаагүй байсан.

5.23 Мөн Зам, тээврийн салбарт хэрэгжүүлсэн ТАХ-ний хэрэгжилтэй холбоотой баримт материал архивт бүрэн хадгалаагүй, төсөл хэрэгжүүлэх чадамж сүл хэт хавтгайруулсан олон төсөл арга хэмжээг төлөвлөсөн, “МТЗ” ТӨХХ-ийн хэрэгжүүлж буй “Шинэ төмөр зам”, зүүн чиглэлийн Даланзадгад-Сайншанд-Хөөт-Чойбалсан 1165 км зам, Ухаахудаг /тавантолгой/ - Гашуунсухайт чиглэлийн 267 км замын зөвлөх үйлчилгээнд үр ашиггүй зарцуулалт хийгдсэн” гэж ерөнхийлөн дүгнэжээ.

5.24 Барилга, хот байгуулалтын салбарт хэрэгжсэн төслийн хяналтыг тус салбарын сайдын шийдвэрээр “Дэд бүтэц” төслийн нэгж, мөн “Гудамж” төслийн нэгж татан буугдсанаар Сангийн яамны дэргэд “Хөгжлийн хөтөч-дэд бүтэц” төслийг баталж, төсөл

хэрэгжүүлэх нэгж байгуулсан ч тэдгээрийн үйл ажиллагааны үр дүнгийн асуудал хөндөгдөөгүй орхигдсон байна.

5.25 Засгийн газрын 2014 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн “Оюутолгой төслийн санхүүжилтийн хүрээнд шаардагдах зардлыг шийдвэрлэх тухай” 274 дүгээр тогтоолоор Оюутолгой төслийн үр ашигтай байдлыг хангах, төслийн бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай стратеги, санхүү, хууль болон олон нийтийн харилцааны зөвлөх үйлчилгээнд шаардлагатай 10.0 сая ам.долларын зээлийг баталснаас олгосон санхүүжилт, үр дүнгийн байдалд нарийвчилсан шалгалт хийгдээгүй байсан.

5.26 МУХБ-ны эх үүсвэрээр төсвийн хөрөнгө оруулалтын шинж чанартай төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх үеийн буюу Гаалийн ерөнхий газар, Шадар сайдын багц, БСШУС-ын салбарын хүрээний нэг бус төсөл, арга хэмжээний талаар тус тус харгалзан ЗТХЯ, Онцгой байдлын Ерөнхий газар болон Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хороонд хандаж нэмэлт тайлбар, тодруулгыг авах тухай хүсэлт явуулж, дараах албан хариуг авсан.

- **Зам, тээврийн хөгжлийн яам:** /ЗТХЯ/ Тус салбарт олгосон нийт 1,320,165.8 сая төгрөгийн зээлийн (86+4) TAX-ний хүрээнд:

- ◆ Тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын хүрээнд тус яамны ТНБД-ын удирдамжаар байгуулагдсан ажлын хэсэг шалгалт хийж, тайлан баримт бичгийг сайдын 2018 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 01/3244 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлжээ.
- ◆ Нийт 90 TAX-ний хүрээнд гэрээний үнийн дун 1,567,529.3 сая төгрөг байсан байна.
- ◆ Авто замын барилгын 53, авто замын хяналтын 16, авто замын зургийн 12, гүүрийн барилгын 5, төмөр замын барилгын 4 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэгч, Хөгжлийн банк, захиалагч гэсэн 3 талт гэрээг байгуулж байжээ.
- ◆ ЗТХЯ-ны архивд байсан Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн 35, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын архивд байсан 2 төсөл, арга хэмжээний ХАА-ны баримт бичигт хяналт хийсэн ч үлдэх TAX-ний мэдээлэл, баримтгүй тул хяналтын ажил орхигдсон байжээ.
- ◆ Тус салбарт хэрэгжсэн 90 TAX-ний гэрээний биелэлт, хэрэгжилтийн байдлыг дүгнэх ажлын хэсэг, Хөгжлийн банкны төлөөллийг оролцуулан 2 чиглэлд нийт 14 төслийн ашиглалтын байдлыг хянасан байна.

- **Хөгжлийн банкны эх үүсвэрээс санхүүжүүлсэн авто замын төслийн хэрэгжилтийг хянан үзсэн тайлан<sup>30</sup>,**

- ◆ Засгийн газрын 124 дүгээр тогтоолоор 18 чиглэлийн 24 TAX-г 2013 онд 570 тэрбум төгрөгөөр Хөгжлийн банкнаас санхүүжүүлэхээр батлахдаа 4 чиглэлийн 10 төслийн 331.7 км авто замын үнийн дунг тусгаагүй;
- ◆ Тогтоолоор батлагдсан хөрөнгийг Хөгжлийн банк гаргаж чадаагүй, дараа он руу шилжүүлсээр ирсэн;
- ◆ Хөрөнгийн эх үүсвэр тодорхойгүй байхад аймгийн төвүүдийг холбох зам, барилгын ажлыг бүгдийг нь эхлүүлэхийн тулд Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэх төслийн жагсаалтад оруулах, дутсан санхүүжилтийг дараагийн ээлжид шийдвэрлүүлэх, хойшлуулах зэрэээр асуудалд хандаж байсан;
- ◆ Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын гэрээг ажлын тоо хэмжээ, улирлын үргэлжлэх хугацаа, газар зүйн онцлогийг үл харгалзсан, нэгэн ижил загвараар буюу 1 км авто замыг 530 орчим сая төгрөгөөр байгуулсан нь уулархаг бүсэд замын төсөөт өртөг хүрэлцэхгүй болсон;
- ◆ Олон жилийн өмнө хийгдсэн зураг төслийг дахин хянаж баталгаажуулах ажил хийгдээгүй, талбайн хяналтыг шаардлагын түвшинд хэрэгжүүлж чадаагүй;
- ◆ Гүйцэтгээгч зөвлөхийн хяналт хэрэгжүүлэх ААНБ-уудын санхүү, техник, тоног төхөөрөмж, хүн хүчиний чадамжийг үл харгалзан гэрээ байгуулсан;
- ◆ Гэрээт ажил хэрээжих хугацаанд импортын материалын үнэ өссөн нь гэрээний хэрэгжилтэд нөлөөлсөн. Жишээ нь: Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 67 км авто зам /Загастайн даваа орчим/-ын төсөөт өртөг

<sup>30</sup> Эх сурвалж: Хөгжлийн банкнаас санхүүжүүлэн зам, тээврийн салбарт хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хийсэн шалгалтын танилцуулга

нэмэгдэх шаардлагатай буюу нийт төсөөт өртгийг дутуу баталснаас болж, хугацаанд нь хэрэгжүүлж чадаагүй байна/;

- ◆ Төмөр замын барилгын ажлын талаар зээлийн зарцуулалтын байдалд тойм дүгнэлт хийхэд барилга угсралтын ажлын газарт буусан буюу бодит байдлаар боссон ажлаас гадна бодит байдалтай нийцэхгүй доорх ажлын зардлыг хэтрүүлэн үр ашиггүй зардал гаргасан гэж дүгнэсэн. Үүнд:
  - ◊ “МТЗ” ТӨХК үйл ажиллагааны зардалд 2,301,287 ам.доллар зарцуулсан. “МТЗ” ТӨХК-ийн хэрэгжүүлж буй “Шинэ төмөр зам” төслийн мэргэжлийн ажлын багаас гадна компанийн төв байранд компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлд ямар ч хамааралгүй, үр бүтээлгүй, зорилго тодорхойгүй, ажлын байр олноор бий болгосон, компанийн дотоод менежмент, хөдөлмөр зохион байгуулалт туйлын хангалтгүй гэдгийг тогтоосон.
  - ◊ Техникийн зөвлөх үйлчилгээнд зүүн чиглэлийн зам буюу Даланзадгад-Сайншанд-Хөөт-Чойбалсан чиглэлийн 1165 км замд 5.8 сая ам.доллар, Ухаахудаг/тавантолгой/-Гашуунсуухайт чиглэлийн 267 км замын техникийн зөвлөх үйлчилгээнд 2.4 сая ам.доллар зарцуулсан. Техникийн зөвлөхийн өгсөн мэргэжил арга зүйн зөвлөмж нь туйлын ядмаг бөгөөд зөвлөмжийн ач холбогдол бүхий нэгдсэн тайлангүй гэж дүгнэсэн байна.
  - ◊ Зүүн чиглэлийн зам буюу Даланзадгад-Сайншанд-Хөөт-Чойбалсан чиглэлийн 1165 км замын хуулийн зөвлөх үйлчилгээнд 4.09 сая ам.доллар, Ухаахудаг/тавантолгой/-Гашуунсуухайт чиглэлийн 267 км замын зураг төсөл болоод барилгын ажлын гэрээтэй холбоотой хуулийн зөвлөх үйлчилгээнд 2.07 сая ам.доллар зарцуулсныг “МТЗ” ТӨХК нь дотооддоо зохион байгуулах бүрэн боломжтойг тэмдэглэсэн.
  - ◊ “Даланзадгад-Сайншанд-Хөөт-Чойбалсан” чиглэлийн 1165 км замын зураг төслийн гэрээтэй холбоотой санхүүгийн зөвлөх үйлчилгээнд 1.9 сая ам.доллар, Ухаахудаг/тавантолгой/-Гашуунсуухайт чиглэлийн 267 км замын зураг төсөл болоод барилгын ажлын гэрээтэй холбоотой санхүүгийн зөвлөх үйлчилгээнд 0.9 сая ам.долларыг тус тус зарцуулсан бол энэхүү санхүүжилтийг “МТЗ” ТӨХК нь дотоод нөөц бололцоог ашиглан зохион байгуулж болох байсныг цохон тэмдэглэсэн.
  - ◊ Нэхцөл байдлаас үзэхэд зөвхөн 3 төрлийн зөвлөх үйлчилгээнд 17.3 сая ам.долларыг үр ашиггүй зарцуулсан байна гэж дүгнээд “МТЗ” ТӨХК-ийн удирдлага болон түүний ТУЗ нь удирдлага, зохион байгуулалтын хуульд хангалтгүй, зээлийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, хэрэв нарийвчлан авч үзсэн бол залилангийн шинж чанарыг агуулж байсан байна.

- **Гаалийн өрөнхий газар:** /ГЕГ/ Тус салбарт олгосон нийт 31,105.7 сая төгрөгийн зээлийн 2 TAX-ний хүрээнд:
  - ◆ Нарийвчилсан хяналт шалгалтын талаар дурдаагүй, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 350 дугаар тогтоолоор төсөл хэрэгжсэн дүнгээр Зам, тээврийн хөгжлийн яаманд балансад шилжүүлсэн байна.
- **Эрчим хүчиний яам:** /ЭХЯ/ Тус салбарт олгосон нийт 582,614.4 сая төгрөгийн зээлийн 50 TAX-ний хүрээнд:
  - ◆ Нарийвчилсан хяналт шалгалтын талаар дурдаагүй, хэрэгжсэн гэх 50 төслийн жагсаалтаас улсын комиссын актаар баталгаажаагүй 1, төсөөтэй тооцоо нийлсэн болон гүйцэтгэгч гэрээт ажлаа хугацаанд нь дуусгаагүйгээс шүүхэд хандсан 2 төсөл гэх зэрээр зөвхөн жагсаалт ирүүлжээ.
- **Барилга, хот байгуулалтын яам:** /БХБЯ/ Тус салбарт олгосон нийт 171,807.9 сая төгрөгийн зээлийн 37 TAX-ний хүрээнд:
  - ◆ Нарийвчилсан шалгалт хийгдээгүй, Хөгжлийн банкны санхүүжилтээр 2012-2016 онд 34 TAX-г хэрэгжүүлснээс “Дэд бүтэц” төслийн нэгж 23 /төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий “Дэд бүтэц” төслийн нэгжийг салбарын сайдын 2013 оны 92 дугаар тушаалаар байгуулсан/, яам хариуцан 11 төслийг хариуцан хэрэгжүүлснийг тэмдэглэснээс өөрөөр ач холбогдол бүхий асуудлыг хөндөөгүй байна.
- **Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам:** /УУХҮЯ/ Тус салбарт олгосон нийт 11,098.9 сая төгрөгийн зээлийн 3 TAX-ний хүрээнд:

- ◆ Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт хэрэгжсэн “Нүүрснээс синтетик байгалийн хий үйлдвэрлэх” төслөөс нарийвчилсан ТЭЗҮ-г УУХҮЯ-ны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөр хэлэлцүүлж хүлээн авснаар төслийн үйл ажиллагаа зогссон, “Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор” төслийн нэгжийг Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 9 дүгээр тогтоолоор татан буулгажээ.
  - ◆ Гэвч дээрх 2 төслийн нэгж татан буугдахад тэдгээрийн санхүүгийн үйл ажиллагаа, зээлийн ашиглалт, зарцуулалт, үр дүн болон төслийн нийт үр өгөөж, үр нөлөөт байдлын тухай хяналт шалгалтын танилцуулгад дурдсан зүйлгүй байна.
  - ◆ “Замын-Үүд дэх Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламжийн автоматажуулалт” төсөл хэрэгжиж дууссан байна.
- **Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам:** /ХХААХҮЯ/ Тус салбарт олгосон нийт 7,995.0 сая төгрөгийн зээлийн 1 ТАХ-ний хүрээнд:
- ◆ Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг чиглэлийн дагуу хийсэн хяналт шалгалтын тайланг ирүүлснээс гадна яамны Дотоод аудитын хорооноос өмнө нь зээлдүүлэгчийн төлөөлөл болоод Тариалан эрхлэлтийг дэмжих сан, ХХААХҮЯ-ны хамтарсан шалгалтын дунг үндэслэн 2016 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр батламжилсан 01 тоот тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Газар тариалангийн агуулах” худалдан авах ажиллагаатай холбоотой гарсан зөрчилд АТГ эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байгаа гэх боловч уг хэрэг хэрхэн шийдвэрлэгдсэн талаар мэдээлэлгүй байна.
- **Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам:** /БСШУСЯ/ Тус салбарт олгосон нийт 2,000.0 сая төгрөгийн 1 ТАХ-ний хүрээнд:
- ◆ Сангиин сайд, Эрүүл мэнд, спортын сайд /хуучин нэрээр/, Хөгжлийн банкны Гүйцэтгэх захирлын хамтарсан 2015 оны “төсөл санхүүжүүлэх өрөнхий нөхцөлийг тохиорлох гэрээ” 77/2/283, 1/22 дугаар бүхий гэрээгээр “Увс аймгийн Улаангом сумын наадмын талбайн дуусгал 2500 суудал” нэртэй 2,000.0 сая төгрөгийн ажил хийгдэж, мэдээлэл ирүүлэх асуудлаар Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны дарга Б.Бат-Эрдэнэд хандана уу гэсэн хариуг ирүүлжээ.
- **Шадар сайдын багц:** Тус салбарт олгосон нийт 20,000.0 сая төгрөгийн 1 ТАХ-ний хүрээнд:
- ◆ Сангиин сайд, Хөгжлийн банкны гүйцэтгэх захиралтай байгуулсан 2015 оны 74/2/280/131 тоот гэрээний дагуу Онцгой байдлын албан дээрээсээ “Увс аймгийн Улаангом сумын наадмын талбайн дуусгал 20.0 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосноор төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж дууссан байна.
- **Сангийн яам:** УИХ-ын ХШТХ-ны 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн “Мэдээлэл ирүүлэх тухай” УИХ-16/8655 дугаар албан бичгийн хариуг 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 03/8116 дугаар бичгээр хариу ирүүлсэн. Тус салбарт олгосон нийт 87,649.7 сая төгрөгийн 3 ТАХ-ний хүрээнд:
- ◆ Засгийн газрын 2014 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 274 дүгээр тогтоолоор баталсан “Эрдэнэс Оюутолгой” төслийн зөвлөх үйлчилгээний төсөлд Сангийн яам, “Эрдэнэс Оюутолгой” ХХК болон Хөгжлийн банк хоорондын гурван талт 2014 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр байгуулсан “137/3-ОТ-С 2014-99” дугаартай 2 жилийн хугацаатай, жилийн 7.65 хувийн хүүтэй, нийт 10.0 сая ам.долларын гэрээг байгуулж, нийт 2014 оны 11 дүгээр сараас 2015 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийг хүртэл 8 удаагийн санхүүжилтээр нийт 2,512,000.20 ам.долларын “зээл олгосон ч санхүүжилтийн үр дүнг тооцож тодорхойлсон зүйлгүй” байна.
  - ◆ Хувийн орон сууцны зээлийн санхүүжилт болон нэмэлт санхүүжилтийн төсөлд зориулан 2012, 2013 онд Сангийн яам, Хөгжлийн банкны ТҮЗ, Төрийн банктай 2012 оны 05 дугаар сарын 16-ны өдөр 50.0 тэрбумын болон 2013 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр 30.0 тэрбум төгрөгийн буюу нийт 80.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийн гэрээ байгуулж, дамжуулан зээлийн санхүүжилт олгосон. Дээрх төслийн зээлийн гэрээнд нэмэлт оруулсан асуудал байсан бөгөөд энэхүү өөрчлөлт 2013 оны 12 дугаар сард тус тус хийгдэж нийт 80.0

тэрбум төгрөгийн зээлийг ам.доллар /дундаж ханш 1375.18/-т хөрөүүлснээр нийт 58.4 сая ам.доллар болсон. Сангийн яам, Хөгжлийн банк 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр нийт өглөг, авлагыг харилцан суутгаж, хүүгийн хамт 145.4 тэрбум төгрөгөөр /тооцоо нийлэх үеийн ханш 2489.53/ тооцоо нийлжээ.

- ◆ Гудамж төслийн үйл ажиллагааг шинээр байгуулагдсан “Хөгжлийн хөтөч-Дэд бүтэц төсөл”-ийн нэгж үргэлжлүүлэн хариуцжээ. Төслийн үйл ажиллагаанд ҮАГ-аас аудит хийсэн ч аудитын мөрөөр тус нэгж ямар үйл ажиллагаа явуулж үр дүнд хүрсэн нь тодорхойгүй байна. Түүнчлэн АТГ-ын Мөрдөн шалгах хэлтсээс нээсэн 2016 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 06/6278, 10 дугаар сарын 11-ний өдрийн 06/7014, 11 дүгээр сарын 18-ны өдрийн 03/6016, 2017 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 06/1379, 08 дугаар сарын 10-ны өдрийн 03/6016 дугаар албан бичгээр “эрүүгийн 2014250003287 дугаартай хэргийн хэрхэн шийдвэрлэгдсэн байдлын талаар ямар ч мэдээлэлгүй” байна.
- **НЗДТГ:** Нийслэлийн бүсэд дэд бүтцийг сайжруулах чиглэлээр олгосон нийт 305,790.1 сая төгрөгийн 171 TAX-ний хүрээнд:
  - ◆ Төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг нээлттэй сонгон шалгаруулалт явуулалгүйгээр сонгож шууд гэрээ байгуулсан нь хуулийн зохих шаардлагатай нийцээгүй, үүнээс шалтгаалан төслийн үндэслэл, тооцоолол, төсөвт шинжээч ажиллуулах шаардлага үүсэж байсан.
  - ◆ Гудамж төслийн хүрээнд баригдах авто замын ажлын зураг төсөл боловсруулахаас зам, барилга угсралтын ажлыг бүрэн дуусгах хүртэл хяналт, зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх гэрээтэй “Си ти ай инженеринг интернейшил” ХХК нь төрийн захирагааны төв байгууллагад бүртгэлгүй, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлгүй байгууллага захиалагчийн хяналтыг гүйцэтгэсэн байна.
  - ◆ Аттар өргөөгийн уулзвараас Яармагийн гүүр 1 км авто замын барилгын ажилд 2013 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр 440.0 сая төгрөгөөр гэрээ байгуулсан ч зураг төсвийг магадлалаар баталгаажуулсны дараа дахин гэрээ байгуулж гэрээний үнийн дунг 1,895.5 сая төгрөг болгон өөрчилж байжээ.
  - ◆ Засгийн газрын 118 дугаар тогтоолоор “Дэд бүтэц” төслийн дэд бүтцийн барилга байгууламж, шугам, сүлжээний ажлыг гүйцэтгэхээр тусгагдсан 2 ажил нь төсөл хэрэгжихээс өмнө гүйцэтгэсэн ажил байгаа ба эдгээр ажил нь төсөвт өртгийн ихээхэн зөрүүтэй, хугацаандаа ашиглалтад ороогүй байжээ.
  - ◆ Төслийн үр дүнд шинээр 36.2 км авто зам, 123.0 у/м гүүр барьж, 68.06 км авто зам өргөтгөн шинэчилсэн, 22 уулзварын өргөтгөл шинэчлэлтийг хийж, гэр хорооллын 9 гудамжны зам барилгын ажлын тохижилт хийгдэж, зам барилгын 93 зураг төсөл /цаашид ашигласан эсэхийг тодруулах шаардлагатай/ боловсруулагдаж, авто зам дагуу 1306 ширхэг гэрэлтүүлэг хийгдсэн.
  - ◆ Гэр хорооллын 3 гудамжны зураг төслийг боловсруулж, шинэчлэлтийн ажлыг авто зам, дэд бүтцийн барилгын хамт хийж, Хүй 7 худгийн тохижилтын зураг төслийг боловсруулж, тохижилт, зам барилгын ажлыг гүйцэтгэсэн. Туулын хурдны зам, Сэлбэ голын ТЭЗҮ, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийж, зураг төслийг гүйцэтгэсэн.
  - ◆ Гэр хорооллын дахин төлөвлөлтийн байршилуудад цахилгааны хаалттай дэд өртөө 47 ком, цахилгаан хуваарилах байгууламж 5 ком, цахилгааны дэд станц 4 ком, цахилгааны 171.5 км шугам, дулааны бага оврын 12 ширхэг эх үүсвэр, цэвэр усны 11.9 км шугам, бохир усны 7.6 км, дулааны 13 км шугам, ус хангамжийн 5.8 км шугам, ариутгах татуургын 3.6 км шугам сүлжээ ашиглалтад оруулсан гэж мэдээлсэн.

5.27 Төсвийн хөрөнгөөр эргэн төлөгдөх нөхцөлтэй төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд нарийвчилсан хяналт хийх тухай Засгийн газрын 2016 оны 49, 2017 оны 52 дугаар хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгавар нь бүхэлдээ дурдсан хяналт шалгалтын ажлын үр дүнд суурилан төсвийн хөрөнгө оруулалтын шинж чанартай төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг сайжруулах, цаашид авах арга хэмжээний дүгнэлт санал нь МУХБ-ны үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн ажиллуулахад чиглэгдэж байсан ч энэхүү шалгалтын үр нөлөөг тооцсон гэх хангалттай баримт материал алга байна.

**Сангийн яам, Монголбанкны хамтарсан шалгалтын ажлын хэсэг /2020 он/ шалгалтынхаа дунд суурилсан шуурхай арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй**

5.28 Сангийн яам, Монголбанкны хамтарсан шалгалтын гол зорилго нь 2019 онд МУХБ-нд хийсэн өргөтгөсөн хяналт шалгалтаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилттэй танилцах, банкны өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журмын хэрэгжилт болон үйл ажиллагааны нөхцөл байдлыг бодитоор үнэлэхэд оршиж байсан.

5.29 МУХБ-ны үйл ажиллагаанд 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдрөөр тасалбар болгон Засгийн газар, Монголбанкнаас хамтарсан шалгалт /өргөтгөсөн/-ыг гүйцэтгэсэн. Энэхүү шалгалтын дүнд үндэслэн Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн 169 дүгээр тогтоолоор илэрсэн нөхцөл байдалтай уялдуулан алдаа зөрчлийг засаж ажиллахыг Хөгжлийн банкны ТҮЗ-д даалгасан шийдвэр гарснаас өөрөөр үр дүнг үнэлэх зүйл алга байна.

5.30 Сангийн яам (Монголбанктай хамтарсан) 2020 хийж гүйцэтгэсэн хяналт шалгалтын тайлангаа 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн албан бичгээр Хянан шалгах Түр хороонд ирүүлсэн.

5.31 Энэхүү хамтарсан шалгалт нь 2019 онд тус банканд хийсэн өргөтгөсөн хяналт шалгалтаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилттэй танилцах, банкны өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журмын хэрэгжилт болон үйл ажиллагааны нөхцөл байдлыг бодитоор үнэлэх зорилготой байсан гэж ирүүлсэн албан бичигт дурджээ.

5.32 Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” 122 дугаар тогтоолоор “Монгол Улсын Хөгжлийн банк” ХХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлж байхаар тогтоож, 2020 оны 129 дугаар тогтоолоор банкны дүрмийг шинээр баталснаар Сангийн яам энэхүү шалгалтыг ахалсан.

- Гэвч ажлын хэсгийн хамтарсан шалгалтын тайлангаас үзэхэд тус банкны үйл ажиллагаанд үссэн хүндрэлтэй байдлын нөхцөл, учир шалтгааны талаар дурдсан зүйлгүй, шалгалтын дунд үндэслэсэн хариу арга хэмжээний талаар тайлagnaагүй байгаа нь энэхүү шалгалтын тайланг “Хөгжлийн банк”-д албажиж хүргүүлээгүй байгаатай холбоотой гэж үзэж болохоор байна.
- Тайланийн агуулгыг нягтлан үзэхэд хамрах хүрээний асуудлаар нөхцөл байдалд сууриссан мэдээллийг дурдсанаас өөрөөр дүн шинжилгээнд сууриссан тодорхой гаргалгаа бүхий асуудлыг хянан шалгагчдын зүгээс олж хараагүй болно.
- Тайланд дурдсанаар зөвхөн зээлийн орчны асуудлаар цаашид авах арга хэмжээний санал гэсэн асуудлаар сайжруулалт хийхийг дурдсанаас өөрөөр “нөхцөл байдал”-д сууриссан холбоотой талуудын хүлээх ёстай хариушлага, ёс зүйн болоод нийтээр хүлээх алдагдал түүнээс улбаалан талуудын оролцоог хөндсөн, тэдгээрт үндэслэгдсэн хууль тогтоомжийн үл нийцэлтэй холбогдсон асуудал энэхүү тайланд тусгагдаагүй байна.

5.33 Хөгжлийн банкны 2020 оны 04 дүгээр сарын 1-ний өдрийн банкны бүртгэлээр 1.8 их наяд төгрөгийн 44 зээлдэгчийн зээлийн ангиллыг бууруулж, шинэчлэн тогтоосноор нийт 787.4 тэрбум төгрөгөөр зээлийн эрсдэлийн санг нэмэгдүүлэх тохируулгын гүйлгээ хийхийг чиглэл болгосон.

5.34 Банкны өөрийн ангилснаар зээлдэгч бүрд байгуулсан сангийн хувийн дундаж хэмжээ 16.9 хувь байсан бол тохируулга хийснээр 45.7 хувь, сангийн зөрүү 28.8 хувьд хүрсэн гэдгийг онцолсон нь энэхүү шалгалтын онцлог байна.

5.35 Ажлын хэсгийн хамтарсан шалгалтаар,

- II “Зээлийн үйл ажиллагаа”-тай холбогдуулан цаашид авч хэрэгжүүлэх 7 арга хэмжээний саналын гол агуулга нь,
  - Зээлийн орчны хяналт удирдлагын тогтолцоог сайжруулж, батлагдсан дүрэм журмыг дагаж мөрдөх, эрсдэлийн санг зохих ёсоор байгуулж, стандартын дагуу банкны бүртгэл, тайланд үнэн зөв бүртгэх, зохицуулалтгүй болон сайжруулалт шаардлагатай дүрэм журам, мөн тус банкны хуульд оруулах өөрчлөлт, мэргэжлийн удирдлага ур чадварын асуудлаар дотоод хяналтын тогтолцоог төлөвшүүлэх асуудлыг хөнджээ.

- /III/ “Активын бүтэц, бусад актив хөрөнгийн удирдлага”-ын талаар тайланд хэрхсэнийг авч үзвэл, шалгалтаар активын бүтцэд гарсан үндсэн үзүүлэлтийн өсөлт бууралт буюу өөрчлөлтийг харуулж, дотоодын арилжааны банкуудад байршуулах мөнгөн хөрөнгийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлэх, бүртгэлтэй хөрөнгө оруулалт, үнэт цаас, өрийн бичгийн мэдээллийг дурдсаны зэрэгцээ авлага, үнэ цэнэ буурч болзошгүй болон эрсдэлтэй активын төлөвтэй уялдуулан зохих журмын дагуу ангилж, бүртгэл тайланд тусгах асуудлыг хөндсөн байна.
  - Тухайн үед хурийн түүгийн нийт 334.0 тэрбум төгрөгийн хүүгийн авлага бүртгэлтэй, үүнээс 321.0 тэрбум төгрөг буюу нийт зээлийн хүү, түүний 288.9 тэрбум төгрөг буюу 90.0 хувь чанаргүй зээлд хамаарч байсныг дурдажээ.
- /III/ “Татан төвлөрүүлсэн хөрөнгө, төлбөр түргэн чадвар”-ын асуудлаар тайланд дурдсанаар татан төвлөрүүлсэн хөрөнгийн хувьд өсөлт гараагүй, бүтцийн хувьд тогтвортой, банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлтийг хангаж байгаа ч цаашид зээлийн орчны чанаргүй төлөв, эрсдэлийн сан нэмж байгуулсан тохиуулгын гүйлгээний дараа ч гэсэн гадаад эх үүсвэр татах үеийн байгуулсан гэрээний хэрэгжилтэд нөлөөлж болзошгүй байдлыг хөндсөн.
  - Татан төвлөрүүлсэн хөрөнгө, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлтийг хангаж байхуйц урьдчилсан нөхцөлийг тооцож байх, банкны санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд СТОУС-ыг нэн даруй нэвтрүүлэх, эх үүсвэрээ байршуулсан банк, санхүүгийн байгууллагатай тохирч төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлтийг шинэчлэн тогтоох арга хэмжээний саналыг бичсэн.
- /IV/ “Зах зээлийн болон үйл ажиллагааны эрсдэлийн мэдрэмж” хэсэгт ТҮЗ-ийн 2019 оны 76 дугаар тогтоолоор баталсан эрсдэлийн удирдлагын бодлогыг удирдлага болгон ажиллаж, чиг үүргийг хэрэгжүүлсэн байдлын талаар авч үзсэн ба тайланд хүүгийн болон ханшийн эрсдэлийг онцгойлон алдагдал хүлээж болзошгүйг сэргийлж дурдсан.
  - Энэхүү асуудлаар “зөвхөн” удирдлагын түвшинд хянан үзэж, актив пассивын удирдлагын хороо нь үр нөлөөтэй ажиллах шаардлагыг дэвшүүлжээ.
- /V/ “Өөрийн хөрөнгийн хүрэлцээ” банкны чанаргүй актив нэмэгдэхийн хирээр шалгуур үзүүлэлт буурч бодит байдлаар хөрөнгийн хүрэлцээг хангаж чадахгүйд хүрэхийг сануулсан байна.
  - Нийт зээлийн багцад хийсэн шинжилгээгээр 787.4 тэрбум төгрөгийн үнэ цэнийн бууралт нэмж бүртгэгдсэнээр тус банкны нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа 5.51 хувь, нийт өөрийн хөрөнгийн зохистой харьцаа 4.86 хувь болж алдагдах, шаардлагатай нэмэлт өөрийн хөрөнгийн хэмжээ 230.9 тэрбум төгрөгт хүрнэ гэж тооцоолсон.
  - “Ашигт ажиллагааны шинжилгээ”-ээр цэвэр хүүгийн харьцааг 0.8 хувь гэж тооцоолон эрсдэлийн сангийн зардал өсөж байгаатай холбогдуулан өөрийн хөрөнгийн өгөөж хасах утгатай болж эрсдэлийн сангийн зардал, нийт орлогын харьцаа 480.7 хувь байгаа тул чанаргүй актив болон алдагдлын хэмжээг бууруулахад онцгой анхаарч ажиллахыг зөвлөсөн байна.
- /VI/ “Банкны бүтэц, удирдлага, зохион байгуулалт”-ын хувьд өмнөх шалгалтаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүйг тэмдэглэж, энэ нь банкны үйл ажиллагааны дотоод хяналт, удирдлага болон ажилтнуудын сахилга хариуцлагатай холбоотой гэж үзсэн.
  - Тус банкны үйл ажиллагаанд сүүлийн 2 жил дараалан 2 удаагийн хамтарсан шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний хэрэгжилт бүрэн хангагдахгүй, удаашралтай, удаа дараа давтагдсан, хангагдах эсэх нь тодорхойгүй, үр дүн хангалтгүй, ажилтнуудын сахилга хариуцлага дунд зэрэг хэвээр байна гэж дүгнэжээ.

## Хамтарсан ажлын хэсэг тайлангаа албан ёсны болгож МУХБ-нд хүргүүлээгүй байна

5.36 Засгийн газрын 2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” 122 дугаар тогтоолоор МУХБ-ны төрийн эзэмшилийн хувьцаа эзэмшигчийн эрхийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад шилжүүлснээр энэхүү шалгалтыг гүйцэтгэх гол үндэслэл болсныг дурдаж байна.

5.37 Энэхүү хяналт шалгалтын ажлын үр нөлөө нь цаг хугацааны хувьд болон ил тод байдлын хувьд ач холбогдлоо алдсан. ХШТХ-ноос анх 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн “Нотлох баримт ирүүлэх тухай” УИХ-16/8039 дүгээр албан бичгээр ажлын 2020 оны тайлан гаргасан шийдвэр, өгсөн чиглэл, үүрэг даалгаврын хэрэгжилтийг ирүүлэхийг хүссэн.

5.38 ХШТХ-ны даргын 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн УИХ-16/10569 дугаар бүхий “Шаардлага хүргүүлэх тухай” албан бичиг явуулсны хариуд энэхүү дотоод албан хэрэгцээний гэгдэх тайланг 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр ирүүлсэн.

5.39 Сангийн яамны тайлбарт хамтарсан ажлын хэсгийн 2020 онд тус банканд хийсэн шалгалтыг дотоод албан хэрэгцээний шалгалт хэмээжээ. Хамтарсан ажлын хэсгийн шалгалт тодорхой үр дүнд хүрч ажилласан ч МУХБ-нд тайлангаа албан ёсоор хүргүүлээгүй, УИХ-ын ХШТХ-нд 2022 оны 11 дүгээр сард ирүүлсэн зэрэг нь хяналт шалгалтын ажлын үр нөлөө хангагдахгүй байх, шалгалтын мөрөөр хийх үе шатны ажлыг орхигдуулах, гаргасан саналын хэрэгжилт биелэгдэхгүй болж үр нөлөөг тооцох боломжгүйд хүргэсэн байна.

5.40 Ажлын хэсгийн тайланг МУХБ-нд албан ёсоор хүргүүлж тайлагнаагүй нь нөхцөл байдал улам хүндрэхэд хүргэсэн байж болзошгүй юм. Шалгалтын зорилго нь өмнөх шалгалтын үр дүнгийн байдалд хяналт хийх байсан боловч шалгалтын тайлан албан ёсоор албажаагүйгээс шалгалтын үр дүн гараагүй.

5.41 Ажлын хэсгийн хамтарсан шалгалтын тайлангаас үзэхэд тус банкны үйл ажиллагаанд үүссэн хүндрэлтэй байдлын нөхцөл, учир шалтгааны талаар дурдсан зүйлгүй, шалгалтын дүнд үндэслэсэн хариу арга хэмжээний талаар тайлагнаагүй байна.

5.42 Тайланд дурдсанаар зөвхөн зээлийн орчны асуудлаар цаашид авах арга хэмжээний санал хэсэгт үйл ажиллагааны чиглэл, горимын хувьд сайжруулалт хийх асуудлыг дурдсанаас өөрөөр нөхцөл байдалд суурилсан холбоотой талуудын хүлээх ёстой хариуцлага орхигдох эрсдэлийг үүсгэсэн.

5.43 Өөрөөр хэлбэл, хариуцлага ёс зүйн болоод нийтээр хүлээх алдагдал, түүнээс улбаалан талуудын оролцоог хөндсөн, тэдгээрт үндэслэгдсэн хууль тогтоомжийн үл нийцэлтэй холбоотой тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохих асуудал энэхүү тайланд тусгагдаагүй байна.

## Монголбанкны хэсэгчилсэн болон өргөтгөсөн хяналт шалгалтын үр дүн

5.44 МУХБ-ны тухай хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр болсноор Засгийн газартай хамтран хэсэгчилсэн болон ээлжит хяналт шалгалтыг гүйцэтгэсэн байна.

5.45 Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан удирдамж /2011.03.25-2017.04.26/ бүхий иж бүрэн хяналт шалгалтаар дараах асуудлыг илрүүлэн зөвлөмж өгч байсан байна.

- ☒ Хөгжлийн банкнаас шууд санхүүжүүлсэн зээл нь хуулийн 10.1.2-т заасан эдийн засгийн болон санхүүгийн үр ашигтай, зээлийг эргэн төлөх чадвартай байх гэсэн шаардлага хангагдаагүй;
- ☒ Банк эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 23.2-т заасны дагуу зээлийн хувийн хэргийн бүрдлийг хангаагүй;
- ☒ 2011 онд 602.2 тэрбум төгрөгийн, 2012 онд 5.7 тэрбум төгрөгийн, 2016 онд 191.8 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан;
- ☒ Шууд санхүүжүүлсэн 8 төсөл нь Зээлийн бодлогын 5.5 дахь заалт буюу барьцаа хөрөнгийн шаардлага хангаагүй;
- ☒ Хүүгийн болон ханшийн эрсдэл банкийг алдагдалд оруулах өндөр эрсдэл тогтоогдсон;

- ☒ Актив пассивын хугацааны зөрүүгийн шинжилгээгээр төлбөрийн чадварын эрсдэлд өртөж болзошгүй, хөрвөх чадварын удирдлагын бодлого тодорхойгүй “дефолт” үүсэж болзошгүй гэж дүгнэж байсан.

5.46 Уг шалгалтын дунд суурилан банкны тухай хууль, тогтоомжид заасан шаардлагуудын хүрээнд Хөгжлийн банкны ТУЗ-ийн үйл ажиллагаа, зохистой засаглал, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавихыг чиглэл болгож байсан байна.

5.47 Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан удирдамж /2017.04.26-2018.07.20/ бүхий Иж бүрэн хяналт шалгалтаар дараах гол асуудлыг хөндөж байсан байна. Үүнд:

- ☒ Хөгжлийн банкны зээлдэгч “Нью Хаппи”, “Хөтөл”, “Эрэл”, “Капитал банк” зэрэг компаниудын нийт 378.7 тэрбум төгрөгийн 9 зээлд үнэ цэнийн бууралт тооцож, нийт 80.3 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан нэмж байгуулах тухай Улсын байцаагчийн мэдэгдлийг хүргүүлсэн.
- ☒ Шалгах өдрөөр нэмж байгуулсан 80.3 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сангийн тохицуулгын гүйлгээг хийснээр МУХБ 3.5 их наяд төгрөгийн актив хөрөнгөтэй, 2.5 их наяд төгрөгийн татан төвлөрүүлсэн хөрөнгөтэй, 2.1 их наяд төгрөгийн зээлийн өрийн цэвэр үлдэгдэлтэй, 1.02 их наяд төгрөгийн өөрийн хөрөнгөтэй, 53.0 тэрбум төгрөгийн тухайн жилийн алдагдалтай, 157.7 тэрбум төгрөгийн өмнөх үеийн алдагдалтай байна гэж дүгнэсэн.

5.48 Уг шалгалтаар тус банканд мөрдөж байгаа “Зээлийн тусгайлсан болон бүлгийн эрсдэлийн сан байгуулах дотоод аргачлал”-ыг Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан 2017 оны А-294/340 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бodoх бүртгэлийн багц материал” болон Монголбанкны Ерөнхийлөгчийн 2017 оны А-251 дүгээр тушаалаар баталсан “Хөгжлийн банкны актив ангилах, активийн эрсдэлийн сан байгуулах журам”-тай нийцүүлэн баталж, мөрдөж ажиллах үүрэг өгсөн нь агуулгын хувьд өмнөх шалгалтаар өгсөн цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал давтагдсан шинжтэй байна.

- ☒ Зээлдэгчээс аудитлагдсан санхүүгийн тайланг авдаггүй;
- ☒ Барьцаа хөрөнгийг мэргэшсэн биш эдийн засагч үнэлж, зээлдэгч болон түүнтэй холбогдох этгээд нь бусад банк санхүүгийн байгууллагад чанаргүй зээлийн үлдэгдэлтэй байхад зээл олгосон;
- ☒ Олгосон зээлийн зарцуулалт болон төслийн гүйцэтгэлтэй холбоотой хяналт сул;
- ☒ Зээлийн эргэн төлөгдөх эх үүсвэр хангалтгүй, зээлийн бүтэц олон удаа өөрчлөгдсөн, хугацаа сунгагддаг зэрэг нийтлэг зөрчлүүд давтагдсан;
- ☒ Тусгайлсан зээлийн эрсдэлийн санг байгуулахдаа Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан 2017 оны А-294/340 дугаартай тушаалаар батлагдсан “Нягтлан бodoх бүртгэлийн багц материал” болон “Хөгжлийн банкны актив ангилах, активын эрсдэлийн сан байгуулах журам” баримтлаагүй;
- ☒ Бүлгийн эрсдэлийн санг байгуулах дотоод аргачлалыг баталж мөрдөөгүй;
- ☒ Зөвхөн 90 хоногийн хугацаа хэтрэлттэй болон хэвийн зээлүүдийг бүлэглэн авч үзэж байгаа нь мөн тухайлсан журмыг баримтлаагүй байжээ.

5.49 Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан удирдамж /2021.12.13/-тай хэсэгчилсэн шалгалтаар доорх гол асуудлыг хөндсөн. Үүнд:

- ☒ МУХБ-наас 2020 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 2/977 дугаар албан бичгээр тус банкны санхүүгүүлсэн төсөл, хөтөлбөрийн зээлд холбогдох журам, аргачлалын дагуу 2020 оны эхний хагас жилийн байдлаар 800.0 гаруй тэрбум төгрөгийн эрсдэлийн санг нэмж байгуулах тооцоо гарсан нь дараах хүндрэлд хүргэж болзошгүйг анхааруулан тайландаа тусгасан байна. Тухайлбал,
  - ✓ Банкны төлбөрийн чадвар, өөрийн хөрөнгийн хүрэлцээнд нөлөөлөх,
  - ✓ Гаднын банк, санхүүгийн байгууллагуудаас татсан эх үүсвэр буцаан дуудагдах зэрэг томоохон эрсдэлтэй эртнээс бодитойгоор нүүр тулаад байсныг харуулж байна.

5.50 МУХБ нь 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 44 зээлдэгчээс 6 зээлдэгчийн зээлд эрсдэлийн санг нэмж байгуулсан. Бусад зээлд эрсдэлийн сан нэмж байгуулах тохицуулгыг 2020 оны жилийн эцсийн байдлаар авч үзэхэд банкны тайлант үеийн алдагдал 779.9 тэрбум төгрөг, хуримтлагдсан алдагдал 934.5 тэрбум төгрөгт хүрч өсөх тооцоолол гарч байсан.

5.51 Монголбанкны 2021 оны 7 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон хийсэн хэсэгчилсэн шалгалтаар хийсэн тохицуулах бичилтийн дараа МУХБ нь 3.3 их наяд

төгрөгийн актив хөрөнгөтэй, 1.5 их наяд төгрөгийн зээлийн цэвэр өрийн үлдэгдэлтэй, 259.4 тэрбум төгрөгийн өөрийн хөрөнгөтэй болж, банкны тухайн жилийн алдагдал 742.0 тэрбум төгрөг, хурийтлагдсан алдагдал 987.6 тэрбум төгрөгт хүрэх болсон байна.

5.52 Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан удирдамж /2021.12.13/-тай “Хэсэгчилсэн шалгалт”-аар МУХБ-ны санхүүгийн голлох үзүүлэлт дараах байдалтай байсанд дүгнэлт өгсөн. Үүнд:

- Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан журамд заасны дагуу МУХБ-ны 2019 оны жилийн эцсийн тайлан тэнцэлд бүрэн байгуулагдаагүй нийт 337.8 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн санг нэмж байгуулах тохируулгын гүйлгээг хийж, нийт 305.0 тэрбум төгрөгийн тайлант үеийн алдагдалтай, 460.0 тэрбум төгрөгийн хурийтлагдсан алдагдалтай болсон<sup>31</sup>.
- Сангийн яам 2020 оны 2 дугаар сараас эхлэн МУХБ-ны хувьцаа эзэмшигч болсонтой холбоотой Сангийн яам, Монголбанкны хамтарсан иж бүрэн шалгалт /2020.04.01-ний байдлаар/ хийх үед тус банкны 1.8 их наяд төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэл бүхий 44 зээлдэгчийн зээлд 787.4 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн санг нэмж байгуулахаар тооцоолж байсан.

5.53 Тайланд тэмдэглэгдсэнээр Сангийн сайд болон Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдөр хамтран баталсан МУХБ-ны үйл ажиллагаанд хийх хамтарсан шалгалтын удирдамжийн дагуу хийгдсэн газар дээрх иж бүрэн шалгалтын дүн эцэслэсэн байдлаар батлаагүйг “тэмдэглэсэн” юм.

5.54 Монголбанкны оролцоотойгоор хийгдсэн хяналт шалгалтаар зээлийн эрсдэлийн сангийн хэмжээг зохистой түвшинд байгуулахыг чиглэл болгон ирсэн ч тэр бүр хэрэгжилт хангагдаагүй байсан.

Дурслэл 9. Хөгжлийн банкны зээлийн эрсдэлийн санг нэмж байгуулах зөвлөмж, тохируулга (тбл.төг)

	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022*
ХӨНДЛӨНГИЙН АУДИТ	PwC	PwC	PwC	Deloitte Orch audit	Deloitte Orch audit	KPMG	KPMG	KPMG	KPMG	KPMG
ЗАСГИЙН ГАЗАР	6.2	24.7	46.4	115.4	21.1	21.2	13.9	-	349.4	
МОНГОЛБАНК				352.4			320.5			
ҮНДЭСНИЙ АУДИТИН ГАЗАР					476.6	80.3	337.8	787.4	755.7	792.6



5.55 МУХБ нь жилийн эцсийн санхүүгийн тайлан, НББ-д хийвэл зохих зээлийн чанарын үзүүлэлттэй холбоотой тохируулга бичилт буюу үнэ цэнийн бууралтаас шалтгаалж бий болох эрсдэлийн сангийн хэмжээг хөндлөнгийн аудитын байгууллагын зөвлөмжөөр тайлагнадаг байсан бөгөөд эрх бүхий байгууллагын нийт 6 удаагийн шалгалтаар эрсдэлийн сангийн хэмжээнээс материаллаг дүнгээр зөрүү үүсэж байсан нь Монголбанк болон хөндлөнгийн баталгаажуулах аудитын хяналт шалгалтын дүгнэлт зөвлөмж тэр болгон үр дүнтэй байж чадаагүйг илтгэж байна.

#### Монголбанк шалгалтын материалыг баталсан шийдвэртээ өөрчлөлт оруулж байжээ

<sup>31</sup> \*Хөгжлийн банкны активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулах, зарцуулах журам

5.56 МУХБ-ны гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчийн 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн “Хүсэлт хүргүүлэх тухай” 2/690 дүгээр албан бичгээр тус банкнаас Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн А-290 дугаартай тушаал, Монголбанкны улсын байцаагчийн 2018 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн 2018/12039/005 дугаартай мэдэгдлийг хууль бусад тооцуулах тухай нэхэмжлэлийг Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд гаргасныг үндэслэн, шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байсныг мэдэгдсэн.

5.57 Тус банкны нийт зээлийн хэмжээг 2.6 их наяд төгрөгөөс хэтрүүлэхгүй байх гэсэн хязгаарлалт нь МУХБ-ны зээлийн үйл ажиллагааг хэвийн явуулахад хүндрэлтэй байдал үүсгэж байгааг дурдан хязгаарлалтыг авах талаар тодорхой арга хэмжээ авч дэмжлэг үзүүлэхийг хүсжээ.

5.58 Монголбанкнаас тухайн тушаал нь Монголбанкнаас хийх дараагийн газар дээрх хяналт шалгалтын акт, материал батлагдах хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр үйлчлэх болохыг Монголбанкны 2019 оны А-1/36 дугаар албан бичгээр тус банканд мэдэгдэж байсан.

5.59 Гэвч МУХБ-нд хийсэн шалгалтын дүнгийн тухай Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн А-290 дугаар тушаалын “ХОЁР” дахь хэсгийн 1 дэх заалтын “2.6” гэснийг “3.0” гэж өөрчилсүгэй хэмээн 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн А-184 дүгээр тушаалаар өөрчлөлт оруулж, “нэмэгдэж буй 400 тэрбум төгрөгийн зээлийн олголтыг “Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал та биечлэн хариуцахыг” мэдэгдсэн байна.

#### **Үндэсний аудитын газрын хяналт шалгалтын үр нөлөө хангалтгүй байсан**

5.60 ЯАГ-аас Хөгжлийн банкны үйл ажиллагаатай холбоотой дараах сэдвээр гүйцэтгэсэн аудитын тайланг ХШТХ-нд ирүүлсэн<sup>32</sup>. Үүнд:

Хүснэгт 20 Аудитын тайлангийн мэдээлэл

Аудитын сэдэв /гүйцэтгэсэн он/	Гол асуудал
Гадаадын зээл, тусламж, Засгийн газраас гадаад зах зээлд гаргасан бонд, МУХС-гийн хөрөнгөөр 2008-2013 оны 9 дүгээр сар хүртэл хугацаанд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын чанартай төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн /2014/	<ul style="list-style-type: none"> <li>Бондын хөрөнгөөр санхүүжүүлэх хөтөлбөр, TAX-ний төлөвлөлт, зарцуулалтын талаар ЯАБЗ-ийн гаргасан зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байсныг тогтоосон.</li> </ul>
Засгийн газраас гаргасан үнэт цаас болон Чингис Самурай бондын хөрөнгийн зарцуулалт, Хөгжлийн банкны хуулийн хэрэгжилт, Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн төслийн үр дүн /2015/	<ul style="list-style-type: none"> <li>МУХБ-ны бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө, эх үүсвэрийн ашиглалтыг сайжруулах шаардлагатай гэж үзсэн.</li> </ul>
Улсын төсвийн хөрөнгөөр 2015 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дунд хийсэн гүйцэтгэлийн аудит /2016/	<ul style="list-style-type: none"> <li>TAX хугацаандаа хэрэгжээгүй, гүйцэтгэлийг баталгаажуулаагүй, газар чөлөөлөлт хийгдээгүй, гэрээ байгуулаагүй, зураг төсөл бүрэн бус TAX-г санхүүжүүлсэн.</li> </ul>
Хөгжлийн банкны хөрөнгөөр санхүүжүүлсэн зарим арга хэмжээний хэрэгжилт, үр дунд хийсэн аудитын зөвлөмжийн хэрэгжилт /2017/	<ul style="list-style-type: none"> <li>Анх удаа дааетан аудитыг гүйцэтгэж, тухайн үед зөвлөмжийг хэрэгжүүлсэн гэж дүгнэсэн.</li> </ul>
Монгол Улсын Засгийн газар, Хөгжлийн банкны хооронд улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй үүссэн өр, авлагын тооцоог 2016 оны жилийн эцсийн байдлаар баталгаажуулах аудитын тайлан /2017/	<ul style="list-style-type: none"> <li>Өр, авлагын тооцоог нийлж, баталгаажуулж дуусаагүй, зээлийн хөрөнгийг ТЕЗ-дүйн санхүүгийн тайландаа эцслэн тусгаагүй байсан.</li> </ul>
Монгол Улсын хөгжлийн банкны үйл ажиллагаа, зээл олголтын үр дүн, эргэн төлөлтийн байдалд хийсэн гүйцэтгэлийн аудит /2019/	<ul style="list-style-type: none"> <li>Зөвлөмжийн биелэлтийг тайлагнаагүй, аудитын мөрөөр гүйцэтгэх үе шатны ажил хийгдээгүй.</li> </ul>
Монгол Улсын Хөгжлийн банк ХХК-ийн 2021 нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан /2022/	<ul style="list-style-type: none"> <li>“Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн ч аудитын мөрөөр хийх үе шатны ажил эхлээгүй.</li> </ul>

<sup>32</sup> 2022 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1230

5.61 ҮАГ-аас 2019 онд гүйцэтгэсэн аудитын хүрээнд нийт 3.0 их наяд төгрөг, 341.5 сая ам.доллар, 168.0 сая иений мөнгөн дүн бүхий 25 алдаа зөрчлийг илрүүлж, зөвлөмжөөр 2.0 их наяд төгрөг, 19.4 сая ам.долларын, эрсдэлийн аудит хийх шаардлагатай гэж үзсэн 7.6 тэрбум төгрөг, 257.4 сая ам.долларын ажил үйлчилгээ, албан шаардлагаар 786.9 тэрбум төгрөгийг, 138.9 тэрбум төгрөг 64.7 сая ам.доллар, 168 сая иений алдаа зөрчилтэй холбогдох асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлжээ.

5.62 Уг аудит үе шаттайгаар үргэлжилсэн бөгөөд нэмэлт горим хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу МУХБ-ны 2012-2017 оны үйл ажиллагаа, төслийн орлогоос эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр шууд олгосон зээл, Засгийн газрын холбогдох тогтоолуудын дагуу арилжааны банкуудаар дамжуулан олгосон зээлийг түүврийн аргаар хамруулж, УИХ-ын 2016 оны 81 дүгээр тогтоол, Засгийн газрын 2017 оны 42, 219 дүгээр тогтоолуудын хүрээнд МУХБ-аас Сангийн яаманд шилжүүлсэн “улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр олгосон зээл”-ийн багцаас хэрэгжилт хангалтгүй төсөл, хөтөлбөрийн шалтгаан нөхцөлийг тодорхойлсон.

5.63 Аудитын дунд эрх зүйн зохицуулалт хангалтгүй, эрсдэлийн удирдлагын тогтолцоо бүрэн бүрдээгүй байхад МУХБ-ны тухай хууль /2011 он/ батлагдсан гэж үзсэн. Банкны захиргааны нэгжийн орон тоо банкны үйл ажиллагаатай бүрэн уялдаагүй, арвилан хэмнэлттэй ажиллах зарчмыг хангаагүй, үр ашиггүй зарцуулалт, худалдан авах ажиллагаанд мөрдөж буй журмын зохицуулалт хангалтгүй байгаа нь арвилан хэмнэлтгүй худалдан авалт хийгдэх нөхцөлийг бүрдүүлж байсныг илрүүлсэн.

5.64 Тооцоо судалгаагүйгээр эх үүсвэр татаж, мөнгөн хөрөнгийн удирдлагыг зохисгүй хэрэгжүүлснээс их хэмжээний алдагдал хүлээсэн, бэлтгэл ажлыг бүрэн хангахгүйгээр бонд гаргасан, зарим бондын эх үүсвэр татах үйл ажиллагааны зардал өндөр байгаа нь бодит хүү нэмэгдэхэд хүргэснийг хөндөж байсан.

5.65 2012-2015 онд мөнгөн хөрөнгийн удирдлагыг зохистой хэрэгжүүлээгүйгээс их хэмжээний орлого олох боломжийг алдаж, 102.1 тэрбум төгрөгийн ханшийн алдагдал хүлээсэн, санхүүжүүлсэн төслийн үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт иж бүрэн бус, зээл олголтод мөрдөгдөж буй дүрэм, журмын мөрдөлт, зохицуулалт хангалтгүй байсаны дээр санхүүжүүлсэн зарим зээл хуулийн зорилго, зорилтод нийцээгүй, УИХ-аас батлаагүй хөтөлбөрүүдэд арилжааны банкуудаар дамжуulan зээл олгосныг тэмдэглэж байсан.

5.66 Түүнчлэн арилжааны банкаар дамжуulan зээлийн багц, төслийн орлогоос эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн багцын хувьд хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг бүрэн тодорхойлоогүй байна гэх мэтчилэн голлох дүгнэлтүүдийг хийсэн байна.

5.67 Хууль хяналтын байгууллагад шилжүүлэх саналын хүрээнд тооцоо судалгаагүйгээр эх үүсвэр татаж, мөнгөн хөрөнгийн удирдлагыг зохисгүй хэрэгжүүлснээс их хэмжээний алдагдал хүлээсэн 3, төслийн үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт иж бүрэн бус, зээл олголтод мөрдөж буй дүрэм, журмын зохицуулалт хангалтгүй байсантай холбоотой 7 асуудлыг шилжүүлсэн.

5.68 Аудитын болон хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудлын мөрөөр үе шатны ажлыг гүйцэтгээгүйгээс аудитын ач холбогдлыг бууруулсан байна.

5.69 ҮАГ-аас аудитын дунд суурилан МУХБ-ны хуулиар тодорхойлсон зорилго, зорилтын хэрэгжилт хангалтгүйг тэмдэглэн УИХ-ын анхааралд 1, МУХБ-ны ТУЗ-ийн даргад 2, гүйцэтгэх удирдлагад 6 бүлэг асуудлаар зөвлөмж хүргүүлсэн хэдий ч аудитын мөрөөр хийх үе шатны ажлууд бүрэн хэрэгжээгүй, аудитын үр нөлөөг тооцож ажиллаагүй байна.

## ҮАГ-ЫН “Хязгаарлалттай” дүгнэлт гаргасан санхүүгийн тайлангийн аудитын мөрөөр давтан шалгалтын ажил хийгдээгүй байна

5.70 МУХБ-нд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт 66 хуулийн этгээдийн 3.2 их наяд төгрөгийн үндсэн болон хүүгийн үлдэгдэлтэй, үүнээс хэвийн 27, анхаарал хандуулах 4, чанаргүй ангилалд 35 зээлдэгчтэй байсан бөгөөд нийт зээлийн үлдэгдлийн 18.3 хувьтай тэнцэх хэмжээний эрсдэлийн сан байгуулсан нь бодит байдалтай нийцэхгүй, журмын дагуу ТАБ-ын тооцоолсноор 792.7 тэрбум төгрөгөөр нэмж байгуулах шаардлагатай байсныг тэмдэглэсэн.

- Уг аудитаар нийт 983.1 тэрбум төгрөгийн 18 алдаа зөрчил илэрснээс 90.5 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, 950.4 тэрбум төгрөгийн 12 алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлж, 32.6 тэрбум төгрөгийн 5 зөрчилд зөвлөмж хүргүүлж, “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн байна.
- Зочин төлөөлөгчийн зардалд 9.2 сая төгрөг, баяр ёслол арга хэмжээний зардалд 22.6 сая төгрөг, спорт арга хэмжээний зардалд 12.3 сая төгрөг, хэвлэл мэдээллийн зардалд 46.4 сая төгрөг, нийт 90.5 сая төгрөгийн үр ашиггүй зардал гаргасныг тогтоосон.

5.71 Ажлаас чөлөөлөгдсөн 14 хүнд 192.0 сая төгрөгийн тэтгэмж, ажилтнуудад 98.0 сая төгрөгийн эрүүл мэндийн халамж, нийт 290.1 сая төгрөгийн тэтгэмжийн зардал олгосон нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол болон ТӨБЗГ-ын 2021 A-1/354 тоот “Албан даалгавар хүргүүлэх тухай”-д заасан хэмнэх зардлыг хэмнэж ажиллаагүй байсан байна.

### УИХ-ЫН АЖЛЫН ХЭСГИЙН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

5.72 МУХБ-аас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж дүнг УИХ-д танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгээс (ажлын дэд хэсэг) төсөл, хөтөлбөр бүрээр газар дээрх хяналт, шалгалт, барьцаа хөрөнгийн магадалгаа хийж, зориулалт бусаар зарцуулсан 37 зээлийг АТГ-т шилжүүлэх, шалгах үеийн байдлаар үлдэгдэлтэй зээлийн хувьд зээл тус бүрээр авах арга хэмжээг ангилан тайландаа тусгасан байна.<sup>33</sup>

### ЗАСГИЙН ГАЗРЫН ТҮВШИНД ШИЙДВЭРЛЭХ ШААРДЛАГАТАЙ<sup>34</sup> ГЭЖ ҮЗСЭН

**5.73 Хэрэгжүүлэх арга хэмжээний санал:** Төрийн өмчит компаниудын хувьд зээлийн үүргийн гүйцэтгэлийг хангуулахад Засгийн газрын шууд болон шууд бус оролцоотойгоор хэрэгжүүлэхийг санал болгосон байна.

Хүснэгт 21 Төрийн өмчит компаниудын зээлийн үүргийн гүйцэтгэлийг хангуулах санал

№	Зээлдэгчийн нэр	Зээлийн ангилал	Зээлийг зориулалтын дагуу ашигласан эсэх	Зээлийн үлдэгдэл /тбм.төг/		Шийдвэрлэсэн байдал
				Тухайн үеийн	2023.03.31	
1	ТОСК БҮ-1 орон сууцны хороолол	Чанаргүй	Зориулалт нотлогдоогүй	75.3	-	Бэлэн мөнгө+Үнэт цаас
2	ТОСК БҮ-2 орон сууцны хороолол	Чанаргүй	Зориулалт нотлогдоогүй	97.4	-	
3	ТОСК Шинэ Яармаг орон сууцны хороолол	Чанаргүй	Зориулалт нотлогдоогүй	107.1	-	Бэлэн мөнгө+ӨБҮХХ
4	ТОСК Хөдөлгөөнт	Чанаргүй	Зориулалтын дагуу	25.6	25.6	Шүүхэд хандсан
5	Эрчим хүчний яам - ТТЦ станц	Анхаарал хандуулах	Зориулалтын дагуу	46.3	60.4	-
6	Эгийн голын усан цахилгаан станц	Чанаргүй	Зориулалтын дагуу	43.9	58.6	
7	Эрдэнэс Монгол ХХК	Анхаарал хандуулах	Зориулалтын дагуу	152.4	43.9	Бэлэн төлөлт
8	ДЦС-4 ТӨХХ	Хэвийн	Зориулалтын дагуу	248.4	274.3	-
9	Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХХК	Хэвийн	Зориулалтын дагуу	20.2	42.2	-
10	Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХХК	Хэвийн	Зориулалтын дагуу	205.3	234.0	
11	Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ	Хэвийн	Зориулалтын дагуу	16.9	9.6	

<sup>33</sup> МУХБ-наас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж дүнг Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийн ажлын тайлан, 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдөр

<sup>34</sup> Ажлын хэсгийн тайлан, 121 хуудас

12	МИАТ ТӨХК	Хэвийн	Зориулалтын дагуу	16.1	-	Бэлэн төлөлт
13	ДИ БИ ЭМ Лизинг ХХК	Хэвийн	Зориулалтын дагуу	0.4	-	Бэлэн төлөлт
	<b>Нийт</b>			<b>1,054.8</b>	<b>748.7</b>	

5.74 Монгол Улсын Их Хурлаас байгуулсан хяналт шалгалтын ажлын хэсгийн тайлагнал, үр дүнд суурилан Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн “Монгол Улсын Хөгжлийн банкнаас олгосон зээлийн өр төлбөрийг барагдуулах зарим арга хэмжээний тухай” 220 дугаар тогтоолоор төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой зарим хуулийн этгээдийн тус банкнаас авсан зээлийн өр төлбөрийг барагдуулах арга хэмжээг зээлдэгч бүрээр шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг нэр заан холбогдох албан тушаалтан, хуулийн этгээдэд даалган ажилласан байна.

5.75 Гэвч Засгийн газрын 220 дугаар тогтоолоор шийдвэрлэхээр чиглэл өгсөн төрийн хэвшлийн зээлдэгч нарийн зээлийн ашиглалт, зарцуулалтад нарийвчилсан хяналт хийх шаардлагатай байсан.

### ХУВИЙН ХЭВШЛИЙН ЗЭЭЛ, ҮҮНЭС

**Шүүх, хууль хяналтын байгууллагад шилжсэн<sup>35</sup>, “барьцаа хөрөнгийн дутагдалтай гэж үзсэн”**

**5.76 Хэрэгжүүлэх арга хэмжээний санал:** Шүүх, хууль хяналтын байгууллагаар шийдвэрлэх шаардлагатай бөгөөд барьцаа хөрөнгийн дутагдалтай 21 зээл байгаа бөгөөд зээлийн нийт үлдэгдэл 2022 оны 02 дугаар сарын 28-ны байдлаар 1,015.3 тэрбум төгрөг байна. Энэ төрлийн зээлүүдэд “нэмэлт барьцаа гаргуулах, хамааралтай этгээдүүдээр зээлийн эргэн төлөлтийг нь ханглуулах” шаардлагатай гэж үзсэн.

*Хүснэгт 22. Хувийн өмчт компаниудын зээлийн үргийн гүйцэтгэлийг ханглуулах санал*

№	Зээлдэгчийн нэр	Хөгжлийн банкнаас шүүхэд өгсөн эсэх	Хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх шаардлагатай АХ-ын санал	Тухайн үеийн	2023.03.31
				Барьцаа зээлийн харьцаа	Зээлийн үлдэгдэл /тбм.төг/
1	Хөтөл ХХК	Тийм		20.3%	298.6
2	Кью эс си ХХК	Тийм, Ш/ш-тэй		19.4%	192.6
3	Эрэл ХХК	Тийм		29.7%	141.7
4	Бэрэн групп ххк "ё" блок орон сууцны хороолол	Тийм		91.8%	44.6
5	НВЦ ХХК	Тийм		36.5%	74.9
6	Монгол драй милк ХХК	Тийм		84.4%	48.5
7	Энсада-истерн ХХК	Тийм, Ш/ш-тэй		52.5%	34.9
8	Түгээмэлтүүмэн хишиг ХХК	Тийм		70.0%	24.2
9	Инжир ХХК	Тийм		34.5%	7.7
10	Бармон ХХК	Тийм		55.5%	17.2
11	Мондулаан трейд ХХК	Тийм		47.9%	18.0
12	Сонгоулд ХХК	Тийм		23.9%	19.6
13	МБҮ трейд ХХК	Тийм		49.5%	16.9
14	Монгема ХХК	Тийм		94.2%	12.8
15	Газ-импорт ХХК	Тийм		14.0%	7.3
16	Сэлэнгийн герефорд ХХК	Тийм		83.8%	5.5
17	Пи Си Вай ХХК	Тийм		6.9%	4.6
18	Дэд бутэц инженеринг ХХК	Тийм, Ш/ш-тэй		99.8%	2.8
19	Комплант ХХК	Тийм	Шаардлагатай	71.2%	3.9
20	Монгол микрон кашмер ХХК	Тийм	Шаардлагатай	36.6%	15.7
21	Пирамид-Орд ХХК	Тийм	Шаардлагатай	93.1%	23.4
	<b>Нийт</b>			<b>1,015.3</b>	<b>998.21</b>

<sup>35</sup> Ажлын хэсгийн тайлан, 122 хуудас

**5.77 УИХ-ЫН АЖЛЫН ХЭСЭГ:** Хөгжлийн банкны зээлдэгчээс нэмэлт барьцаа гаргуулах, хамаарлтай этгээдүүдээр зээлийн эргэн төлөлтийг дэмжүүлэх санал дүгнэлт нь хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжих боломжтой ёсэх:

**Банкны зүгээс хэрэгжүүлэх арга хэмжээ:**

- Хэрэв зээлдэгчтэй зээлийн мөнгөн хөрөнгөөр ирээдүйд бий болох хөрөнгө барьцаалах нөхцөл бүхий "Ирээдүйд бий болох хөрөнгийн барьцааны гэрээ" байгуулсан тохиолдолд тухайн хөрөнгүүд бодитой бий болсон тухай бүр эрхийн болон биет байдлын доголдолгүй эд хөрөнгийг гэрээний үндсэн дээр барьцаалах;
- Зээлдэгчтэй харилцан тохиролцсоноор барьцааны гэрээ байгуулан нэмэлт эд хөрөнгө барьцаалах;
- Зээлдэгчийн хамаарал бүхий этгээдтэй харилцан тохиролцсоны үндсэн дээр барьцааны гэрээ байгуулснаар эд хөрөнгө барьцаалах;
- Зээлдэгч болон түүний хамаарал бүхий этгээд нь өөрсдөө зөвшөөрсний үндсэн дээр зээлдэгчийг хамтад нь оролцуулсан олон талт гэрээ байгуулсны үндсэн дээр зээлийн төлбөрийг төлүүлэх;
- Шууд дайчлан төлүүлэх боломж эрх зүйн хувьд хомс, харин хууль сахиулах байгууллагын шалгалтаар тус банкны зээлийн мөнгөн хөрөнгийг зээлдэгчийн хамаарал бүхий этгээд ашигласан, зарцуулсан нь баримтаар тогтоогдсон нөхцөлд шууд хариуцуулан төлүүлэх хэлбэрээр нөөц боломж байна.

5.78 Мөн шүүхийн шийдвэр гарч ШШГА-т шилжсэн ч зарим зээлдэгчээс хөрөнгийн үнэлгээнд гомдол гаргах зэргээр бүхий л боломжийг ашиглаж хугацаа хожих аргууд хэрэглэж байгаагаас шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд 1-3 жилийн хугацаа шаардагдаж байгаа тул гүйцэтгэх ажиллагаа хийгдэж байгаа зээлүүдийг шахаж ажиллах шаардлагатай байна.

**Шүүхэд шилжсэн, барьцаа хөрөнгө хүрэлцээтэй<sup>36</sup> буюу “барьцаа хөрөнгөөр үргийн гүйцэтгэлийг хангуулах боломжтой гэж үзсэн”**

**5.79 Хэрэгжүүлэх арга хэмжээний санал:** Шүүхэд шилжсэн, барьцаа хөрөнгө хүрэлцээтэй хувийн секторын 9 зээлийн үлдэгдэл 76.8 тэрбум төгрөг байна. Дараах хүснэгтэд харуулсан зээлүүдийг барьцаа хөрөнгөөр үргийн гүйцэтгэлийг хангуулах боломжтой гэж үзсэн байна.

Хүснэгт 23. Барьцаа хөрөнгөөр үргийн гүйцэтгэлийг хангуулах боломжтой компаниудын санал

№	Зээлдэгчийн нэр	Шүүхэд өгсөн эсэх	Барьцаа зээлийн харьцаа	Зээлийн үлдэгдэл /тбл.төг/	
				Тухайн үеийн	2023.03.31
1	Монгол мах экспо ХХК	Тийм	104.5%	30.0	ӨБҮҮХ шилжүүлж авсан
2	Монгол эм импекс концерн ХХК	Тийм	8525.9%	0.3	Бэлэн төлөлт
3	Зэст-өндөр ХХК	Тийм	218.6%	11.7	12.25
4	Петролеум продакшн ХХК	Тийм	111.7%	12.2	7.25
5	Хатант интернэшил ХХК	Тийм	129.1%	6.7	Бэлэн төлөлт
6	Мон Лаа ХХК	Тийм, ШШГА явагдаж буй	408.6%	7.6	7.57
7	Ган хүдэр орд ХХК	Тийм, ШШГА явагдаж буй	210.3%	5.5	1.59
8	Болор шүр ХХК	Тийм, ШШГА явагдаж буй	115.7%	2.4	1.22
9	Эрд хул ХХК	Тийм, ШШГА явагдаж буй	172.8%	0.6	Бэлэн төлөлт
<b>Нийт</b>				<b>76.8</b>	<b>29.88</b>

<sup>36</sup> Ажлын хэсгийн тайлан, 122 хуудас

**Авлигатай тэмцэх газарт шалгагдаж байгаа<sup>37</sup> буюу “хамааралтай этгээдээр эргэн төлөлтийг дэмжүүлэх гэж үзсэн”**

**5.80 Хэрэгжүүлэх арга хэмжээний санал:** МУХБ-наас зээлийн үүргийн гүйцэтгэл хангагдахгүй байгаа 43 зээлийг Авлигатай тэмцэх газарт шалгуулахаар өгсөн байна. Ажлын хэсгээс газар дээрх хяналт шалгалтаар зориулалтын бус гэж тогтоосон 37 зээлийг АТГ-т шалгуулах санал гаргаснаас 30 нь АТГ-т шалгагдаж буй 43 зээлд багтсан, тэдгээрийг оролцуулан ажлын хэсгээс нэмж 7 зээлийг шалгуулах санал гаргасан байна.

5.81 АТГ-аас шалгаж байгаа 10 зээлийг харуулсан бөгөөд үүнээс барьцаа, зээлийн харьцаа хангагдаж байгаа 4, хангагдахгүй байгаа 6 зээл байна. Зээлийн нийт дүн 278.49 тэрбум төгрөг, барьцаа, зээлийн харьцаа хангагдахгүй байгаа 7 зээлийг нэмж “барьцаа хөрөнгөөр хангуулах, хамааралтай этгээдүүдээр зээлийн эргэн төлөлтийг дэмжүүлэх” арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх нь зүйтэй гэж дүгнэсэн байна.

Хүснэгт 24. АТГ-т шалгуулж үүргийн гүйцэтгэл хангуулах зээлүүд (шүүхийн бус журмаар шийдвэрлүүлэх)

№	Зээлдэгч компани	Зээлийн ангилал	Зориулалт	АТГ-д шалгагдаж байгаа эсэх	Барьцаа, зээлийн харьцаа	Зээлийн үлдэгдэл /тбм.төг/	
						Тухайн үеийн	2023.03.31
1	Бэрэн групп ХХК	Чанаргүй	Зориулалт нотлогдоогүй.	Тийм	213.1%	116.87	190.60
2	Ачлал трейд ХХК	Чанаргүй	Зориулалт бүрэн бус	Тийм	92.8%	53.19	69.57
3	Вертекс майнинг партнер ХХК	Хэвийн	Зориулалтын дагуу	Тийм	95.9%	33.50	Бэлэн төлөлт
4	Изинис-эйр вэйз ХХК	Хэвийн	Зориулалт бүрэн бус	Тийм	78.7%	29.10	31.37
5	Кредос ХХК	Чанаргүй	Зориулалт нотлогдоогүй.	Тийм	40.8%	25.44	25.54
6	Монпеллетс ХХК	Чанаргүй	Зориулалтын дагуу	Тийм	66.6%	2.35	2.95
7	Эйч энд эйч ремикон ХХК	Хэвийн	Зориулалтын дагуу	Тийм	222.1%	2.11	0.59
8	Шанх майнинг ХХК	Чанаргүй	Зориулалтын дагуу	Тийм	90.6%	7.33	7.68
9	Модун ХХК	Чанаргүй	Зориулалт бүрэн бус	Тийм	292.6%	6.11	ӨБҮХ шилжүүлж авсан
10	Дорнын цас ХХК	Хэвийн	Зориулалтын дагуу	Тийм	178.7%	2.49	2.15
<b>Нийт</b>						<b>278.5</b>	<b>330.45</b>

5.82 АТГ-т дараах зээлийн хувийн хэрэг хянагдаж байна. Үүнд:

Хүснэгт 25. АТГ-т шалгуулахаар хандсан бусад зээлүүд

№	Зээлдэгч компани	Зээлийн ангилал	АТГ-д шалгагдаж байгаа эсэх	2023.03.31	
				Зээлийн үлдэгдэл /тбм.төг/	
1	Хөтөл ХХК	Чанаргүй	Тийм	388.36	
2	Мондулаан трейд ХХК	Чанаргүй	Тийм	19.37	
3	Пирамид-орд ХХК	Чанаргүй	Тийм	25.99	
4	Империал гоулд майнинг ХХК	Анхаарал хандуулах	Тийм	12.89	
5	Сэлэнгийн герефорд ХХК	Чанаргүй	Тийм	6.04	
6	Петролеум продакшн ХХК	Анхаарал хандуулах	Тийм	7.25	
7	Монгема ХХК	Чанаргүй	Тийм	13.89	
8	Дэд бүтэц инженеринг ХХК	Чанаргүй	Тийм	2.56	
9	Болор шүр ХХК	Чанаргүй	Тийм	1.22	
10	Инжир ХХК	Чанаргүй	Тийм	10.30	
11	Ган хүдэр орд ХХК	Анхаарал хандуулах	Тийм	1.59	

<sup>37</sup> Ажлын хэсгийн тайлан, 123 хуудас

12	Монгол микрон кашмер ХХК	Чанаргүй	Тийм	13.43
13	Бармон ХХК	Чанаргүй	Тийм	15.40
14	Сонгоулд ХХК	Чанаргүй	Тийм	18.99
15	Зэст-өндөр ХХК	Анхаарап хандуулах	Тийм	12.25
16	Эрэл ХХК	Чанаргүй	Тийм	208.76
17	Монгол драй милк ХХК	Чанаргүй	Тийм	75.98
18	НВЦ ХХК	Чанаргүй	Тийм	70.07
19	Чингис хаан банк	Чанаргүй	Тийм	0.85
20	Газ-импорт ХХК	Чанаргүй	Тийм	8.04
21	Монполимет ХХК	Анхаарап хандуулах	Тийм	86.06
22	Строй-инвест ХХК	Анхаарап хандуулах	Тийм	0.39
23	Эрдэнэс монгол ХХК	Хэвийн	Тийм	43.87
24	МБҮ трейд ХХК	Чанаргүй	Тийм	18.37
25	Түгээмэлтүүмэн хишиг ххк	Чанаргүй	Тийм	25.92
26	Моннис майнинг ХХК	Чанаргүй	Тийм	125.55
27	Пи си вай ХХК	Чанаргүй	Тийм	5.13
28	Энсадад-истерн ХХК	Чанаргүй	Тийм	31.97
29	Цэцэнс майнинг энд энержи ХХК	Хэвийн	Тийм	102.22
	<b>Нийт</b>			<b>1,352.7</b>

**5.83 УИХ-ЫН АЖЛЫН ХЭСЭГ:** Хөгжлийн банкны зээлдэгчийн барьцаа хөрөнгийг хангуулах, “хамааралтай этгээдүүдээр зээлийн эргэн төлөлтийг дэмжүүлэх” санал дүгнэлт нь хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжих боломжтой эсэх:

**Холбогдох  
дүгнэлтийн  
хүрээнд  
банкны  
зүгээс  
хэрэгжүүлэх**

- Өмнөх дүгнэлтэд дурдсан зээлдэгчээс нэмэлт барьцаа гаргуулснаар хамааралтай этгээдээр зээл, барьцаа хөрөнгийн харьцааг хангуулж зээлийн төлбөрийг хийлгэх боломжтой;
- Гэвч зээлдэгчийн хамаарал бүхий этгээд нь тус банктай барьцааны болон бусад гэрээний харилцаанд ороогүй байгаа тохиолдолд зээлийн эргэн төлөлт хийлгэх нь хууль эрх зүйн хувьд хэрэгжих боломж бага байна.

5.84 Мөн зээлийн гэрээ дуусгавар болсон, шүүхийн шийдвэр гарсан зээлүүд дээр нэмэлт барьцаа хөрөнгө авч барьцааны гэрээ байгуулах хууль эрх зүйн хувьд хэрэгжих боломж бага, зээлийн үндсэн гэрээ дуусгавар болсноос нэмэлт гэрээ байгуулах боломжгүй байдалд хүргэж байна.

### Гэрээний дагуу эргэн төлөгдөх боломжтой гэж үзсэн<sup>38</sup>,

**5.85 Хэрэгжүүлэх арга хэмжээний санал:** Төсөл хэвийн үргэлжилж, зээл төлөгдөх боломжтой 8 зээлийн нийт үлдэгдэл 707.85 тэрбум төгрөг байна. Дараах зээлүүдийн гэрээний бүтцэд өөрчлөлт оруулах, барьцаа хөрөнгөөр баталгаажуулах, зээлийн гэрээний хугацааг сунгах зэрэг боломжоор дэмжих нь зүйтэй гэж дараах зээлдэгчдийг нэрлэсэн байна.

Хүснэгт 26. Гэрээний дагуу эргэн төлөгдөх боломжтой зээлүүд

№	Зээлдэгчийн нэр	Зээлийн ангилал	Зориулалт	Тухайн үеийн		2023.03.31 Зээлийн үлдэгдэл /тбм.төг/
				Барьцаа, зээлийн харьцаа	Зээлийн үлдэгдэл /тбм.төг/	
1	Мак цемент ХХК	Хэвийн	Зориулалтын дагуу	154.6%	166.2	-
2	Моннис майнинг ХХК	Чанаргүй	Зориулалтын дагуу	49.7%	125.9	125.55
3	Говь ХК	Анхаарап хандуулах	Зориулалтын дагуу	86.7%	76.5	76.65

<sup>38</sup> Ажлын хэсгийн тайлан, 124 хуудас

4	Строй-инвест ХХК	Анхаарап хандуулах	Зориулалтын дагуу	555.5%	2.2	0.39
5	Цэцэнс майнинг энд энержи ХХК	Хэвийн	Зориулалт бүрэн бус	249.0%	140.5	102.22
6	Вестерн холд ХХК	Хэвийн	Зориулалтын дагуу	99.2%	80.4	87.26
7	Дархан минж ХХК	Хэвийн	Зориулалтын дагуу	207.6%	1.2	-
8	Монполимет ХХК	Анхаарап хандуулах	Зориулалтын дагуу	77.0%	114.9	86.06
<b>Нийт</b>					<b>707.9</b>	<b>478.13</b>

5.86 Банкнаас тухайн хэрэгжүүлж буй арга хэмжээний хувьд хэдийгээр гэрээний дагуу төлөгдөх боломжтой гэж тогтоосон ч эрсдэлтэй “төлөв” нь зээлийн эргэн төлөлтөд хүлээлт үүсгэж байна.

5.87 Тухайлбал, банкны зээлдэгчээс нэмэлт барьцаа гаргуулах, “хамааралтай этгээдүүдээр зээлийн эргэн төлөлтийг дэмжүүлэх” санал дүгнэлт нь хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжих боломжтой эсэх нь эргэлзээтэй байна.

5.88 МУХБ-аас зээлийн үнэ цэнэ, барьцаа хөрөнгийн хүрэлцээг тодорхойлох зорилгоор жил бүр барьцаа хөрөнгийн үнэлгээг шинэчлэн тогтоож байгаа ч энэхүү үнэлгээгээр барьцаа хөрөнгийн хүрэлцээ хангахгүй байгаа зээлдэгчдэд барьцаа хөрөнгийг нэмэгдүүлэх талаар мэдэгдэл өгөхөөс илүүтэй бодитой хамтын ажиллагаа шаардлагатай.

5.89 Мөн чанаргүй активыг бууруулах зорилгоор хугацаа хэтэрсэн, өөрийн үндсэн үйл ажиллагаагаар зээлийн төлбөр барагдуулах боломжгүй зээлдэгчидтэй харилцан тохиролцо замаар барьцаанд байгаа хөрөнгийг гуравдагч этгээдэд эзэмшигүүлж, зээлийн эргэн төлөлтийг хангуулах ажиллагааг хэрэгжүүлж байна.

5.90 Дээрх арга хэмжээний хүрээнд холбогдох хууль тогтоомж болон банкны дотоод эрх зүйн актын хүрээнд дараах байдлаар хэрэгжүүлэх боломжтой юм. Үүнд:

- Хэрэв зээлдэгчтэй зээлийн мөнгөн хөрөнгөөр ирээдүйд бий болох хөрөнгө барьцаалах нөхцөл бүхий “Ирээдүйд бий болох хөрөнгийн барьцааны гэрээ” байгуулсан тохиолдолд тухайн хөрөнгүүд бодитой бий болсон тухай бүр эрхийн болон биет байдлын доголдолгүй эд хөрөнгүүдийг барьцааны гэрээ байгуулан барьцаалах.
- Зээлдэгчтэй харилцан тохиролцсоны үндсэн дээр барьцааны гэрээ байгуулан нэмж эд хөрөнгө барьцаалах;
- Зээлдэгчийн хамаарал бүхий этгээдтэй харилцан тохиролцсоны үндсэн дээр барьцааны гэрээ байгуулан нэмж эд хөрөнгө барьцаалах;
- Зээлдэгч болон түүний хамаарал бүхий этгээд нь өөрсдөө зөвшөөрсний үндсэн дээр зээлдэгчийг хамтад нь оролцуулсан олон талт гэрээ байгуулсны үндсэн дээр зээлийн төлбөрийг төлүүлэх.
- Хууль сахиуулах байгууллагын шалгалтаар тус банкны зээлийн мөнгөн хөрөнгийг зээлдэгчийн хамаарал бүхий этгээд ашигласан, зарцуулсан нь баримтаар тогтоогдсон нөхцөлд шууд хариуцуулан төлүүлэх.

5.91 Хөгжлийн банкны зээлдэгчийн үүргийн гүйцэтгэлийг барьцаа хөрөнгөөр хангуулах, “хамааралтай этгээдүүдээр зээлийн эргэн төлөлтийг дэмжүүлэх” санал дүгнэлт нь хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжих боломжтой эсэх нь хууль хяналтын байгууллагын шийдвэрээс шалтгаалж байна.

5.92 Зээл, барьцаа хөрөнгийн харьцааг хангуулах саналын хувьд зээлдэгчийн хамаарал бүхий этгээд нь тус банктай барьцааны болон бусад гэрээний харилцаанд ороогүй байгаа тохиолдолд зээлийн эргэн төлөлт хийлгэх нь хууль эрх зүйн хувьд боломжгүй байна.

5.93 Ажлын хэсгээс дараах санал дүгнэлтийг илэрхийлснийг хэрэгжилтийн байдалтай холбон авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

#### УИХ-ын Ажлын хэсгийн дүгнэлт-1

Монгол Улсын Хөгжлийн банкны хууль, эрх зүйн зохицуулалтыг ойрын хугацаанд боловсронгуй болгох, холбогдох дүрэм журмыг өөрчлөн шинэчлэх, хэрэгжилтийг нь гүйцэд

хангуулах, банкны бүтэц, зохион байгуулалт, засаглалыг сайжруулах, муудсан зээлүүдийг ангилан цэгцлэх арга хэмжээг авах, сайн хэрэгжиж байгаа болон хэрэгжих боломжтой төслүүдийг дэмжиж үргэлжлүүлэн санхүүжүүлэх, иргэд олон нийтийн дунд түгээд байгаа сөрөг мэдээлэлд бодитой, зөв зохистой хариу өгөх, Хөгжлийн банкны эх үүсвэрийг бүрдүүлсэн гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг алдахгүй байх, улмаар Монгол Улсын болон тус банкны олон улсын зээлжих зэрэглэлийг бууруулахгүй байх нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

### МУХБ-ны хариу арга хэмжээ, хэрэгжилтийн байдал:

- МУХБ-ны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсруулан Сангиин яаманд хүргүүлсэн.
- Засаглалаа сайжруулах, зохистой засаглалын зарчмуудыг хэрэгжүүлэх зорилгоор Дэлхийн банкаас хэрэгжүүлж буй “Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх” (SFFS) төслийн хүрээнд “МУХБ-нд үр ашигтай удирдлагын хүрээнд дэмжлэг үзүүлэх” асуудлаар техникийн туслалцаа авч 2021 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр Дэлхийн банкны төслийн хүрээнд Засаглалын мэргэжлийн зөвлөх Zeljko Sevic-тэй МУХБ-ны засаглал, үйл ажиллагаа, эрсдэлийн удирдлагын талаар зөвлөх үлчилгээ үзүүлэх гэрээ байгуулсан ба уг гэрээний дагуу ТҮЗ-ийн гишүүд, удирдлагуудад сургалт зохион байгуулан, банкны засаглалд шинжилгээ хийн, зөвлөмж өгөх зорилгоор Банкны засаглалын асуудлаар нийт 5 бүлэг тайлан, зөвлөмжүүдийг бэлтгэн ирүүлсэн байна.
- 2020 болон 2021 оны цар тахлын нөхцөл байдлаас үүдэн МУХБ-ны зээлээс төлбөрийн зөрчил үүсгэсэн чанаргүй зээлийн ангиллыг 2020 оны хагас жил, 2021 оны жилийн эцэст ангилал хийгээгүй байсныг 2022 оны 06-р сарын 30-ны өдрөөр зээлийн эрсдэлийн сангийн үнэ цэнийн бууралтыг холбогдох журмын дагуу тооцоолж санхүүгийн тайланд тусгаж бүртгэсэн ба 2022.08.31-ний өдрийн байдлаар нийт зээлийн эрсдэлийн сангийн хэмжээ 933.1 тэрбум төгрөгтэй тэнцижээ.
- Хамтын ажиллагаатай олон улсын, бус нутгийн, хөрш орнуудын банк санхүүгийн байгууллагуудтай харилцаа холбоотой ажиллаж, МУХБ-ны активын чанар, зээлийн эргэн төлөлт болон Эксим банкны чиг үүргийг давхар хэрэгжүүлж эхэлсэн тухай мэдээллийг банкны тайлант хугацааны тоон мэдээллүүдийн хамт хүргүүлж ажиллажээ.

### УИХ-ЫН АЖЛЫН ХЭСГИЙН ДҮГНЭЛТ-2

Шүүхээр шийдвэрлүүлэх асуудлаас гадна эдийн засгийн болон нийгмийн үр ашигтай, төсөлт амжилттай хэрэгжсэн эсхүл хэрэгжих боломжтой, цаашид төслийн үйл ажиллагааны орлого, мөнгөн урсталаар зээлийн төлбөрийг эргэн төлөх чадамжтай зээлдэгчдэд Хөгжлийн банк дотоод нөөц боломжкоо ашиглан шаардлагатай бол гэрээний бүтцийн өөрчлөлт хийх, төсөл хэрэгжүүлэгчдийн барьцаа хөрөнгийг нэмэгдүүлэх, нэмэлт санхүүжилт олгох, барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэл хангуулах нь зарим төсөл дээр оновчтой шийдэл байж болохыг харгалзан үзэж “Шүүхийн бус журмаар өр авлага барагдуулах” зарчмыг судлах, хууль санаачлах шаардлага бий болж байна.

### МУХБ-ны хариу арга хэмжээ, хэрэгжилтийн байдал:

- Зээлдэгчийн санхүүгийн нөхцөл, төслийн болон барьцаа хөрөнгийн чанар байдлыг харгалзан, шүүхийн бус журмаар зээл, хүү төлүүлэх ажиллагаанд эвлэрэх, бүтцийн өөрчлөлт оруулах, хэлцэл байгуулах зэрэг шүүхийн бус аргаар ажиллаж байгаа 10 зээлийн 403 тэрбум төгрөг. Үнд: Монгол мах экспо ХХК, Капитал банк, Болор шүр ХХК, Чингисхаан банкны зээлийн өр төлбөрт барьцаа хөрөнгийг банкны ӨБҮХ-д шилжүүлэн худалдан борлуулах замаар зээлийг төлүүлэхээр ажиллаж байна.
- Мөн барьцаа хөрөнгийг нэмэгдүүлэх, компанийн хувь зээмшилийг худалдах, хэлцэл хийх замаар хамтран ажиллах зэрэг ажиллагааг авч хэрэгжүүлж байна. МУХБ нь шүүхийн бус журмаар өр авлага барагдуулах зорилгоор Актив удирдлагын компанийн тухай хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулгыг боловсруулан хүргүүлжээ.

### УИХ-ЫН АЖЛЫН ХЭСГИЙН ДҮГНЭЛТ-3

Мөн МУХБ-д мөрдөгдөж буй олон дүрэм журам, МУХБ-ны тухай хуулийн хэрэгжилтэд үр дагаврын үнэлгээг яаралтай хийлгүүлж нөхцөл байдлыг үнэлэх шаардлага гарч ирсэн гэж үзэж байна.

### МУХБ-ны хариу арга хэмжээ, хэрэгжилтийн байдал:

Монгол Улсын Засгийн газрын 2021.8.18-ны өдрийн 252 дугаар тогтоолоор Монгол Улсын Хөгжлийн банкны дүрмийг шинэчлэн баталсан. Дүрэм шинэчлэгдсэнтэй холбогдуулан, засаглалыг сайжруулах хүрээнд дараах баримт бичгүүдийг баталж мөрдүүлсэн:

- МУХБ-ны ТҮЗ-ийн 2021.8.27-ны 21 дүгээр тогтоол, 2022.5.13-ны 28 дугаар тогтоолоор МУХБ-ны зохион байгуулалтын бүтцийг тус тус шинэчлэн баталжээ.
- МУХБ-ны батлагдсан бүтцийн хүрээнд газар, хэлтэс, албаны чиг үүргийг Гүйцэтгэх захирлын 2021.9.08-ны A-76 дугаар тушаал, 2022.8.23-ны өдрийн A-57 дугаар тушаалаар тус тус шинэчлэн батлан мөрдүүлжээ.
- Бүтэц, чиг үүрэг өөрчлөгдсөнтэй холбогдуулан ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг Гүйцэтгэх захирлын 2021.08.31-ний A-71 дүгээр тушаал, 2021.09.08-ны A-77 дугаар тушаалаар тус тус шинэчлсэн.

Холбогдох дүрэм журмуудыг шинэчлэх ажлын хүрээнд доорх дүрэм журмуудыг баталсан:

- “МУХБ-ны ТҮЗ-ийн үйл ажиллагааны журам” ТҮЗ-ийн 2022.04.22-ны 24 дүгээр тогтоол
- “МУХБ-ны Дотоод аудитын дүрэм” ТҮЗ-ийн 2022.06.02-ны 33 дугаар тогтоол
- “МУХБ-ны Дотоод аудитын ёс зүйн дүрэм” ТҮЗ-ийн 2022.06.02-ны 33 дугаар тогтоол
- “Хөдөлмөрийн дотоод журам” Гүйцэтгэх захирлын 2022.3.10-ны A-21 тушаал
- “Автомашин ашиглалтын түр журам” Гүйцэтгэх захирлын 2022.9.30-ны A-69 тушаал
- “Албан хэрэг хөтлөлтийн түр журам” Гүйцэтгэх захирлын 2021.9.14-ний A-78 тушаал

Дараах журмыг хүчингүй болгосон:

- “Ахмадын сан бүрдүүлэх, зарцуулах, тайлاغнах журам”
- “Ажлын төлөвлөлт гүйцэтгэлийг үнэлэх журам”
- “Автомашин ашиглалтын журам”
- “Ажилтанд тэтгэмж олгох, хөнгөлөлт үзүүлэх, шагнах журам”
- “Мэргэжил, ур чадварын түвшин тогтоох комиссын ажиллах журам”
- “Ес зүй, сахилгын хорооны ажиллах журам” МУХБ нь 2022 оны 8 дугаар сараас дотоодын хяналтын чиг үүргийг бүрэн хэмжээгээр хэрэгжүүлж эхлээд байгаа ба дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх зорилгоор 2018 оноос хойш эрх бүхий байгууллагуудын шалгалтаар өгөгдсөн үүрэг даалгавар, зөвлөмжүүд хэрэгжилтүүдийг хянах ажлын хүрээнд Банкны үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журмын хэрэгжилтүүд, 2019-2022 онуудын бизнес төлөвлөгөө, газар нэгжүүдийн чиг үүргийн хэрэгжилтэд давтан хяналт хийх ажлыг эхлүүлсэн.

### МУХБ-ны үйл ажиллагаанд эрх бүхий байгууллагаас хийх хяналтын тогтолцоог эргэн харах шаардлагатай

5.94 Дэлхийн банкны судалгаагаар олон улсад үйл ажиллагаа явуулж байгаа Хөгжлийн банкуудын 72 хувь банкны хяналт шалгалтын зохицуулагч гол байгууллага болох Төв банкны хяналтаар хэрэгждэг, 28 хувь Засгийн газрын агентаар хэрэгждэг бол олон улсын Хөгжлийн банкуудын 78 орчим хувь Базелийн хяналт шалгалтын үндсэн стандартын дагуу хэрэгждэг байна.

5.95 Олон улсын Хөгжлийн банкны хувь нийлүүлэгч, хяналт тавьдаг байгууллага тусдаа байдаг, бие даасан хяналт шалгалтын тогтолцоотой байхаас гадна Хөгжлийн банканд хяналт тавих асуудал нь арилжааны банканд тавих хяналтаас ихээхэн ялгаатай буюу энэ нь хэт их зохицуулалтад орохыг хүсдэггүй, төрийн ашиг сонирхол илүүтэй, дотоод хяналтын тогтолцоо сул байдагтай холбоотой юм.

5.96 Үүнтэй холбоотойгоор олон улсын жишигт нийцсэн байдлаар тус банкны үйл ажиллагаанд тавигдах хяналт шалгалтын ажлын үр нөлөө сул байсан байна.

5.97 Эрх бүхий байгууллагын тухайлсан шалгалт, аудитын хуулийн этгээдийн баталгаажуулах аудитын үр нөлөөт байдал дараагийн шатандаа ахиц дэвшлээр үнэлэгдэх учиртай ч хангалттай баримт алга байна.

5.98 Эрх бүхий байгууллагын хяналт шалгалтын үр нөлөө хангалттай түвшинд байж чадаагүй, нөгөө талаас дурдсан байгууллагуудын тусгайлсан, нарийвчилсан, өргөтгөсөн, хэсэгчилсэн зэрэг шалгалтуудын мөрөөр буюу давтан хийсэн болон ээлжит хяналт шалгалтын үеэр өмнөх шалгалтын илрүүлэлт, алдаа зөрчлийг хэрхэн арилгасан талаар үндсэндээ хянаж байгаагүй байна.

5.99 Хяналт шалгалтын үр дүн, өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлсэн учир холбогдолтой, бодит нөхцөл байдлыг илтгэх хангалттай нотлох зүйл олдоогүй, хууль тогтоомжид заасан МУХБ-ны үйл ажиллагаанд тавих төрийн хяналтын чиг үүрэг хангалтгүй хэрэгжиж ирсэн байна.

## ЗУРГАА. ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ СОНСГОЛ, МЭДЭЭЛЛИЙН ХУРААНГУЙ

Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах Түр хорооны 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн “Түр хорооны сонсгал товлон зарлах тухай” 09 дүгээр тогтоолоор сонсголыг 3 ѿ шаттайгаар зохион байгуулахаар шийдвэрлэсэн<sup>39</sup>.

### МУХБ-ны зээлийн багцын мэдээлэл

6.1 МУХБ нь Хөгжлийн банк нь 2012 оноос 2023 оны 1-р улирал хүртэлх хугацаанд нийт 7.5 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээний зээлийн санхүүжилтийг I) улсын төсвөөс эргэн төлөгдөх II) арилжааны банк болон охин компаниар дамжуулан III) шууд санхүүжилт гэсэн үндсэн 3 хэлбэрээр олгосон.

Хүснэгт 27. МУХБ-ны нийт олголт, санхүүжилтийн хэлбэрээр (тбм.төг)

Санхүүжилтийн хэлбэр	Нийт олголт - 2012-2023 эхний улирал		2023.03.31-ний байдлаар	
	Олгосон зээлийн дүн*	Төслийн тоо	Зээл, хүү үлдэгдэл дүн	Зээлдэгчийн тоо
Төсөвт шилжүүлсэн багц	2,540.2	355	-	-
Дамжуулан багц	1,646.1	2,548	0.85	1
Шууд зээлийн багц	3,303.0	91	2,558.5	46
<b>Нийт дүн</b>	<b>7,489.3</b>	<b>2,994</b>	<b>2,559.4</b>	<b>47</b>

\*Тайлбар: Олголт хийх тухай бүрийн ханшаар төгрөгт хөрвүүлэн тооцсон.

6.2 Нийт олгосон 7.5 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээний багцын 75% хувь хаагдсан бол 25% нь үлдэгдэлтэй байна. Үлдэгдэлтэй зээлийн багцыг 2023 оны 1-р улирлын байдлаар зээл, хүү, торгуулийн хүүг хуримтлуулан тооцсоноор буюу өссөн дүнгээр 2.56 их наяд төгрөгтэй тэнцэж байна.

Хүснэгт 28. МУХБ-ны нийт олголт, санхүүжилтийн болон зээлдэгчийн өмчийн хэлбэрээр (тбм.төг)

Зээлдэгчийн хэлбэр	Улсын төсөв		Дамжуулан		Шууд		Нийт		Хувь
	Олгосон дүн	Төслийн тоо							
<b>Хаагдсан</b>	<b>2,540.2</b>	<b>355</b>	<b>1,645.3</b>	<b>2547</b>	<b>1,447.7</b>	<b>42</b>	<b>5,633.2</b>	<b>2944</b>	<b>75.2%</b>
Салбарын яамд	2,540.2	355	-	-	-	-	2,540.2	355	45.1%
Төрийн өмчтөлөө	-	-	81.0	6	744.9	11	826.0	17	14.7%
Хувийн хэвшил	-	-	1,564.3	2541	702.8	31	2,267.1	2572	40.2%
<b>Үлдэгдэлтэй</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>0.9</b>	<b>1</b>	<b>1,855.2</b>	<b>49</b>	<b>1,856.1</b>	<b>50</b>	<b>24.8%</b>
ЗГ-ын харьяа яамд	-	-	-	-	-	-	-	-	37.3%
Төрийн өмчтөлөө	-	-	-	-	693.0	8	693.0	8	62.7%
Хувийн хэвшил	-	-	0.9	1	1,162.3	41	1,163.1	42	75.2%

<b>Нийт</b>	<b>2,540.2</b>	<b>355</b>	<b>1,646.1</b>	<b>2548</b>	<b>3,303.0</b>	<b>91</b>	<b>7,489.3</b>	<b>2994</b>	<b>100.0 %</b>
Салбарын яамд	2,540.2	355	-	-	-	-	2,540.2	355	33.9%
Төрийн өмчтөлөө	-	-	81.0	6	1,437.9	19	1,518.9	25	20.3%
Хувийн хэвшил	-	-	1,565.1	2542	1,865.1	72	3,430.2	2614	45.8%
<b>Хувь</b>	<b>33.9%</b>		<b>22.0%</b>		<b>44.1%</b>				<b>100.0%</b>

6.3 Нийт олголтыг валютаар авч үзвэл, 4.2 их наяд төгрөг, 1.6 тэрбум ам.доллар, 130.2 сая евро, 8.8 тэрбум иен, 81.5 сая юань тус тус олгосон.

6.4 МУХБ-наас 2016 оны эцсээр нийт зээлийн багцын үлдэгдлийн 50-аас дээш хувийг буюу тухайн үеийн ханшаар 3.1 их наяд төгрөгийн багц улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон нь улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийг банкны эх үүсвэр

<sup>39</sup> Сонсголын хүрээнд ХШТХ-ны хянан шалгагч, шинжээч нарын бие даасан дүгнэлтийг тусгайллан архивын нэгж болгосон

бусад харьцаа үзүүлэлтийг тооцолгүйгээр их хэмжээтэй олгосон буюу төсвийн шинжтэй үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллага гэж хэлж болохор хэмжээнд хүргэсэн.

**6.5 МУХБ-ны эх үүсвэрээр олгосон зээлийн багцыг эдийн засгийн салбараар ангилан харуулбал дараах байдалтай байна. Үүнд:**

**Хүснэгт 29. МУХБ-ны улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлөөр олгосон санхүүжилт, эдийн засгийн салбараар болон валютаар**

<b>Эдийн засгийн салбар</b>		<b>MNT /тэрбум/</b>	<b>USD /сая/</b>	<b>Нийт олгосон /тэрбум төгрөг/</b>	<b>Хувь</b>	<b>Төсөвт шилжсэн дүнгээр**</b>
<b>Улсын төсөв</b>	Авто зам*	931.2	209.4	1,236.6	48.7%	(1,432.4)
	Инженерийн дэд бүтэц	506.2	2.1	509.5	20.1%	(511.4)
	Төмөр зам	3.7	224.4	361.4	14.2%	(562.3)
	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	3.0	170.6	303.9	12.0%	(427.7)
	Уул уурхай	0.6	2.5	5.5	0.2%	(6.8)
	Боловсруулах үйлдвэрлэл	0.6	4.1	7.9	0.3%	(10.9)
	Бусад	32.6	59.9	115.3	4.5%	(177.9)
	<b>Нийт</b>	<b>1,477.8</b>	<b>673.0</b>	<b>2,540.2</b>	<b>100.0%</b>	<b>(3,129.5)</b>

\*Гудамж төслийн санхүүжилтийг тус салбарт хамраулсан.

\*\* 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орох хүртэл хугацаанд олгосон 12.5 тэрбум төгрөгийн санхүүжилт баатсан.

**6.6 МУХБ-ны тухай 2017 оны хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн цагаас хойш улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл олгоогүй ба дамжуулан зээл, шууд зээл гэсэн хэлбэрээр санхүүжилтийг олгосон.**

**Хүснэгт 30. МУХБ-ны дамжуулан болон шууд хэлбэрээр олгосон санхүүжилт, эдийн засгийн салбараар болон зээлдэгчийн өмчийн хэлбэрээр (тбм.төг)**

<b>Эдийн засгийн салбар</b>		<b>Төрийн өмчит</b>	<b>Хувийн хэвшил</b>	<b>Нийт олгосон дүнгээр</b>	<b>Хувь</b>	<b>Үүнээс 2023.03.31 үлдэгдэл дунгээр</b>
<b>Дамжуулан</b>	Боловсруулах үйлдвэрлэл	-	525.1	525.1	31.9%	-
	Уул уурхай, олборлолт	32.5	-	32.54	2.0%	-
	Барилга		125.0	125.0	7.6%	-
	Хөдөө аж ахуй	48.5	806.6	855.1	51.9%	0.9
	Зочид буудал,үйлчилгээ	-	108.4	108.4	6.6%	-
	<b>Нийт</b>	<b>81.0</b>	<b>1,565.1</b>	<b>1,646.1</b>	<b>100.0%</b>	<b>0.9</b>
<b>Шууд зээл</b>	Боловсруулах үйлдвэрлэл	165.3	991.1	1,156.4	35.0%	1,506.7
	Уул уурхай, олборлолт	391.2	375.7	767.0	23.2%	301.6
	Барилга	366.8	424.8	791.5	24.0%	187.1
	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	341.0	2.2	343.2	10.4%	435.6
	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	173.6	22.9	196.5	5.9%	40.9
	Хүний эрүүл мэнд	-	37.4	37.4	1.1%	69.6
	Хөдөө аж ахуй	-	6.0	6.0	0.2%	9.0
	Хог, хаягдлын менежмент	-	4.9	4.9	0.1%	8.0
<b>Нийт төслийн зээл</b>	<b>Нийт</b>	<b>1,437.9</b>	<b>1,865.1</b>	<b>3,303.0</b>	<b>100.0%</b>	<b>2,558.5</b>
	Боловсруулах үйлдвэрлэл	165.3	1,516.2	1,681.5	34.0%	1,506.7
	Уул уурхай, олборлолт	423.8	375.7	799.5	16.2%	301.6
	Барилга	366.8	549.8	916.5	18.5%	187.1
	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	341.0	2.2	343.2	6.9%	435.6
	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	173.6	22.9	196.5	4.0%	40.9
	Хүний эрүүл мэнд	-	37.4	37.4	0.8%	69.6
	Хөдөө аж ахуй	48.5	812.6	861.1	17.4%	9.8
<b>Зочид буудал, үйлчилгээ</b>		-	108.4	108.4	2.2%	-
<b>Хог, хаягдлын менежмент</b>		-	4.9	4.9	0.1%	8.0
<b>Нийт</b>		<b>1,518.9</b>	<b>3,430.2</b>	<b>4,949.1</b>		<b>2,559.4</b>

**6.7 МУХБ-ны зээл олголт, тэдгээрийн үлдэгдлийг чанарын ангиллаар авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:**

## Хүснэгт 31. Нийт олголт, үлдээгдлийг чанарын ангиллаар (тбм.төг)

Санхүүжилтийн хэлбэр		Хэвийн		Анхаарал хандуулах		Чанаргүй		Нийт	
		Олгосон дунгзэр	Үүнээс 2023.03.31 үлдээгдэл дүнгээр	Олгосон дунгзэр	Үүнээс 2023.03.31 үлдээгдэл дүнгээр	Олгосон дунгзэр	Үүнээс 2023.03.31 үлдээгдэл дүнгээр	Олгосон дунгзэр	Үүнээс 2023.03.31 үлдээгдэл дүнгээр
Улсын төсөв	Хаагдсан	2,540.2	-	-	-	-	-	2,540.2	-
	Үлдэгдэлтэй	-	-	-	-	-	-	-	-
	<b>Нийт</b>	<b>2,540.2</b>	-	-	-	-	-	<b>2,540.2</b>	-
Дамжуулан	Хаагдсан	1,526.6	-	24.4	-	94.3	-	1,645.3	-
	Үлдэгдэлтэй	-	-	-	-	0.9	0.9	0.9	0.9
	<b>Нийт</b>	<b>1,526.6</b>	-	<b>24.4</b>	-	<b>95.2</b>	<b>0.9</b>	<b>1,646.1</b>	<b>0.9</b>
Шууд зээл	Хаагдсан	830.3	-	354.4		263.1		1,447.7	-
	Үлдэгдэлтэй	611.1	519.7	545.7	595.5	698.4	1,443.3	1,855.2	2,558.5
			<b>519.7</b>		<b>595.5</b>		<b>1,443.3</b>		<b>2,558.5</b>
<b>Нийт</b>	Хаагдсан	4,897.1	-	378.8	-	357.4	-	5,633.2	-
	Үлдэгдэлтэй	611.1	519.7	545.7	595.5	699.3	1,444.1	1,856.1	2,559.4
<b>Нийт</b>		<b>5,508.2</b>	<b>519.7</b>	<b>924.5</b>	<b>595.5</b>	<b>1,056.7</b>	<b>1,444.1</b>	<b>7,489.3</b>	<b>2,559.4</b>

**МУХБ-ны зээлдэгчийн хамаарлыг хянасан байдал**

6.8 Хяналт шалгалтын ажлын хүрээнд УБЕГ-аас ирүүлсэн 54 мянга гаруй хуудас бүхий хуулийн этгээдийн улсын бүртгэлийн лавлагаанд түшиглэн Хөгжлийн банк үйл ажиллагаа явуулж эхэлсэн 2012 оноос хойш улс төрийн өндөр албан тушаал, ТЕГ, ЦЕГ, АТГ, УЕПГ-ын удирдлага, МУХБ-ны ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлагын багт тухайн үед ажиллаж байсан болон ажиллаж байгаа 306 иргэн, тэдгээрийн гэр бүл, албан тушаалын хамаарал бүхий 1627 иргэн дээр бүртгэлтэй 4568 хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийг МУХБ-ны нийт 3000 зээлдэгчийн идэвхтэй, идэвхгүй хувьцаа эзэмшигч, өмнөх ба одоогийн гүйцэтгэх удирдлага, эцсийн өмчлөгч нар дээр бүртгэлтэй хуулийн этгээдийн мэдээлэлтэй тулгах замаар улс төрийн хамаарлыг тодорхойлсон.

6.9 МУХБ-ны зээлдэгчдийн улс төрийн хамаарлыг нийт 1933 иргэний дээр бүртгэгдсэн 4568 хуулийн этгээдээр “Улс төрийн хамаарлын хүрээ” гэж тодорхойлсон:

- МУХБ үйл ажиллагаа явуулж эхэлсэн 2012 оноос хойш Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд, УИХ-ын гишүүн, Засгийн газрын гишүүн, дэд сайд, Төрийн нарийн бичгийн даргаар ажиллаж байсан болон одоо ажиллаж байгаа төрийн өндөр албан тушаалтнууд;
- ТЕГ, ЦЕГ, АТГ, УЕПГ-ын удирдлагаар ажиллаж байсан болон одоо ажиллаж байгаа албан тушаалтнууд;
- Дээр дурдсан төрийн өндөр албан тушаалтнуудын гэр бүл, албан тушаалын хамаарал бүхий хүмүүс;
- Хөгжлийн банкны ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлагын багт ажиллаж байсан болон одоо ажиллаж байгаа Монгол Улсын иргэд;

6.10 МУХБ-ны шууд зээлдэгч 77, арилжааны банкаар дамжуулан зээлдэгч 2542, Засгийн газарт шилжүүлсэн багцын 355 төсөл, хөтөлбөрийг гүйцэтгэгч 279 компани, МУХБ-ны охин компаниудаас санхүүжүүлсэн 42 зээлдэгч, нийт 3000 гаруй зээлдэгчийн идэвхтэй, идэвхгүй хувьцаа эзэмшигч, өмнөх ба одоогийн гүйцэтгэх удирдлага, эцсийн өмчлөгч нар дээр бүртгэлтэй хуулийн этгээдүүдийн мэдээллийг улс төрийн хамаарлын хүрээлэлтэй тулгаж нягтлахад 125 хуулийн этгээд, 8 иргэн, нийт 133 зээлдэгч улс төрийн хамааралтай байсан.

6.11 Улс төрийн хамааралтай зээлдэгчид нь МУХБ-наас нийт 1.5 их наяд төгрөгийн дүн бүхий зээл авсан байгаа нь тус банкны нийт олгосон 7.5 их наяд төгрөгийн зээлийн 20 хувийг эзэлж байна.

6.12 Тухайлбал, Түр хорооны нотлох баримтыг шинжлэн судлах Нэг дэх сонсголын хүрээнд МУХБ-ны шууд зээлдэгч 77 компаниас 15 нь улс төрийн хамааралтай. Улс төрийн

хамаарал тогтоогдсон 15 компанид нийт 746.7 тэрбум төгрөгийн дүн бүхий зээл олгосон нь нийт 3.5 их наяд төгрөгийн шууд зээлийн багцын 21.3 хувь болсон.

6.13 Түр хорооны нотлох баримтыг шинжлэн судлах Хоёр дахь сонсголын хүрээнд МУХБ-ны эх үүсвэрээр Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй 355 төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэгч 279 компаниас 39 компани улс төрийн хамааралтай. Улс төрийн хамаарал тогтоогдсон 39 компани нь нийт дүнгээр 523.6 тэрбум төгрөгийн дүн бүхий төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэгчээр шалгарч, ажил гүйцэтгэсэн нь Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр МУХБ-ны эх үүсвэрээр хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрт олгосон нийт 2.5 их наяд төгрөгийн 20.6 хувь болсон.

6.14 Түр хорооны нотлох баримтыг шинжлэн судлах Хоёр дахь сонсголын хүрээнд МУХБ-ны охин компаниудаас санхүүжүүлсэн 35 зээлдэгчээс 8 нь улс төрийн хамааралтай. Улс төрийн хамаарал тогтоогдсон 8 компани нь нийт дүнгээр 18.2 тэрбум төгрөгийн санхүүгийн түрээсийн үйлчилгээ олгосон нь МУХБ-ны охин компаниудаас санхүүжүүлсэн 161.6 тэрбум төгрөгийн багцын 14.5 хувь болсон.

6.15 Түр хорооны нотлох баримтыг шинжлэн судлах Гурав дахь сонсголын хүрээнд арилжааны банкуудаар дамжуулан олгосон 2542 зээлдэгчээс 63 хуулийн этгээд, 8 иргэн улс төрийн хамаарал тогтоогдсон 71 зээлдэгчид нийт дүнгээр 242.1 тэрбум төгрөгийн дүн бүхий зээл олгосон нь МУХБ-ны эх үүсвэрээс арилжааны банкуудаар дамжуулан олгосон 1.6 их наяд төгрөгийн багцын 16.2 хувийг тус тус эзэлж байна..

#### **УИХ-ЫН ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ СОНСГОЛ-И**

6.16 ХШТХ-ны сонсголын I шатанд Хөгжлийн банкнаас шууд санхүүжүүлсэн зээлийн олголт, эргэн төлөлтийн байдал, зээл олгосон албан тушаалтан, зээлдэгчид болон хамаарал бүхий этгээдүүдээс гэрчийн мэдүүлэг авах, зээлийн ашиглалт, зарцуулалтын төлөв байдалд гаргасан хянан шалгагч, шинжээч нарын дүгнэлт, мэдээллийг сонсохоор шийдвэрлэсэн.

6.17 Хяналт шалгалтын хүрээнд буюу шинжээчийн дүгнэлт гаргах ажлын хүрээнд төслийн орлогоос эргэн төлөгдөх нөхцөлтэй төрийн болон хувийн хэвшилд олгосон шууд зээлийн гэрээнд заасан нөхцөлөөрх зориулалт төсөл тус бүрд харилцан адилгүй, бүрэн хангагдаагүй байна. /Нэгтгэсэн жагсаалтыг хавсралт 5-д үзүүлэв/

6.18 Шууд санхүүжүүлсэн зээлийн хүрээнд нийт 3,278.0 тэрбум төгрөгийн 94 зээл олгосноос 598.4 тэрбум төгрөг буюу 18.3 хувь зориулалтын дагуу, 2,433.8 тэрбум төгрөг буюу 74.2 хувь зориулалт бүрэн бус, 234.9 тэрбум төгрөгийн зээл буюу 7.2 хувь зориулалт бусаар зарцуулагдсан, 0.3 хувь буюу 10.7 тэрбум төгрөгийн зээлийн зориулалтыг иж бүрэн нотлох боломжгүй байна.

6.19 Шууд санхүүжүүлсэн зээлийн хүрээнд хувийн хэвшилд олгосон зээлдэгчийн зээлийн зориулалт МУХБ-ны тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусгасан зорилго, зорилттой бүрэн нийцэхгүй байна.

6.20 Тухайлбал, хуулийн нийцлийг шалгахад хуулийн зорилттой нийцсэн төсөл 33.0 хувь, бүрэн бус нийцэлтэй төсөл 49.5 хувь, нийцээгүй төсөл 17.5 хувийг тус тус эзэлж байна.

**МУХБ-наас шууд санхүүжүүлсэн төрийн өмчит нэгжид олгосон зээлийн багц**

6.21 МУХБ нь 2012-2021 оны хугацаанд төрийн өмчит 12 байгууллагын 13 төсөлд нийт 1,412.92 тэрбум төгрөгийн зээл олгосноос уул уурхайн салбарт 4 төсөл, барилгын салбарт 2 төсөл, тээвэр, дэд бүтцийн салбарт 3 төсөл, эрчим хүчний салбарт 4 төсөл хэрэгжсэн байна.

Хүснэгт 32. Төрийн өмчит нэгжид олгосон зээл

№	Зээлдэгчийн нэр	Төслийн нэр	Салбар		Олгосон дүн		
			Огноо	Валют	сая валют	тэрбум төгрөг	
1	Эрдэнэс Тавантолгой ХК	Төмөр замын төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг эхлүүлэхэд шаардагдах санхүүжилт, эргэлтийн хөрөнгийн санхүүжилт	2012.10.05 2013.02.01 2014.12.31	USD USD USD	100.00 100.00 50.00	138.69 139.26 94.28	
2	Багануур ХК	Багануурын нүүрсний уурхайн хүчин чадлыг өргөтгөх	Уул уурхай	2013.04.24	MNT	18,634.0	18.63
3	Геологийн төв лаборатори	Геологийн төв лаборатори		2014.08.12	MNT	379.9	0.38
4	МГТБҮ ТӨХХК	"Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"		2018.04.26	MNT	165,330.3	165.33
5	ТОСК ТӨҮГ	Аймаг бүрт 1000 айл хөтөлбөр Буянт-Ухаа 1 төсөл, Буянт-Ухаа 2 төсөл,		2014.08.06 2013.10.02 2015.06.22	MNT MNT USD	27,226.42 84,700.0 35.51	27.23 84.70 70.0
6	ТОСК ТӨҮГ /Хөдөлгөөнт цогцолбор/	Барилгын хийц үйлдвэрлэх хөдөлгөөнт цогцолбор	Барилга	2016.02.05	USD	7.06	14.23
7	МИАТ ТӨХХК	Боинг-767-300ER загварын агаарын хөлөг худалдан авах санхүүжилт		2014.11.13	USD	101.82	152.59
8	Зорчигч тээвэр гурав ОНДААТҮГ	"Цахилгаан автобусаар парк шинэчлэл хийх төсөл"	Тээвэр, дэд бүтэц	2020.12.22	MNT	21,000.0	21.0
9	Эрдэнэс монгол ХХК	Тавантолгой-Гашуунсуухайт чиглэлийн 245 км авто зам		2014.02.12	MNT	170,595.48	170.6
10	ДЦС-4 ТӨХХК	"Турбоагрегат шинэчлэл төсөл"		2018.07.20	EUR	77.51	237.88
11	ДБНХС ТӨХХК	"Чойбалсангийн дулааны цахилгаан станцын 50МВт-ын өргөтгөл" төсөл		2021.10.28	CNY	70.18	31.69
12	ЭГУЦС ТӨХХК	"Цахилгаан станц" төсөл	Эрчим хүч	2013.12.05	USD	10.60	21.46
13	Эрчим хүчний яам	ТТЦС төслийн бэлтгэл үеийн зардлын санхүүжилт		2014.01.30	USD	14.82	24.97
<b>Нийт</b>							<b>1,412.92</b>

6.22 Дээрх 13 зээлдэгчид олгосон зээлийн 65.5 хувь буюу 925.05 тэрбум төгрөгийн зээлийг гадаад валютын зээл эзэлж байгаа бөгөөд 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар хаагдсан "Эрдэнэс Тавантолгой" ХК, "Багануур" ХК, "Геологийн төв лаборатори" ТӨҮГ, "МИАТ" ТӨХХК, "ТОСК" ТӨҮГ-т олгосон 5 зээлийн хувьд ханшийн зөрүүгээс үүссэн нийт 266.5 тэрбум төгрөгийг зээлийн үндсэн төлбөрт нэмж төлсөн байна.

Хүснэгт 33. Төрийн өмчийн зээлдэгчийн эргэн төлөлтийн судалгаа-1

Зээлдэгчийн нэр	Валют	Олгосон дүн		Зээлийн эргэн төлөлт (тэрбум төгрөгөөр)			
		сая валютаар	тэрбум төгрөгөөр	Зээл (1)	Хүү (2)	Торгууль (3)	Нийт (1+2+3)
Эрдэнэс Тавантолгой ХК	USD	100.00	138.69	(242.98)	(89.65)	(1.27)	(333.90)
	USD	100.00	139.26	(242.76)	(84.71)	-	(327.47)
	USD	50.00	94.28	(99.63)	(7.96)	(0.19)	(107.79)
Багануур ХК	MNT	18,634.00	18.63	(18.63)	(5.24)	(0.038)	(23.92)
Геологийн төв лаборатори	MNT	379.90	0.38	(0.38)	(0.06)	(0.0008)	(0.44)
МИАТ ТӨХХК	USD	101.82	152.59	(149.86)	(13.75)	(0.0907)	(163.70)
	JPY	-	-	(29.35)	(6.31)	(0.0392)	(35.70)

TOCK TӨҮГ	MNT	27,226.42	27.23	(27.23)	(7.28)	-	(34.51)
	MNT	84,700.00	84.70	(84.70)	(46.72)	(0.2506)	(131.67)
	MNT	-	-	(83.59)	(31.29)	(1.3085)	(116.19)
	USD	35.51	70.00	(13.14)	(25.94)	(0.2594)	(39.34)
Нийт		<b>725.75</b>	<b>(992.26)</b>	<b>(318.91)</b>	<b>(3.4494)</b>	<b>(1,314.62)</b>	

6.23 Төрийн өмчийн бусад 8 зээлдэгчийн зээлийн нийт үлдэгдэл 737.42 тэрбум төгрөг байгаагаас борлуулалтын орлого нь төгрөгөөр хийгддэг ДЦС-4, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК болон “Эгийн голын усан цахилгаан станц” ТӨХХК, “Тавантолгойн цахилгаан станц”-ын төсөлд олгосон 5 зээлийг гадаад валютаар олгосон нь цаашид ханшийн эрсдэлд өртөж, зээлийн эргэн төлөлтөд хүндрэл учрах эрсдэл хэвээр байна.

Хүснэгт 34. Төрийн өмчийн зээлдэгчийн эргэн төлөлтийн судалгаа-2

Зээлдэгчийн нэр	Валют	Олгосон дүн		Зээлийн эргэн төлөлт (тбл.төг)	Зээлийн үлдэгдэл 2022.12.31			
		сая валютаар	тэрбум төгрөгөөр		Үндсэн зээл	Хүг	Торгууль	Нийт (тбл.төг)
TOCK TӨҮГ /Хөдөлгөөнт цогцолбор/	USD	7.06	14.23	(0.11)	19.25	6.04	0.35	25.65
Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ	MNT	21,000.00	21.00	(13.28)	11.19	0.06	-	11.25
ДЦС-4 ТӨХК	EUR	77.51	237.88	(40.45)	278.59	0.30	0.02	278.91
МГТБҮ ТӨХХК	MNT	165,330.30	165.33	(0.29)	166.04	62.79	-	228.83
Эрдэнэс монгол ХХК	MNT	170,595.48	170.60	(224.51)	42.65	0.22	-	42.87
ДБЭХС ТӨХК	CNY	70.18	31.69	(1.97)	34.77	0.47	-	35.24
ЭГУЦС ТӨХХК	USD	10.60	21.46	-	36.51	18.55	1.25	56.31
ЭХЯ /ТТЦС төсөл/	USD	14.82	24.97	(15.36)	51.04	7.32	-	58.36
Нийт		<b>687.16</b>	<b>(295.98)</b>	<b>640.04</b>	<b>95.77</b>	<b>1.62</b>	<b>737.42</b>	

6.24 Төрийн өмчит нэгжүүдэд олгосон зээлийн зарцуулалтыг зээлдэгчийн МУХБ болон арилжааны банк дахь харилцах дансны хуулгад үндэслэн нягталсан бөгөөд данс хөөх аргын хувьд 8 зээл зориулалтын дагуу, 5 зээл зориулалт бүрэн бус гэж үзэхээр байна.

Хүснэгт 35. Төрийн өмчийн зээлдэгчийн зээлийн зарцуулалт

Зориулалтын дагуу	Зориулалт бүрэн бус
<ul style="list-style-type: none"> <li>- Эрдэнэс монгол ХХК</li> <li>- TOCK TӨҮГ /Хөдөлгөөнт цогцолбор/</li> <li>- ДЦС-4 ТӨХК</li> <li>- Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК</li> <li>- Геологийн төв лаборатори ТӨҮГ</li> <li>- Багануур ХК</li> <li>- МГТБҮ ТӨХХК</li> <li>- Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Эрдэнэс Тавантолгой ХК</li> <li>- TOCK TӨҮГ /Буянт-Ухаа 1,2, Аймаг бүрт 1000 айл хөтөлбөр/</li> <li>- ЭХЯ /Тавантолгой цахилгаан станц төсөл/</li> <li>- Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК</li> <li>- МИАТ ТӨХК</li> </ul>

6.25 МУХБ-ны санхүүжилтээр эрчим хүчний салбарт хэрэгжүүлсэн “Эгийн голын усан цахилгаан станц”, “Тавантолгой цахилгаан станц” зэрэг ач холбогдол бүхий төслүүдийн хэрэгжилт, үр дүн хангальтгүй, зээлийг хэрхэн эргэн төлөх нь тодорхойгүй байна.

## УИХ-ЫН ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ СОНСГОЛ-II

6.26 ХШТХ-ны II дахь шатанд тус банкны эх үүсвэрээр улсын төсвөөс эргэн төлөгдхөн нөхцөлтэй, хөрөнгө оруулалтын шинж чанартай төсөл, арга хэмжээ /355/-нд олгосон зээлийн ашиглалт, зарцуулалт, үр дүн болон банкны үйл ажиллагаанд эрх бүхий байгууллага, хөндлөнгийн хяналт шалгалтын болон олон улсын аудитын компаниудын дүгнэлт зөвлөмж, өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, үр дүнгийн байдал холбогдох гэрч, албан тушаалтнаас мэдүүлэг тайлбар авах байдлаар зохион байгуулахаар шийдвэрлэсэн.

### МУХБ-НЫ ЭХ ҮҮСВЭРЭЭР УЛСЫН ТӨСВӨӨС ЭРГЭН ТӨЛӨГДӨХ НӨХЦӨЛТЭЙ ОЛГОСОН ЗЭЭЛИЙН БАГЦ

6.27 УИХ-ЫН 2011 ОНЫ 02 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДРИЙН “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 15 дугаар тогтоолоор дараах төсөл, хөтөлбөрийг тус банкны санхүүжилтээр 2011 оноос хэрэгжүүлж эхлэхийг Засгийн газарт үүрэг болгосон байна<sup>40</sup>.

6.28 МУХБ нь Монгол Улсын 2015, 2016 оны төсвийн тухай хууль болон УИХ-ЫН 2011 оны 15 дугаар, 2014 оны 30 дугаар тогтоол, Засгийн газрын холбогдох тогтоолуудыг үндэслэн 2012-2017 онд нийт 355 төсөл, хөтөлбөрт нийт 2,540.2 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон.

Хүснэгт 36. МУХБ-НЫ САНХҮҮЖИЛТЭЭР ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ /МОО, ТБМ.ТӨГ, ТЕЗ-ААР/


Захиалагч	Төслийн тоо	Олгосон санхүүжилт							Нийт**
		Автозам, барилга, байгууламж	Төмөр зам	Тоног төхөөрөмж, их засвар	Бусад*	Хяналтын зөвлөх үйлчилгээ	Зураг төсөл, ТЭЗҮ		
Зам, тээврийн хөгжлийн яам	86	914.4	361.4	17.1	-	23.6	3.6	1,320.2	
Эрчим хүчиний яам, ДЦС-3, 4	50	278.7	-	303.9	-	-	-	582.6	
Барилга, хот байгуулалтын яам	37	171.8	-	-	-	-	-	171.8	
Гудамж төсөл	99	113.0	-	-	6.8	8.1	11.0	138.9	
Нийслэлийн автозамын хөгжлийн газар	46	104.0	-	-	-	3.3	0.7	107.9	
Сангийн яам, Гаалийн өрөнхий газар	5	30.9	-	-	87.6	0.2	-	118.8	
Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар	26	59.0	-	-	-	-	-	59.0	
Шадар сайд	1	-	-	20.0	-	-	-	20.0	
Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	3	2.6	-	-	8.5	-	-	11.1	
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	1	8.0	-	-	-	-	-	8.0	
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	1	2.0	-	-	-	-	-	2.0	
Нийт	355	1,684.4	361.4	341.0	103.0	35.2	15.2	2,540.2	

\* Бусад ангилалд – 6 хувийн орон сууцны зээлийн санхүүжилт, зөвлөх үйлчилгээ болон газар чөлөөлөлт, нөхөн олговор, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хамруулаас

\*\* - ам.доллароор олгосон зээлийн хувьд тухайн үеийн ханшаар төгрөгт хөрвүүлж илэрхийлэв

<sup>40</sup> УИХ-ЫН 2010 ОНЫ 36 ДУГААР ТОГТООЛООР БАТАЛСАН “ШИНЭ БУТЭЭН БАЙГУУЛАЛТ” ДУНД ХУГАЦААНЫ ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨР; УИХ-ЫН 2010 ОНЫ 32 ДУГААР ТОГТООЛООР БАТАЛСАН “ТӨРӨӨС ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО”; “МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2011 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ” УИХ-ЫН 2010 ОНЫ 45 ДУГААР ТОГТООЛОД ЗААСАН “САЙНИШАНД” АЖ ҮЙЛДВЭРИЙН ЦОГЦОЛБОР”; УИХ-ЫН 2008 ОНЫ 47 ДУГААР ТОГТООЛООР БАТАЛСАН “ӨӨРИЙН ХӨРӨНГӨӨР ГҮЙЦЭТГЭН ДАРАА ТӨЛӨГДӨХ НӨХЦӨЛТЭЙГӨӨР БАРИХ АВТО ЗАМ, ЭРЧИМ ХҮЧНИЙ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТАД ОРСОН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР”.

## Дурслэл 10. Зээл олголтын шийдвэрийн үндэслэл



МУХБ-наас олгосон нийт 2,540.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийн 88.9 хувь буюу 2,260.4 тэрбум төгрөгийг УИХ, Засгийн газрын тогтоолыг үндэслэн 295 төсөл, арга хэмжээнд олгосон;

Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хууль, Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуулиар Хөгжлийн банкны эх үүсвэрээр, төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг баталснаар өмнөх онуудад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байсан 60 төсөл, арга хэмжээнд нийт 279.8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна.

6.29 Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт “Хөгжлийн банкнаас ... санхүүжүүлэх төсөл, хөтөлбөр нь дараах шаардлагыг хангасан байна” гэж, хуулийн 8.1 дэх хэсэгт “... санхүүжүүлэх төсөл хөтөлбөрийн жагсаалтыг УИХ жил бүрийн хаврын чуулганаар батална” гэж заасан нь хуулийн 10.1 дэх шаардлагыг хангасан төсөл хөтөлбөрийн жагсаалтыг батлах шаардлагатай гэсэн агуулгатай байсан.<sup>41</sup>

6.30 УИХ-ын 2011 оны 15 дугаар тогтоолд заасан УИХ-ын 2010 оны 32, 36, 45 дугаар тогтоолоор баталсан хөтөлбөрүүд нь төрөөс тухайн салбарт баримтлах бодлого, хөгжүүлэх ерөнхий чиглэл, зорилтыг тодорхойлсон буюу бодлогын баримт бичгийн шинжтэй, хэрэгжүүлэх тодорхой төсөл, хөтөлбөрийн жагсаалт агуулаагүй байна.

6.31 Хөгжлийн банкны зээлээр төсөл, арга хэмжээ санхүүжүүлэх чиглэлийг Засгийн газарт өгсөн УИХ-ын дараах тогтоолуудыг Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн /2011 он/ 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт "... хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд зориулан зээл олгох бөгөөд санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг Улсын Их Хурал жил бүрийн хаврын чуулганаар батална" гэж заасантай нийцсэн гэж үзэх үндэслэлтүй байна. Үүнд:

- Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2012 оны 37 дугаар тогтоол,
- Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулах авах зарим арга хэмжээний тухай 2013 оны 63 дугаар тогтоол;
- Засгийн газарт чиглэл өгөх тухай 2014 оны 30 дугаар тогтоол;

6.32 Засгийн газрын дараах тогтоолоор ЗГҮЦ-ыг арилжаалж бүрдүүлсэн хөрөнгөөр тодорхой төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэхийг ЭЗХС болон МУХБ-ны ТҮЗ-д даалгасан нь МУХБ-ны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, /2011 он/ УИХ-ын 2011 оны 15 дугаар тогтоолтой нийцээгүй байна. Тухайлбал:

- Засгийн газрын 2013 оны “Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах тухай” 123 дугаар тогтоол нь хууль, УИХ-ын тогтоол үндэслэл болгоогүй бөгөөд “Замын-Үүд хилийн боомтын зам талбайн өргөтгөл, авто зам барилга 11 км” төслийг санхүүжүүлэхийг зөвшөөрсөн;
- Засгийн газрын 2014 оны “Төслийн нэгжийг санхүүжүүлэх тухай” 104 дүгээр тогтоол нь УИХ-ын 2011 оны 65 дугаар тогтоолыг үндэслэж, “Нүүрснээс синтетик байгалийн хий үйлдвэрлэх” төслийг санхүүжүүлэхийг зөвшөөрсөн;
- Засгийн газрын 2014 оны “Монголын хөрөнгийн биржийн талаар авах арга хэмжээний тухай” 152 дугаар тогтоолоор төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүжүүлэхийг даалгасан;
- Засгийн газрын 2014 оны “Оюутолгой төслийн санхүүжилтийн хүрээнд шаардагдах зардлыг шийдвэрлэх тухай” 274 дүгээр тогтоолоор санхүүжүүлэхийг зөвшөөрсөн;

<sup>41</sup> Эх сурвалж: Засгийн газрын 2016 оны 36 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн шалгалтын тайлан

**“Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн хүрээнд санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөр /БХБЯ, ЭХЯ, НХОГ/**

6.33 УИХ-аас 2010 оны 36 дугаар тогтоолоор баталсан “Шинэ бүтээн байгуулалт”<sup>42</sup> дунд хугацааны хөтөлбөрийн хүрээнд Солонго хороолол, Баянголын амны орон сууцны хороолол, Ирээдүй цогцолбор хороолол, Буянт-Ухаа орон сууцны хороолол, Яармаг орон сууцны хороолол, 14 дүгээр хорооллын дэд бүтцийн 74 төсөлд нийт 354,751.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

6.34 Хөтөлбөр хэрэгжсэнээр цахилгаан хангамжийн 8 хуваарилах байгууламжийн барилга, тоног төхөөрөмж, 250-630кВ-ын хүчин чадалтай 96 хаалттай дэд станцын барилга, тоног төхөөрөмж, цахилгаан хангамжийн 10 кВ-ын 157.5 км урт кабель шугам, 26 ус дулаан дамжуулах төвийн барилга, тоног төхөөрөмж, цэвэр ус хангамжийн 20 гүний худаг, 2800м<sup>3</sup> багтаамжтай 2 усан сан, ф100-400 мм-ийн голчтой 35.5 км урттай цэвэр усны шугам хоолой, бохир ус хангамжийн 4 насос станцын барилга, ф150-600 мм-ийн голчтой 21.3 км урттай бохир усны шугам хоолойг угсралтад гаргасан байна.

Хүснэгт 37. Шинэ бүтээн байгуулалт хөтөлбөрийн хүрээнд хэрэгжсэн төслийн мэдээлэл /сая төгрөг/

<b>Барилга, хот байгуулалтын яам</b>	
Төсөл, арга хэмжээний тоо	26
Төсөвт өртөг	123,973.0
Олгосон санхүүжилт	103,485.6
<b>Эрчим хүчний яам</b>	
Төсөл, арга хэмжээний тоо	21
Төсөвт өртөг	194,750.1
Олгосон санхүүжилт	192,252.2
<b>Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар</b>	
Төсөл, арга хэмжээний тоо	28
Төсөвт өртөг	78,725.0
Олгосон санхүүжилт	59,013.7

6.35 Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр МУХБ-ны санхүүжүүлсэн 74 төслийг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч наарт 2017 онд хүлээлгэн өгөх үед 50 төсөл бүрэн хэрэгжсэн, 24 төсөл 5-96 хувийн гүйцэтгэлтэй байсан бөгөөд Түр хорооны хяналт шалгалтын ажлын хүрээнд хэрэгжилтийн байдлыг нягтлахад 13 төсөл хэрэгжиж дуусаагүй, 2017 оноос хойш улс, нийслэлийн төсвөөс хөрөнгө батлагдаагүйгээс хөрөнгө оруулалт үр дүн, үр ашиггүй болох, төсөвт өртөг өсөх эрсдэлтэй байгааг анхаарч арга хэмжээ авч, шийдвэрлэх шаардлагатай байна. /Дэлгэрэнгүй Хавсралт 6-д үзүүлэв/

- *Барилга, хот байгуулалтын яам – 3 төсөл, арга хэмжээ;*
- *Эрчим хүчний яам – 3 төсөл, арга хэмжээ;*
- *Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар - 7 төсөл, арга хэмжээ;*

6.36 Төслийн удирдах хороо нь Засгийн газрын 2013 оны 118 дугаар тогтоол, Эдийн засгийн хөгжлийн сайдын 2013 оны “Түр журам батлах тухай” 29 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын үнэт цаасны хөрөнгөөр санхүүжүүлэх төслийг хэрэгжүүлэхэд баримтлах журам”-ыг тус тус үндэслэн үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд уг түр журам нь эрх зүйн чадамжгүй байсан<sup>43</sup> гэж үзэхээр байна. /Дэлгэрэнгүй тайлбарыг Хавсралт 7-д үзүүлэв/

### Гудамж төсөл

6.37 Монгол улсын Засгийн газрын 2013 оны 46 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын /2014 оны 96-р тогтоолоор Улаанбаатар хот болон аймгийн төөвүүдийн болгон өөрчилсөн/ авто замын сүлжээг өргөтгөн хөгжүүлэх, гэр хорооллын дэд бүтцийг цогц

<sup>42</sup> хот төлөвлөлт, эрчим хүч, инженерийн дэд бүтэц, авто замын сүлжээг олон улсын жишигт хүргэх, хүн амын орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, иргэдийг ажлын байраар хангах замаар улсын хэмжээнд тулгараад байгаа эдийн засаг, нийгмийн бэрхшээлтэй асуудлуудыг цогцоор шийдэн хөгжлийг жигд хангах, хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь ханган баталгаажуулах зорилго бүхий

<sup>43</sup> Уг түр журам захираганы хэм хэмжээний актаар бүртгэгдээгүй, Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолоор баталсан Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журмыг зөрчсөн. Эх сурвалж: Засгийн газрын 2016 оны 36 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн шалгалтын тайлан

байдлаар шийдвэрлэх зорилго бүхий “Гудамж төсөл”-ийг, Эдийн засгийн хөгжлийн сайдын 2013 оны 33 дугаар тушаалаар “Гудамж” төслийн нэгжийг байгуулж дараах дэд төслүүдийн хүрээнд 99 төсөлд 138,857.8 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

- “Хотын төв” дэд төсөл - УБ хотод нийт 33 уулзварын өргөтгөл, шинэчлэлийн ажил, 20.4 км авто зам барилгын ажил болон зураг төсөл;
- “Гэр хороолол” дэд төсөл - БГД, 16-р хороо, Гандантэгчинлэн хийд орчмын дахин төлөвлөлтийн иж бүрэн зураг төсөл;
- “Хурдны зам” дэд төсөл - Туулын хурдны зам, Сэлбэ гол дагуух хурдны замын зураг төсөл, ТЭЗҮ
- “Аймгийн төв” дэд төсөл – Архангай, Увс, Хэнтий аймгийн төвийн авто замын шинэчлэл;
- Хүй долоон худаг дах бүтээн байгуулалт - Хатуу хучилттай 8,5 км авто зам, Авто зогсоол, худалдаа үйлчилгээний талбай

Хүснэгт 38. Гудамж төслийн хүрээнд хэрэгжсэн төсөл, арга хэмжээ /сая төгрөг/

Ангилал	Төслийн тоо	Төсөвт өртөг	Нийт олгосон санхүүжилт
Барилга байгууламж	55	124,569.6	113,004.7
Зураг төсөл	37	10,734.4	9,940.0
Хяналтын зөвлөх үйлчилгээ	1	9,874.1	8,070.0
Төслийн нэгжийн үйл ажиллагааны зардал	1	7,991.1	6,265.2
Газар чөлөөлөлт, нөхөн олговор	1	1,300.0	402.9
ТЭЗҮ /Туулын хурдны зам, Сэлбэ гол дагуух хурдны зам/	2	1,041.6	1,019.4
Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ	2	158.7	155.6

6.38 Гудамж төслийн хүрээнд хэрэгжиж байсан боловч бүрэн дуусаагүй дараах ажлуудын хувьд гүйцэтгэгчийн хийсэн ажлын тоо хэмжээ, олгосон санхүүжилтийн зарцуулалтыг нягтлах, ашиглалтад хүлээн авах шаардлагатай байна. Үүнд:

- “Үйлдвэрчний эвлэлийн гудамжийг Москва хорооллын арын далангаар явуулж Өнөр хороолол 33-р байрны арын замтай холбох 1 км автозам” - нийт 702.1 сая төгрөгийн санхүүжилт олгосон боловч газар чөлөөлөлт, санхүүжилтийн эх үүсвэр зэрээс шалтгаалан бүрэн дуусаагүй,
- Доржийн гудамж, Монелийн 4 замын уулзвар өргөтгөл, шинэчлэлт - Авто замын уулзвар болон автозамын хамт хийгдэх гэрээтэй хэдий ч “Гудамж” төсөл зогсонги байдалд орсны улмаас зөвхөн уулзвар хийгдсэн байдалтай ажил зогссон, өнөөдрийг хүртэл байнгын ашиглалтад хүлээн авах комисс ажиллаагүй байна.

6.39 Гудамж төслийн хүрээнд нийт 10,959.4 сая төгрөгийн авто замын зураг төсөл, ТЭЗҮ боловсруулсан боловч төслийн нэгж болон Нийслэлийн авто замын хөгжлийн газар хүлээлцэх ажил дуусаагүй, зураг төслийн ашиглалт хангалтгүй байгаа нь Хөгжлийн банкны санхүүжилт үр дүнгүй болох эрсдэлтэй байгааг харуулж байна.

#### Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хууль, Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуулийн хүрээнд хэрэгжсэн төслүүд

6.40 УИХ-аас баталсан Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хууль, Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар хавсралтаар баталсан Хөгжлийн банкны эх үүсвэрээр төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад шинээр эхлэх 5 төсөл, арга хэмжээ, өмнөх онуудад улсын төсвийн санхүүжилтээр хэрэгжиж байсан 32 төсөл, арга хэмжээнд нийт 154,741.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. /Дэлгэрэнгүйг Хавсралт 8-д үзүүлэв/

Хүснэгт 39. БХБЯ, ЭХЯ-нд хэрэгжсэн төслийн мэдээлэл /сая төгрөг/

Төсвийн ерөнхийлөн захирагч	
Барилга, хот байгуулалтын яам	
Төсөл, арга хэмжээний тоо	12
Төсөвт өртөг	88,436.7
Олгосон санхүүжилт	68,322.3
Эрчим хүчний яам	
Төсөл, арга хэмжээний тоо	25
Төсөвт өртөг	92,946.5
Олгосон санхүүжилт	86,419.6

6.41 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын шинж чанартай төслүүдэд олгосон зээлийн санхүүжилт нь МУХБ-ны дунд болон урт хугацааны стратеги төлөвлөгөө, бизнес төлөвлөгөөнд тодорхойлсон зорилго, ТҮЗ-ийн 2011 оны 13 дугаар тогтоолоор баталсан зээлийн бодлого, МУХБ-ны тухай хуулийн /2011 он/ 8 дугаар зүйлийн 8.1-д "... Монгол Улсын хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд зориулан зээл олгох" гэж заасантай нийцэхгүй байна.

- Сумын төвийн гэрэлтүүлэг, авто зам, тохижилт /Ховд аймгийн Эрдэнэбүрэн, Мянгад, Манхан, Ховд, Мөст, Чандмань сумадад/,
- Хатуу хучилттай авто зам 1.79 км /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 11-р хороо, Хонхор тосгон/,
- Төв замаас Гордок хүртэлх хатуу хучилттай авто зам, 1 км /Улаанбаатар, Налайх дүүрэг/,
- Хотын зам, тохижилт, ногоон байгууламж /Өвөрхангай, Арвайхээр сум/,
- Аймгийн төвийн авто замын дуусгалт, 5.87 км /Орхон, Баян-Өндөр сум/,
- Аймгийн төвийн авто замын үлдэгдэл санхүүжилт 5,08 км /Орхон, Баян-Өндөр сум Дэнж баг/,
- ФМ-104.5 радиогийн хажуугийн 250 м замыг асфальтан зам болгох, сансрын колонкийн арын төв зам хүртэлх /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/,
- Лүн-Эрдэнэсант-Арвайхээр чиглэлийн A0301 авто зам,
- Улаанбаатар-Баянчандмань чиглэлийн A0402 авто зам засвар,
- Улаанбаатар-Дархан чиглэлийн A0401 авто зам засвар,
- Улаанбаатар-Зуунмод чиглэлийн A0201 авто зам засвар.

### **Зам, тээврийн хөгжлийн яам**

6.42 Монгол Улсын Их Хурлын 2010 оны 36 дугаар, 2011 оны 15 дугаар тогтоолын хүрээнд Хөгжлийн банк нь Монгол Улсын 2015, 2016 оны Төсвийн тухай хууль, Засгийн газраас баталсан дараах тогтоолуудыг үндэслэн автозамын салбарт хэрэгжсэн 1,099.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 84 төсөлд нийт 958.7 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна. /Дэлгэрэнгүйг Хавсралт 9-д үзүүлэв/

Хүснэгт 40. ЗТХЯ-нд хэрэгжсэн төслийн мэдээлэл /сая төгрөг/

Үндэслэл, ангилал	Төслийн тоо	Төсөвт өртөг	Олгосон санхүүжилт
<b>УИХ, Засгийн газрын тогтоолын хүрээнд:</b>			
Авто зам, гүүр	35	914,184.9	821,945.6
Зураг төсөл	15	24,512.1	23,645.9
Их засвар	4	17,600.0	17,101.9
Хяналтын зөвлөх үйлчилгээ	11	3,607.8	3,607.8
<b>Нийт</b>	<b>65</b>	<b>959,904.7</b>	<b>866,301.3</b>
<b>Монгол Улсын 2015, 2016 оны төсвийн тухай хуулийн хүрээнд:</b>			
Авто зам, гүүр	19	140,052.2	92,446.5

6.43 МУХБ-ны санхүүжилтээр хэрэгжүүлж, 2014 онд ашиглалтад орохоор төлөвлөж байсан дараах 4 төсөл, арга хэмжээ шалгах үеийн байдлаар бүрэн дуусаагүй, ашиглалтад хүлээн аваагүй байна.

- Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 27 км авто замын барилга,
- Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 50 км авто замын барилга,
- Хужирт-Төвхөн Хийд-Улаанцутгалан чиглэлийн авто зам барилга 90.1 км,
- Ховд-Улаангом чиглэлийн авто замын зураг 190 км.

### **Шинэ төмөр зам төсөл**

6.44 Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 28 дугаар тогтоолоор Шинэ төмөр зам төсөлд нийт 55.0 сая ам.долларын зээлийг тогтоолын 1, 2 дугаар хавсралтад заасан ажлыг санхүүжүүлэхийг Хөгжлийн банкны ТҮЗ-ийн даргад зөвшөөрч, эргэн төлөлтөд шаардагдах хөрөнгийг тухай бүр улсын төсөвт тусгаж байх Эдийн засгийн хөгжлийн сайд, Сангийн сайд нарт даалгажээ. /Дэлгэрэнгүйг Хавсралт 10-т үзүүлэв/

- Тус тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-д заасан I, II дахь үе шатны төмөр замын суурь бүтцийг барих ажлын хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлын жагсаалтыг баталж нийт 22.5 сая ам.доллар;
- Хөгжлийн банк, ЭЗХЯ, ЗТЯ, Монголын төмөр зам ТӨХК нь 55.0 сая ам.долларын зээлийн гэрээг 2013.02.20-ны өдөр байгуулсан бөгөөд уг зээлийн гэрээнд 2013.12.31-ний өдөр дуустал санхүүжилт олгох боломжтой, ашиглагдаагүй байгаа санхүүжилт цуцлагдахаар заасан тул 22.52 сая ам.доллар олгосон байна.

6.45 Монголын төмөр зам ТӨХК-ийн ТҮЗ-ийн 2011.03.01-ний өдрийн 23 дугаар тогтоолоор “Даланзадгад-Чойбалсан чиглэлийн 1100 орчим км төмөр замын суурь бүтэц барих төсөлд Зөвлөх үйлчилгээ үзүүлэх багаар “McKinsey & Company” компанийг сонгож, гэрээ байгуулахыг гүйцэтгэх захирал Б.Батзаяад зөвшөөрсөн байх бөгөөд уг компанийг хэрхэн сонгон шалгаруулсан талаарх баримт материал байхгүй байна.

6.46 Монголын төмөр зам ТӨХК нь Төрийн өмчийн хорооны 2011 оны “Зээл авах зөвшөөрөл олгох тухай” 107 дугаар тогтоолыг үндэслэн 16,342.1 сая төгрөгийн үнэ бүхий 3 илчit тэргийг барьцаалан Хаан банктай 5.65 сая ам.долларын зээлийн гэрээ 2011.04.07-ны өдөр байгуулж, дараах ажлуудыг гүйцэтгүүлсэн байна.

- Зээлийн санхүүжилтээр Даланзадгад-Тавантолгой-Сайншанд-Баруун Урт-Чойбалсан чиглэлийн дагуу геологи, геодези, байгаль орчинд нөлөөлөх байдлын өрөнхий үнэлгээ судалгааны ажлуудыг Геомастэр ХХК, Эко Гидро Гео ХХК, Найчуран Састэйнэбл ХХК зэрэг компаниар гүйцэтгүүлсэн байна.
- Маккинсэй энд Консалтинг компанитай Даланзадгад-Тавантолгой-Цагаан суварга-Зүүнбаян, Сайншанд-Баруун урт, Хөөт, Чойбалсан чиглэлийн 1100 км орчим төмөр замын суурь бүтэц барих ажлын ТЭЗҮ болоевсруулахтай холбогдсон “Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г 2011.04.07-ны өдөр байгуулсан гэрээний 1.5.1-д “Зөвлөхүүд гэж МакКинсэй, Пиллсбури, БиЭнПи Парibus болон Либерти партнера ХХК-ийг” гэж заасан байх бөгөөд Либерти партнера ХХК-ийг төлөөлж Ч.Ганбат<sup>44</sup> гарын үсэг зурсан байна.

6.47 Хөгжлийн банкнаас 2013 оны 02 дугаар сарын 21-ний өдөр олгосон 22.52 сая ам.долларын санхүүжилтээс Геомастер ХХК, Найчрал састанэбл ХХК, Эко гидро гео ХХК, Sidney austin LLP, MDS Associates ХХК-иудад нийт 1.92 сая ам.долларыг, Монголын төмөр зам ТӨХК-д 6.49 сая ам.долларыг Хаан банк хооронд 2011.04.07-ны өдөр байгуулсан зээлийн гэрээний үндсэн төлбөр, хүүгийн төлбөрийг төлөх зорилгоор шилжүүлсэн байна.

6.48 Засгийн газрын 2012 оны “Төмөр замын талаар авах зарим арга хэмжээний тухай” 93 дугаар тогтоолоор Монголын төмөр зам ТӨХК-д олгосон төмөр зам барих тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, төмөр замын суурь бүтэц эзэмшигч хувьцаат компанийн үйл ажиллагаа эхлэх хүртэл Сайншанд-Тавантолгой-Ухаахудаг чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барих-ашиглах-шилжүүлэх төрлөөр концессыг шууд олгож 2012 оны эхний хагаст багтаан Ухаахудаг-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийн барилга угсралтын ажилтай зэрэг эхлүүлэхээр шийдвэрлэжээ.

6.49 Засгийн газрын 2012 оны “Төмөр замын суурь бүтцийг барих концессын гэрээний тухай” 161 дүгээр тогтоолоор дараах концессын гэрээг байгуулах, суурь бүтэц барих тусгай зөвшөөрөл олгож, ЗТБХС-ын 2012 оны “Эрх олгох тухай” 157 дугаар тогтоолоор гэрээнд гарын үсэг зурах эрхийг тус яамны ТНБД, Төмөр замын газрын дарга нарт олгосны дагуу 2012.05.31-ний өдөр дараах гэрээг байгуулжээ. Үүнд:

- Сайншанд – Тавантолгой – Ухаахудаг – Гашуунсухайт чиглэлийн төмөр замын Сайншандаас Тавантолой чиглэлд 225 км төмөр замын суурь бүтцийг Монголиантранс Лайн ХХК-тай,
- Ухаахудаг – Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг Энержи ресурс рэйл ХХК-тай тус тус байгуулах,

6.50 ЗТБХЯ, ТӨХ, Төмөр замын газар нь дээрх тогтоолын дагуу төмөр замын суурь бүтэц “Барих-ашиглах-шилжүүлэх” концессын гэрээг 2012 оны 5 дугаар сард байгуулж, Энержи ресурс рэйл ХХК нь зураг төслийн болон барилга угсралтын ажлыг эхлүүлж байсан боловч Засгийн газрын 2012 оны 121, 2013 оны 28 дугаар тогтоолоор дээрх концессын

<sup>44</sup> ЗТБХС-ын 2010.12.28-ны өдрийн 427 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсгийн ахлагч Ч.Ганбат

гэрээнүүдийг цуцалж, Монголын төмөр зам ТӨХК-д төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрөл, төмөр замын суурь бүтцийн “барих-ашиглах-шилжүүлэх” концессыг олгохоор шийдвэрлэжээ.

- ЗТС, ТӨХ, Монголын төмөр зам ТӨХК болон "Энержи Ресурс" ХХК, "Энержи Ресурс Рэйл" ХХК-иуд "... барих-ашиглах-шилжүүлэх концессын гэрээг цуцлах гэрээ"-г 2013.05.06-ны өдөр байгуулсан,
- Монголын төмөр зам ТӨХК, Энержи Ресурс Рэйл ХХК, Samsung C&T болон түүний 100 хувийн охин компани болох Эс Си Ти И Си Эм ХХК нь “Эрх, үүрэг шилжүүлэх гэрээ”-г 2013.05.06-ны өдөр байгуулсан,
- Засгийн газрын 2015 оны “Концессын гэрээ цуцалсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 478 тогтоолоор “Энержи Ресурс” ХХК-ийн Тавантолгой-Гашуунсуухайтын чиглэлийн төмөр замын төсөлд зарцуулсан төлбөрийг 60,335,716.4 ам.доллароор тооцож Хөгжлийн банкны санхүүжилтээр төлөх талаар холбогдох арга хэмжээ авахыг даалгасан,
- Сангийн яам, ЗТХЯ болон Энержи ресурс ХХК, Энержи ресурс рэйл ХХК нь Засгийн газрын 2015 оны 478 дугаар тогтоолыг үндэслэн “Өр төлбөр барагдуулах гэрээ”-г 2016.01.14-ний өдөр байгуулсан,
- Сангийн сайдын 2016.01.14-ний өдрийн 22 дугаар тушаалаар 60,335,716.4 ам.доллартай тэнцэх төгрөгөөр илэрхийлсэн, жилийн 15.2 хувийн хүүтэй векселийг концесс хэрэгжүүлж байсан компанийд эзэмшигүүлэхийг, 2016.12.22-ны өдрийн 414 дүгээр тушаалаар 119.5 тэрбум төгрөг санхүүжүүлэхийг даалгасны дагуу векселийн үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийг 2017.01.13-ны өдөр барагдуулжээ.

6.51 Түр хорооны хяналт шалгалтын ажлын хүрээнд ажлын хэсгийн тайлан, дүгнэлт ЗТХЯ, Сангийн яамны архивд уг тайлан хадгалагдаагүй тухай албан бичгээр хариу ирүүлсэн бөгөөд “Монголын төмөр зам” ТӨХК нь шаардсан баримт материалыг ирүүлээгүй төдийгүй архивд хадгалагдаж буй эсэх талаараа албан бичгээр тайлбар ирүүлээгүй бөгөөд “Энержи ресурс” ХХК-иас гүйцэтгэсэн ажлын тоо, хэмжээг тогтоосон тайлан, дүгнэлтийг нэмэлтээр ирүүлсэн болно.

6.52 “Шинэ төмөр зам” төсөлд Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 82 дугаар тогтоолоор 200.0 сая ам.доллартай тэнцэх төгрөгийн санхүүжилт олгож уг санхүүжилтийг төрөөс оруулсан хувь хөрөнгөд тооцож бүртгэх, 2016 оны 83, 84 дугаар тогтоолоор 4.6 сая ам.доллар 3.6 тэрбум төгрөгийн зээл олгохыг Хөгжлийн банкны ТУЗ-ийн даргад, эргэн төлөлтөд шаардагдах хөрөнгийг тухай бүр улсын төсөвт тусгаж байх Сангийн сайдад даалгажээ.

- Хөгжлийн банк, ЭЗХЯ, ЗТЯ, Монголын төмөр зам ТӨХК 200.0 сая ам.долларын зээлийн гэрээг 2013.05.06-ны өдөр, Хөгжлийн банк болон Монголын төмөр зам ТӨХК нь 4.6 сая ам.доллар 3.6 тэрбум төгрөгийн зээлийн гэрээг 2016.09.29-ний өдөр тус тус байгуулжээ.

6.53 Монголын төмөр зам ТӨХК болон Samsung C&T corporation, Эс Си Ти И Си Эм ХХК нь 439,840,000.0 ам.долларын үнийн дүн бүхий Ухаахудаг-Гашуунсуухайт чиглэлийн 267 км орчим төмөр замын суурь бүтцийг барих ажлын ерөнхий гүйцэтгэгчийн EPC гэрээг 2013.05.06-ны өдөр байгуулсан бөгөөд Хөгжлийн банк дахь зээлийн дансны хуулга болон талуудын 2017.03.21-ний өдрийн санхүүжилтийн тооцоо нийлсэн актаас үзэхэд нийт 18 удаагийн гүйлгээгээр 224.4 сая ам.доллар, 3.6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна.

- Хөгжлийн банкнаас олгосон төгрөгийн зээлээс 2.4 тэрбум төгрөгийг зөвлөх үйлчилгээний Nippon Koei Co., Ltd-д гэрээт ажлын төлбөрт шилжүүлсэн бөгөөд уг зээл улсын төсөвт шилжих үед 1.2 тэрбум үлдэгдэлтэй,
- Монголын төмөр зам ТӨХК-иас ирүүлсэн хүсэлт, ажлын гүйцэтгэлийн дагуу нийт 223.1 сая ам.долларын зээлийг дараах компаниудад ам.доллар болон төгрөгөөр шилжүүлсэн бөгөөд уг зээл улсын төсөвт шилжих үед 1.2 сая ам.долларын үлдэгдэлтэй байжээ.

## Хүснэгт 41. Төслийн хүрээнд олгосон зээлийн зарцуулалт

Гүйцэтгэгч компаниуд	сая ам.доллар	сая төгрөг
Nippon Koei Co Ltd /FEED зураг төсөл боловсруулах/	6.81	5,671.05
Sidney austin LLP /хуулийн зөвлөх үйлчилгээ/	4.14	-
DB int'l GmbH /ДБ ОУТГазар/ /техникийн хяналтын үйлчилгээ/	2.70	-
BNP Paribas (China) Limited Beijing Branch /санхүүгийн зөвлөх үйлчилгээ/	0.96	-
Либерти партнерс ХХК /дотоодын санхүүгийн зөвлөх үйлчилгээ/	0.72	-
Guggenheim partners IM LLC /санхүүгийн зөвлөх үйлчилгээ/	0.61	-
Эм ди эс Associates ХХК /дотоодын хуулийн зөвлөх үйлчилгээ/	0.30	-
Эс Си ТИ И Си Эм ХХК /Samsung C&T/	-	299,064.39
Татварын ерөнхий газар /сүүтган татвар/	-	7,604.85
Геомастер ХХК, Эко гидро гео ХХК	-	5,629.92
Монголын төмөр зам ТӨХК	6.48	4,058.06
Найчрал Саастайнэблэ ХХК /байгаль орчны үнэлгээ/	-	518.68
Өрх ХХК, Монцахэр ХХК /цахилгааны зураг төсөл, дэд өртөө/	-	428.40
Үс ашигласны төлбөр /Цогт-цэций, Ханбогд, Баян-овоо сумын ЗДТГ/	-	193.60
Beijing Jiatong University	-	112.36
Археологи, палеонтологийн авран хамгаалах хайгуул/с зардал	-	90.02
Нийт	22.72	323,371.71

6.54 Ерөнхий гүйцэтгэгч Эс Си Ти И Си Эм ХХК нь төслийн хүрээнд хийгдэх газар шорооны ажилд дотоодын дараах компаниудтай гэрээ байгуулан ажил гүйцэтгүүлсэн байна.

- Эсто ХХК, Мапроуд ХХК, Монроуд ХХК, Нутгийн буян ХХК, Бидний зам ХХК, Кэй эйч эн ар ХХК, Арц суварга ХХК, Хүслэнт бүтээмж ХХК, Жилин мандал ХХК, Дардан говь ХХК, Билэгт зам ХХК, Пауэр логистикс ХХК, Транскон ХХК,
- Транскон ХХК, КЭЙ ЭЙЧ ЭН АР ХХК-иуд нь Монголын төмөр зам ТӨХК-тай “Хөрс хуулалтын ажлын гэрээ” 2011.04.25-ны өдөр байгуулж байсан байх тул 2013-2014 онд олгосон санхүүжилтийг гэрээ, ажлын тоо хэмжээтэй тулган нягтлах шаардлагатай байна.

6.55 Засгийн газраас олгохоор шийдвэрлэсэн санхүүжилт бүрэн олгогдоогүйн улмаас Монголын төмөр зам ТӨХК гүйцэтгэгч компанийн ажлын гүйцэтгэлийн төлбөрийг хийх боломжгүй болсон тул 2016 оны A/21 дүгээр тушаалаар “Самсунг Си энд Ти” корпорац, “Эс Си Ти И Си Эм” ХХК-тай байгуулсан гэрээ дуусгавар болгох, эцсийн тооцоо гаргах ажлын хэсэг байгуулагдан ажилласан.

- Сангийн сайд болон Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 307/05 дугаар хамтарсан тушаалын дагуу хамтарсан ажлын хэсэг байгуулж ажил хүлээн авсан гэх боловч уг ажлын хэсгийн тайлан ЗТХЯ-ны архивд хадгалагдаагүй тухай албан бичгээр хариу ирүүлсэн болно. “Монголын төмөр зам” ТӨХК уг ажлын тайланг ирүүлээгүй төдийгүй архивт хадгалагдаагүй байна гэх боловч энэ тухайга албан бичгээр ирүүлээгүй болно.
- “Грант торнтон” ХХК-ийн 2019 онд гүйцэтгэсэн “Зөвшшилцсэн горимоор гүйцэтгэсэн аудитын гэрээт ажлын тайлан” гэх тайланд “Шинэ төмөр зам” төслийн хүрээнд хийгдсэн зарцуулалтыг түүхэн өртгөөр нь илэрхийлсэн ба ам.долларт хөрвүүлж нийт 276.3 сая ам.долларын хөрөнгө оруулалтын зардлыг баталгаажуулсан байна.
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны “Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай” 2 дугаар тогтоолоор “Монголын төмөр зам” ТӨХК-ийн эргэлтийн хөрөнгөд /дуусаагүй үйлдвэрлэл, бараа материал, урьдчилж төлсөн зардал/ бүртгэлтэй 457.3 тэрбум төгрөг буюу 273.5 сая ам.долларын хөрөнгийг “Тавантолгой төмөр зам” ХХК-д шилжүүлсэн байна.

6.56 Төмөр замын царигаас үл хамааран 2 улсын хил хүртэлх төмөр замыг барих ёстой хэдий ч бүрэн дуусаагүй, “Самсунг Си энд Ти” ХХК-ын гэрээг цуцлах хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлын тоо хэмжээг тогтоосон ажлын хэсгийн тайлан, актыг ирүүлээгүй болно.

### Нийслэлийн авто замын хөгжлийн газар

6.57 Хөгжлийн банк нь УИХ, Засгийн газрын дараах тогтоолуудын хүрээнд Нийслэлийн авто замын газарт хэрэгжсэн 46 төсөлд нийт 107,918.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

- УИХ-ын 2010 оны 36 дугаар, Засгийн газрын 2011 оны 336 дугаар тогтоол,
- Засгийн газрын 2011 оны 105 дугаар,

- Засгийн газрын 2012 оны 106 дугаар,
- Засгийн газрын 2014 оны 230 дугаар тогтоол

6.58 Хөгжлийн банкнаас уг төслүүдийг 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар тасалбар болгон Нийслэлийн авто замын газарт хүлээлцэх үед авто замын барилга угсралт, хяналтын зөвлөх үйлчилгээ бүрэн хэрэгжсэн байжээ.

Хүснэгт 42. Нийслэлийн авто замын хөгжлийн газарт хэрэгжсэн төслийн мэдээлэл /сая төгрөг/

Ангилал	Төслийн тоо	Төсөвт өртөг	Нийт олгосон санхүүжилт
Барилга байгууламж	21	114,522.1	104,007.4
Зураг төсөл	21	683.0	660.6
Хяналтын зөвлөх үйлчилгээ	4	3,384.5	3,250.5

6.59 Хөгжлийн банк, Нийслэлийн авто замын газар хооронд байгуулсан гэрээний дагуу гүйцэтгэгч компаниуд 31 зураг төсөл 2016 онд хүлээлгэн өгсөн хэдий ч ашиглалт, үр дүн хангалтгүй байгаа нь санхүүжилтийн үр ашгийг бууруулж байгаа бөгөөд захиалагч байгууллагын зүгээс "... батлагдсан зураг төслийг жил бүрийн төсвийн төслийн саналд Сангийн яамны журмын дагуу хүргүүлдэг болно ..." гэсэн тайлбар өгсөн болно. Үүнд:

- Зураг төслийн дагуу автозамын барилга угсралтын ажил гүйцэтгэсэн – 14
- Зураг төслийн дагуу автозамын барилга угсралтын ажил хэсэгчлэн гүйцэтгэсэн – 2
- Зураг төслийн дагуу автозамын барилга угсралтын ажил гүйцэтгээгүй - 15

### Гаалийн ерөнхий газар

6.60 Гаалийн ерөнхий газрын “Замын Үүд хилийн боомтын зам талбайн өргөтгөл, 11 км хатуу хучилттай автозам барилга”-ын ажлын Ерөнхий гүйцэтгэгч “Тай фа шян групп”-д 30.89 тэрбум, зөвлөх үйлчилгээний Ти Ай Би ХХК-д 208.25 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

- Засгийн газрын 2013 оны 123 дугаар тогтоол, Ерөнхий сайдын 2013 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” 55 дугаар захирамжийг үндэслэн 2013.04.25-ны өдөр С-АЗ-Б 2013-5 тоот гэрээг МУХБ, Гаалийн Ерөнхий газар, БНХАУ-ын “Тай Фа Шян” групп байгуулсан.
- Ажлын гүйцэтгэлийг хүлээн авах Улсын комисс 2017.05.12-ны ажлын чанарын акт, холбогдох баримтуудтай нь танилцан газар дээрх шалгалтын комиссын гишүүдийн 100 хувийн саналаар байнгын ашиглалтад оруулахаар шийдвэрлэсэн байна.

### Сангийн яам

6.61 Сангийн сайдын багцад дараах 3 төсөл, арга хэмжээнд нийт 87,649.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Үүнд:

Хүснэгт 43. Сангийн яаманд хэрэгжсэн төслийн мэдээлэл /сая төгрөг/

Нэр	Олгосон огноо	Дуусах огноо	Олгосон дүн сая ам.доллар	Xүү /жил, хувь/	Шилжүүлсэн үлдэгдэл 2016.12.31	Xүү /авлага/
Орон сууцны 6 хувийн зээлийн санхүүжилт	2013.12.31	2017.02.15	36.85	6.75	36.85	37.0
	2013.12.10	2017.02.15	21.54		21.54	26.62
Оюутолгой болон бусад стратегийн ач холбогдол бүхий төслийн санхүүжилт	2014.11.12	2016.11.12	2.51	7.65	2.51	2.54
Монголын хөрөнгийн бирж	2014.05.26	2015.12.31	1.49	7.0	-	-
Нийт дүн	-	-	62.4	-	60.9	61.16

- Орон сууцны зээлийн санхүүжилт:

УИХ-ын 2010 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 36 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ бүтээн байгуулалт дунд хугацааны зорилтот хөтөлбөр”, Засгийн газрын 2011 оны 138, 341, 2012 оны 55 дугаар тогтоолуудын хүрээнд бага, дунд орлоготой иргэдэд жилийн 6 хувийн хүүтэй орон сууцны зээл олгох хөтөлбөрийн санхүүжилтэд зориулж 2012, 2013 онуудад Сангийн яам, Төрийн банктай 50.0 тэрбум болон 30.0 тэрбум төгрөг буюу нийт 80.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийн гэрээг байгуулж, дамжуулан зээлийн санхүүжилтийг олгожээ.

Төрийн банкнаас нийт 1,868 харилцагчдад 80.0 тэрбум төгрөгийн дамжуулан зээлийг олгосон бөгөөд тус санхүүжилт нь бага, дунд орлоготой иргэдэд тохилог, тав тухтай орчинд амьдрах

нөхцөлийг бий болгож, орон сууц худалдан авах боломжийг бий болгох ач холбогдолтой байсан бөгөөд Сангийн яам, Хөгжлийн банк 2016.12.31-ний өдрөөр нийт өглөг, авлагыг харилцан суутгаж хүүгийн хамт 145.4 тэрбум төгрөгөөр тооцоо нийлсэн байна.

- Оюутолгой төслийн нэмэлт санхүүжилтийн төсөл:**

УИХ-ын жагсаалтаар батлаагүй байхад Засгийн газрын 2014 оны 274 дүгээр тогтоолоор төслийн санхүүжилтийн үр ашигтай байдлыг хангах, бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай стратеги, санхүү, хууль болон олон нийтийн харилцааны зөвлөх үйлчилгээнд 10.0 сая хүртэлх ам.долларыг зохих журмын дагуу санхүүжүүлэхийг МУХБ-нд зөвшөөрсний дагуу Эрдэнэс Оюу толгой ХХК-д 2.5 сая ам.долларын зээлийг олгосон байна.

Сангийн яам, Эрдэнэс Оюутолгой ХХК болон Хөгжлийн банк 2 жилийн хугацаатай, жилийн 7.65 хувийн хүйтэй, нийт 10.0 сая ам.долларын зээлийн гэрээг 2014.11.12-ны өдөр байгуулж, Painter Law Firm PLLC, Shearman&Sterling LLP, Comprador Limited, Маркетматрикс ХХК-д 2014.11-2015.09 сарын хугацаанд нийт 2,512,000.20 ам.долларын санхүүжилтийг олгосон хэдий ч уг зөвлөх үйлчилгээний үр дүнд Оюутолгой төслийн хэлэлцээрт бодитой, эерэг үр дүн үзүүлсэн гэх хангалттай бөгөөд зохистой нотолгоог ирүүлээгүй болно.

- Монголын хөрөнгийн бирж:**

Монголын Хөрөнгийн бирж ТӨХК-д Засгийн газрын 2014 оны 152 дугаар тогтоол, ТӨХ /хуучин нэрээр/-ны 2014 оны 329 дүгээр тогтоолыг үндэслэн Лондонгийн хөрөнгийн бирж групптэй байгуулсан “Ажлын мастер гэрээ”-ний төлбөрийг төлөх зориулалтаар 1,494,100.00 ам.долларын зээлийг улсын төсвөөс эргэн төлөх нөхцөлөөр олгосон.

Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуулийн дагуу “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д улсын төсвөөс олгох санхүүжилт, МУХБ-наас олгосон зээл, хүүгийн төлбөрийн нийт үлдэгдлийг 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тооцоо нийлснээр компанийн санхүүгийн тайланд тусгасан байна.

### **УУХҮЯ-нд хэрэгжүүлсэн 3 төсөл, арга хэмжээнээс 2 төсөл, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй, үр ашиггүй зарцуулагдсан байна**

6.62 УУХҮЯ-нд хэрэгжсэн 3 төсөлд нийт 11,098.92 сая төгрөгийн санхүүжилт олгосон боловч 2 төслийн хэрэгжилт хангалтгүй, тодорхой үр дүнд хүрээгүй, төслийн хүрээнд боловсруулсан судалгаа, шинжилгээний тайланг цаашид ашиглах эсэх нь тодорхойгүй, зээл үр ашиггүй зарцуулагдсан байхаар байна.

Хүснэгт 44. УУХҮЯ-нд хэрэгжсэн төслийн мэдээлэл /сая төгрөг/

Төслийн нэр	ЗГ-ын тогтоол	Хүү, %	Эхлэх	Дуусах	Нийт олгосон дүн
Нүүрснээс синтетик байгалийн хий үйлдвэрлэх төсөл	2014 оны 104	10.0	2014.05.29	2017.02.15	585.47
Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор	2013 оны 76	7.38	2013.10.25	2017.06.30	7,920.45
Төсвөөс шилжин ирсэн: Замын-Үүд дэх шингэн түлш шилжүүлэн ачих байгууламжийн автоматжуулалт	2015, 2016 оны Төсвийн тухай хууль	4.7917	2014.10.15	2015.11.01	2,593.00
Нийт					11,098.92

- Замын-Үүд дэх шингэн түлш шилжүүлэн ачих байгууламжийн автоматжуулалт /Улсын төсвөөс шилжин ирсэн/**

Гүйцэтгэгч Эм Pi Ай консалтантс ХХК нь захиалагчтай байгуулсан гэрээний дагуу 2014.10.15-2015.11.01 хугацаанд ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, гэрээний хугацаанд гүйцэтгэн 2015.11.11-нд Барилга байгууламж ашиглалтад оруулах комиссын 63/15 актаар ашиглагч байгууллагад хүлээлгэн өгсөн.

Төсөл хэрэгжсэнээр "Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж" ТӨҮГ иж бүрэн автомат удирдлага, хяналтын системтэй болж хэмжүүр хэмжих хэрэгсэл алдаагүй хэмжиж бүтээгдэхүүний хэвийн болон хэвийн бус хорогдол багасаж, аюулгүй ажиллагааг бүрэн ханган, хүний гар оролцоог бууруулж зардлыг хэмнэсэн гэж УУХҮЯ-ны ХШҮДАГ-аас дүгнэсэн байна.

- Нүүрснээс синтетик байгалийн хий үйлдвэрлэх төсөл:** /Төслийн нэгж татан буугдаж, Эрдэнэс монгол ХХК-д шилжсэн/

БНХАУ-ын Синопек корпорацитай хамтран, үйлдвэрийн ТЭЗҮ болон холбогдох судалгаа, шинжилгээ, төлөвлөлтийн ажлыг хийж, төсөл хэрэгжүүлэх, урьдчилсан бэлтгэлийг хангахад 585.5 сая төгрөгийг зарцуулсан боловч төсөл хэрэгжээгүй тул Засгийн газрын 2016 оны 131 дүгээр тогтоолоор төслийн нэгжийг татан буулгаж, ЗГ-ын 2016 оны “Төслийн нэгж байгуулах тухай” 107 дугаар тогтоолоор “Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр барих” төслийн нэгжийг шинээр байгуулан үйл ажиллагааг үргэлжлүүлэхээр болсон байна.

Засгийн газрын 2019 оны 451 тогтоолын дагуу УУХҮЯ дэргэдэх төслийн нэгжийг татан буулгаж, УУХҮЯ төрийн нарийн бичгийн даргын 2020 оны А/06 дүгээр тушаалаар “Эрдэнэс Монгол” ХХК-д шилжүүлсэн бөгөөд “Эрдэнэс Монгол” ХХК-ийн балансад ТЭЗҮ боловсруулсан зардал, төслийн нэгжийн санхүүжилтийн зардал бүртгэгдээгүй төдийгүй тус төслийг хэрэгжүүлэхэд хөрөнгө оруулалтын зардал өндөр, үр ашиг багатай гэсэн урьдчилсан дүгнэлт гаргасан, МУХБ-наас олгосон 585.5 сая төгрөгийн санхүүжилт үр ашиг, үр дүнгүй болсон байна.

- Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор** /Төслийн нэгжийг татан буулгах тухай шийдвэр гарсан боловч хэрэгжээгүй/

УИХ-ын 2008 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого, УИХ-ын 2010 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2011 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн хүрээнд “Сайншанд” аж үйлдвэрийн цогцолбор” төслийг МУХБ-ны зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасан байна.

Засгийн газрын 2013 оны “Сайншанд” аж үйлдвэрийн цогцолборын бүтээн байгуулалтыг эхлүүлэх тухай” 76 дугаар тогтоолоор байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, суурьшлын бүсийн хэсэгчилсэн төлөвлөгөө, зөвлөх үйлчилгээнд 2013 онд шаардагдах 14.2 тэрбум төгрөгийг МУХБ-наас санхүүжүүлэхийг зөвшөөрсөн байна.

Хүснэгт 45. “Сайншанд цогцолбор”-ын хүрээнд хийгдсэн ажлууд /сая төгрөг/

Засгийн газрын 2012 оны 216, 2013 оны 376 тогтоолын хүрээнд /Төсөл хэрэгжүүлэгч/	МУХБ-ны олгосон	Дүн	Зөрчил
<b>Натур Фрэндли ХХК</b>			
Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ: С-СШ-50СБ/2 Гэрээ: САҮЦ-03/35 Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх. /2013.10.25/	Төсөвт өртөг Гэрээний үнийн дүн Санхүүжүүлсэн Үлдэгдэл	6,000.0 5,549.7 4,439.8 1,109.9	Тогтоолд зааснаас өөр тендер зарлагдаж, өөр ажил хийсэн. Гэрээний хугацаагаа сунгуулах хусалтийг 2014.09.16-нд өгч хугацаагаа сунгуулсан. 2014.06.25-нд эцсийн тайлланг хүлээн авсан.
<b>Flour/ФПММ ХХК</b>			
Зөвлөх үйлчилгээ, 216 тогтоолын хүрээнд. Цогцолборын ерөнхий төлөвлөгөө (зам, тээвэр, эрчим хүч, усан хангамж) болон нийгмийн үйлчилгээний барилга, байгууламжийн ТЭЗҮ, зураг төслийг боловсруулах: С-СШ-3Y2013-178 гэрээгээр: Төслийн ерөнхий зөвлөх, шинэчилсэн мастер төлөвлөгөө боловсруулах /2013.09.20/	Төсөвт өртөг Гэрээний үнийн дүн Санхүүжүүлсэн Үлдэгдэл	7,266.0 2,733.3 1,714.9 1,018.4	Гэрээний төлбөрийг гадаад гүйвуулгаар шилжүүлсэн тул зарцуулалтыг нягтлах боломжгүй байсан.
<b>Taylor Wessing CoLTD, Legal policy CoLTD</b>			
Хуулийн зөвлөх үйлчилгээ: С-СШ-3Y2013-169 Хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх /2013.08.13/;	Төсөвт өртөг Гэрээний үнийн дүн Санхүүжүүлсэн Үлдэгдэл	604.8 604.8 604.8 -	2013.09.28, 11.05 -нд явцын тайллан, 2013.12.30-нд эцсийн тайлангаа егсэн. 2014.01.23-нд Гэрээг дүгнэх ажлын хэсгийн 100 хувийн саналаар тайлланг хүлээн авсан байна.
<b>Гови трейвел ХХК</b>			
Суурьшлын бүсийн хэсэгчилсэн төлөвлөгөө: Гэрээ: САҮЦ-03/40 Суурьшлийн бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөл боловсруулах, зөвлөх үйлчилгээ. /2013.11.02/	Төсөвт өртөг Гэрээний үнийн дүн Санхүүжүүлсэн Үлдэгдэл	300.0 285.0 142.5 142.5	Барилгын зураг төсөл боловсруулах үйл ажиллагааг 2008.04.14-с эрхэлж байгаа ААН-н гэрчилгээтэй. Тусгай зөвшөөрлөө 2013.06.28-нд 3 жилээр сунгуулсан. 2014.02.10-нд 3 дах тайлангаа егсэн.
Нийт	Төсөвт өртөг Гэрээний үнийн дүн Санхүүжүүлсэн Үлдэгдэл	14,170.8 9,172.8 6,902.0 2,270.8	

6.63 Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор ТӨХХК нь 2014 оны жилийн эцсийн байдлаар МУХБ-наас нийт 8,1 тэрбум төгрөгийн санхүүжилт авснаас 604.8 сая төгрөгийн гүйлгээ данс буруугаас буцаагдсанаар судалгаа шинжилгээний ажилд 6,297.2 сая төгрөг, хуулийн зөвлөх үйлчилгээнд 604.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

- Засгийн газрын 2013 оны 76 тогтоолд “Цогцолборын байгаль орчны төлөв байдлын үнэлгээ” гэсэн ажилд “Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх” ажлын тендер зарласан нь уг тогтоол болон СЯ, УХААЯ, МУХБ, САҮЦ ТӨХХК нарын хооронд байгуулсан “Төсөл санхүүжүүлэх, эргэн төлөлтийг зохицуулах тухай гэрээ”-ний “УХААЯ-ны эрх, үүрэг” гэсэн 6 дугаар бүлгийн 6.8 дахь хэсэгт “Санхүүжилтийг гэрээнд заасан зориулалтаас өөрөөр ашиглахгүй байх, хөрөнгийн үр дүнтэй зарцуулалтыг хангах бүхий л арга хэмжээг авна” гэж заасныг, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4<sup>45</sup>, 6 дугаар зүйлийн 6.1<sup>46</sup>, 6.2<sup>47</sup> дэх заалттай нийцэхгүй байна.
- “Натур фрэндли” ХХК нь “Тус улсын нутаг дэвсгэр дээр шинээр байгуулах болон одоо ашиглаж байгаа үйлдвэр, үйлчилгээний газар, барилга байгууламж, тэдгээрийг шинэчлэх, өргөтгөх, бусад нарийвчилсан үнэлгээ хийх” эрхийг 2 жилийн хугацаатайгаар анх 2008 оны 08 сарын 05-ны өдөр БОАЖЯ-наас авсан боловч “Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ” хийх тусгай зөвшөөрлийг 2010.11.05-нд авсан байна. Энэ нь Тендерийн өгөгдлийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийн (1) 1.1-д “Байгаль орчны зөвлөх үйлчилгээний болон Байгаль орчны үнэлгээний чиглэлээр 5-аас доошгүй жил тасралтгүй үйл ажиллагаа явуулж байсан туршлага” –тай бол 15 оноогоор үнэлэх гэсэн заалттай нийцэхгүй байна.
- Засгийн газрын 2018 оны 9 дүгээр тогтоолоор Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор төслийг татан буулгах ажлыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай нь хамтран хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, дүнг Засгийн газарт танилцуулж гүйцэтгэлийг тайлганахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасан боловч хэрэгжүүлэгүй байна.
- Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор ТӨХХК нь МУХБ дахь 36\*\*\*\*\*77USD дансанд 550.4 мянган ам.доллар, 36\*\*\*\*\*78MNT дахь дансанд 77,1 мянган төгрөгийн үлдэгдлийг 2014.02.05-ны өдрөөс хойш өнөөдрийг хүртэл ашиглаагүй, 2023 оны 2 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар 1.9 гаруй тэрбум төгрөг болж байгаа нь Засгийн газар, Монгол Улсын Хөгжлийн банк хооронд улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй үүссэн өр, авлагын тооцоог дахин нягтлах шаардлагатайг харуулж байна.
- МУХБ нь тус дансны үлдэгдлийн талаар СЯ-ны ТнБД Б.Нямаад 2017.01.13-ны өдрийн 2/83 тоот албан бичгээр, САҮЦ ТӨХХК-г төлөөлөх, гэрээг дүгнэх эрх бүхий этгээдийг томилж өгөх тухай ТӨБЗГ-ын дарга Ц.Ням-Осорт 2017.02.22-ны өдрийн 6/313 дугаар албан бичгээр тус тус мэдэгдэж байсан боловч шийдвэрлэгдээгүй, тус төслийн хүрээнд хийгдсэн судалгаа шинжилгээний ажлыг УУХҮЯ хүлээн аваагүй байна.

### Эрүүл мэнд, спортын яам /БСШУЯ/

6.64 Монгол Улсын 2011 оны төсвийн хуульд анх хөрөнгө батлагдан хэрэгжиж эхэлсэн ажлын үлдэгдэл санхүүжилтэд “Наадмын талбайн дуусгал, 2500 суудал /Ус, Улаангом сум/” 2,000.0 сая төгрөгийн санхүүжилт батлагджээ.

6.65 Уг төслийн барилга, угсралтын ажил гүйцэтгэх гэрээ, үе шатны ажлын гүйцэтгэл, санхүүжилтийн баримт, байнгын ашиглалтад хүлээн авах комиссын акт зэрэг баримтууд БШУЯ, Биеийн тамир, спортын улсын хороонд хадгалагдаагүй байх бөгөөд тус аймаг дахь Төрийн аудитын байгууллагаас “уг төслийг “Арвижих-Ус” ХХК гүйцэтгэн байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн, Ус аймгийн Улаангом сумын ЗДТГ-ын хөрөнгөд 2016.12.31-ний өдөр 4,093.1 сая төгрөгөөр бүртгэгдсэн” гэх мэдээлэл, холбогдох баримтыг ирүүлсэн болно.

### Шадар сайд, Онцгой байдлын албаны техник, тоног төхөөрөмж төсөл

6.66 “Онцгой байдлын албаны командын байрны барилга, техник, тоног төхөөрөмж” төсөл, арга хэмжээнд 20,000.0 сая төгрөг батлагдсан бөгөөд ОБЕГ нь тоног төхөөрөмжийн тендер

<sup>45</sup> 3.1.4 “байгаль орчны төлөв байдлын үнэлгээ” гэж аливаа төслийн техник, эдийн засгийн төлөвлөлтийн баримт бичиг, зураг төсөл, улсын болон бус нутаг, салбарын хэмжээнд хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах явцад тэдгээрийг хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлыг судлан тогтоож цаашид төсөл, хөтөлбөр, төлөвлөгөө, бодлого боловсруулахад анхаарах байгалийн нөхцөл, орчны онцлогийг тодорхойлохыг;

<sup>46</sup> 6.1 Төсөл хэрэгжүүлэгч нь энэ хуулийн 3.1.4-т заасан үнэлээгээ хийлгэж, болзошгүй нөлөөллийг судалсан байна.

<sup>47</sup> 6.2. Төлөв байдлын үнэлээгээ төсөл хэрэгжүүлэгч нь эрх бүхий мэргэжлийн байгууллага болон судалгаа, шинжилгээний байгууллагын оролцоотойгоор хийлгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хандан чиглэл гаргуулна.

шалгаруулалт зохион байгуулж, нийт 18,910.75 сая төгрөгийн автомашин, техник, тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээг байгуулжээ.

6.67 Тендерийн хэмнэлт болох 1,089.25 сая төгрөгөөр “Гамшигийн удирдлагын командын байр”-ны тендер шалгаруулалт зохион байгуулж, Экологи бьюлдинг констракшн ХХК-тай 1,055.5 сая төгрөгийн гэрээ байгуулсан бөгөөд МУХБ-аас олгосон санхүүжилтээс нийт 19,966.3 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 33.7 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 46. Онцгой байдлын албан д хэрэгжсэн төслийн мэдээлэл /сая төгрөг/

№	Үзүүлэлт	Гүйцэтгэгч компани	Батлагдсан төсөвт өртөг	Гэрээний дүн	Тендерийн хэмнэлт
1	ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, БАГАЖ ХЭРЭГСЭЛ				
	Галын албаны автомашин, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл	Бодиз автомотив ХХК, Номин трейдинг ХХК, Цөм трейд ХХК, Хүрд ХХК, Нанопланет ХХК, Магна тайэrs Монголия ХХК, Новелнетворк ХХК, Файр стоп ХХК, Батсээр ХХК, Спарровст ХХК, Буурал жанжин ХХК, Номин трейдинг ХХК	15,447.00	14510.27	936.73
	Аврах ажлын багаж техник, тоног төхөөрөмж	Орем трейд ХХК, Нанопланет ХХК, Эйтийм ХХК	4,553.00	4,400.48	152.52
	Дүн		20,000.0	18,910.75	1,089.25
2	БАРИЛГА БАЙГУУЛАМЖ (тендерийн хэмнэлтээр зохион байгуулсан)				
	Гамшигийн удирдлагын командын байр	Экологи бьюлдинг констракшн ХХК	1,089.25	1,055.50	33.7
	НИЙТ ДҮН:		20,000.00	20,000.00	20,000.00

### ХХААХҮЯ - Газар тариалангийн бүтээгдэхүүний агуулах

6.68 Засгийн газрын 2008 оны 70 дугаар тогтоолоор баталсан “Атрын гурав дахь аян” тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийн хүрээнд “Дархан-Уул аймгийн Дархан суманд хэрэгжсэн газар тариалангийн бүтээгдэхүүний агуулах төсөл, арга хэмжээ”-г анх 2014 онд улсын төсвөөс, 2015 онд МУХБ-ны эх үүсвэрээс тус бүр 8.0 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй баталсан бөгөөд Сангийн яам, ХХААЯ, МУХБ-ны хооронд 2015.05.22-ны өдөр 2/255 дугаар бүхий гэрээ байгуулж, төслийг санхүүжүүлжээ.

Хүснэгт 47. ХХААХҮЯ-нд хэрэгжсэн төслийн мэдээлэл /сая төгрөг/

TAX-ний нэр	Төсвийн тухай хууль	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Олгосон санхүүжилт
Газар тариалангийн бүтээгдэхүүний агуулах /Дархан-Уул аймаг, Дархан сум/	2014	16,000.0	8000.0	Улсын төсөв 8000.0
	2015		8000.0	Хөгжлийн банк 7,995.0
<b>Дүн</b>				<b>15,995.0</b>

6.69 Төслийн хүрээнд ХХААХҮЯ нь үр тариа хадгалах элеватор 15.9 тэрбум төгрөгөөр худалдан авах гэрээг “Дархан гурил тэжээл” ХК-тай байгуулж Дархан-Уул аймаг дахь ашиглалтад ороод 36 жил болж буй хуучин элеваторыг засаж сайжруулсныг 2015 оны 10 дугаар сарын 22-ны өдөр хамтарсан актаар хүлээн авчээ.

- ХААХҮЯ-ны ТНБД-ын баталсан удирдамжийн дагуу тус яамны Дотоод аудитийн газраас 2016 онд тус төслийн худалдан авах ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар ижил түвшний хүчин чадалтай агуулахын төсөвт өртөгтэй харьцуулахад 3 дахин өндөр үнээр хуучин агуулах худалдан авч төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан үндэслэлээр АТГ-т шалгуулахаар шилжүүлсэн.
- ТЭДС-гийн нийт агуулахын хүчин чадлын ердөө 16-33 хувийг ашиглаж урсгал зардалд 2016-2018 онд нийт 2,218.2 сая төгрөг зарцуулж байгаа нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх бодит хэрэгцээ шаардлага, тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөөгүй, үр ашиггүй хөрөнгө оруулалт байсан гэдгийг холбогдох байгууллагын шалгалтаар нотолсон.

6.70 Зээлийн ашиглалт, хэрэгжилтийг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 49 дүгээр хуралдааны тэмдэглэлийн дагуу Хөгжлийн банктай хамтран шалгаж, ХХААХҮЯ-ны Дотоод аудитын хороогоор хэлэлцүүлснээр дараах зөрчилтэй

асуудлыг илрүүлэн хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн ч өнөөдрийг хүртэл эцэслэн шийдвэрлэгдээгүй байна.

- Тендерийн баримт бичиг боловсруулахдаа шинэ барилга барих боломжит хугацаанаас богино хугацаа тогтоосон нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 6.1-ийн “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална” гэсэн заалт;
- Тендерийг үнэлэхдээ санхүүгийн өр төлбөртэй “Дархан гурил тэжээл” ХК-ийг шалгаруулсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 27.3.Тендер нь энэ хуулийн 27.1-т заасан бүх нөхцөлийг нэгэн зэрэг хангасан бол шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ” гэсэн заалт;
- Тендерийг үнэлэхдээ тендерт оролцогчийн санал болгосон үнийг шууд хүлээн зөвшөөрч гэрээний үнийг тогтоосон нь Төсвийн тухай хуулийн 14.2.3-ийн “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 5.1.1-ийн “үнэлгээчин болон үйлчлүүлэгч харилцан тохиrolцсон” гэсэн заалт;
- Төсөл, арга хэмжээг эхлүүлэх, хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаагүй, холбогдох эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл аваагүй нь тухайн үед мөрдөж байсан Барилгын тухай хуулийн 15.1.1, 13.2, 13.5, 15.2, 16.2, 16.6 дахь заалт;
- Гүйцэтгэлийн анхан шатны баримт бүрдүүлэхдээ зөрүүтэй, бодит бус баримт хавсарган санхүүжилт авсан нь НББТХ-ийн 13.1, 13.5, 13.6 дахь заалт;
- Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх хугацааг 158 хоног хэтрүүлж, 1.6 тэрбум төгрөгийн алданги тооцох ёстой байтал санхүүжилтийг бүрэн шилжүүлсэн;
- Захиалагч барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын бүрэлдэхүүнд барилгын техникийн хяналтын улсын байцаагч оруулаагүй атлаа дүгнэлтийг нөхөн гаргуулсан нь үндэслэлгүй;
- 1982-1983 онд ашиглалтад орсон анхны барилга байгууламж нь зэргэлдээх байгууламжаас бүрэн тусгаарлагдаагүйн улмаас хортон шавьж тархах, механик бохирдол дамжих эрсдэлтэй тул хүнсний зориулалттай улаан буудай нөөцлөн хадгалах боломж бүрдээгүй гэж Мэргэжлийн хяналтын газрын дүгнэлт удаа дараа гарсан;
- 1982-1983 онд ашиглалтад орсон хуучин объектыг бусад ижил хүчин чадалтай обьектуудын үнэлгээтэй харьцуулахад З дахин өндөр үнээр үнэлэн худалдан авсан байгаа нь бодит бус, хийсвэр үнэлгээ гэж дүгнэх үндэслэлтэй;
- Зарим байгууламжийн ажил бүрэн дуусаагүй, хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцөл хангагдаагүй байхад ТЕЗ-ийн шийдвэрийг үндэслэн холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр 15.9 тэрбум төгрөгийн өртөгтэй барилга, байгууламжийг ТЭДС-гийн данс бүртгэлд тусгасан нь ТБОНӨТХ-ийн 24.3 дахь заалт.


## УИХ-ЫН ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ СОНСГОЛ-III

6.71 ХШТХ-ны сонсголын III шатанд Хөгжлийн банкны эх үүсвэрээс арилжааны банкаар дамжуулан олгосон 2542 төсөл, хөтөлбөрийн зээлийн ашиглалт, зарцуулалт, үр дүн, шаардлагатай тохиолдолд гэрчээс тайлбар, мэдүүлэг авах болон Хөгжлийн банкны бусдаас татаан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийн удирдлага, зарцуулалт, ашиглалт, үр дүнгийн талаар хянан шалгагчийн мэдээлэл сонсохоор шийдвэрлэсэн.

6.72 Монгол Улсын Засгийн газраас баталсан тогтоол, шийдвэрийн хүрээнд Хөгжлийн банк нь 2012-2021 онуудад нийт 17 төсөл, хөтөлбөрийн хүрээнд 11 арилжааны банкаар дамжуулан 1,565.12 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний санхүүжилтийг 2542 дэд төсөлд зориулан олгосон байна. /Дэлгэрэнгүйг Хавсралт 11-т үзүүлэв/

6.73 Энэхүү санхүүжилтийн 96.6 хувь нь зээлийн гэрээний дагуу эргэн төлөгдсөн, Капитал банкны зээл ΘБҮХХ-өөр хаагдсан бол Чингис хаан банк 0.85 тэрбум төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэлтэй /шүүхийн шийдвэртэй/ байна. Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн хөтөлбөр тус бүрийн хэрэгжсэн он цагийн дараалал дараах байдалтай байна.

*Дурслэл 11. Арилжааны банкаар дамжуулан олгосон төсөл хөтөлбөрийн зээлийн үе шат*



## ХАА, хөнгөн үйлдвэрийн ноос, ноолуур, сүү, хүлэмж болон оёдлын салбарын төсөл

6.74 Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 126 болон 141 дүгээр тогтоолын дагуу ноос, ноолуур, оёмол болон сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарын техник тоног төхөөрөмжийг шинэчлэх, хүлэмжийн аж, ахуйг байгуулах ажлуудад хөнгөлттэй зээлийн эх үүсвэрийг МУХБ-аар санхүүжүүлэн, Голомт банкаар дамжуулан олгосон байна. Тус “ХАА, хөнгөн үйлдвэрийн ноос, ноолуур, сүү, хүлэмж болон оёдлын салбарын төсөл” хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгтгэн харуулбал дараах байдалтай байна.

*Хүснэгт 48. Хөтөлбөрт зарцуулсан зээлийн дүн тоо, тэрбум төгрөг/*

Салбар	Эх үүсвэр	Хэрэгжилт	Үлдэгдэл
Ноолуурган бүтээгдэхүүний үйлдвэрлэл	107.36	54 зээл	100.35
Ноосон бүтээгдэхүүний үйлдвэрлэл	70.22	18 зээл	46.02
Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл	43.23	47 зээл	38.49
Оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэл	21.07	17 зээл	3.61
Хүлэмжийн аж ахуй	27.15	32 зээл	25.87
<b>НИЙТ ДҮН</b>	<b>269.03</b>	<b>168</b>	<b>214.36</b>
			<b>17.48</b>

6.75 МУХБ-ны ТҮЗ-ийн 2013 оны 48 дугаар тогтоолд үндэслэн Чингис бондын эх үүсвэрээс 2013 оны 08 дугаар сарын 15-ны өдөр Голомт банканд 269.03 тэрбум төгрөгийн төсөл санхүүжүүлэх эх үүсвэрийг шилжүүлснээр нийт 168 зээлдэгчид 214.36 тэрбум төгрөгийн зээлийг дамжуулан олгосон бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн байдлаар<sup>48</sup> нийт 22 дэд зээлдэгчийн 17.48 тэрбум төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэлтэй, чанаргүй зээлийн ангилалд бүртгэлтэй байна.

<sup>48</sup> Голомт банк гэрээнд заасан эргэн төлөлтийн хуваарийг дагуу Хөгжлийн банканд зээлээ төлж дуусгасан.

6.76 Эдийн засгийн хөгжлийн яам, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам, Хөгжлийн банк болон Голомт банк хооронд байгуулсан 2013 оны 2/194 дугаартай “Ерөнхий нөхцөл тохиролцох, хамтран ажиллах гэрээ”-ний 2.5-д “Ноолууран, ноосон оёмол болон сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон хүлэмжийн аж ахуйг байгуулах ажлыг дэмжих зорилгоор үндсэн хөрөнгийн санхүүжилтийн гуравны нэгтэй тэнцэх төлбөрийн зориулалттай байна. Энэ зориулалтаас өөрөөр ашиглахыг хориглоно” гэж заасан бөгөөд Голомт банкнаас дамжуулан олгосон 214.36 тэрбум төгрөгийн санхүүжилтийг данс хөөх аргаар шалгаж үзэхэд нийт 35.4 тэрбум төгрөгийг бэлэн мөнгөөр зарлагадаж зориулалт нотлогдоогүй бол 11.5 тэрбум төгрөгийг хадгаламжийн дансанд байршуулж, 29.2 тэрбум төгрөгийг зээл, зээлийн хүүгийн төлбөрт шилжүүлж зориулалт бусаар зарцуулсан гэж үзэхээр байна.

6.77 Хөтөлбөрийн хувьд санхүүжилтийн эх үүсвэрийг банктай гэрээ байгуулсан өдөр гэрээний дүнгээр бүхэлд нь шилжүүлж, улирлын чанартай санхүүжилтийг зорилтолт хугацаанд нь дэд зээлдэгчид олгож чадаагүйгээс эргэн төлөлтийн хугацаа богиносож, зарим ААН-ийн хувьд дарамт болсон гэж дүгнэж байна.

#### **Арьс, ширийг дотооддоо гүн боловсруулах болон түүгээр бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үндэсний үйлдвэрлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгох төсөл**

6.78 Хөтөлбөрийн хүрээнд арьс ширний салбарын 57 үйлдвэрт нийт 85.7 тэрбум төгрөгийн зээл олгосон нь төрөөс арьс ширний салбарын үйлдвэрлэл эрхлэгчдэд бодлогын дэмжлэгийн хүрээнд хөнгөлөлттэй зээл олгож, техник технологио сайжруулах, түүхий эд бэлтгэх, эргэлтийн хөрөнгөө нэмэгдүүлэх, үйлдвэрийн хүчин чадлаа бүрэн ашиглах, үйлдвэрлэл, борлуулалт болон экспортын хэмжээгээ нэмэгдүүлэх таатай боломж олгох зорилготой байсан.

6.79 Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 198, 217 дугаар тогтоолоор арьс, ширийг гүн боловсруулах, түүгээр эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэхээр заасны дагуу Хөгжлийн банкнаас 110.4 тэрбум төгрөг хүртэлх санхүүжилт олгох гэрээ байгуулж, арилжааны 9 банкаар дамжуулан, 57 дэд төсөлд нийт 85.7 тэрбум төгрөгийн зээл олгосон.

6.80 Тогтоолоор баталсан дүн 140.4 тэрбум төгрөг, банкуудтай байгуулсан гэрээний дүн 110.4 тэрбум төгрөг бөгөөд үүнээс 85.7 тэрбум төгрөгийг дэд зээлдэгч нарт олгож, сонсголд мэдээлэх үеийн байдлаар 5 зээлдэгчийн нийт зээлийн өрийн үлдэгдэл 7.8 тэрбум төгрөг байна.

*Хүснэгт 49. Төсөл, хөтөлбөрийн хүрээнд хамрагдсан ч төлөгдөөгүй зээлдэгч /сая төг/*

№	Зээлдэгч	Огноо		Зээлийн хүү /жил/	Олгосон зээл	Төлбөрийн үлдэгдэл		
		Эхлэх	Дуусах			Зээл	Хүү, алданги	Нийт
<b>Голомт банк</b>								
1	Бэлон ХХК	2015.07.22	2020.07.22	7.0%	6,500.0	5,395.4	478.4	5,873.8
2	Мон мастер ХХК*	2014.12.12	2018.12.12	7.0%	150.0	56.9	16.1	73.0
3	Фучер холдинг ХХК	2016.04.21	2021.07.07	7.0%	1,500.0	1,015.4	101.8	1,117.2
<b>Үндэсний хөрөнгө оруулалтын банк</b>								
4	Өсөх хүрд трейд ХХК	2015.11.25	2020.10.25	7.0%	350.0	340.6	66.3	406.8
<b>Төрийн банк</b>								
5	Орчид ХХК	2015.07.23	2021.05.03	7.0%	17,667.0	261.3	71.3	332.6
<b>Нийт дүн</b>				-	<b>26,167.0</b>	<b>7,069.6</b>	<b>733.9</b>	<b>7,803.4</b>

6.81 УИХ-ын 2012 оны 74 дүгээр тогтоолын 2.5-д “арьс ширний үйлдвэрүүдийг үйлдвэрийн шинэ бүс рүү шилжүүлэх арга хэмжээг 2017 оны 12 дугаар сарын 31-ний дотор үе шаттайгаар зохион байгуулах” гэж заасан нь хэрэгжээгүй байна.

6.82 Арилжааны банкаар дамжуулан олгосон төсөл, хөтөлбөрийн зээлийн үр дүнд ажилгүйдэл, экспорт, импорт орлох бүтээгдэхүүний хэмжээ, улсад татан төвлөрүүлэх орлого, ААН, малчин өрхийн дундаж орлого, тогтвортой байдал зэрэг шалгуур үзүүлэлт,

хүрэх үр дүнгийн үзүүлэлт тодорхой бус байсан нь “Бодлогын гэрээ”-ний хэрэгжилт, үр нөлөө болон зээлдэгч бүрээр гэрээний хэрэгжилтийг дүгнэх ажил хангалтгүй хийгдсэн байна.

### **Экспортыг дэмжих, импортыг орлох үйлдвэрлэлийн 888 төсөл**

6.83 МУХБ-ны тухай хуулийн /2011 он/ 8 дугаар зүйлийн 8.1-д “... санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг Улсын Их Хурал жил бүрийн хаврын чуулганаар батална” гэж заасан хэдий ч МУХБ нь Засгийн газрын 2013 оны 239 дүгээр тогтоолоор баталсан “Экспортыг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд экспортыг дэмжих, импортыг орлох үйлдвэрлэлийн төслүүдийг санхүүжүүлсэн байна.

6.84 Хөтөлбөрийн зорилтыг экспортын орлогыг нэмэгдүүлэх, гадаад худалдааны бүтцийн зохистой байдлыг хангах, экспорт, импортыг орлох дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, экспортын үр ашигтай санхүүжилтийг хангах, экспортын болон экспортыг дэмжих импортын лизингийн үйлчилгээ үзүүлэх байгууламжийн тогтолцоог үүсгэн хөгжүүлэх гэж тодорхойлжээ.

6.85 МУХБ нь Засгийн газрын 2013 оны 239 дүгээр тогтоолоор баталсан “Экспортыг дэмжих хөтөлбөр”, Засгийн газрын 2014 оны 212 дугаар тогтоолоор баталсан “Экспортыг дэмжих, импортыг орлох үйлдвэрлэлийн төслийг санхүүжүүлэх, хяналт тавих, тайлагнах журам”, Засгийн газрын 2014 оны 176 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Экспортыг дэмжих, импортыг орлох үйлдвэрлэлийн төслүүдэд санхүүжилт олгосон байна.

*Хүснэгт 50. Хөтөлбөрт хамрагдсан дэд зээлдэгчдийн мэдээлэл /тбм.төг/*

Дэд хөтөлбөрийн нэр	Төслийн тоо	Мөнгөн дүн
Экспортыг дэмжих, импортыг орлох дотоодын үйлдвэрлэлийн 2 тэрбум төгрөгөөс дээш	39	184.3
Экспортыг дэмжих, импортыг орлох дотоодын үйлдвэрлэлийн 2 тэрбум төгрөгөөс доош	655	99.9
<b>Нийт</b>	<b>694</b>	<b>284.3</b>

6.86 МУХБ-аас экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр 131, импортыг орлох чиглэлээр 757 нийт 888 төслийн жагсаалтыг арилжааны банкуудад 2022.04.07-ны өдөр хүргүүлж, арилжааны банкаар дамжуулан зээл олгохтой холбоотойгоор хамтран ажиллах харилцааг зохицуулах санамж бичгийг 13 арилжааны банктай 2014.04.23-ны өдөр байгуулжээ.

6.87 Экспортыг дэмжих, импортыг орлох дотоодын үйлдвэрлэлийн “2.0 тэрбум төгрөгөөс дээш” санхүүжилт хүссэн төслүүдэд зээл олгохтой холбоотойгоор МУХБ-ны Зээлийн хорооны хурлын шийдвэрийг 2014.07.22-ны өдөр, ТҮЗ-ийн “Зөвшөөрөл олгох тухай” 48 дугаар тогтоолыг 2014.07.23-ны өдөр тус тус гаргасан.

6.88 Арилжааны банкууд болон МУХБ-нд хадгалагдаж буй архивын баримт, зээлийн хувийн хэрэг, ЭЗХЯ-аас 2023.03.13-ны өдрийн 03/359 дүгээр албан бичгээр ирүүлсэн баримт материалаас үзэхэд Засгийн газрын 2014.09.04-ний өдрийн хуралдааны 48 дугаар тэмдэглэлд дараах 11 төслийг танилцуулсан байх бөгөөд бусад 28 төслийг танилцуулсан гэх баримт материал байгаагүй болно. Үүнд:

- *Об пластик ХХК, Актив хийц ХХК, Майндтэч ХХК, Хаан хүнс ХХК, Юнико ХХК, Оверсийс бест ХХК, Мөнхийн тун ХХК, Шохойн булаг ХХК, Батлайн ХХК, Кайзер фрайшерай ХХК, Бүти ХХК*

*Хүснэгт 51. Арилжааны банкны дамжуулан зээл олголтын байдал /тоо, тбм төгрөг/*

Арилжааны банк	Яамнаас дэмжсэн		Арилжааны банкны баталсан		МУХБ-аас мэдэгдэл хүргүүлсэн		Олгосон	
	Toо	Мөнгөн дүн	Toо	Мөнгөн дүн	Toо	Мөнгөн дүн	Toо	Мөнгөн дүн
Худалдаа хөгжлийн банк	10	139.5	9	132.6	9	61.6	9	61.6
Капитал банк	11	73.6	7	67.9	7	30.9	7	28.8
Улаанбаатар хотын банк	4	34.8	4	32.0	4	32.0	4	32.0
Хаан банк	6	43.6	4	32.5	4	32.5	4	10.6
Голомт банк	5	23.2	5	23.2	5	23.2	5	23.2
Хас банк	5	19.4	5	15.8	5	15.8	5	15.8
Үндэсний хөрөнгө оруулалтын банк	3	8.0	3	7.1	3	7.1	3	7.1

Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах Түр хороо

Төрийн банк	1	4.5	1	3.0	1	3.0	1	3.0
Капитрон банк	2	4.5	2	3.2	1	2.2	1	2.2
Чингис хаан банк	1	2.8	1	2.8	0	-	0	-
<b>Нийт</b>	<b>48</b>	<b>353.8</b>	<b>41</b>	<b>320.0</b>	<b>39</b>	<b>208.2</b>	<b>39</b>	<b>184.3</b>

6.89 Дэд зээлдэгчдийн харилцах дансны хуулгаас үзэхэд МУХБ-наас Капитал банканд 5,000.0 сая төгрөгийн эх үүсвэр шилжүүлсэн боловч Капитал банк дэд зээлдэгч болох Монлабел ХХК-д 3,000.0 сая төгрөгийн зээл олгосон бөгөөд нийт олгосон 184.2 тэрбум төгрөгийн санхүүжилтээс 66.5 тэрбум орчим төгрөгийн бэлэн зарлагын гүйлгээ хийсэн байх тул зарцуулалтыг нягтлах боломжгүй байлаа. Мөн зарим дэд зээлдэгч нарын гүйлгээний утга, харилцах дансны мэдээллээс харахад нийт 44.8 тэрбум төгрөгийг зээлийн эргэн төлөлт, арилжааны банк дахь бусад зээл, зээлийн хүүгийн төлбөрт зарцуулсан гэж үзэхээр байна.

Хүснэгт 52. Хөтөлбөрийн хүрээний зээлийн ашиглалт, зарцуулалт /тоо, сая төгрөг/

Ангилал	Төслийн тоо	Олгосон зээлийн дүн	Бэлэн зарлага	Дотоод шилжүүлэг	Гадаад шилжүүлэг, валют арилжаа	Зээл төлөлт, дахин санхүүжилт	Шимтгэл, бусад
500 саяас 1.0 тэрбум төгрөг	2	1,950.0	950.1	981.0	-	-	18.9
1.0-1.5 тэрбум төгрөг	1	1,330.0	538.0	167.8	541.1	69.8	13.3
1.5-2.0 тэрбум төгрөг	3	6,000.0	5,095.6	582.1	318.0	-	3.5
2.0 тэрбум төгрөгөөс дээш	33	174,972.1	59,956.6	45,928.5	21,469.3	44,819.2	462.5
<b>Нийт</b>	<b>39</b>	<b>184,252.1</b>	<b>66,540.2</b>	<b>47,659.4</b>	<b>22,328.4</b>	<b>44,889.0</b>	<b>498.3</b>

6.90 Засгийн газрын 2014.06.03-ны өдрийн “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” 176 дугаар тогтоолын дагуу ЭЗХЯ, Сангийн яам, Хөдөлмөрийн яам, МУХБ нь Ерөнхий нөхцөл тохиролцох, хамтран ажиллах гэрээг 2014.07.04-ний өдөр, МУХБ, ЖДҮХС, Арилжааны банкууд нь Гурван талт зээлийн гэрээг 2014.08.08-ны өдөр банкны баталгааны гэрээг зээлийн багц тус бүрд байгуулснаар “2.0 тэрбум төгрөгөөс доош” хөтөлбөрийн зээл хэрэгжиж эхэлсэн байна.

Хүснэгт 53. Арилжааны банкны дамжуулан зээл олголтын байдал /тоо, тбм төгрөг/

Арилжааны банк	Яамнаас дэмжсэн		Арилжааны банкны баталсан		МУХБ-аас мэдэгдэл хүргүүлсэн		Олгосон	
	Toо	Мөнгөн дүн	Toо	Мөнгөн дүн	Toо	Мөнгөн дүн	Toо	Мөнгөн дүн
Хас банк	295	26.66	295	26.19	295	26.18	295	26.18
Хаан банк	153	16.97	153	16.94	153	16.93	153	16.93
Чингис хаан банк	22	14.06	22	14.06	22	14.06	22	14.06
Үндэсний хөрөнгө оруулалтын банк	19	12.92	19	12.22	19	12.22	19	12.22
Голомт банк	57	8.92	57	8.67	57	8.67	57	8.65
Капитал банк	31	8.98	31	8.54	31	8.52	31	8.52
Төрийн банк	23	5.75	23	5.71	23	5.71	23	5.71
Худалдаа хөгжлийн банк	16	4.45	16	4.45	16	4.45	16	4.45
Капитрон банк	37	2.41	37	2.41	37	2.41	37	2.41
Улаанбаатар хотын банк	2	0.85	2	0.85	2	0.85	2	0.85
<b>Нийт</b>	<b>655</b>	<b>101.97</b>	<b>655</b>	<b>100.03</b>	<b>655</b>	<b>100.00</b>	<b>655</b>	<b>99.98</b>

6.91 Нийт олгосон зээлийг байршилын хувьд авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 54. Хөтөлбөрийн хүрээний зээлдэгч арилжааны банкны зээл олголт /тоо, сая төгрөг/

№	Байршил	Toо	Дүн
1	Архангай	16	469.0
2	Баян-Өлгий	37	882.0
3	Баянхонгор	11	2,668.5
4	Булган	28	1,212.0
5	Говь-Алтай	10	436.0
6	Говьсүмбэр	16	500.0

7	Дархан	30	1,903.0
8	Дорноговь	10	552.5
9	Дорнод	27	1,922.0
10	Дундговь	22	595.0
11	Завхан	23	1,209.9
12	Орхон	17	1,965.0
13	Өвөрхангай	22	1,247.0
14	Өмнөговь	19	2,240.0
15	Сүхбаатар	8	605.0
16	Сэлэнгэ	8	1,454.0
17	Төв	24	3,690.5
18	Увс	16	720.0
19	Ховд	18	917.0
20	Хөвсгөл	18	535.0
21	Хэнтий	18	714.8
	Улаанбаатар		
1	Баянзүрх дүүрэг	51	17,372.9
2	Хан-Уул дүүрэг	41	15,151.1
3	Сүхбаатар дүүрэг	37	13,043.6
4	Сонгинохайрхан дүүрэг	40	12,707.6
5	Баянгол дүүрэг	29	8,646.4
6	Чингэлтэй дүүрэг	26	5,135.8
7	Налайх дүүрэг	11	980.0
8	Багануур дүүрэг	22	506.5
	<b>Нийт</b>	<b>655</b>	<b>99,982.1</b>

6.92 МУХБ-аас тус хөтөлбөрийн хүрээнд 300 хуулийн этгээдэд 88.02 тэрбум төгрөг, 365 иргэнд 11.9 тэрбум төгрөгийн зээл олгосон бөгөөд дэд зээлдэгчийн харилцах дансны хуулгаас зээлийн зарцуулалтыг үзэхэд нийт санхүүжилтийн 56.2 орчим хувь буюу 56,153.9 сая төгрөгийг бэлэн мөнгөний зарлага, 9.2 орчим хувь буюу 9,175.1 сая төгрөгийг зээл, хүүгийн эргэн төлөлтөд зарцуулсан гэж үзэхээр байна.

Хүснэгт 55. Дэд зээлдэгчдийн зээлийн ашиглалт, зарцуулалт /тоо, сая төгрөг/

Ангилал	Төслийн тоо	Олгосон зээлийн дун	Бэлэн зарлага	Дотоод шилжүүлэг	Гадаад шилжүүлэг, валют арилжаа	Зээл төлөлт, дахин санхүүжилт	Шимтгэл, бусад
1.5-2.0 тэрбум төгрөг	16	28,776.0	16,224.5	5,764.0	2,291.8	4,093.7	45.3
1.0-1.5 тэрбум төгрөг	10	12,279.0	8,964.1	2,707.7	227.4	223.7	152.3
500 саяас 1.0 тэрбум төгрөг	31	19,237.8	7,105.6	5,834.1	2,383.5	3,055.0	145.4
250.0-500.0 сая төгрөг	41	14,474.1	8,126.1	4,077.2	1,862.6	350.8	31.5
100.0-250.0 сая төгрөг	62	8,988.5	4,958.1	2,596.5	781.5	552.9	49.2
50.0-100.0 сая төгрөг	53	2,650.0	1,760.3	743.4	0.0	122.5	3.0
50 сая төгрөг хүртэл	442	13,576.6	9,015.3	3,529.8	9.9	776.4	15.2
<b>Нийт</b>	<b>655</b>	<b>99,982.0</b>	<b>56,153.9</b>	<b>25,252.9</b>	<b>7,556.8</b>	<b>9,175.1</b>	<b>441.9</b>

6.93 ЖДҮХС нь 2012-2016 онд Хөдөлмөрийн яам, Аж үйлдвэрийн яам, ХХААХҮЯ-ны харьяанд шилжсэн, 2020 оноос Жижиг, дунд үйлдвэрийн газар болсон, 2014-2023 оны хугацаанд удаа дараа бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийгдэж, хүний нөөцийн тогтвортгүй байдлаас шалгаалан архивын баримт материал иж бүрэн бус байна.

6.94 ЖДҮХС-ийн зүгээс 2017 оны 5 дугаар сард экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох /2 тэрбум төгрөгөөс доош/ 99.98 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон 655 төслийн хэрэгжилт, зээлийн зориулалт зарцуулалтад аймаг, дүүрэгт хэрэгжсэн төсөл тус бүрээр хяналт хийсэн тухай 4 боть баримт архивд хадгалагдаж буй хэдий ч нэгтгэн дүгнэсэн тайлан боловсруулаагүй, төслийн үр дүнг тооцсон талаар тусгагдаагүй байна.

6.95 Салбарын яамны зүгээс “Экспортыг дэмжих хөтөлбөр”-ийн хэрэгжилт болон нийт 284.2 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан 694 төслийн үр дүнг нэгтгэн тайлагнаагүй байна.

6.96 МУХБ 2018-2020 онд арилжааны банкуудаар дамжуулан олгосон дэд зээлийн хэрэгжилт, эх үүсвэрийн ашиглалтад хяналт тавьж эхэлсэн хэдий ч хамрах хүрээ хязгаарлагдмал, үр нөлөө хангалтгүй байжээ.

### Жижиг, дунд үйлдвэрийн “50.0” тэрбум төгрөгийн дамжуулан зээл

6.97 Монгол Улсын Их хурал, Засгийн газраас баталсан “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн хүрээнд Бүсийн тулгуур төв, аймаг орон нутагт жижиг, дунд үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар ажлын байр бий болгох УИХ-ын 2011 оны 15, Засгийн газрын 2012 оны 138, 208 дугаар тогтоолуудыг үндэслэн Сангийн яам, ХХААХҮЯ, МУХБ хооронд “Төсөл санхүүжүүлэх ерөнхий нөхцөл”-ийг тохиролцох 77/03/1-35 тоот гэрээг 2012.07.05-ны өдөр, МУХБ, ХХАХҮЯ, арилжааны банкууд хооронд гурван талт гэрээг 2012.07.10-ны өдөр байгуулжээ.

6.98 Засгийн газрын 2012 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 208 дугаар тогтоолын дагуу Хөгжлийн банкны зээлийн эх үүсвэрийн үндсэн хүү болон тус банкаас олгосон зээлийн хүүгийн зөрүү, валютын ханшийн зөрүүгийн алдагдлыг 2012-2013 оны улсын төсөвт тусган санхүүжүүлэхээр заасан. Үүний дагуу эргэн төлөлтийн хуваарь болон бодит төлөлттэй уялдуулан Сангийн яамнаас Хөгжлийн банканд гадаад валютын ханшийн зөрүүгийн төлбөрт 20,374.5 сая төгрөг, зээлийн хүүгийн төлбөрт 10,213.1 сая төгрөг, нийт 30,587.6 сая төгрөгийг төлсөн байна.

6.99 2023.03.13-ны өдрийн байдлаар тус хөтөлбөрийн эргэн төлөгдөөгүй 9 зээл буюу 4 банкны 3,150.3 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.

6.100 ХХААХҮС-ын 2010 оны 58 дугаар тушаалаар баталсан журмын<sup>49</sup> хүрээнд 2012 онд олгосон 1 зээл, 2013 оны А/44 тоот тушаалаар баталсан журмын хүрээнд 2013 онд 500.0 саяас 1.5 тэрбум хүртэл төгрөгөөр олгосон 23 зээл, 500.0 саяас доош дүнгээр 2013-2014 онд 127 зээл олгосноос, Капитал банк нь 2012.08.28-ны өдөр “Каракум” ХХК-д 2.0 тэрбум төгрөгөөс дээш дүнгээр зээл олгосон нь дээрх журмын заалттай нийцэхгүй байна.

6.101 Төсөл хэрэгжүүлэхээр зээл авсан 151 зээлдэгчийн зээлийн данс болон харилцах дансны гүйлгээний зарцуулалтыг данс хөөх аргаар нэг бүрчлэн шалгахад нийт зээлийн 54.6 хувь буюу 25.7 тэрбум төгрөгийг бэлэн мөнгөөр авсан, 14.1 хувь буюу 6.6 тэрбум төгрөгийг зээл хаасан, 15.6 хувь буюу 7.4 тэрбум төгрөгийг өөрийн болон бусад дансанд шилжүүлсэн, 9 хувь буюу 4.2 тэрбум төгрөгийг валют арилжаа хийж гадаадад шилжүүлсэн, 4.2 хувь буюу 1.98 тэрбум төгрөгийг төсөлд зориулсан төлбөр тооцоонд зарцуулсан харагдаж байгаагас зээл зориулалтын дагуу зарцуулагдсан, төсөл хөтөлбөрийнхөө зорилгод нийцсэн гэсэн дүгнэлтийг өгөх боломжгүй байна.

6.102 ХХААХҮС-ын 2010 оны 58 дугаар тушаалаар баталсан ЖДҮ-ийг хөгжүүлэх чиглэлээр улсын төсвөөс олгох хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журмын 2.2.1-д “Бүсийн болон орон нутгийн эдийн засагт дорвito хувь нэмэр оруулах, Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд зээл олгох, ажлын байр бий болгох, Техник, тоног төхөөрөмж худалдан авах, Хөрөнгө оруулалт хийх”, Хөдөлмөрийн сайдын 2013 оны А/44 тоот тушаалаар баталсан ЖДҮ-ийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэн, зарцуулах, түүнд хяналт тавих журмын 2.9-д<sup>50</sup> заасантай нийцэхгүй байна.

6.103 Мөн арилжааны банкуудаас зээлдэгчтэй байгуулсан гэрээний 8 дугаар зүйлийн 8.3.8 дахь<sup>51</sup> заалтуудын хэрэгжилт тодорхойгүй байна.

6.104 Муу зээлийн ангилалд байгаа 30 зээлдэгчдээс зээлийн өрийг үлдэгдэлтэй байгаа 11 компани байгаагас “Монголын цахилгаан шат” ХХК-ийн төлөгдөөгүй зээлийн үлдэгдлийн дүн 29.6 хувийг зээлж байна. Зээлийн гэрээ байгуулсан хамгийн өндөр дүнгээр зээлийн

<sup>49</sup> ХХААХҮС-ын 2010 оны 58 дугаар тушаалаар баталсан ЖДҮ-ийг хөгжүүлэх чиглэлээр улсын төсвөөс олгох хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих, тайлгааны журмын 1.4-т “Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхээр олгох зээл нь тодорхой зориулалттай, нэг зээлдэгчид 500 сая төгрөг хүртэл санхүүжилт бүхий... эргэн төлөгдөх баталгаатай” байна.

<sup>50</sup> “ААНБ, иргэн, ТББ-аас аливаа нөхцөл болзол тавьсан эх үүсвэрийг санд оруулах, холбоогох хууль журамд зааснаас бусад зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно”

<sup>51</sup> Зээлийг зориулалт бусаар ашигласан, үр ашиггүйгээр зарцуулсан нь тогтоогдвол ...зээлийн гэрээг дуусгавар болгох

үлдэгдэлтэй “Монголын цахилгаан шат” ХХК, Хаан банк хооронд байгуулсан 2012.07.01-ний өдрийн ЗГ/13-53 тоот гэрээний 3 дугаар зүйлийн 3.3.1<sup>52</sup>-дэх заалт хэрэгжээгүй байна.

6.105 ЖДҮГ-ын архивын баримтаар ХХААХҮС-ын 2015.03.03-ны өдрийн “Томилолтоор ажиллуулах тухай” 33 дугаар тушаалаар Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хэрэгжилт, сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шалгалтыг ХХААХҮЯ болон ЖДҮХС-ийн бүрэлдэхүүнтэй 7 ажлын хэсэг байгуулж ажилласан.

6.106 Ажлын хэсгүүд удирдамжийн дагуу 2012 онд олгосон 48.9 тэрбум төгрөгийн, 151 төсөлд нийт 12 чиглэлийн хүрээнд хяналтыг гүйцэтгэсэн байна. Үүнээс шинээр байгуулах 51, үйл ажиллагаагаа өргөжүүлэх 98 төслийг санхүүжүүлснээр шинээр 2540 ажлын байр бий болж, 1290 ажлын байр хадгалагдана гэж төсөлд тусгасан боловч ААН-үүдийн хувьд 2012 оны тухайд 1034 хүнийг ажлын байраар хангасан бол 2022 онд 901 болж буурсан байна. Тус ажлын хэсгийн тайланд төслийн хэрэгжилт болон зээлийн зориулалт, зарцуулалтын талаар нэгдсэн үнэлгээ, дүгнэлт өгсөн, үр дүнг тооцсон талаар тусгагдаагүй байна гэсэн тайлбар мэдээллийг ЖДҮГ-аас ирүүлсэн<sup>53</sup>.

6.107 Хөтөлбөрийн хүрээнд арилжааны банкуудаас хөнгөлөлттэй зээл авсан зээлдэгчдийн зээлийн болон депозит дансны хуулгыг данс хөөх аргаар шалгахдаа, зээлийн хувийн хэргийг давхар хянан үзсэн бөгөөд арилжааны банкуудад төслийн хэрэгжилт, зориулалт, зарцуулалтын талаар хяналт шалгалт хийсэн тайлан, мэдээ байгаагүй болно.

6.108 МУХБ, ХХААХҮЯ болон арилжааны банк хооронд байгуулагдсан гурван талт санхүүжилтийн гэрээний 7.2.3<sup>54</sup> дахь заалт, бусад заалтуудыг гэрээлэгч талууд бүрэн хэрэгжүүлээгүй, төслийг санаачилсан, төсөлд хяналт тавих эрх бүхий төрийн захиргааны төв байгууллагууд гаргасан тогтоол шийдвэрийнхээ хэрэгжилтийн үр дүнг нэгтгэж дүгнээгүй, нийгэм эдийн засагт үзүүлсэн үр ашгийн талаар судалгаа, шинжилгээ хийгдээгүй байна.

6.109 Шинжээчийн дүгнэлтийн хувьд гүйлгээ бүрд харгалзах гэрээ, санхүүгийн анхан шатны баримт материалтай танилцах боломжгүй, зөвхөн арилжааны банкнаас ирүүлсэн харилцах дансны хуулганд үндэслэн данс хөөх аргаар зээлийн зарцуулалтыг нягталсан тул худалдан авч буй ажил, үйлчилгээ, бараа материал нь зориулалтын дагуу байсан эсэхийг эцэслэн тогтоох боломж хязгаарлагдмал байлаа.

### **Жижиг, дунд үйлдвэрийн “70.0” тэрбум төгрөгийн дамжуулан зээл**

6.110 Засгийн газрын 2015 оны 66 дугаар тогтоолоор Хөгжлийн банкнаас жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд олгох зээлийн хүүг 9 хувиар тогтоож, зээл олгох ажлыг холбогдох хууль тогтоомж болон “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор хөнгөлөлттэй зээл олгох журам”-ын дагуу зохион байгуулахыг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбатад үүрэг болгосон. Мөн зээлийн эх үүсвэрт шаардагдах 70.0 тэрбум хүртэлх төгрөгийн санхүүжилтийг зохих журмын дагуу шийдвэрлэхийг банкны ТҮЗ-д зөвшөөрч, зөвлөлийн 2015 оны 37 дугаар тогтоолоор зээлийн ерөнхий нөхцөлийг баталсан байна.

6.111 Монгол Улсын Иргэний хууль, Хөгжлийн банкны тухай хууль, Банкны тухай хууль, УИХ-ын 2011 оны 15, Засгийн газрын 2013 оны 239, 2015 оны 66 дугаар тогтоол, Аж үйлдвэрийн сайдын 2015 оны 05 дугаар сарын 8-ны өдрийн 100 дугаар тушаалаар баталсан “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор хөнгөлөлттэй зээл олгох журам”-ыг үндэслэн Хөгжлийн банк, ЖДҮХС, арилжааны банк хооронд “Дамжуулан зээлдүүлэх гэрээ”-г тус байгуулсан. Гэрээний хүрээнд 212 иргэн, 194 хуулийн этгээд, нийт 406 зээлдэгчид 69.9 тэрбум төгрөгийн зээл олгосноос бүс, орон нутгийн хэмжээнд 264 дэд төсөлд 9.1 тэрбум төгрөгийг олгосон байна.

6.112 Төсөл хэрэгжүүлэхээр зээл авсан 406 зээлдэгчийн зээлийн данс болон харилцах дансны гүйлгээний зарцуулалтыг данс хөөх аргаар нэг бүрчлэн шалгахад, нийт зээлийн 57

<sup>52</sup> Зээлийн төлбөрийг Хавсралт 1-ээр тохиролцсон “Зээл буцаан төлөх хуваарь”-ийн дагуу төлнө

<sup>53</sup> Эх сурвалж: ЖДҮГ-аас ирүүлсэн албан бичиг/

<sup>54</sup> “Энэхүү санхүүжилтийн эх үүсвэрээр олгосон дэд санхүүжилтийн хөнгөлөлттэй зээлийн зориулалт, зарцуулалтад хяналт тавиж ажиллахыг Зээлдэгчээс шаардах, шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хяналт тавих, газар дээрх шалгалт хийх эрхтэй”

хувь буюу 39.9 тэрбум төгрөгийг бэлэн мөнгөөр зарлагадсан, 13 хувь буюу 9.0 тэрбум төгрөгийг зээл хаасан, 16.0 хувь буюу 11.3 тэрбум төгрөгийг өөрийн болон бусад дансанд шилжүүлсэн, 2 хувь буюу 1.7 тэрбум төгрөгийг валют арилжаа хийж гадаадад шилжүүлсэн, 10.0 хувь буюу 7.1 тэрбум төгрөгийг төсөл хэрэгжүүлэхэд зориулсан төлбөр тооцоонд зарцуулсан нь баримтаар нотлогдож байгаа бөгөөд зээлийг зориулалтын дагуу ашигласан, зээл төсөл, хөтөлбөрийнхөө зорилтод нийцсэн тухай дүгнэлтийг өгөх боломжгүй байна.

6.113 Аж үйлдвэрийн сайдын 2015 оны 100 дугаар тушаалаар баталсан журмын 1.6-д “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлд хамрагдан зээлийн үлдэгдэлтэй, зээлээ төлж дууссан ч ашиглалтын явцад зориулалт бусаар ашигласан нь тогтоогдсон эсвэл банк, ББСБ, Татварын алба, Нийгмийн даатгалын байгууллага болон ШШГБ-д өр, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй тохиолдолд зээлд хамрагдахгүй” гэсэн заалт, зээлийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийх үүрэг бүхий ЖДҮХС болон АҮЯ хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

6.114 Баримтаас үзэхэд зээл төлж дуусах хугацааны үед хэвийн зээл 335 буюу 82.5 хувьтай төлөгдсөн байгаа ч муу зээл 49 буюу 12.9 хувьтай байна. Мөн арилжааны 5 банкны 11 зээлийн 2.75 тэрбум төгрөг өнөөдрийн байдлаар тухайн арилжааны банкууд дээрээ төлөгдөөгүй үлдэгдэлтэй, муу зээлийн ангилалд байгаа 49 зээлдэгчдээс өнөөдрийг хүртэл зээлээ төлөөгүй үлдэгдэлтэй 11 компани байна.

6.115 МУХБ-ны гүйцэтгэх захирлын баталсан шалгалтын удирдамжийн дагуу 2014-2018 онд арилжааны банкуудаар дамжуулан санхүүжүүлсэн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаа, зээлийн зориулалтыг хамруулан 2018-2019 онд шалгах ажлын хэсгийг байгуулж хяналт шалгалтыг хийсэн байна. Дээрх хяналт шалгалтад 8 банкны 294 дэд зээл хамрагдсаны 33 зээлд төсөл хэрэгжсэн гэсэн дүгнэлтийг өгсөн нь газар дээрх хяналт шалгалтад хамрагдсан дэд зээлдэгчдийн 11 хувийг эзэлж байгаа нь Засгийн газрын шийдвэрээр хэрэгжүүлсэн энэ төсөл үр дүнтэй хэрэгжсэн гэх үндэслэл бага байна.

#### **АҮЯ болон ЖДҮХС-гийн хяналт шалгалтын талаар:**

6.116 ЖДҮГ-аас ирүүлсэн албан бичигт ЖДҮГ-ын архивын баримтаас ХХААХҮС-ын 2015 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн “Томилолтоор ажиллуулах тухай” 33 дугаар тушаалаар Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хэрэгжилт, сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шалгалтыг ХХААХҮЯ болон ЖДҮХС-гийн бүрэлдэхүүнтэй 7 ажлын хэсэг байгуулж гүйцэтгэсэн байна.

6.117 Тус ажлын хэсгүүд удирдамжийн дагуу 12 чиглэлийн хүрээнд хяналтын ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд 2015 онд олгосон 69.9 тэрбум төгрөгийн санхүүжилтэд 406 төсөл хамрагдсанаас шинээр байгуулах 94, үйл ажиллагаагаа өргөжүүлэх 312 төслийг санхүүжүүлж, шинээр 1672 ажлын байрыг бий болгож, 2286 ажлын байр хадгалахаар төсөлд тусгагдсан гэжээ.

6.118 Төслийн хэрэгжилт болон зээлийн зориулалт, зарцуулалтад нэгдсэн үнэлгээ, дүгнэлт өгсөн, үр дүнг тооцсон талаар тухайн үеийн тайланд тусгаагүй байна.

#### **Үйлдвэрлэлийн чиглэлийн экспортыг дэмжих, импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх төсөл**

6.119 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх эхний шаардлага Засгийн газрын 2015 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 312 буюу “Экспортыг дэмжих, импортыг орлох үйлдвэрийн төслүүдийг санхүүжүүлэх тухай” тогтоолын дагуу хэрэгжсэн.

6.120 Хөтөлбөрийн хүрээнд дамжуулан зээлийн гэрээний хэрэгжилттэй холбоотой хангагдаагүй зохицуулалт бүхий доорх заалтуудын хэрэгжилт хангалтгүй байсан. Үүнд:

- Зээлийн зориулалт буюу гэрээнд заасан шаардлагыг хангасан төслүүдийг зээлдэгчээр дамжуулан санхүүжүүлнэ. Зориулалт бусаар ашиглахыг хориглоно.
- Зээлийн ашиглалт буюу зарцуулалт, зээлийн үйл ажиллагаанд хяналт тавих, газар дээр нь хяналт шалгалт хийх, энэ зорилгоор дэд зээлдэгчийн үйл ажиллагаатай танилцах боломжийг үндсэн зээлдэгчид олгох.
- Зээлийн хөрөнгийг гэрээнд заасан зориулалтас өөрөөр ашиглахгүй байх.

- Талууд гэрээгээр хүлээсэн үргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу хариуцлага хулээнэ.
- Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд үндсэн зээлдэгчид мэдээллийг саадгүй гаргаж өгөх.
- Арилжааны банк нь Хөгжлийн банкнаас авсан зээлийг зориулалтын дагуу дэд зээлдэгчийн дансанд ажлын З хоногийн дотор шилжүүлэх.
- Дэд зээлийн хугацаа сунгах эсхүл дэд зээлийн эргэн төлөлтийн хуваарыт нэмэлт өөрчлөлт оруулах зэрэгээр дэд зээлийн нөхцөлийг 1 удаа өөрчилж болох бөгөөд энэ тохиолдолд Хөгжлийн банкнаас зөвшөөрөл авах ба дэд зээлийн нөхцөлд нэмэлт өөрчлөлт орсноос хойш ажлын З хоногийн дотор холбогдох зээлийн хорооны шийдвэр, нэмэлт гэрээ, шинэчилсэн хуваарийг Хөгжлийн банканд хүргүүлнэ.

6.121 Хөтөлбөрийн хүрээнд хуулийн зохицуулалттай нийцсэн байхуйц “Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль”-ийн хэрэгжилт хангагдаагүй. Үүнд:

- Засгийн газраас гаргасан болон түүнийг дэмжсэн МУХБ-ны ТУЗ-ийн “Экспортыг дэмжих, импортыг орлох үйлдвэрүүдийн төслийг санхүүжүүлэх тухай” шийдвэр нь хуулиар олгогдсон зээл олгох зохицуулалтад үндэслэнсээс бус хөгжлийн томоохон төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэхэд нийцсэн, банкны оролцоотойгоор эдийн засгийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх “хөшүүрэг” болж чадаагүй, “дамжуулан зээл”-ийн зохион байгуулалт анхаарал хандуулжээ.
- ТУЗ-ийн тогтоолын “бусад нөхцөл” гэж тодорхойлсон “Тавигдах шаардлага” нь Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн үндсэн агуулгыг зөрчиж байна.
- Засгийн газрын 2015 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 312 дугаар тогтоолоор 2014 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 212 дугаар тогтоолоор баталсан “Экспортыг дэмжих, импортыг орлох үйлдвэрлэлийн төслийг санхүүжүүлэх, хяналт тавих тайлagnah журам” хүчингүй болсноор төрийн байгууллагын хяналтын механизм зогссон.

6.122 “Төслийн хэрэгжилтэд хяналт тавих гэрээ”-ний хэрэгжилт хангалтгүй байсан. Тухайлбал:

- Хөтөлбөрийн хүрээнд арилжааны банкаар дамжуулан олгосон төсөл, хөтөлбөрийн зээлийн үр дүнд экспортыг дэмжих болон импортыг орлох ямар бүтээгдэхүүнийг бий болгож, өрсөлдөх чадвартай, үнэ цэнэ бүхий үйлдвэрлэл нэмэгдсэн эсэх талаар тодорхой мэдээлэл алга байна.
- Шинэ дэвшилтэд технологи, шинэ бүтээгдэхүүнийг бий болгож үйлдвэрлэл, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлж, ямар бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн тогтвортой байдал, суурийг тавьж өсөлтийг бий болгосон, олон улсын зах зээлд нэвтрүүлж өрсөлдөх боломж бий болгосон талаар хангалттай, иж бүрэн нотлох зүйлс алга байна.
- Түүнчлэн ажлын байр нэмэгдүүлэх зэрэгээр голлох шалгуур болон хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг нэг бүрчлэн тооцсон эсэх нь тодорхой бус, үр дүнг тооцсон гэх баримт материал хангалтгүй, “Төслийн хэрэгжилтэд хяналт тавих гэрээ”-ний хэрэгжилтийг дүгнэж, төслийн санхүүжилтийн үр өгөөжийг тооцсон гэх нэгтгэсэн үнэлгээ, дүгнэлт гэх хангалттай мэдээлэлгүй, эх сурвалж үгүй болно.

6.123 Зээлийн зарцуулалтыг нотлох баримтын бүрдэл, нотлох зүйл хангалтгүй байсан.

- Голомт банк: “Форвард блок констракшн” ХХК /төслийн баримт бичигтгүй/, “Дашваанжил” ХХК,
- ХААН банк: “Эн Ти Эм” ХХК /төсөл бүрэн хэрэгжээгүй/, “Өлзий дэн” ХХК, “Улаанбаатар Бүк” ХХК
- Төрийн банк: “Алтай групп” ХХК, “Битумина сэнтрал азия” ХХК, “Драгон холдинг” ХХК
- Улаанбаатар хотын банк: “Файнаншл алиянс” ХХК /төсөл бүрэн хэрэгжээгүй/, “Монгол керамик” ХХК, “Нью грийн лайф” ХХК

6.124 Зээлийн үлдэгдэлтэй /Петролеум продакшн ХХК, “Алтай групп” ХХК/ байгаа нь төслийн үр ашгийн судалгаа, үр дүн хангалтгүй, нөгөө талаас зээлдэгчийн сахилга бат сүл байгааг илтгэнэ. Төрийн банк, МУХБ-ны БТТХ-ийн ашиглалт ижил утгатай бөгөөд эх үүсвэрийн ашиглалт хангалтгүй байгааг илтгэж байна.

6.125 Холбогдох журамд арилжааны банкууд дэд зээлийн олголт, ашиглалт, эргэн төлөлтийн байдалд, Хөгжлийн банк эх үүсвэрийн зээлийн олголт, ашиглалт, эргэн төлөлтийн байдалд тус тус хяналт тавих, холбогдох яамдын төсөл хариуцсан нэгж хэрэгжилтийн явц, худалдан авалт, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалт зэрэг бүх үйл

ажиллагаанд хяналт тавьж ажиллахаар заасан хэдий ч талуудын хяналт хангалтгүй, үр нөлөөтэй байж чадсан гэх нотолгоо хангалтгүй байсан.

6.126 Мөн “Экспортыг дэмжих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлснээр экспортыг дэмжих, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэсэн тоо хэмжээ, үнийн дүн болон хөтөлбөрийн хүрээнд шинээр бий болсон болон тогтвортой хадгалж үлдсэн ажлын байрны талаар нэгдсэн судалгаа, тайлан, статистикийн мэдээлэл алга байна.

#### **Ази, европын дээд түвшний 11 дүгээр уулзалтын зочид төлөөлөгчдийг хүлээн авч байрлуулах зочид буудлууд болон Асем вилла хотхон төслийн зээл**

6.127 Монгол Улсын ҮАБЗ-ийн 2014.12.22-ны өдрийн 63/37 дугаар зөвлөмжийн дагуу Ази, Европын дээд түвшний 11 дүгээр уулзалтыг Улаанбаатар хотод зохион байгуулахаар тогтжээ. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2014.12.30-ны өдрийн 163 дугаар зарлигаар Ази, Европын дээд түвшний 11 дүгээр уулзалтыг зохион байгуулах ажлыг удирдан зохион байгуулах, чиг үүрэгтэй Үндэсний зөвлөл байгуулагдсан байна.

- Засгийн газрын 2015.06.02-ны 226 дугаар тогтоолоор “ACEM”-д оролцох төлөөлөгчдийг байрлуулах зочид буудлуудад олгох хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрт шаардагдах 150.0 тэрбум төгрөгийг баталж, МУХБ-ны ТҮЗ-ийн 73 дугаар тогтоолоор ерөнхий нөхцөлийг баталсан байна.
- Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Засгийн газрын 2015 оны 226, 344 дүгээр тогтоолыг үндэслэн Сангийн сайдын 2015 оны 241 дүгээр тушаалаар “Ази Европын дээд түвшний уулзалтын төлөөлөгчдийг байрлуулах зочид буудлуудад олгох хөнгөлөлттэй зээлийг санхүүжүүлэх, хяналт тавих журам”-ыг баталсан байна.

6.128 Худалдаа хөгжлийн банк нь “Скай ресорт” ХХК-ийн Асем вилла төслийн санхүүжилт болох 125.0 тэрбум төгрөгөөс Монголбанканд урт хугацаат репо хэлцлээр 65.0 тэрбум төгрөгийг, Төв банкнаас банканд олгох барьцаат зээлээр 60.0 тэрбум төгрөгийг хүснэгтэд заасан хүүгийн түвшинд мөнгөжүүлсэн байна.

*Хүснэгт 56. Хөтөлбөрийн хүрээнд Худалдаа хөгжлийн банканд олгосон санхүүжилт /сая төгрөг/*

Банкны нэр	Гэрээний огноо	Дуусах огноо	Хүүгиin түвшин	Олгосон санхүүжилт 2015	2016
ХХБ	2015.09.25	2021.09.23	4.0%	60,000	
	2016.03.23	2021.12.14	7.5%	-	10,000
	2016.02.25	2021.11.23	7.5%	-	20,000
	2016.03.03	2021.11.29	7.5%	-	20,000
	2016.02.08	2021.10.06	7.5%	-	15,000
				60,000	65,000

6.129 “Скай ресорт” ХХК нь МУХБ-ны эх үүсвэртэй Худалдаа Хөгжлийн банкнаас 2015.09.25-ны өдрийн ЗГ-22 тоот зээлийн гэрээ байгуулан 125.0 тэрбум төгрөгийн зээл авсан байх бөгөөд тус гэрээний 4.2-т “Зээлдээг нь зээлийг Богдхан Уул, Хүрхрээгийн аманд байрлах Асем вилла төслийг санхүүжүүлэх зориулалтаар ашиглана.” гэж заасан байна.

6.130 Сангийн сайдын 2015 оны 241 дүгээр тушаалаар баталсан “Ази, Европын дээд түвшний уулзалтын төлөөлөгчдийг байрлуулах зочид буудлуудад олгох хөнгөлөлттэй зээлийг санхүүжүүлэх, хяналт тавих журам”-ын дараах заалтууд хэрэгжээгүй байна. Үүнд:

- Журмын 2.2-т “Хөгжлийн банкнаас арилжааны банкаар дамжуулан Зочид буудлуудад олгох зээл нь дараах ерөнхий нөхцөлтэй байна. 2.2.2-т жилийн 9 хувиас илүүгүй хүүтэй”
- Журмын 3.1-т “Зочид буудлуудад олгох хөнгөлөлттэй зээлийг санхүүжүүлэх арилжааны банкууд дараах чиг үргийг хэрэгжүүлнэ. 3.1.3-т Эх үүсвэрийн ашиглалт, хэрэгжилтийн тайланг ХБ-нд сар бүр ирүүлэх”
- Журмын 5.1-т “Энэхүү журамд заасан дэд зээлийн олголт, ашиглалт, эргэн төлөлтийн байдалд арилжааны банкууд болон Ерөнхий сайдын 2015 оны 17 дугаар захирамжийн 1 дүгээр хөвсралтаар батлагдсан ажлын хэсэг, эх үүсвэрийн зээлийн олголт, ашиглалт, эргэн төлөлтийн байдалд Хөгжлийн банк тус тус хяналт тавина.”
- Журмын 5.2-т “Энэхүү журмын дагуу зээлийн харилцаанд оролцогчид зээлийг зориулалтын бусаар ашигласан, хуурамч материал бүрдүүлсэн, худал мэдээлэл өгсөн, зочдыг хүлээж авах төсөл хэрэгжээгүй нь тогтоогдвол холбогдох хууль тогтоомж, гэрээнд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ” гэсэн заалтууд байна.

6.131 Холбогдох шийдвэрийг үндэслэн МУХБ-наас арилжааны банкуудад эх үүсвэрийг олгосноор дараах төслүүдийг санхүүжүүлсэн байна.

*Хүснэгт 57. Хөтөлбөрийн хүрээнд санхүүжилт олгосон банк, дэд зээлдэгч /сая төгрөг/*

№	Зээлдэгч банк	Дэд зээлдэгч	Төслийн нэр	Олгосон дүн
1	Худалдаа хөгжлийн банк	Скай резорт ХХК	ACEM Вилла цогцолбор	125,000.0
2		Макс ложинг ХХК	Рамада зочид буудал	2,500.0
3		Макс хотелс ХХК	Холидэй Инн Улаанбаатар	24,496.1
4		Пума империал ХХК	Империал зочид буудал	21,384.0
5		Хурд интернэшил ХХК	Foir Point by Sheraton	14,000.0
6		Сэлбэ плаза ХХК	UB City зочид буудал	967.8
7		Хасэбэ-интернэшил ХХК	Цэцэг зочид буудал	1,612.5
		<b>Дүн</b>		<b>189,960.4</b>
8	Голомт банк	Чингис хаан цогцолбор ХХК	Чингис зочид буудал	9,400.0
9		Дизайнер клуб ХХК	Спрингс зочид буудал	303.1
10		Номадс Рэзидентс ХХК	Notel nine Ulaanbaatar	12,296.9
		<b>Дүн</b>		<b>22,000.0</b>
11	Улаанбаатар банк	Сити тоувер хотел ХХК	City tower зочид буудал	11,320.0
		<b>Дүн</b>		<b>11,320.0</b>
12	Хаан банк	Амури Оргил ХХК	Grand hill зочид буудал	900.0
13		Премиум Палас Улаанбаатар	Премиум Палас ХХК	
14		Континентал ХХК	Континентал зочид буудал	800.0
15		Хаан палас ХХК	Кэмпински зочид буудал	729.0
		<b>Дүн</b>		<b>2,429.0</b>
16	Төрийн банк	Чингис хааны хүрээ ХХК	Чингис хүрээ цогцолбор	6,500.0
17		Мика интерпрайз ХХК	Мика зочид буудал	1,216.0
				7,716.0
		<b>НИЙТ ДҮН</b>		<b>233,425.4</b>

#### **Тайж групп ХХК-ийн хэрэгжүүлсэн "Max боловсруулах үйлдвэрийн төсөл"**

6.132 Монгол Улсын Засгийн газрын 2015.08.03-ны өдрийн 319 дүгээр тогтоолоор Монгол Улсын хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдэд шаардагдах эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор Олон улсын Хөрөнгө оруулалтын банканд 20.0 хүртэлх сая еврогийн зээлийн шугам нээхийг Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлд зөвшөөрсөн байна.

6.133 Олон улсын Хөрөнгө оруулалтын банкнаас 2015.09.01-ний өдрийн 16-22/654 тоот албан бичгээр Оросын Холбооны Улсад бүтээгдэхүүнээ экспортолдог "Тайж групп" ХХК-ийн "Max боловсруулах үйлдвэрийг өргөтгөх" төслийн санхүүжилт болох 2.0 сая еврого тус банкнаас авсан 20.0 сая еврогийн эх үүсвэрээс санхүүжүүлэх боломжтой талаар мэдэгдсэн байна.

6.134 Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016.01.12-ны өдрийн 06 тоот тогтоолоор "Тайж групп" ХХК-ийн хэрэгжүүлж буй "Max боловсруулах үйлдвэрийн өргөтгөл" төсөлд зориулж 4.5 тэрбум төгрөгийн зээлийг Голомт банкаар дамжуулан дараах нөхцөлөөр олгохыг зөвшөөрсөн. Хөгжлийн банкнаас 2016.02.01-ний өдөр 3-ЭИ-С-2016-06 дугаартай "Дамжуулан зээлдүүлэх гэрээ"-г Голомт банктай байгуулж, 2015.04.05-ны өдөр 2.5 тэрбум төгрөг буюу нийт 4.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон бөгөөд тус зээл бүрэн төлөгдж, хаагдсан байна.

#### **"Max хөтөлбөр"-ийн хүрээнд дамжуулан олгосон зээл**

6.135 Монгол Улсын Засгийн газрын 2015.08.03-ны өдрийн 321 дүгээр тогтоолоор махны нөөц бүрдүүлэхэд шаардагдах 80.0 тэрбум төгрөг, экспортын зориулалттай мах, махан бүтээгдэхүүн бэлтгэхэд шаардагдах 100.0 тэрбум төгрөг, нийт 180.0 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зээлийн эх үүсвэрийг шийдвэрлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд, Хүнс, хөдөө аж ахуйн сайд, Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлд тус тус даалгаж, Монголбанкны ерөнхийлөгчид зөвлөсөн байна.

6.136 Монгол Улсын Засгийн газрын 2015.12.14-ний өдрийн 492 дугаар тогтоолоор "Max хөтөлбөр"-ийг баталж, Монгол Улсын Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016.02.04-ний өдрийн 16 дугаартай тогтоолоор тус хөтөлбөрийн хүрээнд арилжааны банкуудаар дамжуулан олгох зээлийн нөхцөлийг баталсан байна.

6.137 Монгол Улсын Хөгжлийн банкнаас тус хөтөлбөрийн хүрээнд арилжааны 3 банкаар дамжуулан нийт 10 дэд зээлдэгчид 24.9 тэрбум төгрөгийн зээлийг дамжуулан олгосноос Худалдаа хөгжлийн банкаар дамжуулан 6 дэд зээлдэгчид нийт 17.7 тэрбум төгрөгийн зээлийн санхүүжилтийг, Хаан банкаар дамжуулан 2 дэд зээлдэгчид нийт 3.1 тэрбум төгрөгийн зээлийн санхүүжилтийг, Голомт банкаар дамжуулан 2 дэд зээлдэгчид нийт 4.2 тэрбум төгрөгийн зээлийн санхүүжилтийг тус тус олгосон бөгөөд тус зээлүүд нь бүрэн төлөгдөж, хаагдсан байна.

Хүснэгт 58. Хөтөлбөрийн хүрээнд хамрагдсан арилжааны банк /сая төгрөг/

№	Банкны нэр	Гэрээний огноо	Дамжуулан зээлдүүлэх гэрээний дугаар	Дэд төслийн тоо	Зээлийн дүн	Эзлэх хувь
1	Голомт банк	2016.04.12	3-MX-XO/2016-26	2	4,200.0	16.8%
2	ХХБ	2016.04.12	3-MX-XO/2016-24	6	17,692.8	70.8%
3	Хаан банк	2016.04.12	3-MX-XO/2016-25	2	3,103.6	12.4%
	<i>Нийт</i>			10	24,996.4	100.0%

### Газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтвортжуулах богино хугацааны хөтөлбөр

6.138 Засгийн газрын 2016.01.11-ний өдрийн 42 дугаар тогтоолоор “Газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтвортжуулах” богино хугацааны хөтөлбөрийг баталж, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах 100.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэж, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдэд 2 хүртэл жилийн хугацаатай зээл олгох арга хэмжээ авахыг банкны ТҮЗ-д зөвшөөрсөн байна.

6.139 МУХБ-ны ТҮЗ-ийн 2016.04.04-ний өдрийн 26 дугаар тогтоолоор тус хөтөлбөрийн хүрээнд олгох дамжуулан зээлийн нөхцөлийг тодорхойлсон.

6.140 МУХБ-ны ТҮЗ-ийн 2016.04.06-ны өдрийн 30 дугаар тогтоолоор тус хөтөлбөрийн зээлдэгчид “Төрийн банк”-ийг нэмж, зээлийн хүүгийн хувийг жилийн 9.0 хувь болгон өөрчилж, бусад нөхцөлийг хэвээр үлдээх, 2016 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 41 дүгээр тогтоолоор Капитрон банкийг зээлдэгчээр нэмэх өөрчлөлтийг тус тус оруулсан байна.

6.141 МУХБ-наас ирүүлсэн тайлан мэдээгээр тус хөтөлбөрийн хүрээнд арилжааны 5 банкаар дамжуулан нийт 93 дэд зээлдэгчид нийт 24.3 тэрбум төгрөгийн зээлийг дамжуулан олгосноос 4 дэд зээлдэгчийн нийт 99.5 сая төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэл бүрэн төлөгдөж дуусаагүй, 1 дэд зээлдэгчийн 14.0 сая төгрөгийн зээлийн эх үүсвэрийг арилжааны банкнаас дэд зээлдэгчид олгоогүй, Хөгжлийн банканд буцаан шилжүүлсэн байна.

*Хүснэгт 59. Газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтвортжуулах богино хугацааны хөтөлбөрт хамрагдсан арилжааны банк*

№	Банкны нэр	Гэрээний огноо	Дамжуулан зээлдүүлэх гэрээний дугаар	Дэд төслийн тоо	Зээлийн дүн	Эзлэх хувь
1	Голомт банк	2016.04.14	3-ГТ-ХО/2016-29	20	5,887.0	24.2%
2	ХХБ	2016.04.20	3-ГТ-ХО/2016-30	8	2,273.0	9.4%
3	Хаан банк	2016.04.20	3-ГТ-ХО/2016-31	17	5,184.8	21.3%
4	Төрийн банк	2016.04.12	3-ГТ-ХО/2016-28	42	10,485.8	43.2%
5	Капитрон банк	2016.05.23	3-ГТ-ХО/2016-36	6	477.4	2.0%
<b>Нийт</b>				<b>93</b>	<b>24,298.0</b>	<b>100.0%</b>

6.142 “Голомт банк”-аар дамжуулан 20 дэд зээлдэгчид нийт 5.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосноос 1 дэд зээлдэгч буюу “Хастав” ХХК-ийн 66.0 сая төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэл бүрэн төлөгджэх хаагдаагүй байна.

6.143 “Төрийн банк”-аар дамжуулан 42 дэд зээлдэгчид нийт 10.5 тэрбум төгрөгийн зээлийн санхүүжилтийг олгосноос 3 зээлдэгч буюу Энх ногоон тал ХХК-ийн 1.0 мянган төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэл, Дэвших түвшин ХХК-ийн 7.5 сая төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэл, Навка ХХК-ийн 25.0 сая төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэл тус тус бүрэн төлөгджэх хаагдаагүй байна.

6.144 “Хаан банк”-аар дамжуулан 17 дэд зээлдэгчид нийт 5.2 тэрбум төгрөгийн зээлийн санхүүжилтийг олгосноос Өлзийт хараа ХХК-ийн 14.0 сая төгрөгийн зээлийг Хаан банкнаас тус зээлдэгчид олгоогүй, зээлийн эх үүсвэрийг Хөгжлийн банканд буцаан шилжүүлсэн байна.

6.145 ХХБ-аар дамжуулан 8 дэд зээлдэгчид нийт 2.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг, Капитрон банкаар дамжуулан 6 дэд зээлдэгчид нийт 477.4 сая төгрөгийн зээлийн санхүүжилтийг тус тус олгосноос тус зээлүүд нь бүрэн төлөгджэх хаагдаагүй байна.

#### **Ноолуурын салбарын эргэлтийн хөрөнгийн зориулалттай олгох хөнгөлөлттэй зээл /2015, 2018, 2019, 2020/**

6.146 МУХБ нь ноолуурын салбарыг дэмжих, ноолуурын эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор 4 удаагийн “Ноолуур хөтөлбөр”-ийн хүрээнд 2015 он, 2018 он, 2019 он, 2020 онд давхардсан тоогоор 8 арилжааны банкаар дамжуулан нийт 90 зээлдэгчид 282.98 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Үүнд:

- УИХ-ын 2015 оны 41 дүгээр тогтоол, Засгийн газрын 2015 оны 149, 171 тогтоолд үндэслэн, МУХБ-ны ТУЗ-ийн 2015 оны 39 дүгээр тогтоолоор “Ноолуур боловсруулах үндэсний үйлдвэрүүдэд түүхий эд бэлтгэх эргэлтийн хөрөнгийн зориулалтаар арилжааны банкуудаар дамжуулан олгох хөнгөлөлттэй зээлийн хэмжээ 100.0 тэрбум хүртэлх төгрөгийг, банканд жилийн 6 хувийн хүүтэй, дэд зээлдэгчид жилийн 9 хүртэл хувийн хүүтэй, 3 хүртэл жилийн хугацаатайгаар олгох”-оор шийдвэрлэсэн байна.
- Хэрэгжилт 2015 он: Арилжааны 7 банкаар дамжуулан 11 хуулийн этгээдэд 56.2 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна.
- УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоол, Засгийн газрын 2018 оны 47 дугаар тогтоолд үндэслэн, МУХБ-ны ТУЗ-ийн 2018 оны 46 дугаар тогтоолоор “Ноолуур хөтөлбөр”-ийн хүрээнд эргэлтийн хөрөнгөд зориулж 150.0 тэрбум хүртэлх төгрөгийн зээлийг арилжааны банкуудаар дамжуулан, ноолуурын түүхий эд бэлтгэх эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийг банканд жилийн 10 хувийн хүүтэй, дэд зээлдэгчид жилийн хүү 12-13 хувийн хүүтэй, 2 хүртэл жилийн хугацаатайгаар санхүүжилт олгох”-оор шийдвэрлэсэн байна.
- Хэрэгжилт 2018 он: Арилжааны 5 банкаар дамжуулан 18 хуулийн этгээдэд 97.8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна.
- Засгийн газрын 2018 оны 47 дугаар тогтоолд үндэслэн, МУХБ-ны ТУЗ-ийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор “Ноолуур хөтөлбөрийн хүрээнд эргэлтийн хөрөнгөд зориулж (ноолуурын самнах, ээрэх болон түүнээс дээш

үйлдвэрлэлийн дамжлага суурилагдсан үйлдвэрлэл эрхлэгч ААН-үүд)-д 150.0 тэрбум хүртэлх төгрөгийн зээлийг арилжааны банкуудаар дамжуулан, ноолуурын түүхий эд бэлтгэх эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийг банканд жилийн 10.0 хувийн хүүтэй, дэд зээлдэгчид жилийн хүү 12 хувийн хүүтэй, зээл олгосноос хойш 2 хүртэл жилийн хугацаатайгаар санхүүжилт олгохоор шийдвэрлэсэн байна.

- Хэрэгжилт 2019 он: Арилжааны 3 банкаар дамжуулан 14 хуулийн этгээдэд 65.1 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна.
- Монгол УИХ-ын 2020 оны 32 дугаар тогтоол, Засгийн газрын 2020 оны 101 дүгээр тогтоол, МУХБ-ны ТҮЗ-ийн 2020 оны 25 дугаар тогтоолоор “Ноолуур бэлтгэлийн зээлийн санхүүжилтийн нийт эх үүсвэрийн хэмжээ 300.0 тэрбум төгрөг хүртэл, Засгийн газрын 9 хувийн зээлийн хүүгийн хөнгөлөлттэй, дэд зээлдэгчийн төлөх хүү зээл олгосноос хойш 1 жилийн хугацаанд жилийн 3 хувийн хүүтэй байхаар санхүүжилт олгохоор шийдвэрлэсэн байна.
- Хэрэгжилт 2020 он: Арилжааны 4 банкаар дамжуулан 43 хуулийн этгээдэд 66.9 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна.

6.147 МУХБ-наас “Ноолуур хөтөлбөр”-ийн хүрээнд санхүүжилт олгоходоо арилжааны банктай санхүүжилтийн гэрээ байгуулан, зээлийн эрсдэлийг оролцогч банк хариуцахаар тусгасан бөгөөд дэд зээлдэгчийн төлбөрийн чадвараас үл хамааран зээлдэгч банк хуваарийн дагуу буцаан төлөх зохицуулалтыг хийсэн бөгөөд 2023.01.31-ний өдрийн байдлаар МУХБ-нд бүрэн төлөгдөж дууссан бол 5 дэд зээлдэгчийн хувьд арилжааны банканд төлөгдөөгүй 8.8 тэрбум төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэлтэй байна. Үүнд:

- Капитал банкаар дамжуулан олгосон дэд зээлдэгч “ГТС” ХХК-ийн 2,305.0 сая төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэлтэй /Ноолуур хөтөлбөр 2015 он/
- Голомт банкаар дамжуулан олгосон дэд зээлдэгч “Осин” ХХК-ийн 1,811.0 сая төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэлтэй /Ноолуур хөтөлбөр 2019 он/,
- Капитрон банкаар дамжуулан олгосон дэд зээлдэгч “Наранзолбоот кашмер” ХХК-ийн 1,530.0 сая төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэлтэй /Ноолуур хөтөлбөр 2020 он/,
- Төрийн банкаар дамжуулан олгосон дэд зээлдэгч “Далай одод треид” ХХК-ийн 794.9 сая төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэлтэй /Ноолуур хөтөлбөр 2020 он/,
- Төрийн банкаар дамжуулан олгосон дэд зээлдэгч “Амэ треид” ХХК-ийн 2,347.1 сая төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэлтэй /Ноолуур хөтөлбөр 2020 он/.

6.148 МУХБ-аас арилжааны банкаар дамжуулан 4 удаагийн “Ноолуур хөтөлбөр”-ийн хүрээнд нийт 283.0 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосноос дэд зээлдэгчийн зээл болон харилцах дансны хуулгыг данс хөөх аргаар зарцуулалтыг хяналад нийт 66.8 тэрбум төгрөгийг бэлэн мөнгөөр зарлагадаж зориулалт нотлогдоогүй бол 9.4 тэрбум төгрөгийг хадгаламжийн дансанд байршуулж, 84.1 тэрбум төгрөгийг зээл, зээлийн хүүгийн төлбөрт шилжүүлсэн нь холбогдох дансны хуулгаар нотлогдож зориулалт бүрэн бусаар зарцуулсан гэж үзэхээр байна.

6.149 Ноолуурын салбарыг дэмжих хөтөлбөрийн зээлийн зарцуулалтад хяналт шалгалтыг хэрэгжүүлэх явцад яамдууд /гэрээнд оролцогч/ холбогдох банктай хамтран хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналтыг хангалтгүй зохион байгуулснаас хөнгөлөлттэй зээлийн зарим хэсгийг зориулалт бусаар зарцуулсан, арилжааны банкнаас хөтөлбөрийн зээлийг олгоходоо зээл судлах хугацаа их зарцуулдаг, улирлын чанартай санхүүжилтийг зорилтот хугацаанд нь олгож чадаагүйгээс эргэн төлөлтийн хугацаа богиносож зээлдэгчийн хувьд өрийн дарамт үүсгэж байна.

6.150 Цаашид зээлийг зориулалт бусаар зарцуулсан нь нотлогдсон тохиолдолд, зээлийг төлж дууссан эсэхээс үл хамаарч хүүгийн хэмжээг МУХБ-нд алдагдалгүй байхаар нөхөн төлүүлж, цаашид гарах эрсдэлээс хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзлээ.

**Газар тариалан хөтөлбөр (2020 Ковидын үеийн хөнгөлөлттэй нөхцөлтэй)**

6.151 Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 138 дугаар тогтоолоор газар тариалангийн тогтвортой хөгжлийг дэмжих зарим арга хэмжээг баталж, үр тариа, тосны ургамал, тэжээлийн ургамал, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнийн тариалалт, хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийн эргэлтийн болон тариалах талбай, хураан авах ургацын хэмжээг өсгөх, хүн амын хүнсний үйлдвэрлэл, нөөцийг нэмэгдүүлэх, хангамж, үнийг тогтвожуулах зорилгоор 150.0 тэрбум төгрөгийн 3 хувийн хүйтэй, 1 жилийн хугацаатай зээлийн эх үүсвэрийг судлан шийдвэрлэсэн.

6.152 Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, таримлын үр, бордоо, ургамал хамгааллын бодис нийлүүлэгчдэд олгох, зээлийн хүүгийн зөрүү 13.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг төсөвт тусган шийдвэрлэх талаар холбогдох арга хэмжээ авахыг Сангийн сайд болон ХХААХҮ-ийн сайд нарт даалгасан.

6.153 МУХБ-ны ТҮЗ-ийн 2020 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор тус хөтөлбөрийн хүрээнд олгох дамжуулан зээлийн үндсэн нөхцөлийг тодорхойлсон байна.

6.154 ХХААХҮЯ, Сангийн яам, МУХБ хооронд 2020 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 85/2150-200722/06/264 дугаартай “Газар тариалангийн зээлд хүүгийн хөнгөлөлт олгох гэрээ” байгуулсан байна.

6.155 МУХБ-наас ирүүлсэн тайлан мэдээгээр тус хөтөлбөрийн хүрээнд арилжааны 3 банкаар дамжуулан нийт 883 дэд зээлдэгчид нийт 76.3 тэрбум төгрөгийн зээлийг дамжуулан олгосноос 6 дэд зээлдэгчийн нийт 1.7 тэрбум төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэл бүрэн төлөгдж дуусаагүй, 3 дэд зээлдэгчийн 1.1 тэрбум төгрөгийн зээлийн эх үүсвэрийг арилжааны банкнаас дэд зээлдэгчид олгоогүй, Хөгжлийн банканд буцаан шилжүүлсэн байна.

**Хүснэгт 60. Хөтөлбөрийн хүрээнд хамрагдсан арилжааны банк**

16. Газар тариалан хотолбор (2020 Ковидын үеийн хөнгөлөлттэй нөхцөлтэй)						
Д/д	Банкны нэр	Гэрээний огноо	Дамжуулан зээлдүүлэх гэрээний дугаар	Дэд төслийн тоо	Зээлийн дүн (сая төгрөг)	Эзлэх хувь
1	Голомт банк	2020.09.10	ЗГ-ГТ-ДЗ 2020-53	8	7,062.5	9.3%
2	Хаан банк	2020.09.15	ЗГ-ГТ-ДЗ 2020-54	752	60,309.5	79.0%
3	Төрийн банк	2020.09.10	ЗГ-ГТ-ДЗ 2020-55	73	8,974.9	11.8%
<b>Нийт</b>				<b>833</b>	<b>76,346.9</b>	<b>100.0%</b>

6.156 Голомт банкаар дамжуулан 8 дэд зээлдэгчид нийт 7.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосноос 6 дэд зээлдэгчийн зээл бүрэн төлөгдж хаагдсан, 2 дэд зээлдэгч буюу Товхонхан ХХК-ийн 900.0 сая төгрөгийн зээл, “Дайчин Монгол” ХХК-ийн 120.0 сая төгрөгийн зээлийг Голомт банкнаас тус зээлдэгчдэд олгоогүй, зээлийн эх үүсвэрийг Хөгжлийн банканд буцаан шилжүүлсэн байна.

6.157 “Төрийн банк”-аар дамжуулан 73 дэд зээлдэгчид нийт 8.9 тэрбум төгрөгийн зээлийн санхүүжилтийг олгосноос 3 зээлдэгч буюу “Нью ариг ус” ХХК-ийн 1.08 тэрбум төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэл, “Тост уул” ХХК-ийн 162.8 сая төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэл, “Тунамал агро” ХХК-ийн 92.2 сая төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэл тус тус бүрэн төлөгдж хаагдаагүй, “Харвахын гол” ХХК-ийн 132.0 сая төгрөгийн зээлийг Төрийн банкнаас тус зээлдэгчид олгоогүй, зээлийн эх үүсвэрийг Хөгжлийн банканд буцаан шилжүүлсэн байна.

6.158 “Хаан банк”-аар дамжуулан 752 дэд зээлдэгчид нийт 60.3 тэрбум төгрөгийн зээлийн санхүүжилтийг олгосноос 3 зээлдэгч буюу “Хайрхан үр тариа” ХХК-ийн 337.0 сая төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэл, иргэн Э.Батзулын 18.1 сая төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэл, иргэн Б.Баасанжавын 23.8 сая төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэл тус тус бүрэн төлөгдж хаагдаагүй байна.

**Хүнсний улаан буудайн нөөц бүрдүүлэх төсөл (2021)**

6.159 Засгийн газрын 2020 оны 180 дугаар тогтоолоор “Хүнсний хомсдол үүсэх, үнэ өсөхөөс урьдчилан сэргийлэх, хангамжийг тогтвожуулах, аюулгүй байдлын нөөц бүрдүүлэх зорилгоор хүнсний улаанбуудайг импортлоход шаардагдах 100.0 тэрбум төгрөгийн

санхүүжилтийг Хөгжлийн банкны эх үүсвэрээр холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэх талаар судалж, шуурхай арга хэмжээ авахыг Сангийн сайдад даалгаж, Хөгжлийн банкны ТҮЗ-д зөвлөсөн байна.

6.160 ХХААХҮЯ-наас 2020 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 01/4100 тоот албан бичгээр хүнсний улаанбуудайг импортлоход шаардагдах 100.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх арга хэмжээ авахыг МУХБ-наас хүссэн албан бичиг ирүүлжээ.

6.161 2021 оны 1 дүгээр сард арилжааны 3 банктай “Дамжуулан зээлдүүлэх гэрээ” байгуулан 5 дэд төсөлд 20.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон нь хугацаандаа бүрэн төлөгдсөн байна.

*Хүснэгт 61. Хөтөлбөрийн хүрээнд хамрагдсан арилжааны банк*

№	Банкны нэр	Гэрээний огноо		Дэд төсөл	Олгосон зээлийн дүн	Эзлэх хувь
		эхлэх	дуусах			
1	Голомт банк	2021.02.10	2022.02.10	1	2,000.0	10%
2	ХХБанк	2021.02.04	2022.04.08	2	7,109.0	35%
3	Хаан банк	2021.01.21	2022.04.07	5	11,005.0	55%
<b>Нийт дүн</b>				5	20,114.0	100%

6.162 2021 оны 1 дүгээр сард арилжааны 3 банктай “Дамжуулан зээлдүүлэх гэрээ” байгуулан 5 дэд төсөлд 20.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон нь хугацаандаа бүрэн төлөгдсөн байдалтай ч хүнсний улаанбуудайг импортлох зорилго байсан эсэх, үнэ ханш, чанарын хувьд шаардлага хангасан эсэх, дотоодын ААН-үүдээс худалдан авах асуудал зөвшөөрөгдсөн эсэх нь тодорхойгүй байна.

6.163 Хэрэв тийм бол тусгай хөтөлбөр гаргах шаардлагагүй байсан байж болохыг хяналт шалгалтын явцад бүрэн нотолж чадаагүй ч Засгийн газрын дэмжлэгтэй дамжуулан зээлийн хөтөлбөр нь МУХБ-ны тухай хуулийн үндсэн зарчмыг алдагдуулсан, нөгөө талаас Засгийн газрын шийдвэрийг дэмжсэн энэхүү оролцоо нь тус банкны хуулиар хүлээн зөвшөөрсөн үндсэн зорилготой нийцэхгүй байна.

6.164 Импортын улаан буудайн үнэ ханш, чанарын ялгаа болон импортын гэгдэх улаанбуудайн нөөц бүрдүүлэлт, хүнсний аюулгүй байдлын улсын нийт нөөцийн харьцаа, бүрдэлт, дотоодын зах зээлийн эмзэг байдлын нөлөөлөл, чанарын шинжилгээ ба баталгаажуулалт, хадгалах хугацаа, үр ашгийн тооцооллын талаарх мэдээлэл хангалттай бус байна.

6.165 Хүнсний аюулгүй байдал болон салбарын хүрээнд уламжлал байдлаар хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр, санхүүжилтийн механизмын сонголт, үр нөлөөг үнэлэх тогтолцоог хянан үзэж байх шаардлагатай.

## ДОЛОО. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ДҮГНЭЛТ

Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хороо нь холбогдох хуулийн хүрээнд арилжааны 12 банканд газар дээрх хяналт шалгалтын удирдамжийн хүрээнд зээлдэгч бүрийн санхүүжилтэд данс хөөх аргаар зарцуулалтыг шалгаж, дараах дүгнэлтийг гаргалаа.

1. МУХБ-наас шууд санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрийн хувьд 18.3 хувь зориулалтын дагуу буюу зээлийн гэрээнд заасны дагуу зарцуулалтыг хийсэн, 74.2 хувь зориулалт бүрэн бус буюу зээлийн тодорхой хэсгийг зээлийн гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглаагүй (арилжааны банк болон бусад санхүүгийн байгууллагын зээл хаасан, хадгаламжинд байршуулсан, ББСБ-нд хөрөнгө оруулсан, бусдад шилжүүлсэн гэх мэт), 7.4 хувь нь зээлийг 100 хувь зориулалт бусаар ашигласан, 0.3 хувь нь нягтлах боломжгүй буюу зээлийг бэлэн зарлагын гүйлгээгээр зарцуулалт хийсэн байна.
2. Монгол Улсын Хөгжлийн банкны шууд зээлдэгч 77, арилжааны банкаар дамжуулан зээлдэгч 2542, Засгийн газарт шилжүүлсэн багцын 355 төсөл, хөтөлбөрийг гүйцэтгэгч 279 компани, МУХБ-ны охин компаниудаас санхүүжүүлсэн 42 зээлдэгч, нийт 3000 гаруй зээлдэгчийн идэвхтэй, идэвхгүй хувьцаа эзэмшигч, өмнөх ба одоогийн гүйцэтгэх удирдлага, эцсийн өмчлөгч нар дээр бүртгэлтэй хуулийн этгээдүүдийн мэдээллийг улс төрийн хамаарлын хүрээлэлтэй тулгах нягтлахад 125 хуулийн этгээд, 8 иргэн, нийт 133 зээлдэгч улс төрийн хамааралтай байна. Улс төрийн хамааралтай зээлдэгчид нь МУХБ-наас нийт 1.5 их наяд төгрөгийн дүн бүхий зээл авсан байгаа нь тус банкны нийт олгосон 7.5 их наяд төгрөгийн зээлийн 20 хувийг эзэлж байна.
3. МУХБ-наас шууд санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийг олгоходо хууль, бодлого, журмыг хангасан эсэх нийцлийг шалгахад хуулийн зорилттой нийцсэн төсөл 33.0 хувь, бүрэн бус нийцэлтэй төсөл 49.5 хувь, нийцээгүй төсөл 17.5 хувийг тус тус эзэлж байна.
4. Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах хороо байгуулагдаж ажилласнаас хойш зээлдэгчид зээлийн гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу зээлийн эргэн төлөлтөө идэвхжүүлсэн нь 2022 оны 4 дүгээр сарын 14-ний өдрөөс 2023 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн хооронд нийт 1.08 их наяд төгрөгийн эргэн төлөлт хийгдсэнээс харагдаж байна.
5. МУХБ-нд 2011 оноос ажиллаж байсан гүйцэтгэх удирдлагын баг нь мөнгөн хөрөнгийн зохистой удирдлагыг хэрэгжүүлээгүйгээс тухайн үеийн зах зээлийн хүүгийн хэмжээгээр харьцуулан тооцоолоход 120 гаруй тэрбум төгрөгийн алдагдсан боломжийн зардал үүсгэж, банкны ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн байна.
6. Хянан шалгах түр хорооноос олон нийтэд шууд дамжуулан танилцуулсан нээлттэй 3 удаагийн сонсгол нийт 13 өдрийн турш нийт 672 (Нэмэлтээр 132 иргэнийг гэрчээр дуудсан) иргэнийг гэрчээр дуудсан бөгөөд үүнээс 356 иргэн оролцсон байна.

## НАЙМ. ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ, ЗӨВЛӨМЖ

МУХБ нь Монгол Улсын хөгжлийн бодлогын хүрээнд томоохон төсөл, хөтөлбөрүүдийг урт хугацаанд, зорилтот хэлбэрээр санхүүжүүлэх зорилгоор байгуулагдсан төрийн өмчит банк юм.

Хөгжлийн банк нь өнгөрсөн 10 жилийн хугацаанд дараах үндсэн 2 чиглэлээр Засгийн газартай хамтран ажиллаж иржээ. Үүнд:

1. Санхүүжилт шаардлагатай байгаа төсөл, хөтөлбөрүүдийн эдийн засгийн болон нийгмийн хөгжилд үзүүлэх нөлөөллийг судлах, үнэлэх, шийдвэр гаргах, санхүүжилт олгох;
2. Хөрөнгө оруулагчидтай том төсөл санхүүжүүлэх замаар хамтран ажиллах, хөрөнгө татах.

Хөгжлийн банк дээрх зорилгын хүрээнд нийт 7.5 их наяд төгрөгийн санхүүжилт олгосон боловч, өнөөдрийн байдлаар чанаргүй зээлийн багц хэт томорч, банк төлбөрийн чадваргүй болох эрсдэлд орсон. Хөгжлийн банкны санхүүжүүлсэн төслүүдийн дийлэнх нь үндсэн зорилгод нийцсэн, үр ашигтай байж чадсан эсэх нь эргэлзээтэй байна.

Монгол Улсын Хөгжлийн банк цаашид өнөөгийн мөрдөгдөж буй эрх зүйн орчин, засаглалаар үйл ажиллагаагаа үргэлжлүүлбэл өнөөдөр бий болсон нөхцөл байдал дахин давтагдах нь цаг хугацааны асуудал гэдэг нь тодорхой байна. Ер нь манай улсад Хөгжлийн банк байх хэрэгтэй юу гэх асуудал ч хөндөгдсөн. Иймд Хянан шалгах түр хорооноос МУХБ-ийг цаашид хэрхэх талаар дараах 3 хувилбарыг дэвшүүлж, тооцоо судалгаа хийсний үндсэн дээр улсад хамгийн бага зардалтай, хамгийн өндөр өгөөжтэй байх хувилбарыг сонгон хэрэгжүүлэх нь зүйтэйг тэмдэглэж байна.

1. Татан буулгах
2. Хөгжлийн банк хэлбэрээр үйл ажиллагааг нь хэвээр үргэлжлүүлэх
3. Иж бүрэн өөрчлөн зохион байгуулалт хийх

## ТАТАН БУУЛГАХ

МУХБ-ны нийт хөрөнгө 2023 оны эхний улирлын байдлаар 3.9 их наяд төгрөг, чанаргүй зээл болон анхаарал хандуулах зээлийн үлдэгдэл 1.5 их наяд төгрөг, хуримтлагдсан алдагдал 455 тэрбум төгрөг байна. Банкны санхүүгийн тайлангийн үзүүлэлтээр мөнгөн урсгалын зөрүү 2023 оны аравдугаар сарын байдлаар 1.03 их наяд төгрөгт хүрэх, 2025 оны арванхоёрдугаар сар хүртэл дунджаар 0.95 их наяд төгрөг байхаар байна. Гадаад бондын эх үүсвэрийн батлан даагч нь Засгийн газар. Татан буулгасан тохиолдолд дээрх алдагдал улсын төсөвт дарамт учруулах, гадаад валютын улсын нөөцөөс төлөгдөх эрсдэлтэй байна.

Ийм нөхцөлд МУХБ-ыг татан буулгах нь хамгийн амархан боловч санхүүгийн хувьд өндөр зардалтай, эдийн засгийн хувьд үр ашиггүй, ирээдүйд дахин хөгжлийн хөтөлбөрүүд санхүүжүүлэх институц байгуулах шаардлага үүссэн нөхцөлд бүгдийг шинээр эхлэх шаардлага тулгарна.

## ХӨГЖЛИЙН БАНК ХЭЛБЭРЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГААГ НЬ ХЭВЭЭР ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ

Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагаанд гарсан алдаа, дутагдалд дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна:

- Сүүлийн 20 гаруй жилд “хэт ойртсон”, зааг ялгаагүй, хаалттай, авлигажсан улс төр-бизнес-банк санхүүгийн санхүүжилтийн тогтолцоо Монгол Улсад нутагшиж, тэр нь Хөгжлийн банкны засаглал, хүний нөөц, шийдвэр гаргалтад гүнзгий нэвтэрсэн;
- Засаглалын хувьд зохистой зарчим хэрэгжээгүй, улс төрийн хууль бус нөлөөллөөс ангид, тогтвортой, мэргэжлийн шийдвэр гаргаж чадаагүй;
- Банкны үндсэн бизнесийн загвар нь тооцоолол судалгаа, шинжилгээнд бүрэн суурилаагүй, орлого олох, эх үүсвэрийн болон үйл ажиллагааны зардлыг нөхөх үйл ажиллагааны чиглэл хангалтгүй;
- Нийт зээлийн санхүүжилтийн дийлэнх нь үндсэн зорилгodoо нийцээгүй;
- Зээлийн зарцуулалт, үр дүнд хийх хяналт сул, хариуцлагын тогтолцоо байхгүй;

Түр хорооны болон өнгөрсөн хугацаанд төрийн бүх шатны байгууллагуудаас хийгдсэн хяналт, шалгалтуудын дүгнэлтүүдээс үзэхэд ийм эрх зүйн орчинтойгоор, ийм засаглалтайгаар, ийм үйл ажиллагааны чиглэл, ийм санхүүгийн үзүүлэлтэйгээр цаашид үйл ажиллагаагаа хэвийн гүйцэтгэх боломжгүй гэж дүгнэж байна.

## ИЖ БҮРЭН ӨӨРЧЛӨН ЗОХИОН БАЙГУУЛАХ

Хөгжлийн банкийг олон улсын жишигт нийцсэн үйл ажиллагаатай, улсын томоохон стратегийн төсөл хөтөлбөрүүдийг санхүүжилтээр ханган эдийн засагт дэмжлэг үзүүлэх бодлогын банк байх үндсэн зорилго, зорилтыг биелүүлэхэд дараах асуудлуудад хариулт өгч, бодлогын шийдлүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Нэгт, Банкны үйл ажиллагааны чиглэлийг олон улсын сайн туршлагад нийцүүлж, балансын бүтцийн өөрчлөлтийн болон бизнес загварын хувьд дахин өөрчлөн байгуулалт хийх, үйл ажиллагааг төрөлжүүлэх төлөвлөгөө гаргах;

Хоёрт, Компанийн засаглалын зохистой зарчмыг хэрэгжүүлж, улс төрийн томилгоог халж, мэргэжлийн ТУЗ-ийн багийг сонгон шалгаруулж, хараат бус гишүүдийн тоог нэмж, гүйцэтгэх удирдлагыг багаар сонгон шалгаруулж, гэрээ хийн үнэлэлт дүгнэлт гаргаж ажилладаг байх;

Гуравт, Банкны хяналт шалгалтын тогтолцоог олон улсын банк, санхүүгийн стандартай нийцүүлэх, аливаа зохицуулалтын хувьд стандарт, дүрэм журмын дагуу тогтоодог байх;

Дөрөвт, Дээрх гурван зөвлөмжийг хангах хүрээнд холбогдох хууль тогтоомж, бодлого, заавар, журамд өөрчлөлтүүдийг хийх;

### **Өнөөгийн нөхцөл байдалд өөрчлөн байгуулалт хийж, Хөгжлийн банкны бизнес загварт шинэчлэл хийх зөвлөмжийн хүрээнд:**

- Санхүүгийн өнөөгийн нөхцөл байдалд үнэлэлт хийх, активын чанарын үнэлгээг гаргах, эх үүсвэрийн эргэн төлөлт, балансын бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөг боловсруулах;
- Зах зээлийн эрсдэлийн хэм хэмжээг тогтоож, актив, пассивын хугацааны болон хүүгийн шинжилгээг нарийвчлан хийсний үндсэн дээр Хөгжлийн банкны үйл ажиллагааны чиглэлийг олон улсын сайн туршлагад нийцүүлж, бизнес загварын хувьд дахин өөрчлөн байгуулалт хийх, шаардлагатай бол үйл ажиллагааг төрөлжүүлэх;

### **Банкны засаглалтай холбоотой зөвлөмжийн хүрээнд:**

- Хөгжлийн банкны засаглал, удирдлагын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэх Банкны хяналтын Базелийн хорооноос 2015 онд баталсан “Банканд зориулсан Компанийн засаглал зарчмууд”, Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага (OECD)-аас гаргасан “Компанийн засаглалын зарчмууд”, “Төрийн өмчит компанийн засаглал”-ын баримт бичгүүдэд засаглал, удирдлагын тогтолцооны үе шат бүхэнд баримтлах зарчмууд, дотоод хяналт ба эрсдэлийн удирдлагын тогтолцооны бүтэц, эрх хэмжээг тусгасан засаглалын зарчмуудыг хэрэгжүүлэх дэлгэрэнгүй тайлбарыг тусгасан байгаа тул эдгээр баримт бичгүүдэд үндэслэн Банкны засаглалын бодлого, Эрсдэлийн бодлогыг боловсруулан баталж, хэрэгжүүлэх болон дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх;
- Банкны үйл ажиллагаатай холбоотой аливаа асуудлыг мэргэжлийн түвшинд сонирхлын зөрчилгүй, хараат бус байдлаар шийдвэрлэх чадвартай ТУЗ-ийн гишүүдийг томилох; ТУЗ-ийн гишүүдтэй гэрээ байгуулах,
- Гүйцэтгэх удирдлагын багийг багаар нь сонгон шалгаруулж, гэрээ хийн үнэлэлт дүгнэлт хийн ажилладаг байх;

### **Банкны хяналт шалгалтын тогтолцоотой холбоотой зөвлөмжийн хүрээнд**

- Олон улсын жишгээр хөгжлийн банкуудын 72 хувь нь Төв банкны, 28 хувь нь Засгийн газрын хяналтад байгааг харгалзан үр ашигтай, зохистой хяналтын тогтолцоог бий болгох;
- Банкны хяналт шалгалтын тогтолцоог олон улсын банк, санхүүгийн стандартад нийцүүлж, энэ хүрээнд холбогдох эрх зүйн орчин, дүрэм журмуудыг тогтоох;

Дээрх зөвлөмжийн хүрээнд Хөгжлийн банкийг иж бүрэн өөрчлөн зохион байгуулах бүтцийн өөрчлөлт хийх, холбогдох хууль тогтоомжийн өөрчлөлтийн төслийг боловсруулахыг Засгийн газарт чиглэл болгосон УИХ-ын тогтоол гаргах нь зүйтэй гэж үзлээ.

### **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРОО**

**ХАВСРАЛТУУД**

Хяналт шалгалтын ажлын явцад цуглуулсан болон судалсан зүйлс, энэхүү тайланд бичигдсэн дүгнэлт бичвэрийг дэмжиж дараах хавсралтуудыг бэлтгэсэн.

**Хавсралт 1****Монгол Улсын Хөгжлийн банкны “Удирдах албан тушаалтын томилгоо, бүрэлдэхүүн, ажилласан хугацааны судалгаа**

№	Нэр	Албан тушаал	Томилогдсон огноо	Чөлөөлөгдсөн огноо	Ажилласан хугацаа /хоног/
<b>ТҮЗ-ИЙН ДАРГА</b>					
1	Ч.Хашчууун	Үндэсний хөгжил шинэтгэлийн хорооны дарга	2010.10.14	2011.04.21	189
2	Б.Батжаргал	Сангийн яамны төсвийн бодлогын газрын дарга	2011.04.21	2012.07.25	461
3	Б.Батбаяр	Сангийн яамны Санхүү, эдийн засгийн бодлогын газрын дарга, ТҮЗ-ийн дарга	2012.07.25	2012.10.06	73
4	Б.Шинэбаатар	Эдийн засгийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэч	2012.10.06	2016.08.10	1404
5	Б.Даажамба	ЗГХЭГ-ын тэргүүн дэд дарга	2016.08.10	2018.04.30	628
6	М.Баярмагнай	ЭХЯ-ны Төрийн захиргаа удирдлагын газрын дарга	2018.04.30	2020.05.29	760
7	С.Наранцогт	Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга	2018.04.30	2022.02.01	1373
8	Б.Сүх-Очир	Сангийн яамны Санхүү, бодлогын газрын дарга	2022.02.01	2022.03.24	51
9	Ж.Ганбат	Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга	2022.03.24		
<b>ТҮЗ-ИЙН ГИШҮҮД</b>					
1	Х.Володя	ТӨХ-ны Төрийн өмчийн удирдлага, менежментийн хэлтсийн дарга	2011.04.21	2012.10.06	534
2	Б.Энэбиш	Эрдэнэс-МГЛ ХХК-ийн гүйцэтгэх захирал	2011.04.21	2012.10.06	534
3	Б.Бямбасайхан	Клин Энержи ХХК-ийн гүйцэтгэх захирал, Ньюком группийн захирал	2011.04.21	2012.10.06	534
4	Д.Болдбаатар	Эдийн засгийн хөгжлийн яамны Эдийн засгийн хамтын ажиллагаа, зээл тусlamжийн бодлогын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэч	2012.10.06	2014.07.16	648
5	Р.Баасанжав	Эдийн засгийн хөгжлийн яамны Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газрын дарга	2014.07.16	2015.01.26	194
6	Ж.Ганбат	Сангийн яамны Төсвийн бодлогын газрын Орлогын хэлтсийн дарга	2011.04.21	2012.10.06	534
7	Д.Баттөр	Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга	2012.10.06	2014.07.16	648
8	О.Хуягцогт	Сангийн яамны төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын төсвийн зарлагын хэлтсийн дарга	2014.07.16	2018.04.30	1384
9	Б.Сүх-Очир	Сангийн яамны Дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга	2015.01.26	2017.08.22	939
10	П.Дорждавга	Сангийн яамны Төрийн Удирдлагын газрын дарга	2020.09.25	2021.11.03	404
11	Д.Ганбат	Монголбанкны Хяналт, шалгалтын газрын захирал	2014.07.16	2016.08.10	756
12	Н.Батсайхан	Монголбанкны Хяналт, шалгалтын газрын захирал	2016.09.15	2017.08.22	341
13	Ч.Отгочууу	Уул уурхайн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэч	2012.10.06	2016.08.10	1404
14	М.Баянмөнх	Үйлдвэр хөдөө аж ахуйн яамны Хүнд үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга	2012.10.06	2015.01.26	842
15	Б.Махбал	Уул уурхайн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга	2016.09.15	2018.04.30	592

Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах Түр хороо

16	Н.Баярчимэг	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга	2018.04.30	2019.01.09	254
17	Б.Батзаяа	Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч	2012.10.06	2014.07.16	648
18	Ж.Бат-Эрдэнэ	Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга	2015.01.26	2018.10.10	1353
19	Б.Даринчулуун	ЗГХЭГ-ийн Хяналт шалгалт, үнэлгээний хэлтсийн дарга	2011.04.21	2012.10.06	534
20	Г.Баясгалан	ЗГХЭГ-ын тэргүүн дэд дарга	2019.01.09	2019.11.19	314
21	Б.Ганбат	ТӨБЗГ-ын дарга, ЗГХЭГ-ын Тэрүүн дэд дарга	2019.01.09	2022.01.09	1096
22	С.Магнайсүрэн	Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга	2018.04.30	2022.02.21	1393
23	Б.Цогбадрах	ХХААХҮЯ-ны санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн санхүүгийн газрын дарга	2019.11.19	2021.11.03	715
24	Т.Жамбалцэрэн	ХХААХҮЯ-ны төрийн нарийн бичгийн дарга	2021.11.03	2022.02.21	110
25	Б.Насанбат	ЭХЯ-ны төрийн нарийн бичгийн дарга	2021.11.03	2022.02.21	110

**ТУЗ-ийн хараат бус гишүүд**

1	С.Дэмбэрэл	МҮХАҮТ-ын дарга	2011.04.21	2012.07.25	461
2	Б.Лхагвасүрэн	Монголбанкны Хяналт, шалгалтын газрын захидал, Хадгаламжийн даатгалын корпорациын гүйцэтгэх захидал	2011.04.21	2014.07.16	1182
3	З.Шагдарсүрэн	Монголын Банкны холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга	2011.04.21	2012.10.06	534
4	Б.Найдалаа	Монголын Банкны холбооны гүйцэтгэх захидал	2012.10.06	2014.07.16	648
5	Ч.Нэргүй	Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын Нэгдсэн бодлого, төлөвлөлт, зохицуулалтын газрын дарга	2012.07.25	2012.10.06	73
6	Ж.Оюунчимэг	Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын Нэгдсэн бодлого, төлөвлөлт, зохицуулалтын газрын дарга	2015.01.26	2020.09.25	2069
7	О.Банзрагч	Улаанбаатар хотын банкны дэд захидал	2015.01.26	2017.08.22	939
8	Б.Баттулга	Волтам ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга	2015.01.26	2018.04.30	1190
9	Д.Бат-Очир	Юнити партнерс ХХК-ийн захидал	2017.08.22	2018.10.10	414
10	Д.Даваасамбуу	Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга	2017.08.22	2020.09.25	1130
11	Ж.Үхэртар	Монголын мэргэшсэн үнэлгээчийн институутийн удирдах зөвлөлийн гишүүн	2017.08.22	2020.09.25	1130
12	Н.Батнасан	МУИС-ын Бизнесийн сургуулийн профессор	2019.11.19	2022.02.21	825
13	Б.Батцэцэг	-	2020.09.25	2022.11.20	786
14	Р.Мөнхтөр	Эс Ай Би ей ХХК, дэд захидал	2020.09.25	2022.02.21	514
15	М.Золжаргал	Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн Төмөр зам төсөл, Хуулийн хэлтэст ахлах зөвлөх	2020.11.27	2022.02.21	451
16	Ү.Амарбат	Орхон их сургуулийн багш	2021.11.03	2022.09.08	309
17	Ү.Бямбасүрэн	ЗГХЭГ-ын дэд дарга	2022.03.24	-	-
18	П.Сайнзориг	ХЭДХЯ-ны төрийн нарийн бичгийн дарга	2022.03.24	-	-
19	Л.Цэдэвсүрэн	БШУЯ-ны төрийн нарийн бичгийн дарга	2022.03.24	-	-
20	Д.Эрдэнэбаяр	Бус нутаг, аж үйлдвэрийн бодлогын газрын дарга	2022.03.24	-	-
21	Г.Буян	Өмгөөллийн "Эл Би Партерс" ХХК-ийн гүйцэтгэх захидал	2022.03.24	-	-
22	Д.Сувдаа	МУИС-ийн БС тэнхимиийн эрхлэгч	2022.03.24	-	-
23	С.Насанжаргал	Тэтгэвэрт	2022.03.24	-	-

## Гүйцэтгэх захирлын судалгаа

№	Нэр	Албан тушаал	Томилогдсон огноо	Чөлөөлөгдсөн огноо	Ажилласан хугацаа /хоног/
1	Ким жанг жинг	Гүйцэтгэх захирал	2011.09.05	2013.07.09	673
2	Н.Мөнхбат	Гүйцэтгэх захирал	2013.08.01	2016.08.11	1106
3	Б.Батбаяр	Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч	2016.08.12	2019.05.20	1011
		Гүйцэтгэх захирал	2017.02.16		
4	Г.Амартувшин	Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч	2019.05.28	2019.12.31	217
5	Н.Мөнхсүх	Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч	2020.04.16	2021.08.03	474
6	Н.Мандуул	Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч	2021.08.03	-	-

## Тэргүүн дэд болон дэд /орлогч/ захирал, газрын захирлын судалгаа

№	Нэр	Албан тушаал	Томилогдсон огноо	Чөлөөлөгдсөн огноо	Ажилласан хугацаа /хоног/
1	Л.Болормаа	Тэргүүн дэд захирал	2011.04.28	2012.07.20	
2	Э.Уламбаяр	Дэд захирал бөгөөд Хяналт, захиргааны газрын захирал	2011.06.02	2012.08.17	
3	Пак Ёнг Бэй	Дэд захирал бөгөөд Эрсдэлийн удирдлагын газрын захирал	2011.09.05	2013.07.09	
4	Чой Жонг Кук	Дэд захирал бөгөөд Зээлийн газрын захирал	2011.09.05	2013.07.09	
5	Г.Дашдэвгэ	Дэд захирал бөгөөд Хяналт, захиргааны газрын захирал	2012.12.24	2014.03.31	
6	С.Сандагдорж	Тэргүүн дэд захирал	2012.11.07	2014.04.01	
7	Р.Батбаяр	Орлогч захирал бөгөөд Эрсдэлийн удирдлагын газрын захирал	2013.10.29	2016.03.09	
8	А.Бат-Оргил	Орлогч захирал бөгөөд Эрсдэлийн удирдлагын газрын захирал	2014.10.15	2016.09.20	
9	Б.Батбилэг	Орлогч захирал бөгөөд Хяналт, захиргааны газрын захирал	2014.03.31	2016.09.20	
10	М.Бат-Өлзий	Орлогч захирал бөгөөд Актив пассивын удирдлагын газрын захирал	2014.07.23	2016.09.20	
11	Г.Одонтуул	Орлогч захирал бөгөөд Зээлийн газрын захирал	2013.10.21	2016.09.21	
12	Б.Буянмөнх	Орлогч захирал бөгөөд Хөрөнгө оруулалтын газрын захирал	2014.04.01	2016.09.21	
13	Г.Дөлгөөн	Дэд захирал бөгөөд Эрсдэлийн үнэлгээ, удирдлагын газрын захирал	2016.09.20	2018.01.12	
14	Ч.Мөнхбаяр	Дэд захирал бөгөөд Төслийн санхүүжилт, зээлийн газрын захирал	2016.09.20	2020.02.17	
15	Ч.Энхбат	Тэргүүн дэд захирал	2016.09.20	2020.04.16	
16	Б.Чойжилжалбуу	Дэд захирал бөгөөд Актив, пассив, хөрөнгийн удирдлагын газрын захирал	2016.09.20	2020.04.24	
17	Б.Ганбаатар	Дэд захирал бөгөөд Төслийн санхүүжилт, зээлийн газрын захирал	2020.04.06	2020.04.29	
18	Ц.Дамдинсүрэн	Эрсдэлийн газрын захирлын үүрэг гүйцэтгэгч	2020.04.24	2021.08.31	
19	Н.Анун	Хөрөнгийн удирдлагын газрын захирлын үүрэг гүйцэтгэгч	2020.04.24	2021.08.31	
20	Б.Анар	Хууль, тусгай активын газрын захирлын үүрэг гүйцэтгэгч	2020.04.24	2021.10.22	
21	Б.Батбаяр	Санхүүгийн удирдлага, бүртгэл тайлгажнын газрын захирлын үүрэг гүйцэтгэгч	2020.04.24	2021.10.22	
22	Б.Жадамбаа	Зээлийн газрын захирлын үүрэг гүйцэтгэгч	2020.04.24	2021.10.22	
23	С.Цэрэндаш	Бизнес, хөгжил хариуцсан дэд захирлын үүрэг гүйцэтгэгч	2017.04.01	2022.02.01	
24	Х.Лхагвасүрэн	Үйл ажиллагаа хариуцсан дэд захирлын үүрэг гүйцэтгэгч	2021.08.31	2022.02.01	
25	Я.Сод-Эрдэнэ	Захиргаа, удирдлага хариуцсан дэд захирал	2016.09.21	2022.02.01	

Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах Түр хороо

26	О.Батбаатар	Эрсдэлийн удирдлагын газрын захирал	2011.06.02	2022.03.24	
27	Ж.Эрхэмбаатар	Үйл ажиллагаа хариуцсан дэд захирлын үүрэг гүйцэтгэгч	2022.02.11	2022.05.13	
28	З.Батырбек	Захиргаа, удирдлага хариуцсан дэд захирал	2022.02.11	2022.05.13	
29	Ж.Батаа	Тэргүүн дэд захирлын үүрэг гүйцэтгэгч	2021.08.31	-	
30	Л.Тэмүүжин	Хөрөнгийн удирдлагын газрын захирлын үүрэг гүйцэтгэгч	2013.08.12	-	
31	Б.Сайнзаяа	Төслийн санхүүжилтийн газрын захирлын үүрэг гүйцэтгэгч	2021.08.31	-	
32	Б.Амгалан	Экспорт, импорт, худалдааны санхүүжилтийн газрын захирлын үүрэг гүйцэтгэгч	2013.04.01	-	
33	З.Батырбек	Эрсдэлийн удирдлагын газрын захирлын үүрэг гүйцэтгэгч	2022.02.11	-	
34	Т.Баасанжав	Санхүүгийн газрын захирлын үүрэг гүйцэтгэгч	2021.09.13	-	
35	Н.Ануун	Захиргаа удирдлагын газрын захирлын үүрэг гүйцэтгэгч	2020.04.24	-	

## Арилжааны банкуудаас хүлээн авсан нотлох баримт, материалын жагсаалт

№	Банкны нэр	төрөл	Цаасан баримтын тоо		Файлаар хүргүүлсэн дансны хуулга			
			Хавтасны тоо	Хуудасны тоо	PDF /Хуудасны тоо/	Excel /файлын хэмжээ/ мб	Файлын хэлбэр /e-mail/	Файлын хэлбэр /flash/
1	Хаан банк	Дамжуулан	1112	14460	774	3,085.60	241	871
		Шууд			8872	4,454.40	293	
		Бусад			817	264.70	289	
2	Хас банк	Дамжуулан	265	66170		327.70	471	
		Шууд			1903	37.10	44	
		Бусад						
3	Капитрон банк	Дамжуулан	61	16568	5169	37.18	111	128
		Шууд		173	961	10.66	45	
		Бусад			573	92.66	32	3
4	Төрийн банк	Дамжуулан	107	36155	1105	4,951.35	240	268
		Шууд				883.00	40.42	105
		Бусад						
5	Голомт банк	Дамжуулан	411	78969	28	21.17	983	
		Шууд			16870	118.46	683	
		Бусад						
6	ХХБанк	Дамжуулан	191	67722	42458	40.78	136	83
		Шууд			38931	67.37	44	9
		Бусад						
7	Капитал банк	Дамжуулан	43	955	4419	35.47		2
		Шууд				11.07	28	
		Бусад						
8	Ариг банк	Дамжуулан	13	4394	75	0.26	5	
		Шууд						
		Бусад						
9	Богд банк	Дамжуулан						
		Шууд						
		Бусад			174	8.92	4	
10	ЧХБанк	Дамжуулан	37	899	45		39	
		Шууд			343	54.13	27	
		Бусад						
11	ҮХОБанк	Дамжуулан						
		Шууд						
		Бусад						
12	TXБанк	Дамжуулан						
		Шууд						
		Бусад			1	0.01	2	
	НИЙТ	Дамжуулан	2,240	286,292	54,073	8,500	2,226	1,352
		Шууд	-	173	67,880	5,636	1,204	114
		Бусад	-	-	1,565	366	327	3
НИЙТ			4,479	572,930	247,036	29,004	7,515	2,938

## МУХБ-наас шууд олгосон зээлийн шийдвэрлэсэн байдал

№	Зээлдэгчийн нэр	Олгосон зээлийн мэдээлэл (анхны гэрээний нөхцөлөөр)			Зээлийн хугацаа		Зээлийн үлдэгдэл (тбм.төг)	МУХБ-наас зээл олгосон албан тушаалтан /зээлийн гэрээний нөхцөлөөр/		
		валют	олгосон /сая валют/	тбм.төг олгосон өдрийн ханш/	Олгосон огноо	Төлөх огноо		Шийдвэрийн хэлбэр	ТҮЗ дарга	Гүйцэтгэх захирал
1	ГОВЬ ХК 1	MNT	42,900.0	42.9	2018.06.14	2023.06.14	42.9	ТҮЗ тогтоол	М.Баярмагнай	Г.Амартувшин
	ГОВЬ ХК	MNT	40,000.0	40.0	2020.05.22	2022.05.22	33.3	ТҮЗ тогтоол	С.Наранцогт	Н.Мөнхсүх
2	ДАРХАН МИНК ХХК	JPY	94.8	2.1	2018.09.13	2024.03.13	1.1	ГЗ тушаал		Ч.Энхбат
3	ДОРНЫН ЦАС ХХК	MNT	3,500.0	3.5	2018.05.31	2023.11.23	2.2	ГЗ тушаал		Б.Батбаяр
4	ИЗИНС-ЭЙР ВЭЙЗ ХХК	MNT	22,915.0	22.9	2019.10.29	2024.10.29	22.9	ТҮЗ тогтоол	М.Баярмагнай	Г.Амартувшин
5	МИАТ ТӨХК	USD	101.8	152.6	2014.11.13	2022.11.25	15.0	ТҮЗ тогтоол	Б.Батжаргал	Ким Жанг Жин Н.Мөнхбат
6	ВЕРТЕКС МАЙНИНГ ПАРТНЕР ХХК	MNT	33,000.0	33.0	2020.01.03	2024.07.03	12.2	ТҮЗ тогтоол	М.Баярмагнай	Г.Амартувшин
7	ЭЙЧ ЭНД ЭЙЧ РЕМИКОН ХХК	MNT	5,000.0	5.0	2018.09.14	2023.09.14	1.6	ГЗ тушаал		Ч.Энхбат
8	МОДУН ХХК	MNT	5,800.0	5.8	2018.10.23	2022.08.23	4.9	ГЗ тушаал		Б.Батбаяр
9	СТРОЙИНВЕСТ ХХК	USD	1.2	3.0	2017.09.21	2020.08.20	1.3	ГЗ тушаал		Б.Батбаяр
		MNT	1,200.0	1.2	2019.07.10	2021.01.10	-	ГЗ тушаал		Г.Амартувшин
10	ВЕСТЕРН ХОЛД ХХК	USD	28.0	76.6	2019.09.23	2030.09.23	85.7	ТҮЗ тогтоол	М.Баярмагнай	Б.Батбаяр
11	МАК ЦЕМЕНТ ХХК	USD	55.6	113.2	2014.10.01	2024.10.02	132.7	ТҮЗ тогтоол	Б.Шинэбаатар	Н.Мөнхбат (гүүрэн зээл-1)
		MNT	20,000.0	20.0						
12	ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ГУРАВ ОНДААТУГ	MNT	21,000.0	21.0	2020.12.22	2024.08.22	15.1	ТҮЗ тогтоол	С.Наранцогт	Н.Мөнхсүх
13	МОНПОЛИМЕТ ХХК	USD	65.0	126.6	2014.10.28	2021.12.28	90.2	ТҮЗ тогтоол	Б.Шинэбаатар	Н.Мөнхбат
14	ДЦС-4 ТӨХК									
		EUR	76.6	235.0	2018.07.20	2026.08.05	245.1	ТҮЗ тогтоол	М.Баярмагнай (турбоагрегат 1, 2, 3) Б.Батбаяр (турбоагрегат 1, 4) Г.Амартувшин (турбоагрегат 2, 3)	
15	МОНГОЛ ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР ТӨХХК	MNT	162,739.0	162.7	2018.04.26	2028.04.26	162.7	ТҮЗ тогтоол	Б.Даажамба	Б.Батбаяр
16	ЭРДЭНЭС МОНГОЛ ХХК	MNT	170,595.5	170.6	2014.02.12	2028.12.12	141.4	ТҮЗ тогтоол	Б.Шинэбаатар	Н.Мөнхбат
17	ДОРНОД БУСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ ТӨХК	CNY	70.2	31.7	2021.10.28	2031.10.28	32.5	ТҮЗ тогтоол	С.Наранцогт	Н.Мөнхсүх
18	ЭГИЙН ГОЛЫН УСАН ЦАХИГЛААН СТАНЦ ТӨХХК	USD	10.6	21.5	2013.12.05	2021.03.31	33.1	ТҮЗ тогтоол	Б.Шинэбаатар Б.Даажамба (дахин санхүүжилт)	Н.Мөнхбат Б.Батбаяр (дахин санхүүжилт)
19	ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯМ	USD	14.8	25.0	2014.01.30	2022.06.10	46.2	ТҮЗ тогтоол	Б.Шинэбаатар	Н.Мөнхбат
20	ТОСК БҮ-1	MNT	84,700.0	84.7	2013.10.02	2022.10.02	69.1	ТҮЗ тогтоол	Б.Шинэбаатар	Н.Мөнхбат
	ТОСК БҮ-2	USD	35.5	70.0	2015.06.22	2022.06.01	73.6	ТҮЗ тогтоол	Б.Шинэбаатар	Н.Мөнхбат
	ТОСК Хөдлөлгөөнт	USD	7.1	14.2	2016.02.05	2019.08.30	19.3	ТҮЗ тогтоол	Б.Шинэбаатар	Н.Мөнхбат
21	ТОСК&ШИНЭ ЯАРМАГ /Шүүхийн шийдвэрээр ТОСК 24.6 тэрбум, Нью Яармаг хаусинг проект 61.2 тэрбум хариуцах/	USD	50.0	95.9	2015.05.28	2024.12.01	81.6	ТҮЗ тогтоол	Б.Шинэбаатар	Б.Батбаяр
22	ГАЗ-ИМПОРТ ХХК	JPY	223.6	4.9	2018.01.04	2021.01.04	5.2	ГЗ тушаал		Б.Батбаяр
23	ЗЭСТ-ӨНДЭР ХХК	JPY	439.4	9.7	2018.08.10	2023.08.10	11.4	ТҮЗ тогтоол	М.Баярмагнай	Б.Батбаяр
24	СОНГОУЛД ХХК	JPY	699.6	15.1	2017.12.28	2020.10.10	17.3	ТҮЗ тогтоол	Б.Даажамба	Б.Батбаяр
25	ЭНСАДА-ИСТЕРН ХХК	USD	9.8	25.2	2018.10.17	2025.10.17	26.9	ТҮЗ тогтоол	М.Баярмагнай	Б.Батбаяр
26	КОМПЛАНТ ХХК	MNT	2,820.0	2.8	2018.04.09	2021.04.09	1.7	ГЗ тушаал		Б.Батбаяр
27	МОННИС МАЙНИНГ ХХК	MNT	107,355.0	107.4	2019.08.07	2025.08.08	106.9	ТҮЗ тогтоол	М.Баярмагнай	Г.Амартувшин
28	НВЦ ХХК	USD	21.0	51.7	2017.09.15	2027.09.15	59.8	ТҮЗ тогтоол	Б.Даажамба	Б.Батбаяр
29	ТҮГЭЭМЭЛТҮМЭН ХИШИГ ХХК	MNT	18,517.3	18.5	2018.08.23	2023.08.23	18.5	ТҮЗ тогтоол	М.Баярмагнай	Б.Батбаяр Г.Амартувшин
30	ШАНХ МАЙНИНГ ХХК	MNT	5,600.0	5.6	2019.09.07	2024.09.07	5.6	ГЗ тушаал		Г.Амартувшин
31	БЭРЭН ГРУПП ХХК арматур	USD	27.2	55.3	2014.04.16	2022.10.15	84.9	ТҮЗ тогтоол	Б.Шинэбаатар М.Баярмагнай	М.Мөнхбат Б.Батбаяр
	БЭРЭН ГРУПП ХХК барилга	USD	11.7	28.5	2017.10.30	2020.10.23	32.7	ТҮЗ тэмдэглэл	Б.Даажамба	Б.Батбаяр
32	ДЭД БҮТЭЦ ИНЖЕНЕРИНГ ХХК	MNT	2,102.0	2.1	2018.09.17	2023.09.14	2.1	ГЗ тушаал		Б.Батбаяр
33	МОНГЕМА ХХК	JPY	419.3	9.1	2017.10.31	2024.10.25	11.5	ТҮЗ тогтоол	Б.Даажамба	Б.Батбаяр
34	ПИСИ ВАЙ ХХК	MNT	4,000.0	4.0	2018.06.13	2019.12.15	3.5	ГЗ тушаал		Ч.Энхбат

Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах Тур хороо

35	ПРОМОН ТРЕЙД ХХК	JPY	731.8	16.1	2017.07.31	2026.09.01	18.4	ТУЗ тогтоол	Б Даажамба	Б.Батбаяр
	ПРОМОН ТРЕЙД ХХК	MNT	2,000.0	2.0	2020.01.17	2026.09.01	1.3		М.Баярмагнай	Г.Амартувшин
36	АЧЛАЛ ТРЕЙД ХХК	USD	15.0	37.4	2017.10.13	2022.10.13	46.8	ТУЗ тогтоол	Б Даажамба	Б.Батбаяр
37	ИМПЕРИАЛГОУЛД МАЙНИНГ ХХК	MNT	16,000.0	16.0	2019.04.02	2022.04.02	15.6	ТУЗ тогтоол	М.Баярмагнай	Б.Батбаяр
38	КЬЮ ЭС СИХХК	USD	71.3	133.7	2014.12.03	2018.12.03	145.9	ТУЗ тогтоол	Б.Шинэбаатар	Н.Мөнхбат
39	МОНДУЛААН ТРЕЙД ХХК	MNT	15,000.0	15.0	2018.10.22	2021.06.22	13.7	ТУЗ тогтоол	М.Баярмагнай	Б.Батбаяр
40	ПИРАМИД-ОРД ХХК	MNT	15,000.0	15.0	2017.11.17	2021.11.17	15.0	ТУЗ тэмдэглэл	Б Даажамба	Б.Батбаяр
41	ХӨТӨЛХХК	USD	61.3	84.8	2012.10.19	2020.10.19	191.0	ТУЗ тогтоол	Б.Шинэбаатар	Н.Мөнхбат
42	ЭРЭЛХХК	USD	23.0	40.0	2013.08.20	2022.06.14	71.8	ТУЗ тогтоол	Б.Шинэбаатар	Н.Мөнхбат
	ЭРЭЛХХК	EUR	13.0	30.4	2014.06.06	2019.04.05	42.6			
43	МБҮ ТРЕЙД ХХК	MNT	11,500.0	11.5	2018.02.13	2023.02.13	11.5	ТУЗ тэмдэглэл	Б Даажамба	Б.Батбаяр
44	МОНГОЛДРАЙ МИЛК ХХК	USD	15.0	36.1	2017.05.18	2023.12.19	43.6	ТУЗ тогтоол	Б Даажамба	Б.Батбаяр
45	МОНПЕЛЛЕТС ХХК	EUR	0.7	1.9	2017.09.18	2023.09.01	2.0	ГЗ тушаал		Б.Батбаяр
46	ПЕТРОЛЕУМ ПРОДАКШН ХХК	MNT	11,493.5	11.5	2017.06.29	2022.06.28	8.9	ТУЗ тогтоол	Б Даажамба	Б.Батбаяр
47	СЭЭНГИЙН ГЕРЕФОРД ХХК	MNT	4,100.0	4.1	2018.08.24	2022.08.24	4.1	ГЗ тушаал		Б.Батбаяр
48	ХАТАНТ ИНТЕРНЭШНЛ ХХК	JPY	138.9	3.1	2017.09.12	2020.08.25	0.1	ГЗ тушаал		
	ХАТАНТ ИНТЕРНЭШНЛ ХХК	MNT	5,200.0	5.2	2018.06.04	2018.12.15	5.1			Б.Батбаяр
49	ЦЭЦЭНС МАЙНИНГ ЭНД ЭНЕРЖИ ХХК	EUR	30.0	85.9	2018.05.02	2026.05.02	55.0	ТУЗ тогтоол	Б Даажамба	Б.Батбаяр
	ЦЭЦЭНС МАЙНИНГ ЭНД ЭНЕРЖИ ХХК	JPY	2,199.7	49.2	2018.06.21	2026.05.02	31.9			
50	МОН ПАА ХХК	MNT	5,643.0	5.6	2014.08.11	2017.12.11	5.2	ТУЗ тогтоол	Б.Шинэбаатар	Н.Мөнхбат
51	МОНГОЛ МАХ ЭКСПО ХХК	MNT	31,897.0	31.9	2017.12.13	2022.12.13	28.6	ТУЗ тэмдэглэл	Б Даажамба	Б.Батбаяр
52	ЧИНГИС ХААН БАНК	MNT	13,009.1	13.0	2014.08.26	2019.12.27	0.9	ТУЗ тогтоол	Б.Шинэбаатар	Н.Мөнхбат
53	КАПИТАЛ БАНК	MNT	6,046.0	6.0	2014.09.08	2020.05.27	4.4	ТУЗ тогтоол	Б.Шинэбаатар	Н.Мөнхбат
	КАПИТАЛ БАНК	MNT	28,840.0	28.8	2014.09.18	2020.06.29	24.3	ТУЗ тогтоол	Б.Шинэбаатар	Н.Мөнхбат
	КАПИТАЛ БАНК	MNT	9,707.0	9.7	2015.08.25	2019.03.05	8.4	ТУЗ тогтоол	Б.Шинэбаатар	Н.Мөнхбат
	КАПИТАЛ БАНК	MNT	15,000.0	15.0	2015.10.14	2017.12.15	14.9	ТУЗ тогтоол	Б.Шинэбаатар	Н.Мөнхбат
54	БАРМОН ХХК	MNT	13,837.5	13.8	2019.01.25	2024.01.25	13.8	ТУЗ тогтоол	М.Баярмагнай	Б.Батбаяр
55	БОЛОР ШҮРХХК	JPY	104.8	2.3	2017.08.30	2017.12.08	2.3	ГЗ тушаал		Б.Батбаяр
56	ГАН ХҮДЭР ОРД ХХК	JPY	239.2	5.1	2017.07.06	2021.07.25	3.8	ГЗ тушаал		Б.Батбаяр
57	ИНЖИР ХХК	USD	2.0	4.8	2018.01.09	2023.01.09	6.1	ГЗ тушаал		Б.Батбаяр Г.Амартувшин
58	МОНГОЛ МИКРОН КАШИМЕР ХХК	MNT	5,000.0	5.0	2018.06.13	2019.12.15	-	ГЗ тушаал		Б.Батбаяр
	МОНГОЛ МИКРОН КАШИМЕР ХХК	JPY	454.8	10.0	2018.01.24	2025.01.24	9.8	ТУЗ тэмдэглэл	Б Даажамба	Б.Батбаяр
59	ЭРД ХУЛ ХХК	MNT	700.0	0.7	2017.08.30	2018.12.08	0.5	ГЗ тушаал		Б.Батбаяр
	<b>Нийт дүн</b>	-	<b>970,280.1</b>	<b>2,671.4</b>	-	-	<b>2,601.2</b>	-	-	-

## МУХБ-НЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙГДСЭН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ТОВЧОО

УИХ, ЗГ, ТҮҮНИЙ ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГААС ХИЙГДСЭН ШАЛГАЛТУУД (Ээлжит бус)

№	Шалгалт орсон он	Хяналт, шалгалтын нэр, төрөл	Шалгалт хамарсан хугацаа	Тайланг хүлээн авсан эсэх	Хариу арга хэмжээ, хэрэгжилтийн тайлан
---	------------------	------------------------------	--------------------------	---------------------------	--

## УЛСЫН ИХ ХУРАЛ

1	2016	УИХ-аас томилогдсон ажлын хэсгийн тайлан	Тодорхойгүй	Тайлан ирээгүй	-
2	2022	УИХ-аас томилогдсон ажлын хэсгийн тайлан	2011-2021.12.31	Тийм	✓

## ЗАСГИЙН ГАЗАР

1	2016	Засгийн газраас томилогдсон ажлын хэсгийн тайлан	2011-2016	Тийм	-
2	2019	Засгийн газраас томилогдсон ажлын хэсгийн тайлан	2011-2019	Тийм	✓

\*УИХ-аас томилогдсон ажлын хэсгийн тайлангаар өгсөн зөвлөмжүүдийн хэрэгжилтийг гаргах зорилгоор БТГХАлбанаас Төлөвлөгөөт бус шалгалт зохион байгуулж байна.

## МОНГОЛБАНКНААС ХИЙГДСЭН ШАЛГАЛТ (Ээлжит)

№	Шалгалт орсон он	Хяналт, шалгалтын нэр, төрөл	Шалгалт хамарсан хугацаа	Тайланг хүлээн авсан эсэх	Хариу арга хэмжээ, хэрэгжилтийн тайлан
1	2017.05.29	Хөгжлийн банканд хийсэн газар дээрх иж бүрэн шалгалтын танилцуулга	2011.03.25-2017.04.26	Тийм	✓
2	2018.11.27	МУХБ-нд хийсэн газар дээрх иж бүрэн шалгалтын танилцуулга	2017.04.26-2018.07.20	Тийм	✓
3	2020.05.15	МУХБ-ны үйл ажиллагаанд хийх хамтарсан (СЯ-тай) шалгалт	2019.02.21-2020.04.01	Албажаагүй	-
4	2021.12.13	МУХБ-нд хийсэн газар дээрх хэсэгчилсэн шалгалтын танилцуулга	2020.04.02-2021.07.31	Тийм	✓

## ҮАГ-ААС БҮРЭН ЭРХИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН ШАЛГАЛТ (ТӨЛӨВЛӨГӨӨТ)

№	Шалгалт орсон он	Хяналт, шалгалтын нэр, төрөл	Хамарсан хугацаа	Тайланг хүлээн авсан эсэх	Хариу арга хэмжээ, хэрэгжилтийн тайлан
1	2015	Хөгжлийн банкны эх үүсвэрийн ашиглалтыг сайжруулах шаардлагатай байна	2011.05.11-2014.12.31	Тийм	✓
2	2017	2015 онд “Засгийн газраас гаргасан үнэт цаас болон Чингис, Самурай бондын хөрөнгийн зарцуулалт, Хөгжлийн банкны хуулийн хэрэгжилт, Хөгжлийн банкны хэрэгжилтээр хэрэгжсэн төслийн үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд давтан аудит хийх	2011.05.11-2014.12.31	Тийм	✓
3	2019	МУХБ-ны үйл ажиллагаа, зээл олголтын үр дүн, эргэн төлөлтийн байдалд хийсэн гүйцэтгэлийн аудит	2012-2017	Тийм	✓
4	2021	Монгол Улсын Хөгжлийн банк ХХК-ийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан	2021.01.01-2021.12.31	Тийм	✓
5	2022	Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагааны үр нөлөө, үр ашигт хийсэн гүйцэтгэлийн аудит	2018-2021	Үгүй	Хойшилсон

**Хөндлөнгийн аудит (Тогтмол)**

№	Шалгалт орсон он	Шалгалт хийсэн байгууллагын нэр	Хяналт, шалгалтын нэр, төрөл	Хамарсан хугацаа	Тайлан байгаа эсэх
1	2011	УБ Аудит ХХК	Санхүүгийн тайлангийн хараат бус хөндлөнгийн аудит	2011.05.11-2011.12.31	Банкны тухайн жилийн тайланд тусгагдсан.
2	2012	УБ Аудит ХХК, Делоитт Онч Аудит ХХК	Санхүүгийн тайлангийн хараат бус хөндлөнгийн аудит	2012.01.01-2012.12.31	Банкны тухайн жилийн тайланд тусгагдсан.
3	2013	PWC Аудит ХХК	Санхүүгийн тайлангийн хараат бус хөндлөнгийн аудит	2013.01.01-2013.12.31	Банкны тухайн жилийн тайланд тусгагдсан.
4	2014	PWC Аудит ХХК	Санхүүгийн тайлангийн хараат бус хөндлөнгийн аудит	2014.01.01-2014.12.31	Банкны тухайн жилийн тайланд тусгагдсан.
5	2015	PWC Аудит ХХК	Санхүүгийн тайлангийн хараат бус хөндлөнгийн аудит	2015.01.01-2015.12.31	Банкны тухайн жилийн тайланд тусгагдсан.
6	2016	Делоитт Онч Аудит ХХК	Санхүүгийн тайлангийн хараат бус хөндлөнгийн аудит	2016.01.01-2016.12.31	Банкны тухайн жилийн тайланд тусгагдсан.
7	2017	Делоитт Онч Аудит ХХК	Санхүүгийн тайлангийн хараат бус хөндлөнгийн аудит	2017.01.01-2017.12.31	Банкны тухайн жилийн тайланд тусгагдсан.
8	2018	KPMG Аудит ХХК	Санхүүгийн тайлангийн хараат бус хөндлөнгийн аудит	2018.01.01-2018.12.31	Банкны тухайн жилийн тайланд тусгагдсан.
9	2018	KPMG Аудит ХХК	Санхүүгийн тайлангийн хараат бус хөндлөнгийн аудит	2019.01.01-2019.12.31	Банкны тухайн жилийн тайланд тусгагдсан.
10	2020	KPMG Аудит ХХК	Санхүүгийн тайлангийн хараат бус хөндлөнгийн аудит	2020.01.01-2020.12.31	Банкны тухайн жилийн тайланд тусгагдсан.
11	2021	KPMG Аудит ХХК	Санхүүгийн тайлангийн хараат бус хөндлөнгийн аудит	2021.01.01-2021.12.31	Банкны тухайн жилийн тайланд тусгагдсан.

**Хөндлөнгийн аудит (Тогтмол бус)**

№	Шалгалт орсон он	Шалгалт хийсэн байгууллагын нэр	Хяналт, шалгалтын нэр, төрөл	Шалгалт хамарсан хугацаа	Тайланг хүлээн авсан эсэх	Хариу арга хэмжээ, хэрэгжилтийн тайлан
1	2017.05.15	Делоитт Онч Аудит ХХК	Санхүүгийн байдалд хийсэн шинжилгээ	2012-2017	Тийм	✓
2	2018.12.04	PWC Аудит ХХК	МУХБ-ны үйл ажиллагааны дэлгэрэнгүй шинжилгээ	2012-2017	Тийм	✓

## МУХБ-наас шууд олгосон зээлийн гэрээний зориулалт, түүний хэрэгжилт

№	Зээлдэгчийн нэр	Олгосон дүн /тбм.төг/	Зээлийн гэрээнд заасан зориулалт	Тайлбар
1	БАГАНУУР ХК	18.6	"... зээлдэгчийн хэвийн үйл ажиллагааг хангахад шаардагдах тоног төхөөрөмж худалдан авах"	Зориулалтын дагуу
2	ГЕОЛОГИЙН ТӨВ ЛАБОРАТОРИ ТӨҮГ	0.4	"... Зээлдэгч тоног төхөөрөмжийн шинэчлэл хийхэд зориулагдана"	Зориулалтын дагуу
3	ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ ТӨХХ	31.7	"... Чойбалсангийн дулааны цахилгаан станцын хучин чадлыг 50 МВт-аар өргөтгөх төслийн санхүүжилт"	Зориулалтын дагуу
4	ДЦС-4 ТӨХХ	237.9	Турбоагрегат №1,2,3,4 шинэчлэлд зориулагдана	Зориулалтын дагуу
5	ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ГУРАВ ОНӨААТУГ	21.0	Цахилгаан автобусаар парк шинэчлэл хийх төсөл	Зориулалтын дагуу
6	МИАТ ТӨХХ	152.6	Боинг"-767-300ER загварын агаарын хөлөг худалдан авах	Зориулалт бүрэн бус
7	МОНГОЛ ГТБУ ҮЙЛДВЭР ТӨХХХ	165.3	Газрын тос боловсруулах үйлдвэр барих	Зориулалт бүрэн бус
8	ТОСК	181.9	Буянт-Хуаа 1, 2 болон аймаг бүрт 1000 айл орон сууц хөтөлбөрийн хүрээнд орон сууцны барилгын ажлыг санхүүжүүлэх	Зориулалт бүрэн бус
9	ТОСК ХӨДӨЛГӨӨНТ	14.2	"... худалдан авахаар төлөвлөж буй барилгын хийц үйлдвэрлэх хөдөлгөөнт цогцолбор (UBM) санхүүжүүлэх"	Зориулалтын дагуу
10	ЭГУЦС ТӨХХХ	21.5	Эгийн голын 315 МВт хучин чадалтай усан цахилгаан станцыг барьж ашиглалтад оруулах	Зориулалт бүрэн бус
11	ЭРДЭНЭС МОНГОЛ ХХК	170.6	"... Тавантолгой-Гашуунсуухайт чиглэлийн 245км авто замыг эзэмшиж, ашиглах эрх, "Энержи ресурс" ХХК-ийн өөрийн хөрөнгөөр барьсан Гашуунсуухайт боомтын хучин чадлыг нэмэгдүүлэх зориулалт бүхий дэд бүтцийг Эрдэнэс МГЛ ХХК-д шилжүүлэхтэй холбоотойгоор нөхөн олговор олгох"	Зориулалтын дагуу
12	ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ ХК	372.2	"... төмөр замын төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг эхлүүлэхэд шаардагдах санхүүжилт", "Засгийн газрын 2012 оны 148 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлд заасны дагуу", "Зээлдэгчийн үйл ажиллагааг дэмжих, нүүрсний экспортыг дэмжих зорилгоор дараах арилжааны банкуудын зээлийг дахин санхүүжүүлэх	Зориулалт бүрэн бус
13	ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ	25.0	Тавантолгойн нүүрсний орд газрыг түшиглэн 450 МВт хучин чадалтай цахилгаан станц барих төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардал болон Хавсралт 2-т заасан үйл ажиллагааг санхүүжүүлэх, талуудын хооронд байгуулсан 2013.05.10-ны өдрийн 3-ДЦ-Б 2013-20 дугаартай гэрээний дагуу олгосон 1.9 сая ам.долларын зээлийн үндсэн болон хүүгийн дахин төлбөрийг санхүүжүүлэх	Зориулалт бүрэн бус
14	БМНС ХХК	5.5	"Архангай аймгийн Цэнхэр сумын тутагт орших Өлшийт тээл алтны шороон ордыг ил аргаар ашиглах төсөл"-ийн хүрээнд хэрэгжүүлж буй ажлыг санхүүжүүлэхэд зориулагдана. Үүнээс өөр зориулалтаар ашиглахыг хориглоно.	Зориулалт бүрэн бус
15	БОЛОР ШҮР ХХК	2.3	"Гэрээний 1.2-д заасан төслийн тоног төхөөрөмж, эргэлтийн хөрөнгө болон үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх"	Нягтлах боломжгүй
16	БЭРЭН ГРУПП ХХК АРМАТИР	55.3	"Япон улсаас авах үндсэн тоног төхөөрөмжийн үнийн дүнгийн 20 хувь, туслах тоног төхөөрөмжийн гэрээний үнийн дүнгийн 80 хувь, үлдэх 20 хувийг нэхэмжлэлийн дагуу хэсэгчлэн санхүүжүүлэхэд зориулагдана."	Зориулалт бүрэн бус
17	БЭРЭН ГРУПП ХХК БАРИЛГА	28.5	Гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд "7 дугаар хорооллын 720 болон 120 айлын Ё блок" орон сууцны дуусаагүй барилгыг ашиглалтанд оруулахад шаардлагатай ажлын санхүүжилт.	Зориулалт бүрэн бус
18	ВЕРТЕКС МАЙНИНГ ПАРТНЕР ХХК	33.0	"Ухаа худаг төслийн уурхайн хөрс хуулалтын үйл ажиллагааг өргөтгөх, техникийн хучин чадлыг нэмэгдүүлэх төсөл"-д ашиглагдах техник, тоног төхөөрөмжийг худалдан авахад зориулагдана. Үүнээс өөр зориулалтаар ашиглахыг хориглоно.	Зориулалт бүрэн бус
19	ГАЗ-ИМПОРТ ХХК	4.9	Хаягдал баттерэйг дахин боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмж, уг тоног төхөөрөмжийн тээврийн зардал, тээврийн хэрэгсэл худалдан авах, төлбөрийг санхүүжүүлэх	Зориулалт бүрэн бус

Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах Түр хороо

20	ГАН ХҮДЭР ОРД ХХК	5.1	"Хорголжин төмрийн үйлдвэрийн төсөл"-ийг санхүүжүүлэхэд зориулагдана. Үүнээс өөр зориулалтаар ашиглахыг хориглоно.	Зориулалт бүрэн бус
21	ЗЭСТ-ӨНДӨР ХХК	9.7	"Ширэн овоо төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах төсөлд зориулагдана"	Зориулалт бүрэн бус
22	ИМПЕРИАЛ ГОУЛД МАЙНИНГ ХХК	16.0	Уурхайд ашиглах техник худалдан авах, Империал гоулд майнинг ХХК-ийн хөрөнгөд бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгийг компанийн өмчлөгчөөс худалдан авах. Уурхайн эргэлтийн хөрөнгөд болон алт баяжуулах үйлдвэрийн барилгын засварт зарцуулсан.	Зориулалт бүрэн бус
23	МАК ЦЕМЕНТ ХХК	133.2	"... Хөх цавын цементийн үйлдвэрийн төсөл санхүүжүүлэхэд зориулагдана"	Зориулалт бүрэн бус
24	МОН ЛАА ХХК	5.6	"... Зээлдэгч болон БНХАУ-ын "Шу гуан жиа гонг компанийн хооронд 2012.12.10-ны өдөр байгуулагдсан "Техник худалдах, худалдан авах гэрээ"-ний үний дүнгийн үлдэгдэл 50 хувийг санхүүжүүлэх"	Зориулалт бүрэн бус
25	МОНВАТТ ХХК	1.8	Улаанбаатар хотын агаарын бохирдлыг Эко тулгат төхөөрөмжийг ашиглан бууруулах төслийн тоног төхөөрөмж худалдан авах. Үүнээс өөр зориулалтаар ашиглахыг хориглоно.	Зориулалтын дагуу
26	МОНДУЛААН ТРЕЙД ХХК	15.0	Техникийн засвар, нарийвчилсан хайгуулын ажилд зарцуулах	Зориулалт бүрэн бус
27	МОННИС МАЙНИНГ ХХК	107.4	Зээлдэгчийн хэрэгжүүлэх "Эрдэнэс-Тавантолгой" херс хуулалтын үйл ажиллагааг өргөтгэх, техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэх" төсөлд ашиглагдах "Liebherr" R9250 загварын экскаватор 1 ширхэг, "Liebherr" R9350 загварын экскаватор 2 ширхэг "Liebherr" T264 загварын өөрөө буулгагч 10 ширхэгийг худалдан авах	Зориулалт бүрэн бус
28	МОНПОЛИМЕТ ХХК	126.6	"Монцемент төсөл"-ийг санхүүжүүлэх ..."	Зориулалт бүрэн бус
29	НВЦ ХХК	51.7	Хөдөө аж ахуй, шувууны гаралтай бүтээгдхүүн үйлдвэрлэлийн цогц төсөл-ийн хүрээнд хэрэгжих 4 дэд төслийн үйл ажиллагаанд шаардлагатай барилга байгууламж, тоног төхөөрөмж, эргэлтийн хөрөнгө, дахин санхүүжилтийн зардал	Зориулалт бүрэн бус
30	НЬЮ ХАППИ ХХК	2.1	Алт-2" үндэсний хөтөлбөрийн хүрээнд Хойт Баясгалангийн жалга-1, 2 алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн олборлолтод ашиглах экскаватор худалдан авахад зориулагдана. Үүнээс өөр зориулалтаар ашиглахыг хориглоно.	Нягтлах боломжгүй
31	СОНГОУЛД ХХК	15.1	Эрээний алтны үндсэн ордыг далд аргаар ашиглах төсөл	Зориулалт бүрэн бус
33	ФОРС ГОЛД МАЙНИНГ ХХК	2.3	Алт-2 үндэсний хөтөлбөрийн хүрээнд Завхан аймгийн Ургамал сумын нутагт Од нэртэй газар орших Цагаан толгойн алтны шороон ордыг ил аргаар ашиглах төсөл хэрэгжүүлэхтэй холбоотойгоор тоног төхөөрөмж худалдан авахад болон үйл ажиллагааны зардалд зориулагдана. Үүнээс өөр зориулалтаар ашиглахыг хориглоно.	Зориулалт бүрэн бус
34	ХААНЫ ХАРГУЙ ХХК	1.1	Дархан Уул аймгийн Хонгор сумын нутаг "Хуурай-1" гэдэг газар MV-020732 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй алтны шороон орд төслийн тоног төхөөрөмж, эргэлтийн хөрөнгө болон үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхэд зориулагдана. Үүнээс өөр зориулалтаар ашиглахыг хориглоно.	Нягтлах боломжгүй
35	ХАТАНТ ИНТЕРНЭШНЛ ХХК	3.1	"Хатант кашимер" төслийн түүхий эд бэлтгэх эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх	Зориулалт бүрэн бус
36	ХАТАНТ ИНТЕРНЭШНЛ ХХК	5.2	"Ноолуур үүн боловсруулах Хатант кашимер төсөл"-ийн эргэлтийн хөрөнгөд зарцуулагдах	Зориулалт бүрэн бус
37	ШАРЫН ГОЛ ХК	5.9	"төслийн хүрээнд техник худалдан авах, эргэлтийн хөрөнгө болон алтны ордын нөөц нэмэгдүүлэх ажлын санхүүжилтэд зориулагдана"	Зориулалт бүрэн бус
38	АЧЛАЛ ТРЕЙД ХХК	37.4	"300 ортой эмнэлгийн барилгын цогцолбор байгуулах"төслийн эмнэлгийн барилгын барилга угсралт, дахин санхүүжилт хийхэд зориулагдана	Зориулалт бүрэн бус
39	БИЙД МАЙНИНГ ХХК	1.2	Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын "Хужиртын хөндий" нэртэй газарт орших MV-017371 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн тоног төхөөрөмж, эргэлтийн хөрөнгө болон үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхэд зориулагдана.	Зориулалт бүрэн бус
40	ГОВЬ ХК	18.9	"Ноолуурган бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон борлуулалтыг нэмэгдүүлэх" төслийн хүрээнд түүхий эдийг бэлтгэх, эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэхэд зориулагдана.	Зориулалт бус

Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах Түр хороо

41	ГОВЬ ХК	48.0	Эргэлтийн хөрөнгө	зориулалт бус
42	ГОВЬ ХК	42.9	Ноолуурын түүхий эд бэлтгэх эргэлтийн хөрөнгөд зарцуулах.	зориулалт бус
43	ГОВЬ ХК	40.0	Ноолуур бэлтгэлийн зээлийн санхүүжилтэд зарцуулах	зориулалт бус
44	ДЭД БҮТЭЦ ИНЖЕНЕРИНГ ХХК	2.1	"Дэд бүтэц-Ухаалаг шийдэл" төсөлд зориулна	зориулалт бүрэн бус
45	ИЗИНС-ЭЙР ВЭЙЗ ХХК	22.9	B737-700 агаарын хөлөг түрээслэн авах, дахин санхүүжилт, нэмэлт шаардлагатай сэлбэг, эргэлтийн хөрөнгө худалдан авахад зориулагдана	зориулалт бүрэн бус
46	МАВАНГҮЙ ХХК	2.1	Өгөөмөр хотхоны 2 дугаар эзлэжийн 74A байрны барилгын ажилд зориулагдана.	зориулалт бүрэн бус
47	МОНГОЛ ЭМ ИМПЕКС КОНЦЕРН ХХК	7.3	"Хатуу тунгандсан эм болон дуслын шингэний үйлдвэр байгуулах" төсөлд зориулна.	зориулалт бус
48	МОНПЕЛЛЕТС ХХК	1.9	Хонины ноосон био бордооны үйлдвэрийн төслийн барилга байгууламж, тоног төхөөрөмж, эргэлтийн хөрөнгө, үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхэд зориулагдана	зориулалт бүрэн бус
49	ПЕТРОЛЕУМ ПРОДАКШН ХХК	11.5	"Хийн конденсат боловсруулах үйлдвэрийн өргөтгөл" төслийг санхүүжүүлэхэд зориулагдана	зориулалт бүрэн бус
50	ПИ АЙ ЭМ ЭМ ХХК	20.0	"Яармагийн гүүрний хажуу дахь 1152 айлын орон сууцны хороолол"-ын эхний ээлжинд баригдах 5 барилгын ажлын санхүүжилтэд зориулагдана	зориулалт бүрэн бус
51	ПИ АЙ ЭМ ЭМ ХХК	4.9	"Яармагийн гүүрний хажуу талын 1152 айлын орон сууцны барилгаас эхний ээлжийн 576 айлын орон сууц барих төслийн санхүүжилтэд зориулагдана.	зориулалт бүрэн бус
52	ПИ СИ ВАЙ ХХК	4.0	Эргэлтийн хөрөнгө	нягтлах боломжгүй
53	СОД МОНГОЛ ГРУПП ХХК	14.9	Тос тосолгооны материалын үйлдвэрийн төсөл. Үүнээс өөр зориулалтаар ашиглахыг хориглоно.	зориулалт бүрэн бус
54	ТИ ЖИ ВАЙ ХХК	0.9	"Эх булгын широон орд" төслийн тоног төхөөрөмж, эргэлтийн хөрөнгө болон үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхэд зориулагдана	зориулалт бүрэн бус
55	ТОСС&ШИНЭ ЯАРМАГ	95.9	"Шинэ Яармаг" орон сууцны хороолол барих төслийг санхүүжүүлэхэд зориулагдана.	зориулалт бүрэн бус
56	ТҮГЭЭМЭЛТҮМЭН ХИШИГ ХХК	9.1	"Тайван зогсоол" төсөлд зориулагдана	зориулалт бүрэн бус
57	ТҮГЭЭМЭЛТҮМЭН ХИШИГ ХХК	9.4	"Тайван зогсоол" төслийн 6 блок болон дэд бүтцийн барилгын санхүүжилтэд зориулагдана.	зориулалт бүрэн бус
58	ХАМТЫН ЭХ БУЛАГ ХХК	1.2	Булган аймгийн Бүрэгхангай сумын нутаг дахь "Туулын зүүн дэнж" алтны широон ордын үйл ажиллагааг эхлүүлэх тоног төхөөрөмж худалдан авах болон эргэлтийн хөрөнгийн санхүүжилэх	нягтлах боломжгүй
59	ХӨТӨЛ ХХК	84.8	Тоног төхөөрөмжийн үлдэгдэл санхүүжилт, төслийн барилгын ажил болон холбогдон гарсан бусад зардлыг дахин санхүүжүүлэх	зориулалт бүрэн бус
60	ШАНХ МАЙНИНГ ХХК	5.6	"Тээвэрчдийн хотхон" төслийн 1 дүгээр ээлжинд баригдах авто зогсоолын тохижилт, хяналтын төхөөрөмж, 5 амрах байр, 1 зоогийн газар, дэд бүтцийн барилгын санхүүжилтэд зориулагдана.	зориулалт бүрэн бус
61	ЭРЭЛ ХХК	24.3	"Байшин үйлдвэрлэх комбинат-1" төслийг санхүүжүүлэхэд зориулагдана.	зориулалт бүрэн бус
62	ЭРЭЛ ХХК	15.6	БҮК 1 төслийг санхүүжүүлэхэд зориулагдана.	зориулалт бус
63	ЭРЭЛ ХХК	30.4	БҮК-1 төслийн хүрээнд Зээлдэгчээс EBAWE Anlagentechnik GmbH компанитай байгуулсан тоног төхөөрөмж худалдах, худалдан авах гэрээний нийт үнийн дүнгийн 70 хувийг аккредитивын үйлчилгээ үзүүлэх нөхцлөөр санхүүжүүлэх, EULER HERMES компанид төлөх экспортын зээлийн даатгалын шимтгэл төлөх	зориулалтын дагуу
64	БАРМОН ХХК	13.8	"Шинэчлэл хороолол" төсөл	зориулалт бүрэн бус
65	ВЕСТЕРН ХОЛД ХХК	76.6	Ховд эко цемент төсөл	зориулалт бүрэн бус
66	ВОЯЖЕР МИНЕРАЛ РЕСУРСЕС ХХК	10.6	Хөхбулагийн алт, зэсийн үндсэн ордыг ил болон далд аргаар ашиглах	зориулалт бүрэн бус
67	ГОЁО ХХК	30.4	Тогтвортой ноолуурын үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх төсөл	зориулалт бус
68	ДАРХАН МИНЖ ХХК	2.1	"Монгол шир" төсөл	зориулалт бүрэн бус
69	ДОРНЫН ЦАС ХХК	3.5	"Хийт хөнгөн бетон гулдмайн үйлдвэрлэл"-ийг өргөжүүлэх төсөл	зориулалт бүрэн бус
70	ИНЖИР ХХК	4.4	"Экспортын наамал дүнз, евро стандартын модон барилга үйлдвэрлэх" төсөл	зориулалт бүрэн бус
71	ИНЖИР ХХК	0.4	"Экспортын наамал дүнз, евро стандартын модон барилга үйлдвэрлэх" төсөл	зориулалт бүрэн бус

Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах Түр хороо

72	КОМПЛАНТ ХХК	2.8	"Орчин үе гэр хорооллын хөгжил" төсөл	зориулалт бүрэн бус
73	КҮЮ ЭС СИ ХХК	133.7	Уул, уурхайн металургийн цогцолбор байгуулах төслийн хүрээнд 33.4 км төмөр зам барих ажлын санхүүжилт	зориулалт бүрэн бус
74	МАКС РӨҮД ХХК	71.8	Баянхонгор-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто замын төсөл	Зориулалтын дагуу
75	МБҮ ТРЕЙД ХХК	11.5	"Мал нядалж, мах бэлтгэх үйлдвэр", "Малын худалдааны төвлөрсөн зах" төсөл	зориулалт бүрэн бус
76	МОДУН ХХК	5.8	"Наран-Ухаа" бичил хорооллын төсөл	зориулалт бүрэн бус
77	МОНГЕМА ХХК	9.1	"Муур, нохойн тэжээл боловсруулах үйлдвэр"-ийн төсөл	зориулалт бүрэн бус
78	МОНГОЛ ДРАЙ МИЛК ХХК	36.1	"Монгол хуурай сүү" төсөл	зориулалт бүрэн бус
79	МОНГОЛ МАХ ЭКСПО ХХК	31.9	Мах боловсруулах цогцолбор төв байгуулах төсөл	зориулалт бус
80	МОНГОЛ МИКРОН КАШМЕР ХХК	5.0	"Самнасан ноолуур, ноолууран ээрмэл, сүлжмэл бүтээгдэхүүний ажлын капитал нэмэгдүүлэх төсөл" <small>(Ноолуур хөтөлбөр 2018-2021)</small>	зориулалт бүрэн бус
81	МОНГОЛ МИКРОН КАШМЕР ХХК	10.0	"Ноолууран ээрмэл, самнасан ноолуур, ноолууран сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх, экспортыг нэмэгдүүлэх төсөл"	зориулалт бүрэн бус
82	ПИРАМИД-ОРД ХХК	15.0	"Буман залуус" 296 айлын орон сууцны хорооллын төсөл	зориулалт бүрэн бус
83	ПРОМОН ТРЕЙД ХХК	16.1	"Малын гаралтай органик протейны үйлдвэрийн төсөл"	зориулалт бүрэн бус
84	ПРОМОН ТРЕЙД ХХК	2.0	"Малын гаралтай органик протейны үйлдвэрийн төсөл"	зориулалт бүрэн бус
85	СКАЙЛЭНД ЭНЕРЖИ ХХК	0.4	Дэвшилтэт техникиг бүхий эрчим хүчиний хэмнэлттэй халаагуур болон бойлуур үйлдвэрлэх төсөл	зориулалт бүрэн бус
86	СОР КАШЕМИР ХХК	4.1	Экспортын борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалт, эргэлтийн хөрөнгийн зээлийн төсөл <small>(“Ноолуур хөтөлбөр 2018-2021)</small>	зориулалт бүрэн бус
87	СТРОЙ-ИНВЕСТ ХХК	3.0	"Шинэ Эрдэнэт орон сууцны төсөл"	зориулалт бүрэн бус
88	СТРОЙ-ИНВЕСТ ХХК	1.2	"Шинэ Эрдэнэт орон сууцны төсөл"	зориулалт бүрэн бус
89	СЭЛЭНГИЙН ГЕРЕФОРД ХХК	4.1	"Мах бэлтгэл, кластерийн үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх" төсөл	зориулалт бүрэн бус
90	ЦЭЦЭНС МАЙНИНГ ЭНД ЭНЕРЖИ ХХК	85.9	"Бөөрөлжүүтийн нүүрсний уурхайг ашиглах" төсөл	зориулалт бүрэн бус
91	ЦЭЦЭНС МАЙНИНГ ЭНД ЭНЕРЖИ ХХК	49.2	"Бөөрөлжүүтийн нүүрсний уурхайг ашиглах" төсөл	зориулалт бүрэн бус
92	ЭЙЧ ЭНД ЭЙЧ РЕМИКОН ХХК	5.0	"Бетон зуурмагийн үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх" төсөл	зориулалт бүрэн бус
93	ЭНСАДА-ИСТЕРН ХХК	25.2	"Экспортод чиглэсэн гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэр" төсөл	зориулалт бүрэн бус
94	ЭРД ХУЛ ХХК	0.7	Их хэтийн ам ("Алт 2" үндэсний хөтөлбөр)	зориулалт бүрэн бус
<b>НИЙТ ДҮН</b>		<b>3,278.0</b>		

**БХБЯ, ЭХЯ-ны хэрэгжилт хангалтгүй байгаа төсөл, арга хэмжээний жагсаалт**

Төсөл, хөтөлбөрийн нэр	Гүйцэтгэгч	Тайлбар
Барилга, хот байгуулалтын яам		
Ирээдүй цогцолбор хорооллын 2 дугаар ээлжийн бохир усны ф150-450 мм-ийн голчтой 2200 м гол шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	Фамилии партнера ХХК	Уг төсөлд нийт 237.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон боловч НИТХТ-ийн 2016 оны 50 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан ундны эх үүсвэрийн хамгаалалтын бүсэд тус төслийн байршил орсон тул 85 хувийн гүйцэтгэлтэйгээр цаашид үргэлжлүүлэх боломжгүй болж 2016 оноос зогссон, цаашид үргэлжлүүлэх боломжгүй байна
"Яармаг" орон сууцны хорооллын цахилгаан хангамжид зориулан 10 кВ-ын түгээх сүлжээнд ойролцоо тооцоогоор 14.3 МВт чадлын хэрэглээг хангах 10 кВ-ын ХБ 3 иж бүрдэл, 2*400 кВА чадалтай ТП 36 иж бүрдэл, 37.6 км урт 10 кВ-ын кабель шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	Хасу Мегаватт ХХК	Төслийн хүрээнд баригдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулахад нэмэлт санхүүжилт шаардлагатай болсон бөгөөд төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилтийг 2022 оны төсвийн төсөлд тусгуулах саналыг яамны 2021.08.13-ны өдрийн 1/3248, 2023 оны төсвийн төсөлд тусгуулах саналыг яамны 2022.08.15-ны өдрийн 1/3787 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн боловч төсвийн хязгаараас шалтгаалан шийдвэрлэгдээгүй.
Яармагийн гүүр орчмын хорооллын дэд станцаас 10 кВ-ын 3 иж бүрдэл ХБ руу татах 12 км, 15 МВт чадлын хэрэглээг хангах кабель шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	Эрчим ХХК, Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ түншлэл	Гүйцэтгэгч компани барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн хэдий ч Их тойруу 110кВ-ын цахилгаан дамжуулах шугам ашиглалтад ороогүй байснаас шалтгаалан улсын комисст хүлээн аваагүй байна. Энэ хугацаанд кабель шугам тасрах, газрын трасс давхцах зэрэг асуудлууд үүссэн. Захиалагч гүйцэтгэгч болон "УБЦС"ТӨХК-тай асуудлыг хэлэлцэн шийдвэрт хүрч Яармаг Арцат дэд станцаас хүчдэлд залгасан боловч гэмтэл гарсныг засварлахаар ажиллаж байна.
Эрчим хүчний яам		
Ирээдүй цогцолбор хорооллын дулааны 4100 м гол шугам, 6 ш дулаан дамжуулах төвийн зураг төсөл, барилга угсралтын ажил	Меговатт ХХК	Нийт хийгдэх ёстой дулааны 4100м гол шугамын угсралтын ажил бүрэн дууссан боловч трассын дагуу 1219 метр газар шугамын хучилт, булалт далангийн ажил хийгдээгүй, 6 ширхэг тоноглол угсралдаагүй, 2016 оноос хойш барилга угсралтын ажил зогссон. Эрчим хүчний яамны нэхэмжлэлтэй хариуцагч "Меговатт" ХХК-д холбогдох иргэний хэрэг нь Хан-Уул дүүргийн анхан шатны шүүх дээр хянан шийдвэрлүүлэх процесс явагдаж байна. Санхүүжилт 92% хийгдсэн.
"ДЦС-4"-өөс "У-18" хүртэл (Москва хорооллын урд тал хүртэл) 4.2 км ф800-гийн голчтой дулааны шугамын барилга угсралтын ажил	БСД-ОД ХХК	Барилга угсралтын ажлын гэрээг нийт 5 удаа сунгасан. Гэрээний үнийг 16,972.6 сая төгрөг болгон нэмэгдүүлсэн. Гүйцэтгэг "БСД-Од" ХХК нь барилга угсралтын ажлыг дуусгаагүй тул ЭХЯ-аас шүүхэд нэхэмжлэл гаргасан. Шүүх хурлын ажиллагаа явагдаж байна.
Сонгинохайрхан дүүргийн 5, 6-р хороо-Ханын материал орчмын гэр хорооллын дулааны 2ф300/400 мм-ийн голчтой 1.1 км шугам, 1ш ус дулаан дамжуулах төв, ф150мм-ийн голчтой 137 м шугам, бие даасан 9.3 Гкал чадалтай дулааны эх үүсвэр, гадна төв бохир усны ф500 мм-ийн 1235 м шугам, бохир усны ф200-300 мм-ийн 1788 м шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	Есенталст оргил констракшн	Тухайн багц ажил нь 5 багц ажлыг гүйцэтгэхээр гэрээ байгуулсан бөгөөд дулааны 1.1 км шугам, гадна төв бохир усны 1235 м шугам, бие даасан 9.3 Гкал чадалтай дулааны эх үүсвэр барилга угсралтын ажил нь хийгдэж, улсын комисс хүлээн авсан, Үлдсэн 2 багц ажил нь газар чөлөөлөлтийн асуудлаас болж хийгдээгүй тул одоогоор гэрээ дүгнэж эцсийн тооцоо хийгээгүй байна.

**НХОГ-т хэрэгжилт хангалтгүй байгаа төсөл, арга хэмжээний жагсаалт**

<b>Төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн нэр, байршил, хүчин чадал</b>	<b>Гүйцэтгэгч компани</b>	<b>Төсөөт өртөг</b>	<b>Нийт олгосон</b>	<b>Ажлын гүйцэтгэл /2022.12.31/</b>
14 дүгээр хороолол, Зүүн хүрээ хорооллын цахилгаан хангамжид зориулан 10 кВ-ын түгээх сүлжээнд 22.0 МВт чадлын хэрэглээг хангах 10 кВ-ын ХБ 4 иж бүрдэл, ХТП 18 иж бүрдэл, 10 км урт 10 кВ-ын кабель шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	Моннис урбан девелопмент ХХК, Бүрд констракшн ХХК, Эрчим концэрн ХХК, Шугам ХХК-ийн түншлэл	7,137.0	3,555.7	58%
Орон сууцны 14 дүгээр хорооллын ф125-300 мм-ийн 4.57 км дулааны шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	Моннис урбан девелопмент ХХК, Бүрд констракшн ХХК, Эрчим концэрн ХХК, Мон-Энержи консалт ХХК-ийн түншлэл	5,369.0	2,332.0	60%
Орон сууцны 14 дүгээр хорооллын 4ш ЦТП, ф100-250 мм-ийн 3.34 км цэвэр усны шугам, 4 ш насос станц, усан сангийн зураг төсөл, барилга угсралтын ажил	Моннис урбан девелопмент ХХК, Бүрд констракшн ХХК, Ухат ХХК-ийн түншлэл	1,596.0	387.8	70%
Цэвэр усны ф32/150 мм-ийн голчтой 1400 м шугамын барилга угсралтын ажил	Асар өргөө ХХК, Буурал сутай ХХК	182.0	105.9	75%
Дулааны ф65/200 мм-ийн голчтой 924 м шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	Назу проперти ХХК, Ховдын тулга ХХК, Дорнын талст ХХК түншлэл	754.0	226.2	2%
Усан хангамж ф32/150 мм голчтой 871 м шугам, ариутгах татуургын ф150/300 мм-ийн голчтой 3100 м шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	Назу проперти ХХК, Ховдын тулга ХХК, Дорнын талст ХХК түншлэл	858.0	270.3	22%
Дулаан хангамжийн эх үүсвэр, уурын зуухны барилга-2ш, хатуул түлшний халаалтын тогoo-6ш, хэрэгцээний халуун усны ялтсан солилцуур-2 ком-ын барилга угсралтын ажил	Асар өргөө ХХК, Буурал сутай ХХК, БЧГ ХХК	873.0	-	75%

**Төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон зээлийн үйл ажиллагаанд мөрдсөн эрх зүйн зохицуулалтын талаар\***

- Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт "Хөгжлийн банкнаас сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн санхүүжүүлэх төсөл, хөтөлбөр нь дараах шаардлагыг хангасан байна гэж заасан болоч бусад заалтаар сонгон шалгаруулалттай холбоотой зохицуулалт байхгүй байх тул МУХБ-ны санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийг ямар арга замаар, ямар шалгуур үзүүлэлтийг баримтлан, хэн сонгон шалгаруулалт хийх асуудал хуулийн нарийвчилсан зохицуулалтгүй байжээ.
- Төсөл хөтөлбөрийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан төслийн нэгжүүд нь ТБОНӨХБАҮХАТХ-д оруулсан нэмэлтийг үндэслэн Эдийн засгийн хөгжлийн сайдын баталсан болон бусад хуулиар тусгайлан эрх олгогдоогүй журмуудыг баримтлан сонгон шалгаруулалт явуулсан байна.
- Засгийн газрын 2013 оны 81 дүгээр тогтоолоор "Гудамж" төслийн эхний ээлжийн санхүүжилтийг ЗГҮЦ-ыг арилжаалж бүрдүүлсэн хөрөнгөөс Хөгжлийн банкаар дамжуулан 200.0 сая ам.доллартай тэнцэх хэмжээний төгрөгийг төсөл, арга хэмжээ тус бүрээр бус нийт дүнгээр баталсан нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.4 дэх заалтыг зөрчсөн бөгөөд тухайн ажлуудын зураг, төсөв хийгдээгүй, төсөөт өртөг тодорхойгүй байсантай холбоотой байна.
- ЭЗХС-ын 2013 оны 29 дүгээр тушаалаар баталсан түр журам нь захиргааны хэм хэмжээний актаар бүртгэгдээгүй байсан тул Засгийн газрын 119 дүгээр тогтоолоор батлагдсан Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журмыг зөрчсөн тул тус түр журмыг эрх зүйн чадамжгүй байсан гэж үзэхээр байна.
- Уг түр журмын 7.2.1-т "үнэт цаасны хөрөнгөөр нийлүүлэгдэх бараа, ажил, үйлчилгээ гүйцэтгэхээр саналаа ирүүлсэн этгээдүүдээс төслийн захирал дор дурдсан шалгуурыг хангасан 2-оос доошгүй этгээдүүдийг сонгон ТУХ-нд танилцуулж шийдвэрлүүлэн зөвшөөрөл авсны үндсэн дээр Хөгжлийн банк, төслийн гүйцэтгэгчтэй гурвалсан гэрээ байгуулан үйл ажиллагааг гүйцэтгүүлэх, өдөр тутмын хяналт тавих" гэж заасан хэдий ч энэхүү журмаар төсөл, хөтөлбөрийн сонгон шалгаруулалтыг хийх асуудлыг зохицуулаагүй байна.
- ЭЗХС-ын 2013 оны "Түр журам батлах тухай" 29 дүгээр тушаал нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.1 дэх хэсэг, Гадаадын зээл, тусlamжийг зохицуулах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг үндэслэл болгон баталсан нь Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолоор баталсан "Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журам"-ын 1.3-т "Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг эрх бүхий этгээд нь зөвхөн хуулиар эрх олгогдсон тохиолдолд гаргана" гэж заасныг болон 1.7.2-т "Тэмдэглэх хэсэгт үндэслэл болгож байгаа хуулийн заалтыг заавал дурдсан байх" гэж заасан шаардлагыг хангаагүй байна.
- Тушаалын хавсралтын 6.4-т "Төслийн удирдах хороо нь дараах эрхийг эдэлнэ", 6.4.5-д "Төслийн санхүүжилт нь МУХБ-аар хийгдэх тул үнэт цаасны хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаа нь ТБОНӨХБАҮХАТХ-иар зохицуулагдахгүй тул гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах асуудлыг төслийн захирлын танилцуулсан саналыг хэлэлцэж шийдвэрлэх" гэж зааж хуулиар тусгайлан эрх олгогдоогүй асуудлаар албаны бүрэн эрхээ хэтрүүлж хэм хэмжээ тогтоосон байна.

\* - Эх сурвалж: Засгийн газрын 2016 оны 36 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн шалгалтын тайлан

**Монгол Улсын 2015, 2016 оны төсвийн тухай хуулийн хүрээнд БХБЯ-нд хэрэгжсэн төсөл, арга хэмжээний жгсаалт**

Төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн нэр, байршил, хүчин чадал	Төсөвт өртөг	Олгосон санхүүжилт
Үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтцийн суурь мэдээллийг бий болгох /улсын хэмжээнд/	8,835.3	7,854.1
Инженерийн шугам сүлжээ /Хэнтий, Хэрлэн сум/	2,124.3	2,124.3
Аймгийн төвийн 1000 айлын орон сууцны хорооллын инженерийн шугам сүлжээ /Баянхонгор, Дорноговь, Төв, Говьсүмбэр, Булган, Увс, Хөвсгөл, Дархан-Уул, Орхон, Сүхбаатар, Өвөрхангай, Өмнөговь, Хэнтий/	22,032.5	19,754.0
Сумын төвийн шинэчлэл төсөл /Архангай, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Өвөрхангай, Дорнод, Дундговь, Завхан, Сүхбаатар, Сэлэнгэ, Өмнөговь, Төв, Увс, Ховд, Хэнтий, Хөвсгөл аймагт тус бүр нэг сум/	18,181.7	14,986.5
Шинээр тавихаар төлөвлөж байгаа төмөр замын дагуу GPS-ийн сүлжээ байгуулах, 1:25000 масштабтай байр зүйн зураглал хийх /11 аймагт/	10,708.5	6,968.4
Гэр хорооллын инженерийн шугам сүлжээ /Хөвсгөл, Мөрөн сум/	3,000.0	1,570.2
Дэд бүтцийн инженерийн шугам сүлжээний өргөтгөл /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	2,829.0	2,424.7
Хорооллын гадна шугам сүлжээний өргөтгөл /Дорнод, Хэрлэн сум/	4,000.0	1,000.0
Цэвэр, бохир усны шугам сүлжээ, усан сан, насосны станц, цэвэрлэх байгууламжийн өргөтгөл, шинэчлэлт /Улаанбаатар, Багахангай дүүрэг/	5,600.3	4,380.1
Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжид 2 дугаар тунгаагуур 2 ширхэг, биоцөөрөм барих /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	5,135.3	4,196.3
Нийтийн зориулалттай орон сууцын цахилгаан шатны шинэчлэл, засварын цех /Улаанбаатар/	4,989.8	2,083.6
Газар хөдлөлийн гамшгийн эрсдлийг бууруулах ажлын хүрээнд инженерийн барилга байгууламж, шугам сүлжээний мэдээллийн сан байгуулах	1,000.0	980.1

**Монгол Улсын 2015, 2016 оны төсвийн тухай хуулийн хүрээнд ЭХЯ-нд хэрэгжсэн төсөл, арга хэмжээний жгсаалт**

Төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн нэр, байршил, хүчин чадал	Төсөвт өртөг	Олгосон санхүүжилт
Баруун-Урт-Асгат-Эрдэнэцагааны 35 кВ-ын 197 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц /Сүхбаатар/	5,400.0	4,110.3
Хорооллын гадны цахилгаан хангамж /Дархан-Уул, Дархан сум, 11, 12, 24, 25, 26 дугаар хороолол/	6,206.6	6,206.6
Хорооллын гадны цахилгаан хангамж /Дархан-Уул, Дархан сум, 2, 3 дугаар хороолол/	3,469.0	3,469.0
Томоохон баг, суурин газруудыг эрчим хүчээр хангах, сумдын 0.4 кВ-ын өргөтгөл, шинэчлэлт /улсын хэмжээнд/	12,469.2	11,359.5
Мардай-Чулуунхороот сумын 35 кВ-ын 160 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц /Дорнод/	3,358.5	3,116.2
Дарханы дулааны цахилгаан станцад хаягдал үнсэн сан шинээр барих /Дархан-Уул/	5,147.5	5,147.5
Эрчим хүчний төвлөрсөн системд холбох, 3 сум /Дорноговь, Хатанбулаг, Мандах сум, Говь-Алтай, Бугат сум/	11,928.0	11,666.4
Төв аймгийн шинэ суурьшлын бүсийн хэрэглэгчдийн цахилгаан хангамжийг сайжруулах /Төв/	2,123.0	1,773.5
Үйлдвэрийн районы 35 кВ-ын 35/6 кВ-ын 2x6300 кВА дэд станц, 35 кВ-ын хуурай салгуурын пунктын өргөтгөл /Дархан-Уул/	2,004.0	2,001.9
Аймгийн төвийн 6 кВ-ын цахилгаан хуваарилах байгууламжийн шинэчлэл /Баян-Өлгий, Өлгий сум/	1,578.1	1,426.6
Багануур-Цэнхэрмандалын 35 кВ-ын цахилгаан дамжуулан агаарын шугам, дэд станц /Хэнтий/	3,415.8	2,862.9
Төвлөрсөн дулаан хангамжийн шугамын шинэчлэл /Хөвсгөл, Мөрөн сум/	725.2	720.5
Гэр хорооллын хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангах /Баян-Өлгий, Өлгий сум/	995.0	497.5

Гэр хорооллын хүчдэлийн уналттай болон шинэ суурьшлын бүсийн гэр хорооллын айл өрхийг цахилгаан хангамжаар хангах /УБ/	6,542.9	6,470.5
Залаат, Бага тэнгэр, Их тэнгэрийн ам, Хан-Уул, Баянзүрх дүүргийн хорооллуудын цахилгаан дамжуулах агаарын шугам /УБ/	4,469.3	4,468.9
Умард дэд станцаас кабель шугам татах 6 дугаар бичил хороололд шинээр 10 кВ-ын хуваарилах байгууламж барих /Улаанбаатар/	1,420.8	1,373.4
35/6 кВ-ын Баянхошуу 2x10 МВА чадалтай шинэ дэд станц барьж, 35 кВ-ын 7.2 км 2 хэлхээ цахилгаан дамжуулах агаарын шугам татах /Улаанбаатар/	1,221.1	1,120.5
Улаанбаатар хотын төвийн 6, 10 кВ-ын кабель шугамын шинэчлэлт /Улаанбаатар/	3,749.1	3,738.9
12 а магистралийн ТК-1211 цэгээс урагш гарсан 2 ф 400 мм голчтой шугамын 2 ф 500 мм болгон өргөтгөх, 3x500x70 хүчин чадалтай шинээр дараалт өргөх насос станц барих, зургийн хамт /Улаанбаатар/	7,296.0	5,698.7
5В магистраль Тк-1893-с Континенталь зочид буудлын баруун талын уулзвар хүртэлх 2100 метр 2x500 мм-ийн шугамыг 2x800 мм болгон өргөтгөх /Улаанбаатар/	2,905.3	2,853.0
1в магистралийн Тк-1893-с Тк-117 цэг хүртэлх 1500 метр 2x500 мм-ын шугамыг 2x700 мм шугам болгон өргөтгөх /Улаанбаатар/	1,498.6	1,498.6
Багануурын дулааны станцын сүлжээний усны зарцуулалт хувьсах насосны горимд шилжих /Улаанбаатар, Багануур дүүрэг/	1,600.0	1,599.9
Дулааны цахилгаан станц 2-ын Р-4 /АК-6/ турбины шинэчлэлийн ажил /Улаанбаатар/	1,428.9	1,428.9
Дулааны станцын КВТС-10/150 зуух барих /Улаанбаатар, Налайх дүүрэг/	856.3	853.7
Дулааны станцын дулаан хангамжийн нэгдсэн системийг үл хамаарах схемд шилжүүлэх, үндсэн магистрал шугам сүлжээг шинэчлэх /Улаанбаатар, Багануур дүүрэг/	1,138.3	956.1

## Хавсралт 9

## Авто замын салбарт хэрэгжилт хангалтгүй байгаа төсөл, арга хэмжээний жагсаалт

Төсөл	Гүйцэтгэгч компани	Төсөвт өртөг	Олгосон санхүүжилт	Тайлбар
Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 27 км авто замын барилга	"Хансуун зам" ХХК	14,254.13	14254.1	ЗТХЯ-ны ТНБД-ын 2017.12.12-ны өдрийн 404 дүгээр тушаалаар комисс ажилласан боловч зураг төсөл, техникийн шаардлага хангаагүй улмаас байнгын ашиглалтад оруулаагүй тул гэрээг цуцалж 4,6 тэрбум төгрөгийг нэхэмжилсэн. Шүүхийн шатанд явж байгаа.
Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 50 км авто замын барилга	"Чайна гео инженеринг" ХХК	12,565.16	6660.04	ЗТЯ-ны /хуучнаар/ ТНБД-ын 2014.10.14-ний өдрийн 435 дугаар тушаалаар комисс ажиллаж зураг төсөл, техникийн шаардлага хангаагүй тул байнгын ашиглалтад ороогүй. Шинэчилсэн гэрээний эхлэх хугацаа 2014.08.28 №С-А3-Б2014-135/16. Нийслэлийн Иргэний хэргийн Давж заалдах шатны шүүхэд гомдол гаргаж 2022 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 210/МА2022/00930 дугаар магадлалаар "Хариуцагч Чайна гео инженеринг ХХК-иас 7,492,132,492.2 төгрөгийг гаргуулах"-аар шийдвэрлэсэн байсан нь 2022 онд эзэслэгдсэн.
Хужирт-Төвхөн Хийд-Улаанцутгала н чиглэлийн авто зам барилга 90.1 км	БНХАУ-ын Металл хийц зам барилгын 11-р ХХК	43,852.67	3,065.9	Гэрээ цуцлагдсан. Энэ талаар ЗТХЯ-наас тайлбар ирүүлээгүй
Ховд-Улаангом чиглэлийн авто замын зураг 190 км	"Гео зураглал" ХХК	475.00	458.3	ЗТХЯ-наас тайлбар ирүүлээгүй

**"Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"-д заасан I, II үе шатны төмөр замын суурь бүтцийг барих ажлын хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлын жагсаалт**

Aжил	Нийт дүн сая төгрөг	Нийт дүн сая ам.доллар	Үндэслэл
<b>Хээрийн судалгааны ажил (Даланзадгад-Чойбалсан 1.165 км)*</b>			
1 Геодези	5,892.6	4.2	"Монголын төмөр зам" ТӨХК, "Геомастер" ХХК-тай 2011.03. 11-ний өдөр байгуулсан 1/001 дүгээр дугаар гэрээ (Ажлын даалгаврыг БНБД 11-07-04 дагуу боловсруулсан)
2 Геологи	5,367.2	3.8	"Монголын төмөр зам" ТӨХК, "Экогидро гео" ХХК-тай 2011.03.11-ний өдөр байгуулсан 1/002 дугаар гэрээ (Ажлын даалгаврыг БНБД 11-07-04 дагуу боловсруулсан)
3 БОНУ	1,037.4	0.7	"Монголын төмөр зам" ТӨХК, "Найчрал Саастайнэблэ" ХХК-тай 2011.03.11-ний өдөр байгуулсан 1/003 дугаар гэрээ
<b>Туршилтын хөрс хуулалт (нийт 100 км)**</b>			
1 Хөрс хуулалт	5,156.1	3.7	"Монголын төмөр зам" ТӨХК, "Транскон" ХХК-тай 2011.04.25-ны өдөр байгуулсан 1/008 дугаар гэрээ
2 Хөрс хуулалт	4,849.3	3.5	"Монголын төмөр зам" ТӨХК, "Кэй Эйч Эн Ар" ХХК-тай 2011.04.25-ны өдөр байгуулсан 1/006 дугаар гэрээ
<b>Урьдчилсан ТЭЗҮ</b>			
1 Хаан банкны үндсэн зээл	7,861.0	5.6	ЗТБХБ-ын сайд, ТӨХ-ны даргын 30/24 дүгээр хамтарсан тушаал, "Монголын төмөр зам" ТӨХК-ийн ТҮЗ-ийн 23 дугаар шийдвэрийн дагуу "Маккинсэй" компанитай байгуулсан 2011.04.07-ны өдрийн гэрээ болон ТӨХ-ны 2011.03.17-ны өдрийн 107 дугаар тогтоол, "Монголын төмөр зам" ТӨХК-ийн ТҮЗ-ийн 2011.04.01-ний өдрийн 24 дүгээр тогтоолын дагуу "Хаан" банктай байгуулсан 2011 оны 3Г-11/108/03 дугаар гэрээ
2 Хаан банкны хүү	1,162.7	0.8	
<b>Нийт дүн</b>	<b>31,326.3</b>	<b>22.5</b>	

\* - Монголын төмөр зам ТӨХК нь Чойбалсан – Хөөт, Баруун-Урт – Сайншанд, Зүүнбаян – Даланзадгад чиглэлийн БОНУ, инженер-геологи геотехникийн ажил, геодезийн судалгааны ажил гүйцэтгэх гэрээг Геомастер, Найчрал саастайнэбл, Эко гидро гео компаниудтай 2011 онд байгуулсан байна.

\*\* - Дээрх трассын төмөр замын төслийн санхүүжилт шийдвэрлэгдээгүй байхад Дорнод аймгийн Булган сумын нутагт 50 км төмөр замын хөрс хуулах ажлын 5.1 тэрбум төгрөгийн гэрээг Транскон ХХК-тай, Сүхбаатар аймгийн нутагт 50 км төмөр замын хөрс хуулах ажлын 4.8 тэрбум төгрөгийн гэрээг Кэй Эйч Эн Ар ХХК-тай 2011.04.25-ны өдөр тус тус байгуулж, ажлыг эхлүүлж байжээ.

## Арилжааны банкуудаар дамжуулан олгосон зээлийн мэдээ

№	Төсөл хөтөлбөрийн нэр	ЗГ-ын тогоо	Зээлдэгчийн нэр	Дамжуулан зээлдүүлсэн банк	Дамжуулан зээлийн хүү /хувь/	Дэд зээлийн хүү /хувь/	Эх үүсвэр (2016 онд ЗГ- ын ажлын хэсээт өгсөн ангиллыг үндэслэв)		Барь- цааны терөл	Хугацаа		2012-2021 онд олгосон	
							нэр	хүү		Эхлэх	Дуусах	Дэд зээл тоо	Санхүүж- сэн дүн
<b>A ХУУЧИН ХУУЛИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН</b>													
1	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих замаар ажлын байр нэмэгдүүлэхэд чиглэсэн төсөл	2012-138	ЖДҮХСан (ХХБ, Голомт, Чингис хаан, Хаан банк, УХОБ, УБХБ, Төрийн банк, Хасбанк, Капитрон банк, Капитал банк)	10 банк	7.38	9.0	Евро бонд Самурай бонд (36.3 тэрбум)	5.75% 1.52%	АБ-ны баталгааны гэрээ	2012.07.17	2017.12.29	151	48,969.1
2	ХАА, хөнгөн үйлдвэрийн ноос, ноолуур, сүү, хүлэмж болон оёдлын салбарын төсөл	2013-126	Голомт банк	1 банк	5.125 дэд зээлд 5.7 дэд зээлд олгоогүй хэсэгт	8.0	Чингис бонд	4.792%	АБ-ны энгийн вексель	2013.08.15	2017.12.01	168	269,030.3
3	Арьс, ширийг дотооддоо гүн боловсруулах болон түүгээр бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үндэсний үйлдвэрлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгох төсөл	2014-217	ХХБ, УБХБ, Капитал банк, УХОБ, Капитрон банк, Голомт банк, Хасбанк, Төрийн банк, Чингис хаан банк	9 банк	5.0	7.0	Кредит Свисс банкны хамтарсан зээл	4.375% + 6M лайбор		2014.08.22	2021.06.25	57	85,709.7
4	Экспортыг дэмжих, импортыг орлох үйлдвэрлэлийн 888 төсөл /2 тэрбуунаас дээш/	2014-212	ХХБ, УБХБ, Хаан банк, Капитал банк, УХОБ, Капитрон банк, Голомт банк, Хасбанк, Төрийн банк	9 банк	5.0	9.0	Кредит Свисс банкны хамтарсан зээл	4.375% + 6M лайбор		2014.09.12	2020.06.29	39	184,252.1
5	Экспортыг дэмжих, импортыг орлох үйлдвэрлэлийн 888 төсөл /2 тэрбуунаас доош-ЖДҮХС/	2014-176	ЖДҮХСан (ХХБ, Голомт банк, Чингис хаан банк, Хаан банк, УХОБ, УБХБ, Төрийн банк, Хасбанк, Капитрон банк, Капитал банк)	10 банк	5.0	7.0	Евро бонд	5.75%	АБ-ны баталгааны гэрээ	2014.08.25	2020.07.30	655	99,982.0

6	Жижиг, дунд үйлдвэрийн 70.0 тэрбум төгрөгийн дамжуулан зээл*	2015-66	ХХБ, УБХБ, Капитал банк, УХОБ, Голомт банк, Хасбанк, Төрийн банк, Хаан банк, Ариг банк	9 банк	6.0	9.0	Кредит Свисс банкны хамтарсан зээл	4.375% + 6M лайбор	АБ-ны энгийн вексель	2015.08.24	2019.03.05	406	69,964.9
7	Ноолуурын салбарт эргэлтийн хөрөнгийн зориулалттай олгох хөнгөлөлттэй зээл	2015-149, 2015-171	ХХБ, УБХБ, Капитал банк, Голомт банк, Хас банк, Хаан банк	6 банк	6.0	9.0	Чингис бонд (2015, 2016 оны 56.2) Төрийн хөрөнгө (2017 оны дахин санхүүжилт 18.64 тэрбум)	4.792%		2015.07.01	2018.12.25	11	74,857.5
8	Үйлдвэрлэлийн чиглэлийн экспортыг дэмжих, импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх төсөл	2015-312	ХХБ, УБХБ, Голомт банк, Хаан банк, УХОБанк, Төрийн банк	6 банк	6.0	9.0	Кредит Свисс банкны хамтарсан зээл	4.375% + 6M лайбор		2015.11.04	2022.09.12	18	121,905.0
9	ACEM Вилла цогцолбор хотхон	2015-331	ХХБанк	1 банк	4.5	(8.0 (60 тэрбум) 13.0 (65 тэрбум))	ACEM Дотоодын үнэт цаас	4.0%		2015.09.25	2021.12.14	1	125,000.0
10	Ази, Европын дээд түвшний 11 дүгээр уулзалтад оролцох төлөөлөлгчдийг байрлуулах зочид буудлын дамжуулан зээл	2015-226	ХХБанк, УБХБанк, Голомт банк, Хаан банк, Төрийн банк	5 банк	4.5	4.5+үнэт цаасны өртгөөс хамаарсан маржин	ACEM Дотоодын үнэт цаас	4.0%		2015.12.25	2019.05.09	15	108,425.4
11	Тайж групп ХХК-ийн хэрэгжүүлсэн "Max боловсруулах үйлдвэрийн төсөл"	2015-319	Голомт банк	1 банк	13.15	13.5+(4%-аас ихгүй маржин)	ОУХОБанкны зээл	4.375% + 6M лайбор		2016.03.25	2020.02.28	1	4,500.0
12	Max хөтөлбөр	2015-321 2015-492	ХХБанк, Голомт банк, Хаан банк	3 банк	9.5	9.5+(3%-аас ихгүй маржин)	Кредит Свисс банкны хамтарсан зээл	4.375% + 6M лайбор		2016.06.17	2018.06.18	10	24,996.4
13	Газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтвортжуулах багино хугацааны хөтөлбөр	2016-42	ХХБанк, Голомт банк, Хаан банк, Төрийн банк, Капитрон банк	5 банк	9.0	12.5	Кредит Свисс банкны хамтарсан зээл	4.375% + 6M лайбор		2016.05.25	2018.12.03	93	24,298.0

Б ШИНЭ ХУУЛИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН											
№	Олонийн салбарт эргэлтийн хөрөнгийн зориулалттай олгосон "Ноолуур" хөтөлбөр (2018)	ХХБанк, Голомт банк, Хаан банк, Капитрон банк, Хасбанк	5 банк	10.0	12.0-13.0	Банкны татан төвлөрүүлсэн эх үүсвэр	АБ-ны энгийн вексель	2018.06.29	2019.12.15	18	97,776.6
								2019.06.14	2021.12.27	14	65,060.0
14	Олонийн салбарт эргэлтийн хөрөнгийн зориулалттай олгосон "Ноолуур" хөтөлбөр (2019)	ХХБанк, Голомт банк, Хаан банк	3 банк	10.0	12.0-13.0	Банкны татан төвлөрүүлсэн эх үүсвэр					
15	Олонийн салбар дэмжих хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл "Ноолуур" хөтөлбөр (2020 Ковидын үеийн хөнгөлөлттэй нөхцөлтэй)	Голомт банк, Хаан банк, Төрийн банк, Капитрон банк	4 банк	1.0	3.0	Банкны татан төвлөрүүлэх эх үүсвэр (эх үүсвэрийн хэмжээ шууд болон дамжуулан санхүүжилтийн нийлбэр дун 300.0 тэрбум төгрөг хүртэл) <b>ХХААХҮЯ-aас хүүгийн зөрүүний гэрээтэй</b>	АБ-ны энгийн вексель	2020.05.20	2021.07.26	47	63,927.0
16	Газар тариалан хөтөлбөр (2020 Ковидын үеийн хөнгөлөлттэй нөхцөлтэй)	Голомт банк, Хаан банк, Төрийн банк	3 банк	1.0	3.0	Банкны татан төвлөрүүлэх эх үүсвэр ( эх үүсвэрийн хэмжээ 150.0 тэрбум төгрөг хүртэл) <b>ХХААХҮЯ-aас хүүгийн зөрүүний гэрээтэй</b>		2020.09.17	2021.12.25	833	76,346.9
17	Хүнсний улаан буудайн нөөц бүрдүүлэх төсөл (2021)	ХХБанк, Голомт банк, Хаан банк	3 банк	9.1	12.10	Банкны татан төвлөрүүлсэн эх үүсвэр		2021.01.21	2022.04.08	5	20,114.0
	<b>НИЙТ /17 төсөл, хөтөлбөр/</b>									2,542	1,565,115.0

--- ОOO ---